

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2026 оны 02 дугаар сар

***Тайлангийн агуулга***

1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
2. СУРГАЛТ СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР
3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ТӨЛӨВЛӨЛТ
4. САНХҮҮ БҮРТГЭЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
5. ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖҮҮЛЭЛТ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ
6. ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
7. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ
8. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ
9. ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ТӨВ ЗӨВЛӨЛ
10. ШИМТГЭЛ ХУРААЛТ АРГА ЗҮЙ
11. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСАГ

---oOo---

## 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 1.1. *Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэг*

- Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах;
- Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулах, аймаг, нийслэлийн төсвийн нарийвчилсан хуваарийг батлах;
- Нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд даатгуулагч, ажил олгогчид олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих;
- Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;
- Тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийн хэмжээг өөрчлөх, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах асуудлаар тооцоо, судалгаа хийж, санал боловсруулан Үндэсний зөвлөл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
- Доод шатны байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, үйл ажиллагааны зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх;
- Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллээр хангах;
- Ажил олгогч, даатгуулагч, хүний өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хянан хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламжлах;
- Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, нийгмийн даатгалын байцаагч, ажилтныг тасралтгүй сургах, мэргэшүүлэх;
- Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт болон хөрөнгө оруулалтын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах;
- Үндэсний зөвлөлийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангах;
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллав.

## 1.2. Бүтэц зохион байгуулалт

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орж, улсын хэмжээнд нийт төрийн байгууллагуудын тоог орон тоог 9 хувиар хассантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Төсвийн тухай хуулийн 14.2.12 “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох.” заалтын дагуу Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газрын агентлагын бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын орон тооны хязгаарыг 93 байсныг 84, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын орон тооны дээд хязгаар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” А/163 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжийг 7 газар, 5 хэлтэстэй байсныг 6 газар, 5 хэлтэстэй болгон, нийгмийн даатгалын байгууллагын орон тооны дээд хязгаарыг 1477 байсныг 1341 байхаар тус тус баталсан байна.

Эдгээр тушаалыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Нийгмийн даатгалын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” А/237 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, албан тушаалын жагсаалт, “Дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” А/238 дугаар тушаалаар дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалт, “Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” А/239 дүгээр тушаалаар аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг тус тус шинэчлэн баталсан.

Бүтцийн өөрчлөлт: Хүснэгт 1.

д/д	ХНХЯамны 2024 оны А/19 дүгээр тушаал /7 газар, 5 хэлтэс/	д/д	ГБХНХЯамны 2025 оны 163 дугаар тушаал /6 газар, 5 хэлтэс/
1	Дотоод аудит, мониторингийн газар	1	Дотоод аудит, мониторингийн газар
2	Захиргаа, удирдлагын газар	2	Захиргаа, удирдлагын газар
2.1	Хуулийн хэлтэс	2.1	Хуулийн хэлтэс
2.2	Сургалтын хэлтэс	2.2	Сургалтын хэлтэс
3	Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар	3	Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар
3.1	Судалгаа, актуар тооцооллын хэлтэс	3.1	Судалгаа, актуар тооцооллын хэлтэс
4	Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар	4	Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар
4.1	Үйлчилгээ хөгжүүлэлтийн хэлтэс	4.1	Үйлчилгээ хөгжүүлэлтийн хэлтэс
5	Шимтгэл хураалт, удирдлага арга зүйн газар	5	Шимтгэл хураалт, удирдлага арга зүйн газар
6	Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар	5	Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар
6.1	Тэтгэврийн нөөц сан, хөрөнгө оруулалтын хэлтэс	5.1	Тэтгэврийн нөөц сан, хөрөнгө оруулалтын хэлтэс
7	Хяналт шалгалтын газар	6	Хяналт шалгалтын газар
		6.1	Шимтгэлийн орлого, өрийн хяналтын арга зүйн хэлтэс
<b>Орон тоо -93</b>		<b>Орон тоо -84</b>	

Нийгмийн даатгалын байгууллагын нийт 1341 орон тооноос төрийн захиргааны албан хаагч 1104, төрийн үйлчилгээний 228 албан хаагч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны 9 албан хаагч байна.


№	Нэгжийн нэр	2024 онд батлагдсан орон тоо	Үүнээс		2025 онд батлагдсан орон тоо	Үүнээс	
			Төрийн захиргааны албан тушаал	Төрийн үйлчилгээний албан тушаал		Төрийн захиргааны албан тушаал	Төрийн үйлчилгээний албан тушаал
1	Нийгмийн даатгалын ерөнхий газар	93	84	9	84	74	10
2	Аймгийн Нийгмийн даатгалын газар (21)	909	783	126	824	710	114
3	Дүүргийн Нийгмийн даатгалын газар (9)	436	339	97	399	313	86
4	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба	12	0	0	9	0	0
5	Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл	8	8	0	7	7	0
6	Мэдээллийн технологийн төв	19	0	19	18	0	18
Нийт		<b>1485</b>	<b>1222</b>	<b>251</b>	<b>1341</b>	<b>1104</b>	<b>228</b>

2025 оны 12 сарын мэдээгээр нийгмийн даатгалын байгууллагад нийт 1285 албан хаагч ажиллаж байсан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь үндсэн чиг үүргийн хүрээнд 9 зорилт, 69 арга хэмжээ бүхий үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчаас эхний хагас жилд **91.4 хувь** буюу “*Маш сайн*”, сүүлийн хагас жилд **92.1 хувь** буюу “*Маш сайн*” гэж үнэлэгдэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалт

Схем-1



Нийгмийн даатгалын салбарын ажилтнуудын бүтэц

Хүснэгт-3

№	Албан тушаалын ангилал	Тоо	Хувь
1	Удирдах албан тушаалтан	155	11.56
2	Гүйцэтгэх албан тушаалтан	1186	77.44
<b>Нийт</b>		<b>1341</b>	<b>100</b>

Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо

Хүснэгт-4

№	Төрийн албан тушаалын ангилал	Тоо
1	Төрийн захиргааны албан хаагч	1113
2	Төрийн үйлчилгээний албан хаагч	228
4	Үүнээс: Улсын байцаагч	627

Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдын боловсрол, мэргэжил (1285 албан хаагч)

Хүснэгт-5

№	Боловсрол			Тоо
1	Доктор	3	Эдийн засагч	349
2	Магистр	112	Нягтлан бодох бүртгэл, татвар	355
3	Бакалавр	1097	Санхүү, банк, даатгал	217
4	Бусад	73	Эрх зүйч	124
			Бусад	240

Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдын нас, хүйсийн мэдээлэл (1285 албан хаагч)

Хүснэгт-6

№	Нас	Тоо	Хүйс	Тоо
1	30 хүртэлх	150	Эрэгтэй	232
2	31-40	528	Эмэгтэй	1053
3	41-50	439	-	-
4	51-60	168	-	-

### 1.3. Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах

Нийгмийн даатгалын байгууллагын зохион байгуулалтын нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбоотойгоор зарим газар, хэлтэс татан буугдсан, нэршил өөрчлөгдсөн, чиг үүрэг өөр газарт шилжсэн, зарим албан тушаалын чиг үүргийг нэгтгэсэн зэрэг шалтгаанаар 33 төрийн захиргааны албан тушаал, чиг үүргийг дахин хуваарилсан байна.

Төрийн албаны зөвлөлөөс 2024 онд зөвшөөрөл олгосны дагуу баталж, мөрдүүлж байгаа 133 албан тушаалын тодорхойлолтоос зохион байгуулалтын нэгж, албан тушаалын ангилал, зэрэглэл, чиг үүрэгт өөрчлөлт ороогүй албан тушаалд хамаарах албан тушаалын тодорхойлолтыг хэвээр үлдээх 97, хүчингүй болгуулах 36, шинэчлэх шаардлагатай 33, албан тушаалын тодорхойлолт байна. 2025 оны байдлаар нийгмийн даатгалын байгууллагад 130 албан тушаалын тодорхойлолт мөрдөгдөж байна.

### 1.4. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны “Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг А/346 дугаар тушаалаар баталсан. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор дараах 6 ажил, үйлчилгээнд 3,560.9 сая төгрөгийн тусламж олгосон байна. Үүнээс:

1. Цалин, нэмэгдэл хөлс-3,203.1 сая төгрөг;
2. Үр дүн урамшуулалд 262,6 сая төгрөг;
3. Олон улсын эмэгтэйчүүдийн баярт зориулж 5.8 сая төгрөг;
4. Томилолтын зардалд 152.9 сая төгрөг;
5. Буцалтгүй тусламжид 31.6 сая төгрөг;
6. Ахмад настнуудад 22.8 сая төгрөгийг тус тус олгосон.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалаар байгууллагын соёл, эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, идэвхжүүлэх зорилгоор “Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын манлайлал” аяныг зохион байгуулсан. Тус газрын нэгж болгон нэг сарын хугацаанд албан хаагчдын дунд 2-3 ажлыг зохион байгуулж, албан хаагчдыг идэвхжүүлсэн.

“Эрүүл мэнд бидний баялаг” аяны хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр тус газрын 50 албан хаагчдыг өөрийнх нь хүсэлтээр томуугийн эсрэг вакцинд хамруулав. Мөн 70 гаруй албан хаагчдыг лабораторийн шинжилгээ, нүд, мэдрэл, дотор, чих хамар, хоолойн төрөлжсөн мэргэшлийн эмч нарын үзлэгт хамруулсан байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын газрын Магадлагч эмч Ж.Оюунчимэг, О.Энхтуяа, Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газрын байцаагч Б.Баттулга нарт хандив цуглуулан тусламж олгосон.

### 1.5. Ахмад настны нийгмийн баталгааг хангах

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025.02.14-ний өдрийн А/34 тоот тушаалаар “Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам”-ыг шинэчлэн батлуулсан. Аймаг, дүүргүүдэд чиглэл хүргүүлэн ажилласан болно.

Уг журмын дагуу нийт ахмад настны баталгааг хангахад 22.8 сая төгрөгийг зарцуулаад байна. Үүнд:

1. Буцалтгүй тусламжаар 4 ахмад настанд 3.0 сая төгрөг;
2. Монгол үндэсний баяр 2025 оны цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан 81 ахмад настанд 10.9 сая төгрөг;

3. “Олон улсын ахмадын өдөр”-ийг тохиолдуулан 82 ахмад настанд 8.9.сая төгрөгийг олгосон байна. 2025 онд нийгмийн даатгалын байгууллагад 694 ахмад настан бүртгэлтэй байна.

*1.6. Ажилтан, албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, Нийгмийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл, бусад нэмэгдэл*

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай” А/16 дугаар тушаалаар ахлах түшмэлийн зэрэг дэвийг 6, дэс түшмэлийн зэрэг дэвийг 41, А/137 дугаар тушаалаар ахлах түшмэлийн зэрэг дэвийг 5, дэс түшмэлийн зэрэг дэвийг 55, А/246 дугаар тушаалаар ахлах түшмэлийн зэрэг дэвийг 3, дэс түшмэлийн зэрэг дэвийг 43, нийт 153 нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдад шинээр болон ахиулан олгуулав.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Мэргэшлийн зэрэг олгох тухай” А/57 дугаар тушаалаар 48 улсын байцаагчид тэргүүлэх мэргэшлийн зэрэг, 58 улсын байцаагчид зөвлөх мэргэшлийн зэрэг, 236 улсын байцаагчид итгэмжит зөвлөх мэргэшлийн зэрэг, нийт 294 улсын байцаагчид мэргэшлийн зэрэг олгосон байна. Үүний үр дүнд эдгээр улсын байцаагчдын цалин сард 230 850-651 300 төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Албан хаагчдын унаа, хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” А/307 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын нөхөх төлбөрийн хэмжээг 35000 төгрөг болгон 11 дүгээр сарын 01-ны өдрөөс, “Унаа, хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/319 дүгээр тушаалаар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын албан хаагчдын унаа, хоолны нөхөх төлбөрийн хэмжээг дүүрэгт 27 000 төгрөг, аймагт 12 000 төгрөг, суманд 10 000 төгрөг болгон шинэчлэн, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна.

*1.7. Ажилтан, албан хаагчдын шагнал, урамшуулал*

2025 онд нийгмийн даатгалын салбарын хэмжээнд “Алтан гадас одон”-д 12, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-д 47, “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-д 2, “Нийгмийн хамгааллын салбарын тэргүүн”-д 25, “Хүндэт жуух бичиг”-д 38, Төрийн албаны зөвлөлд “Төрийн албаны тэргүүний ажилтан”-д 1, Сангийн яаманд “Санхүү банкны тэргүүний ажилтан”-д 8, “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтанд”-2, Сангийн яамны “Жуух бичиг”-т 25, Цахим хөгжил, инноваци, харилцаа хобооны яамны “Мэдээллийн технологийн тэргүүний ажилтан”-д 4, нийт 164 албан хаагчийн ажлын үр дүн, ажилласан хугацааг уялдуулан өргөн мэдүүлсэн. Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Хүндэт ажилтан”-д 66, Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Жуух бичиг”-т 74, нийт 140 албан хаагчийн ажлын үр дүн, ажилласан хугацааг уялдуулан шагнав.

*1.8. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх*

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороо нь 2025 онд дараах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө”-г 2025 оны 03 дугаар сард хэлэлцэн баталж уг төлөвлөгөөнд Нийгмийн даатгалын салбарын “Ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн батлах, сургалт зохион байгуулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зэрэг 10 арга хэмжээг зохион байгуулахаар тусгаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө”-г Төрийн албаны зөвлөлийн “Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт” дэд системд байршуулав.

2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ёс зүйн дэд хороо”-нд 2025 онд нийт 9 гомдол, мэдээллийг иргэд, төрийн албан хаагчдаас ирүүлсэн ба үүнээс 3 гомдлыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны харьяалан шийдвэрлэх гомдол биш байх тул харьяаллын дагуу буюу Орхон, Дархан-Уул, Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хороодод шилжүүлсэн. Харин 6 гомдол, мэдээллийг Нийгмийн даатгалын Ёс зүйн дэд хороо гомдлыг хүлээн авч, төрийн албан хаагч нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан нийтлэг шаардлага, хориглолтыг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргасан. Дээрх 6 гомдол,

мэдээллийг Нийгмийн даатгалын Ёс зүйн дэд хорооны гишүүд дарааллын дагуу хариуцсан судалж, дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлж Ёс зүйн дэд хорооноос ёс зүйн зөрчилгүй гаргаагүй тухай 4 дүгнэлт, Ёс зүйн зөрчилтэй тухай 2 дүгнэлтийг ус гаргасан. Ёс зүйн зөрчил гаргасан тухай 2 дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. Үүний дагуу Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан “Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах” ёс зүйн болон сахилгын шийтгэл ногдуулан шийдвэрлэснийг тус тус Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт системд бүртгэн, тайлагнав.

3. Сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны нэг гишүүн сургагч багшаар, Дэд хорооны дарга болон нэг гишүүн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны шинэчлэл” хэлэлцүүлэгт оролцов. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны даргаас “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт үе шаттай сургалт, хэлэлцүүлгийн хөтөлбөр батлав. Уг хөтөлбөрт тусгагдсаны дагуу Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг Нийгмийн даатгалын салбарын Ёс зүйн дэд хорооны гишүүд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагч нар, Нийгмийн даатгалын даргын зөвлөлийн гишүүд, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын албан хаагч нарт нийт 7 удаагийн “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж танхимаар 380, цахимаар 950 гаруй албан хаагчийг хамруулав. Нийгмийн даатгалын салбарын нийт Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, томилох эрх бүхий албан тушаалтнуудтай 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулж Нийгмийн даатгалын салбарт гарч байгаа ёс зүйн зөрчил, Ёс зүйн дэд хороодын нийтлэг гаргаж байгаа алдаа, түүнийг хэрхэн шийдвэрлэх, дотоод зохион байгуулалт хийж ажиллах талаар чиглэл өгөв. БНСУ-дахь Нийгмийн даатгалын албан хаагч нарт Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, хуульд заасан зөрчлийг ялгаж ойлгох талаар сургалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулав.

4. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан Төрийн албан хаагчийн зарчмаар “Төрийн албан хаагч бид” гэх постер хийж Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас, 30 нэгжийн цахим хуудаст байршуулан түгээв.

#### 1.9. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол шийдвэрлэлт

2025 оны байдлаар НДЕГ-т нийт 5268 албан бичиг ирсэн байна. Үүнд:  
Хариутай-2326,  
Хариугүй-2751,  
Хариутай шийдвэрлэсэн-2256,  
Судалж байгаа-70,  
Шийдвэрлэлтийн дундаж-96,9%,  
Ирсэн бичиг шийдвэрлэлтийн дундаж хоног-10,2

-НДЕГ-аас нийт 3203 албан бичгийг стандартын дагуу боловсруулагдан холбогдох байгууллагууд руу хос бичгээр албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системд /intranet.gov.mn/ бүртгэгдэн тоон гарын үсгээр баталгаажуулан илгээгдсэн.

-Албан бичиг солилцооны дундын систем Эйбл программыг ашигладаг бөгөөд цахимаар албан бичиг солилцооны дундын систем”-тэй холбогдсон бусад байгууллагуудтай 100% цахимаар албан бичгийг солилцож байна.

#### 1.10. “Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийн бэлтгэл ажлыг хангах



хөтлөлтийн стандарт”, 2025.09.18-ны өдөр “Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулав.

-Цахим баримтыг хадгалах, хамгаалах ажлын хүрээнд хадгалалтыг сайжруулан МТТ-д сервер үүсгэн нэмэлтээр хадгалж, хуулбар хувиудыг үүсгэв.

-НДЕГ-ын даргын 2025 оны А/199 тоот тушаалаар “Нийгмийн даатгалын байгууллагын архивын дүрэм”-ийг шинэчлэн батлав.

-НДЕГ-ын даргын А/256 дугаар “Архивын баримтын тооллого хийх тухай” тушаал батлаж, НДЕГ-ын архивд хадгалагдаж байгаа 7791-н цаасан суурьтай хадгаламжийн нэгжид тооллого хийх ажлыг зохион байгуулав.

-НДЕГ-ын даргын 01/3145 тоот албан бичгээр “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 13.6-д заасны дагуу АЕГ-т архивт хадгалагдаж байгаа баримтын тоо хэмжээ, өөрчлөлт хөдөлгөөний мэдээг хүргүүлэв.

-НДЕГ-ын даргын А/328 дугаар тушаалаар “Онцгой байдлын үед архивын баримтыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө”-г батлав.

-Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/63 дугаар тушаалаар баталсан “Архивын байгууллагын дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”-ийн 2.3.3-т заасны дагуу ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулахаар 03/3211 тоот албан бичгийг хүргүүлэв.

### 1.11. Мэдээллийн цахим сангаас хүсэлт гаргасан байгууллага, иргэд, даатгуулагчдад лавлагаа

2025 онд Нийгмийн даатгалын цахим мэдээллийн сангаас 1150 иргэн даатгуулагч, 484 аж ахуйн нэгжид цаасан суурьт мэдээлэл лавлагаа гаргах үйлчилгээг үзүүллээ.

Хууль хяналтын байгууллагын 979 удаагийн мэдээллээр 47746 иргэн, 1083 аж ахуйн нэгжид лавлагаа, мэдээллийг өгч ажиллав.

## 2. СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

### 2.1. Санамж бичиг, хамтран ажиллах гэрээ байгуулах, хамтын ажиллагааны хүрээнд:

Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах, төрийн болон боловсролын байгууллагын түншлэлийг хөгжүүлж, хамтын ажиллагааг үр дүнд хүргэх зорилгоор судалгаа шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах, харилцан дэмжлэг үзүүлэх ажлыг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургуультай хамтран ажиллах “Санамж бичиг”-ийн байгуулав. Энэхүү ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр тус

сургуулийн нийт 100 оюутан, суралцагчдад нийгмийн даатгалын хуулийн талаарх мэдээллийг хүргэн ажиллав.

Санамж бичгийн хүрээнд МУИС-ын багш болон оюутан суралцагчдад зориулсан “Нийгмийн даатгал”-ын өдөрлөгийг Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газартай 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хамтран зохион байгуулав. Уг арга хэмжээнд нийт 31 багш, оюутнуудыг хамруулан нийгмийн даатгалын талаарх мэдээллийг хүргэв.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны хүрээнд “Бизнесээ томруулъя” ТББ-тай хамтран ажиллах Санамж бичгийг байгуулав. Энэхүү санамж бичгийн хүрээнд жижиг, дунд бизнес эрхэгчдийг дэмжих, тэдэнд нийгмийн даатгалын хууль тогтоомж,


цахим үйлчилгээний болон сайн дурын даатгалд хамрагдахын ач холбогдлыг таниулах талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, нийгмийн даатгалын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, ач холбогдлын талаар бизнес эрхлэгчдэд сурталчлах ажлыг зохион байгуулан гүйцэтгэхээр болов.

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс “Санамж бичиг”-ын хүрээнд 2025, 2026 онд хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг (2025.02.03-ны №28 тоот) албан бичгээр ирүүлсэнтэй холбогдуулан 02 дугаар сарын 18-ны өдөр ММНБИ-ын Дэд захирал М.Давааням, Сургалт, судалгаа, стандарт хариуцсан дэд захирал Б.Батцэцэгтэй

Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү, Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Алтанцэцэг, Сургалтын хэлтсийн дарга С.Ундармаа нар уулзалт зохион байгуулж, санал солилцов. Уулзалтаар төлөвлөгөөнд тусгасан ажлын талаар ярилцан, харилцан саналаа тусган хүргүүлэхээр тохиолцсоны дагуу саналаа холбогдох газартай хамтран боловсруулж, 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдөр ММНБИ-д хүрүүлэв.

## *2.2.Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах талаар:*

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын журам”-ын 1.2, 1.3 дахь хэсэг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” А/208 дугаар тушаалын 2.1 дэх заалт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах тухай” А/303 дугаар тушаалыг тус тус үндэслэн Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-11-ний өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулав.



Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтад нийт 411 албан хаагч оролцсоноос 174 буюу 42.3% нь “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын журам”-ын 11.2, 11.3-т заасан шалгуурыг ханган амжилттай дүн үзүүлж, 237 албан хаагч хангалтгүй дүгнэгдлээ.

Шалгалтад тэнцсэн нийт 174 албан хаагч, үүнээс улсын ахлах байцаагчийн эрх олгох 2, шинээр эрх авах 29, сэргээх 40, эрх баталгаажуулах 103, “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын журам”-ын 2.4 дэх хэсэгт заасны дагуу улсын байцаагчийн эрхийг шалгалтгүйгээр олгох 27 албан хаагч байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/304 дүгээр тушаалаар Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын сорилын сан бүрдүүлэх, хянах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, сорилын сангийн жагсаалтыг баталсан. Ажлын хэсгийн гишүүдэд 36 хууль, журмын хүрээнд нийт 2206, үүнээс ерөнхий мэдлэгийн 1614, онол арга зүйн 600, албан хэрэг хөтлөлтийн 50 сорилын санг чиг үүргийн дагуу хуваарилан, хүргүүлсэн. Мэдээллийн технологийн төвийн вэб сервер дээр суурилсан “Зайн сургалт, шалгалт”-ын программ хангамжийн бэлтгэлийг хангуулж, шалгалтад ороолцогчдын өгөгдлийн санг программд оруулах ажлыг тус төвийн ажилтнууд, шалгалтын ажлын хэсгийн гишүүдийн хамт хийж гүйцэтгэв.

Улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх сургалтын хөтөлбөрийг батлуулан, хөтөлбөрийн дагуу сургалт 11 дүгээр сарын 12-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.



Шалгалт зохион байгуулахад шаардагдах зардлын төсвийг урьдчилсан байдлаар 8 хувилбараар тооцоолж, Газрын дарга, нэгжийн удирдлагад танилцуулсан.

Нийслэлд улсын байцаагчийн шалгалтыг МУИС-ийн “Мэдээллийн технологи, электроник”-ийн сургууль дээр зохион байгуулахаар төлөвлөж, зохион байгуулах танхим болон компьютер, техникийг бүрэн бүтэн байдлыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр танилцан, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллав.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн журам”, 2023 оны А/170 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлах журам”-ын төсөлд саналыг тусган боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2025 оны 01/2054 дугаар албан бичгээр хүргүүлэв.

### *2.3. Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын сургалтын талаар:*

2025 онд салбарын хэмжээнд нийгмийн даатгалын албан хаагчдыг чадвахжуулах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 3153 удаагийн сургалтад давхардсан тоогоор 46908 албан хаагчдыг танхим болон цахимаар хамруулснаас Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 32 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт танхимаар 2083, цахимаар 2712, давхардсан тоогоор 4795 албан хаагчийг хамруулан, доорх сургалтыг зохион байгуулав. Үүнд:

-БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх болон хувь хүний хөгжлийн 6 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 96 албан хаагч хамрагдав.

-Эблесофт ХХК-тай хамтран “Эбле программаар албан бичиг, тушаал төлөвлөх, батлуулах арга зүйн” сургалт, Сумын нийгмийн даатгалын байцаагч нарт зориулсан “SIGOS” сиситемийн сургалт, Архивчдын хөгжил сургалт, арга зүйн төвтэй хамтран “Архивын албан хэрэг хөтлөлтийн талаар” сургалт, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газартай хамтран “Хяналт шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ын талаарх сургалт, Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэг, түүний ойлголт” сэдэвт сургалт, Багшийн сургуулийн сургалт, судалгааны төвтэй хамтран “Багшлахуй” захиалгат сургалт зэрэг болно.

Сургалтын платформд 59 видео хичээл, 76 илтгэл (ppt)-ийг байршуулан, албан хаагчдыг боломжтой цагтаа өөрийн нэвтрэх эрхээр орон хичээлүүдийг бие даан судлах боломжийг бүрдүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдад цаг үеийн шинжтэй болон шинэ шинэлэг мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор 20 удаагийн мэдээллийн цагийг зохион байгуулсан бөгөөд танхимаар 954, цахимаар 2363 нийт 3317 албан хаагчид хамрагдав.

Нийгмийн даатгалын албан хаагчдын 2025 оны сургалтын хэрэгцээ, ажил олгогч, иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаар мэдээлэл хүргэх чиглэлийг тодорхойлох зорилгоор асуумж судалгааг зохион байгуулав.

Нийгмийн даатгалын салбарын болон өөрийн эрхэлж буй ажил, албан тушаалын хүрээнд суралцах сургалт, хувь хүний хөгжил, мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр суралцах сургалт, ажил олгогч, даатгуулагч, иргэдэд нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээллийг хүргэх сургалт, нийгмийн даатгалын ерөнхий газарт уламжлах саналаа илэрхийлэх асуумж-судалгаанд аймаг, дүүрэг, сумын нийгмийн даатгалын 542 байцаагч, ажилтнууд хамрагдсан. Энэхүү сургалтын хэрэгцээний үр дүнд үндэслэн Нийгмийн даатгалын байгууллагын 2025 онд зохион байгуулах 3 бүлэг бүхий 31 сургалтын төлөвлөгөө батлуулан, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар (2025.02.21-ний өдрийн 03/425 дугаар)-т албан бичгээр хүргүүлэв. Тайлант хугацаанд сургалтын төлөвлөгөөнд заасан сургалтаас 51 хувь буюу 16 сургалтыг зохион байгуулан, танхимаар 610 албан хаагч, цахимаар 1103 албан хаагчийг хамруулав.

#### *2.4. Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах;*

2025 онд салбарын хэмжээнд иргэд, даатгуулагч ажил олгогчдод нийгмийн даатгалын багц хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зааврыг сурталчилан таниулах, тэдний ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 3775 удаагийн танхимын болон цахим сургалтыг 18473 аж ахуйн нэгжийн 208458 иргэд, даатгуулагчийг хамруулан зохион байгуулснаас Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 59 удаагийн сургалтад 5328 иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулан, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаарх зөвлөгөө, мэдээллийг түгээн ажиллав. Тухайлбал:

Тагнуулын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төв, Мэдээллийн лавлах -19001950, Залуусаа дэмжих үндэсний хөдөлгөөн ТББ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх алба, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, Тээвэр хөгжлийн банк, Голомт банк зэрэг болно.

Тус газар нь хамтын ажиллагааны хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, гуравдугаар шатлалын эмнэлэг, төрийн болон хувийн их, дээд сургууль, арилжааны даатгалын компани, банкуудтай хамтран ажиллаж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд нийт 24 байгууллагын 1421 ажилтан, албан хаагчдыг хамруулан “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл”-ийн талаар сургалт зохион байгуулав.

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Цаг уур, орчны шинжилгээний газар, Оюуны өмчийн газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургууль, Албан журмын даатгагчдын холбоо, Монгол Хөдөө ахуйн хоршоологчдын холбоо, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Монгол даатгал компаний нийт 372 ажилтан, албан хаагчдад Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудыг танилцуулан, тэдний тавьсан нийгмийн даатгалын талаарх асуултад хариулт өгч ажиллав.

#### *2.5. Сургалтын төлөвлөгөөг баталгаажуулах, сургалт зохион байгуулах.*

Нийгмийн даатгалын салбарын 542 байцаагч, ажилтнуудыг хамруулан сургалтын хэрэгцээг тодорхойлох асуумж судалгааг зохион байгуулсан бөгөөд энэхүү сургалтын хэрэгцээний үр дүнд үндэслэн Нийгмийн даатгалын байгууллагын 2025 онд зохион байгуулах 3 бүлэг бүхий 31 сургалтын төлөвлөгөө батлуулж, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар (2025.02.21 03/425 дугаар)-т албан бичгээр хүргүүлэв. Сургалтын төлөвлөгөөнд заасан

сургалтаас 77.4 хувь буюу 24 сургалтыг танхимаар 954 албан хаагч, цахимаар 2363 албан хаагчийг хамруулан зохион байгуулав.

### *2.6. Хилийн чанадад ажиллаж амьдарч байгаа иргэдэд нийгмийн даатгалын талаар мэдлэг олгох цахим сургалт зохион байгуулах.*

Хилийн чанад дахь монголчуудын зөвлөлтэй хамтран ажиллах хүрээнд АНУ, Австрали, Ази, Европ тивийн төлөөлөлтэй хамтран цахим мэдээлэл, уулзалт зохион байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд Унгар, Бельги, Чех, Австри улсад ажиллаж амьдарч байгаа Монголчуудад Нийгмийн даатгалын ач холбогдол, сайн дурын даатгалын талаар мэдээлэл, зөвлөгөөг хүргэх ажлыг зохион байгуулж ажиллав. Үүнд:

- БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн алба хаагч нарт, Сайн дурын даатгал, даатгалд хамрагдахын ач холбогдлыг иргэд даатгуулагч нарт хэрхэн хүргэх арга зүйн талаар мэдээлэл хийсэн.
- Чех улсад байгаа Монголчуудын холбоотой хамтран 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 46 иргэнд “Нийгмийн даатгалын талаарх ойлголт болон хэлэлцээрийн талаар” цахимаар сургалт хийж, асуултад хариулт өгч ажиллав.
- Бүгд Найрамдах Унгар Улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн талаар 2025.07.06-ны өдөр,
- Бүгд Найрамдах Австри Улсад оршин суугаа Монгол Улсын иргэдэд Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн талаар 2025.10.12-ны өдөр,
- Унгар Улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, ач холбогдол сурталчилан таниулах ажлыг 2025.07.06-ны өдөр цахимаар зохион байгууллаа. Нийт 25 иргэн хамрагдсан.
- АНУ, Австрали, Ази, Европ тивийн төлөөлөл болон Нийгмийн бодлогын хорооны гишүүд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаарх сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулав. Сургалтаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, сайн дурын даатгал, даатгалд хамрагдахын ач холбогдол, нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар танилцуулан, зөвлөлийн гишүүдийн тавьсан нийгмийн даатгалын талаарх асуултад хариулт өгч ажиллав.

Зөвлөлийн гишүүд сургалтад хамрагдсанаар тухайн оронд ажиллаж амьдарч байгаа иргэдэд нийгмийн даатгалын талаар мэдээлэл түгээх, тэдэнд тулгамдаад байгаа асуудлыг нийгмийн даатгалын ерөнхий газарт уламжлах, хамтран шийдвэрлүүлэх, зөвлөлийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа иргэд болон иргэд, даатгуулагчдад зориулан “Ажил олгогч, даатгуулагч, иргэдэд” чиглэсэн 6 төрлийн цахим хичээлийн хөтөлбөрийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаар батлуулан, хичээлийг 2025 оны 10 дугаар сарын 24-ны өдөр “Хуульч ньос” компаниар бичлэгийг хийлгэн ажиллав.

Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн богино хугацааны чиглүүлэх сургалтад 4, дунд хугацааны сургалтад 10, дунд хугацааны давтан сургалтад 8, ахлах түшмэлийн сургалтад 12, эрхэлсэн түшмэлийн сургалтад 4 нийт 38 албан хаагчийг хамруулсан бөгөөд улсын төсвийн зардлаар 19, хувийн зардлаар 19 албан хаагч суралцаж, бүрэн төгссөн байна.

## **3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ТӨЛӨВЛӨЛТ**

### *3.1. Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийн хэрэгжилтийг зохион байгуулсан үйл*

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /цаашид “ГБХНХЯ” гэх/-наас боловсруулж ирүүлсэн Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт ажиллаж санал боловсруулан тайлбарын хамт, мөн холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулан ГБХНХЯаманд хүргүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой 9 зөвлөмж, чиглэлийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус газраас дараах баримт бичигт тусгах саналаа ГБХНХЯаманд хүргүүлэв. Үүнд:

1. Батлан хамгаалахын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2025 оны “Заавар батлах тухай” А/95, А81 дүгээр тушаалаар баталсан “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах заавар”;

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл зэрэг болно.

Засгийн газрын 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 221 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн тэтгэврийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 6.0 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 689.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоов. Уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 505.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлж, тэтгэврийн нэмэгдэлд 300.1 тэрбум төгрөг зарцуулснаар дундаж тэтгэвэр 832.7 мянган төгрөгт хүрсэн болно.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу малчин, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх эсхүл эцгийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс хариуцан төлөх, сайн дураар даатгуулагч гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн төлөх тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс болон тэтгэмжийн даатгалын сангаас хариуцан төлөх, Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд нас барсан тэтгэвэр авагчийн авч байсан тэтгэврийн 20 хувиар нөхөр /эхнэр/-ийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх зохицуулалтуудын хэрэгжилтийг тус тус хангуулан ажиллав.

Дээрх ажлын хүрээнд 2025 онд 0-3 насны хүүхдээ асарч байгаа 16.9 мянган эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа 3.9 мянган эх /эцэг/, 55.2 мянган малчин сайн дураар нийгмийн даатгалд хамруулав. Мөн өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалтад 3.6 мянган тэтгэвэр авагч хамрагдав.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон Гадаад харилцааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны “Адилтгах албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 2022 оны А/48, А/130 дугаар хамтарсан тушаалыг хэрэгжүүлэхтэй холбоотой гадаад улсад цэргийн атташе болон атташегийн туслахаар томилогдон ажилласан цэргийн алба хаагчид Цэргийн алба хаасны тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу цэргийн алба хаасны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоох хөдөлмөрийн хөлсний дунджийг тодорхойлохдоо Гадаад харилцааны яамнаас тухайн сард тайлагнасан “01001” кодтой цалин хөлс, холбогдох цэргийн байгууллагаас тайлагнасан “11001” кодтой цэргийн цолны олговрын нийлбэр дүнгээр тооцох, хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний асрамжинд байсан гэр бүлийн гишүүнд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын зардлын төлбөрийг сонгон шалгаруулалтад тэнцсэн сувиллын байгууллагад шилжүүлэх, 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдсөнтэй уялдуулан программд оруулах өөрчлөлт, “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-ыг хэрэгжүүлэхтэй

холбоотой нэрийн дансны программд оруулах өөрчлөлт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой цэцийн гишүүний цалингийн хэмжээг программд оруулах, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан уг хуулийг хэрэгжүүлэх зэрэг 8 удаагийн бодлогын даалгаврыг Мэдээллийн технологийн төвд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Журам батлах тухай” 01 дүгээр тогтоолоор баталсан “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-д заасны дагуу 11.34 хувь байхаар тогтоож, Үндэсний статистикийн хороо, ГБХНХЯам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооны саналыг тус тус авч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэв.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” 10 дугаар тогтоолоор “Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эхний үлдэгдэл болон 2024 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод тооцох хүүг 11.34 хувиар тогтоож, нэрийн дансны 2024 оны орлогын эцсийн үлдэгдлийг тодорхойлж, цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia, “Нийгмийн даатгал” аппликэйшн болон portal.ndaatgal.mn цахим хуудсаар дамжуулан даатгуулагчдад мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулах чиглэлийг Мэдээллийн технологийн төвд хүргүүлж, ондоо багтаан мэдээлэхээр ажиллаж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Тэтгэвэр дундаж хугацааны илэрхийллийг Үндэсний статистикийн хороо, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл жил бүр тогтооно.” гэж заасны дагуу ГБХНХЯамнаас санал ирүүлнэ.

Нийгмийн даатгалын ерөнхий газар /цаашид “НДЕГ” гэх/-ын даргын 2024 оны “Журам, заавар, өргөдлийн маягтын загвар батлах тухай” А/246 дугаар тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам”, “Тэтгэвэр бодох заавар”-ыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 2025 оны 7020 дугаарт, НДЕГ-ын даргын 2025 оны “Заавар батлах тухай” А/267 дугаар тушаалаар “Тэтгэмж бодох заавар”-ыг боловсруулан батлуулж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7399 дугаарт тус тус бүртгүүлж, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Төлөвлөгөө батлах тухай” 06 дугаар тогтоолоор “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-г батлуулав. Төлөвлөгөөнд нийт 62 арга хэмжээ зохион байгуулахаар тусгагдсан бөгөөд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу 43 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 1,625.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгов.

Төлөвлөгөөнд тусгагдсан бусад 19 арга хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын 2.1-д “... төлөвлөгөөнд туссан урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулна.” гэж заасны дагуу тендер шалгаруулалтыг зарласан боловч хамтран зохион байгуулах мэргэжлийн байгууллагууд уг шалгаруулалтад оролцоогүй болно.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалт, сурталчилгааны 8 арга хэмжээ,

үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар даатгуулагч, ажил олгогчид зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын 6 арга арга хэмжээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн ажил олгогчийн шилдэг туршлага, ололт, амжилтыг олон нийтэд сурталчлах 5 арга хэмжээг тус тус мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулав.

“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдсаны дараах арга хэмжээг зохион байгуулж ГБХНХЯаманд хүргүүлэв. Үүнд:

- ✓ “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн орлого, зарлагын хэтийн тооцоолол хийх” ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, шалгаруулалтад Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургууль шалгарав. Тус сургуультай НД35/25-25/03 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан ажиллаж, судалгааны ажлын тайлан;
- ✓ “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн орлого, зарлагын хэтийн тооцоолол хийх” ажлын хүрээнд “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь, хэмжээг тогтоох аргачлал, томъёо боловсруулах” ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, шалгаруулалтад “Үндсэн үүрэг дэс” НҮТББ шалгарав. Тус байгууллагатай НД102/25, 25/02 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ”;
- ✓ “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ түүний зохистой байдалд үнэлгээ хийх судалгааны ажил”-ыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, шалгаруулалтад “Эм ЭМ Си Жи” ХХК шалгарав. Тус компанитай НД72/25, 2507-006 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан ажиллаж, ажлын тайлан;
- ✓ “Орон нутгийн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх үйл ажиллагаатай танилцаж, дүгнэлт хийн, холбогдох зөвлөмжийг боловсруулж, удирдлагаар хангах” ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, шалгаруулалтад “Бодлогын орчил” НҮТББ шалгарав. Тус байгууллагатай НД36/25, 04/03 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан ажиллаж, ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмж зэрэг болно.

### *3.2. Нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлын төсвийн төлөвлөлтийн талаар*

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар сангийн орлого (улсын төсвийн санхүүжилт орсон дүнгээр)-ыг 6,908.1 тэрбум төгрөгөөр, зарлагыг 5,869.5 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг 67.4 тэрбум төгрөгөөр тус тус баталсан бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарь батлах тухай” А/01, “Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарь батлах тухай” А/02 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/15, А/50, А/143, А/161, А/201, А/227, А/282, А/320, “Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/16, А/49, А/129, А/154, А/200, А/243, А/276, А/302 дугаар тушаалуудаар нийгмийн даатгалын сангийн төсвийн аймаг, дүүргийн нарийвчилсан хуваарийг тус тус өөрчлөн батлуулан, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Нийгмийн даатгалын сангийн 2026-2028 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг НДЕГ-ын 2025 оны “Санал хүргүүлэх тухай” 01/636 тоот албан бичгээр, нийгмийн даатгалын сангийн 2026 оны жилийн хязгаарын саналыг 2025 оны “Санал хүргүүлэх тухай” 04/1333 тоот албан бичгээр тус тус ГБХНХЯаманд хүргүүлэв. Уг саналд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг хэвийн өсөлтөөр, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан 8.0 хувиар нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох дундаж цалинг тооцох дараалсан 5 жилийн дээд хязгаарыг

2,400,000 төгрөг болгох зэрэг өөрчлөлтүүдийг тусган нийгмийн даатгалын сангийн орлогыг 8,794.4 тэрбум төгрөгөөр, үүнээс төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийг 2,774.8 тэрбум төгрөгөөр, сангийн нийт зарлагыг 6,963.5 тэрбум төгрөг байхаар тус тус тооцов.

НДЕГ-ын 2025 оны “Төсвийн төсөл, төсөөллийн санал ирүүлэх тухай” 1/1112 тоот албан бичгээр нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2026-2028 оны төсвийн төсөл, төсөөллийг боловсруулж, ирүүлэх чиглэлийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлж, ирүүлсэн саналыг хянан нэгтгэж, нэгтгэсэн төсвийн саналыг боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2-т заасан хугацаанд НДЕГ-ын 2025 оны “Төсвийн төсөл, төсөөллийн санал хүргүүлэх тухай” 01/1740 тоот албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. Уг төсвийн төслийн саналд тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо, сангийн зарлагыг нас, хүйсээр ангилан тооцож, тэтгэвэр бодох цалингийн дээд хязгаарыг 2,400.0 болгон нэмэгдүүлэхэд 333.8 тэрбум төгрөг, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан 10.3 хувиар нэмэгдүүлэхэд 572.5 тэрбум төгрөг шаардагдах тооцооллыг тусгав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг 60.2 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын сангийн орлогыг 7,824.7 тэрбум, үүнээс улсын төсвийн татаасыг 1,624.6 тэрбум төгрөг, сангийн зарлагыг 6,584.8 тэрбум төгрөгөөр тус тус баталсан. Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн аймаг, дүүргийн болон сар, улирлын хуваарь, Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2026 оны төсвийн аймаг, дүүргийн болон сар, улирлын хуваарийг боловсруулан, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.1-д заасан хугацаанд буюу 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэв.

Нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны дунд хугацааны төсөөллийг баталсан аргачлал, зөвлөмжийн дагуу сум, дүүрэг, тасгийн холбогдох байцаагч, ажилтнуудыг ажлын хэсэгт ажиллуулан боловсруулж, цахим системээр 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэх зөвлөмж, чиглэлийг НДЕГ-ын 2025 оны “Төсвийн төсөл, төсөөллийн санал ирүүлэх тухай” 04/1364 тоот албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлэв.

Улсын Их Хурлын Чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 01/3031 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу НДЕГ-ын 2025 оны 01/2381 тоот албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад чиглэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

### 3.3. Судалгаа, тооцооллын ажлын талаар

ГБХНХЯамнаас боловсруулсан Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж байгаатай холбогдуулан дараах тооцооллыг хийв. Үүнд:

- ✓ Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 1 хувиар бууруулахад 261.0 тэрбум төгрөгөөр, 2 хувиар бууруулахад 523.0 тэрбум төгрөгөөр тус тус тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого буурах тооцоолол;
- ✓ Ажил олгогчийн ажилтанд олгосон цалин хөлснөөс тооцох шимтгэлийн дээд хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоовол нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 174.9 тэрбум төгрөгөөр буурах тооцоолол;
- ✓ Ажил гүйцэтгэх гэрээ, Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа даатгуулагчийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй байхаар тогтоовол уг хуулийн өөрчлөлтөд 28.9 мянган даатгуулагч хамрагдаж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 25.3 тэрбум төгрөгөөр буурах тооцоолол;

- ✓ ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.2-1.0, 0.1-0.9 хувиар бууруулахад шимтгэлийн орлого 89.3 тэрбум төгрөгөөр буурах, 0.1 хувийг ажилгүйдлийн даатгалын санд шилжүүлэхээр тооцоход ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого 25.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэх, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого нийт 115.1 тэрбум төгрөгөөр буурах тооцоолол;
- ✓ Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын зохистой харьцааг барих зорилгоор ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.1 пунктээр бууруулахад шимтгэлийн орлого 30.0 тэрбум төгрөгөөр буурах, ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.1 пунктээр нэмэгдүүлэхэд шимтгэлийн орлого 30.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэх тооцоолол;
- ✓ Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох насыг нэмэгдүүлэх: Эмэгтэй даатгуулагч (55-60), 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж, өсгөсөн эх (50-55), газрын дор, хортой, халуун (эрэгтэй 50-55, эмэгтэй 45-50), хүнд (эрэгтэй 55-60, эмэгтэй 50-55) нөхцөлд ажиллагч, малчны (эрэгтэй 55-60, эмэгтэй 50-55) тэтгэвэр тогтоолгох насыг жил бүр 3 сараар нэмэгдүүлэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу тэтгэвэрт зарцуулах хөрөнгө 28.7 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцоолол;
- ✓ Тэтгэвэр бодох дундаж цалинг тооцох дараалсан 5 жилийг 10 жил болгон нэмэгдүүлбэл тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу тэтгэвэрт зарцуулах хөрөнгө 32.7 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцоолол;
- ✓ Хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг “сүүлийн 10 жилд нийтдээ 60 ба түүнээс дээш сар” гэж, хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг “нийтдээ 60 сар ба түүнээс дээш сар” гэж, Тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг “сүүлийн 10 жилд нийтдээ 60 ба түүнээс дээш сар” гэж, хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг “нийтдээ 60-аас доошгүй сар, үүнээс тасралтгүй 36 сар” гэж тус тус нэмэгдүүлбэл тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу тэтгэвэрт зарцуулах хөрөнгө 18.8 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцоолол;
- ✓ Өндөр насны тэтгэврийг 2018 оноос өмнө тогтоолгосон 206.6 мянган эмэгтэй тэтгэвэр авагчийн ажиллаж шимтгэл төлсөн жилийг хүүхдийн тоогоор нэмэгдүүлэхэд тэтгэврийн зардалд 111.0 тэрбум төгрөг нэмж шаардагдах тооцоолол;
- ✓ Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлын 55 өдрөөр тооцож олгоход сангийн зардал 20.6 тэрбум төгрөгөөр буурах тооцоолол;
- ✓ ГБХНХЯам, Дэлхийн банктэй хамтран зохион байгуулсан сургалтын хүрээнд Монгол Улсын тэтгэврийн шинэчлэлийн бодлогын хувилбаруудад хийсэн дүн шинжилгээтэй танилцаж, суурь тэтгэвэр, цалинд үндэслэсэн аргаар тооцсон тэтгэврийн тооцоолол зэрэг болно.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, ажил олгогч, албан журмын болон сайн дурын даатгуулагчийн тоо, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ зэрэг статистик мэдээллийг аймаг, дүүргээр 2024 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн гаргав.

Нийгмийн даатгалын салбарын 2024 оны статистик мэдээллийг Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны “Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” А/175 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу гаргаж, ГБХНХЯам, Үндэсний статистикийн хороонд тус тус хүргүүлэв.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийв. Тухайлбал албан журмын даатгалд 61.0 мянган ажил олгогч, 996.8 мянган даатгуулагч, 140.2 мянган сайн дурын даатгуулагч хамрагдсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад ажил олгогч, даатгуулагчийн тоо тус тус 4 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн тайлангаар сангийн орлого 2024 онд 5.6 их наяд төгрөг буюу өмнөх оноос 31.3 хувиар, сангийн зарлага 5.1 их наяд төгрөг буюу 26.5 хувиар тус тус өссөн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) вэбсайтад “Нийгмийн даатгалын сангийн сарын мэдээний тойм” мэдээллийг сар бүр бэлтгэн байршуулав.

Шил ажиллагааны [www.shilen.gov.mn](http://www.shilen.gov.mn) цахим хуудасны “Нээлттэй мэдээлэл” цэсэд нийгмийн даатгалын сангийн зарлага, мөнгөн хөрөнгийн 2024 оны мэдээллийг тус тус байршуулав. Уг цахим хуудсанд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийгмийн даатгалын сангийн зарлагын 2246, мөнгөн хөрөнгийн 2972, нийт 5218 мэдээллийг байршуулав.

Нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны батлагдсан төсөв, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2026 оны төсвийн төслийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудасны “Засгийн газар, орон нутгийн тусгай сан” дэд цэсэд хуулиар тогтоосон хугацаанд байршуулав.

Тайлант хугацаанд дараах судалгаа, тооцооллыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Судлаач, актуарчтай 2025 оны НД-34/25 дугаартай “Тооцооллын хэрэглээний программ нийлүүлэх гэрээ”-г байгуулж, тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага, даатгуулагч, тэтгэвэр авагчийн дунд болон урт хугацааны тооцоолол, уг тооцооллыг цаашид ашиглах, хөгжүүлэх зориулалт бүхий загвар файлыг хүлээн авч, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулав.

2. Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуультай 2025 оны НД-35/25-25/03 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулж, тэтгэврийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн орлого, зарлагын хэтийн тооцооллыг хийлгэж, тооцооллын файл болон бичмэл тайланг тус тус хүлээн авав. Уг тооцооллыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулав.

3. Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлагын өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлийн талаар судалгаа, шинжилгээ хийж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулав.

Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим хамтран 2024 оны “ТОП-100” Аж ахуйн нэгж, байгууллагыг эрэмблэх, шалгаруулахтай холбоотой төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн дүн болон даатгуулсан даатгуулагчдын тоогоор эрэмбэлэн үзүүлэлт тус бүрээр эхний 500 ажил олгогчийн судалгааг 2024 оны жилийн эцсийн байдлаар гарган хүргүүлэв.

Нийгмийн даатгалын сангийн үндсэн үзүүлэлтүүдийн мэдээллийг сар бүр гаргаж, удирдлагыг мэдээллээр ханган ажиллав.

#### *3.4. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажилласан талаар*

Тайлант хугацаанд Төрийн болон төрийн бус байгууллагатай Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах чиглэлээр дараах хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг байгуулав. Үүнд:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2024 онд байгуулсан НД04/24 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-г дүгнэж, 2025 оны НД09/25, ЭМДЕГ-25/27 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-г шинэчлэн байгуулав.

2. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн хооронд 2024 оны НДСБ-02 дугаартай “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг байгуулав. Мөн тус байгууллагатай Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт, ач холбогдлын талаар ажил олгогч, иргэд даатгуулагчдад сурталчлан таниулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд, олон улсын туршлага сэдэвт сургалт зохион байгуулахаар 2025 оны НД-49/25 тоот “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулав.

3. Нийгмийн даатгалын багц хууль, Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, даатгуулагчдын эрх ашийг хамгаалах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 4 жилийн хугацаатай байгуулав.

4. Нийгмийн даатгалын багц хууль, Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хүрээнд түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлж, бизнес эрхлэгч ажил олгогчид, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 3 жилийн хугацаатай байгуулав.

Цэргийн алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, тэдэнд үзүүлэх тэтгэврийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор цэргийн байгууллагуудтай байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд цэргийн 10 байгууллагад гэрээнд өөрчлөлт оруулах саналаа ирүүлэх албан бичгийг хүргүүлэв.

Монголын ахмадын холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн төслийг боловсруулан НДЕГ-ын 2025 оны 01/1744 тоот албан бичгээр Монголын ахмадын холбоонд хүргүүлэв.

Цэргийн алба хаасны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох үйл ажиллагааг цахимд шилжүүлэх ажлын хүрээнд цэргийн алба хаагчийн тушаал, шийдвэрийн лавлагаа, цэргийн алба хаасан тооцоолол болон холбогдох бусад мэдээллийг цахимаар солилцох зорилгоор НДЕГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын хамтарсан тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт ажиллав.

### *3.5. Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийн талаар*

Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- ✓ БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хүрээнд ОХУ-д ажилласан хугацаагаа баталгаажуулах хүсэлт гаргасан 73 иргэний хүсэлтийг ОХУ-ын тэтгэврийн санд албан бичгээр хүргүүлж, хоёр улсад ажилласан хугацаагаа баталгаажуулахаар хүсэлт гаргасан 48 иргэний ажилласан жилийн тодорхойлолтыг баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлж, 54 иргэнд хэлэлцээртэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөв.
- ✓ БНСУ, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хүрээнд БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанд шимтгэл төлсөн 53 иргэний 254.8 сая вонны шимтгэлийн буцаан олголтын нэхэмжлэх, баримт бичгийг хүлээн авч Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлэв. Мөн хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажилласан иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх чиглэлийг БНСУ дахь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасагт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.
- ✓ Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд Бүгд Найрамдах Чех Улсад тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 95 иргэний Монгол Улсад нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан тухай лавлагаа, 41 иргэний Бүгд Найрамдах Чех Улсад даатгалд хамрагдсан хугацааны гэрчилгээний хүсэлтийг БНЧУ-ын талд хүргүүлэв.
- ✓ Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Унгар Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд тус улсаас тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан 32 иргэний, Монгол Улсад шимтгэл төлж ажилласан жилийг баталгаажуулах 30 иргэний, 1 иргэний сануулах маягт, 14 иргэний дансны мэдээллийн маягт, Унгар улсаас өндөр насны тэтгэвэр авагч 25 иргэний оршин суугаа газрын хаягийн баталгаажуулалтыг Унгар Улсын талд хүргүүлэв.
- ✓ Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд Бүгд Найрамдах Польш Улсад өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 8 иргэний мэдээллийг Польш Улсын талд хүргүүлэв.

- ✓ Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд 1 хүний мэдээллийг Бүгд Найрамдах Турк Улсын Нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэв.
- ✓ Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хооронд Нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах асуудлаар Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд 2025.03.11-13-ны өдрүүдэд зохион байгуулсан шинжээчдийн түвшний уулзалтад оролцов. Уулзалтаар Хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, харилцагч байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох маягтыг хэлэлцэх уулзалтыг 2025 оны 9 дүгээр сард Австри Улсын Вена хотод хийхээр харилцан тохиролцов. Уг хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2025 оны 09 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд БНАУ-ын нийгмийн даатгалын холбоонд зохион байгуулагдсан уулзалтад тус газрын удирдах, гүйцэтгэх 4 албан хаагч оролцов. Хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд солилцох холбогдох хууль тогтоомжийн гэрчилгээ, Мэдэгдэл, Тэтгэвэр тогтоолгох өргөдөл, Монгол Улсад/ Австри Улсад даатгуулсан бүртгэлийн гэрчилгээ, Эмнэлгийн дэлгэрэнгүй дүгнэлт, Бодит зардлын мэдэгдэл, Статистик мэдээлэл, Холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн статистик мэдээлэл зэрэг талууд хооронд мэдээлэл солилцох 16 маягтыг хэлэлцэж нэгдмэл саналд хүрсэн болно.
- ✓ Австралийн Холбооны Улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах хэлэлцээг эхлүүлэх 2 дахь удаагийн уулзалтад оролцов. Уг уулзалтаар Австралийн Нийгмийн үйлчилгээний яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гадаад харилцааны яам, Монгол Улс дахь Австралийн Элчин сайдын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газрын төлөөлөл дараагийн шатны хэлэлцээг 2025 оны 9 дүгээр сард зохион байгуулах, хэлэлцээрийн төслийг боловсруулах талаар санал солилцов. Хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг эхлүүлэх 2 дахь удаагийн уулзалтыг 2025.03.25-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулав. Уулзалтад Австралийн Нийгмийн үйлчилгээний яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гадаад харилцааны яам, Монгол Улс дахь Австралийн ЭСЯ, НДЕГ-ын төлөөлөл оролцож, дараагийн шатны хэлэлцээг 2025 оны 9 дүгээр сард зохион байгуулах, хэлэлцээрийн төслийг боловсруулах талаар санал солилцож, нэгдсэн саналд хүрэв. Австралийн Холбооны Улстай “Нийгмийн хамгааллын хэлэлцээр” байгуулах хамтын ажиллагааны хүрээнд 2025.11.10-13 өдрүүдэд Улаанбаатар хотноо биечилсэн уулзалт хэлэлцээнд оролцож, хэлэлцээрийн төсөл дээр ажиллаж, протокол үйлдэв.
- ✓ “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн хүрээнд Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хангамж, нийгмийн даатгалын газартай хамтран зохмон байгуулсан цахим уулзалтад оролцов. Уулзалтаар талууд Хэлэлцээрийг соёрхон батлуулах явцын талаар харилцан мэдээлэл солилцов. Уг хэлэлцээрийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хангамж, нийгмийн даатгалын газрын Орлогч дарга Хасенова Баян Зарлыковнатай 2025.04.10-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалтад оролцов. Уулзалтаар талууд Хэлэлцээрийг соёрхон батлуулах явцын талаар харилцан мэдээлэл солилцов.
- ✓ Хэлэлцээрийг батлуулах хоёр улсын шинжээчдийн хамтарсан ажлын хэсэгт тус газрын 2 албан хаагч томилогдон ажиллав. Уг ажлын хэсэг 2017 онд байгуулагдсанаас хойш 18 удаагийн хэлэлцээ хийж, хэлэлцээрийн төслийг эцэслэн боловсруулсан. Уг хэлэлцээрийг Улсын Их хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж соёрхон батлав.

Бүгд Найрамдах Киргиз Улсын Нийгмийн сангийн газрын төлөөлөлтэй цахимаар зохион байгуулан уулзалтад оролцож хоёр улсын нийгмийн хамгааллын тогтолцоо, тэтгэврийн бодлогын талаар харилцан туршлага солилцов.

Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийг хэлэлцэх шинжээчдийн 5 дахь удаагийн уулзалтад оролцож 4 дэх шатны хэлэлцээрийн мөрөөр авсан арга хэмжээг хэлэлцэн цаашдын хэлэлцээрийн талаар санал солилцов.

Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- ✓ Хамтран ажиллах тухай найрсаг харилцааны албан захидлыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ослын нийгмийн даатгалын байгууллага, Бүгд Найрамдах Солонгос Улсын Ажилчдын Нөхөн олголт, халамжийн үйлчилгээний газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Будапешт хотын Тэтгэврийн даатгалын хэлтэс, Бүгд Найрамдах Чех Улсын Нийгмийн хамгааллын байгууллага, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний тэтгэврийн алба, Бүгд Найрамдах Польш Улсын Нийгмийн даатгалын байгууллага, Бүгд Найрамдах Турк Улсын Нийгмийн даатгалын байгууллагуудад цахимаар хүргүүлэв.
- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хонконгийн Албан журмын хуримтлалын сангийн газар хооронд хамтран ажиллах Санамж бичгийн төслийг боловсруулан ГБХНХЯаманд хүргүүлэв.
- ✓ Бүгд Найрамдах Хятад Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран ажиллах саналаа ГБХНХЯаманд хүргүүлэв.
- ✓ Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-аас 2025 оны санхүүгийн жилд хэрэгжүүлэх Техникийн хамтын ажиллагааны төсөл “Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах арга хэрэгсэл, авлагын менежмент” төслийг хэрэгжүүлэх саналыг монгол, англи хэл дээр боловсруулан ГБХНХЯаманд хүргүүлэв.
- ✓ Гадаад хамтын ажиллагааны хүрээнд 2025 онд хамтран ажиллах тухай найрсаг харилцааны нийт 7 албан захидлыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ослын нийгмийн даатгалын байгууллага, Бүгд Найрамдах Солонгос Улсын Ажилчдын Нөхөн олголт, халамжийн үйлчилгээний газар, Унгар Улсын Будапешт хотын Тэтгэврийн даатгалын хэлтэс, Бүгд Найрамдах Чех Улсын Нийгмийн хамгааллын байгууллага, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний тэтгэврийн алба, Бүгд Найрамдах Польш Улсын Нийгмийн даатгалын байгууллага, Бүгд Найрамдах Турк Улсын Нийгмийн даатгалын байгууллагад цахимаар хүргүүлэв.
- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хонконгийн Албан журмын хуримтлалын сангийн газар хооронд хамтран ажиллах Санамж бичгийн төслийг боловсруулан ГБХНХЯаманд хүргүүлэв.
- ✓ Бүгд Найрамдах Хятад Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран ажиллах саналыг боловсруулж, ГБХНХЯаманд хүргүүлэв.
- ✓ Бүгд Найрамдах Солонгос Улсын Ажилчдын нөхөн олголт, халамжийн үйлчилгээний газартай хамтран ажиллах саналаа боловсруулан, хүргүүлэв.
- ✓ Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хооронд Нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах шинжээчдийн түвшний 3 дахь шатны уулзалтын хүрээнд Бүгд найрамдах Австри Улсын Европ болон олон улсын харилцааны яамны төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, талууд нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар танилцуулж, харилцан туршлага солилцож, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр болов.
- ✓ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр 23,400 ам долларын үнэ бүхий Нийгмийн даатгалын үйлчилгээний гарын авлага хэвлүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах, видео контент хийх зэрэг чиглэлээр хамтран ажиллав. Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Албан бус эдийн засгийг албажуулах төсөлтэй хамтран “Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах” сургалт зохион байгуулж, НДЕГ, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын нийт 90 албан хаагч хамрагдав.
- ✓ Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-аас 2025 оны санхүүгийн жилд хэрэгжүүлэх Техникийн хамтын ажиллагааны төсөд “Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах арга хэрэгсэл, авлагын менежмент” төслийг хэрэгжүүлэх саналыг боловсруулан ГБХНХЯаманд хүргүүлэв.
- ✓ Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах, системийн шинэчлэл хийх, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зэрэг ажлыг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын албан бус эдийн засгийг албажуулах төслийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү төсөл хөтөлбөрийн

хэрэгжилт, үр дүнд үнэлгээ хийхээр ирсэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зөвлөх, үнэлгээний ахлах Лоес ван дер Графтай уулзалт зохион байгуулав.

- ✓ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Байгаль орчин ба хөдөлмөрийн зохистой нөхцөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Фредди Гуаякантай хийх уулзалтыг зохион байгуулж, ногоон эдийн засаг, ногоон ажлын байр, шилжилтийн үеийн нийгмийн даатгалын асуудлаар санал солилцов.
- ✓ Бүгд Найрамдах Солонгос Улсын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоо, шилдэг туршлагыг судлах, Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасгийн үйл ажиллагаатай танилцах, шалгалт хийх, холбогдох чиглэл зөвлөмж гаргах, тус ажиллаж амьдарч байгаа монголчуудтай уулзалт хийх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын холбогдох ажилтнууд Бүгд Найрамдах Солонгос Улсад 2025.12.01-04-ний өдрүүдэд ажиллав.

### 3.6. *Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилах ажлын талаар*

Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан журам, дүрэм, зааврыг эмхэтгэн Монгол Улс нийгмийн даатгалын шинэ тогтолцоонд шилжих эрхзүйн орчин бүрдсэний 30 жилийн ойд зориулан “Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн эмхэтгэл” номыг дахин хэвлүүлэн аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлэв.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Төлөвлөгөө батлах тухай” 06 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын хууль тогтоомжийн эмхэтгэл” номыг шинээр хэвлүүлэн аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлэв.

Тайлант хугацаанд тус газраас Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийг хэрэгжүүлэхтэй сургалт, сурталчилгаа хийх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- ✓ Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гишүүн 60 аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудад “Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” сургалт;
- ✓ Албан журмын даатгуулагчдын нэгдсэн холбооны 20 ажилтнуудад “Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал” сургалт;
- ✓ Нийслэлийн онцгой байдлын газар, Тагнуулын ерөнхий газрын 70 алба хаагчдад “Цэргийн алыа хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилт” сургалт;
- ✓ Дорноговь, Дархан-Уул, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газраас зохион байгуулсан “Ажил олгогчийн зөвлөгөөн”-нд оролцсон 1000 гаруй ажил олгогчийн дарга, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудад “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ААНБ-ын анхаарах асуудал” сургалт;
- ✓ НДЕГ-ын баталсан “Мэдээллийн цагийн хуваарь”-ийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын ажилтнуудад Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд баталсан тэтгэвэр, нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой баталсан дүрэм, журам, зааврын талаар 4 удаагийн мэдээлэл;
- ✓ Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан “Ахмад настны эрхийн талаарх амлалтаа бэхжүүлэх” хэлэлцүүлэгт оролцож буй төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын 30 гаруй төлөөлөгчдөд “Ахмад настны нийгмийн баталгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр” сэдвээр мэдээлэл;
- ✓ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Баян-Өлгий аймагт зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож, Баян-Өлгий аймгийн иргэд, ажил олгогч, даатгуулагчид, Нийгмийн даатгалын газар, эрүүл мэндийн төвийн албан хаагчид болон зам дагуух Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Ховд аймгуудын Нийгмийн даатгалын газрын албан хаагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаарх сургалт;

- ✓ Унгар улс, Бүгд Найрамдах Чех улсад ажиллаж амьдарч байгаа 90 гаруй иргэд, даатгуулагчдад тэтгэвэр тогтоолтын талаар цахим сургалт зохион байгуулж, зөвлөгөө, мэдээлэл;
- ✓ Монгол HD телевиз, ORI студитэй хамтран зохион байгуулсан “Бизнесээ томруулъя” арга хэмжээнд оролцож, 500 гаруй гарааны болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд “Нийгмийн даатгалын үйлчилгээ, боломж” сэдвээр мэдээлэл;
- ✓ Бүгд Найрамдах Солонгос улс дахь гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 20 албан хаагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн талаар цахим сургалт;
- ✓ НДЕГ-ын даргын 2025 оны “Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шалгалтын хуудасны загвар батлах тухай” А/303 дугаар тушаалаар баталсан “Улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх, сургалтын хөтөлбөр”-т тусгагдсан сэдэв, хуваарийн дагуу аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын байцаагч, ажилтнуудад 8 удаагийн цахим сургалт тус тус зохион байгуулав.

Мөн тус газраас дараах телевиз, радио, хэвлэл мэдээллийн байгууллагад нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгөв. Үүнд:

- ✓ МҮОНТ-ийн Монголын мэдээ агентлагт “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр”, “Нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол”;
- ✓ SBN телевизэд “Нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол”;
- ✓ IKON.mn сайтад “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, түүний дотор хөнгөлөлттэй нөхцөлийн тэтгэвэр” сэдвээр ярилцлага өгөв.
- ✓ “Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээр” сэдвээр 2025.05.21-ний өдөр шууд “LIVE”-т оролцон иргэд, даатгуулагчдад мэдээлэл зөвлөгөө өгч, асуултад хариулав.
- ✓ Монголын радиогийн Хурд агентлагийн “Соёмбо” хөтөлбөрийн “Зочны цаг”-т оролцож “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж” сэдвээр мэдээлэл өгч, сонсогчийн асуултад хариулав.

#### 4. САНХҮҮ БҮРТГЭЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

##### 4.1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын талаар:

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нийгмийн даатгалын сангийн зарлагыг 5,869,455.9 сая төгрөгөөр тодотгон баталсан. Энэ дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 5,848,385.0 сая төгрөг олгож, 99.64 хувийн биелэлттэй, зарлагын гүйцэтгэлийг хангуулав. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын сангаас 5,360,537.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 5,341,089.7 сая төгрөг;
- Тэтгэмжийн даатгалын сангаас 280,490.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 291,519.4 сая төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын сангаас 66,550.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 52,049.7 сая төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын сангаас 161,876.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 163,726.2 сая төгрөг тус тус зарцуулсан.
- 

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан төсвийн хуваарийн дагуу 2025 онд нийт 4,304,362.0 сая төгрөгийн санхүүжилтийг нийгмийн даатгалын байгууллагуудад олгосон.

Мөн Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан “Хамтран ажиллах” гэрээний дагуу төвлөрүүлсэн шимтгэлийн орлогыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын холбогдох дансанд 977,214.8 сая төгрөгийг шилжүүлсэн.

Нийгмийн даатгалын байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд 67,377.5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 62,782,9 сая төгрөг зарцуулагдаж 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үйл ажиллагааны урсгал зардлын хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн эрхийн хүсэлтийн дагуу өссөн дүнгээр “Бусад урсгал шилжүүлэг” зардлын 2,081.4 сая төгрөг, “Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ” зардлын 137.8 сая төгрөг, “Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн хөлс” зардлын 148.3 сая төгрөг, “Харуул, хамгаалалт” зардлын 102,2 сая төгрөг “Зөвлөл, хороо, комиссын гишүүд” зардлын 1,705.9 сая төгрөгийн зардлын санжүүжилт тус тус олгосон.

#### *4.2. Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн тайлангийн талаар:*

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаар “Тайлан хүлээн авах тойрох хуудас”-ыг батлуулан Захиргаа, удирдлагын газар, Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар, Хяналт шалгалтын газар, Шимтгэл хураалт, удирдлага арга зүйн газар, Мэдээллийн технологийн төвд хүргүүлж жилийн болон хагас жилийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан гаргах ажлыг зохион байгуулав.

Харьяа нийгмийн даатгалын байгууллагуудад 2024 он, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах хуваарийг хүргүүлэн мэргэжил арга зүйн зааварчилгаа өгч, 2024 оны жилийн эцсийн болон 2025 оны эхний хагас жилийн холбогдох тайланг хуульд заасан хугацаанд нэгтгэж, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэв.

Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу Үндэсний аудитын газраар нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд аудит хийлгэж, мөн аймаг, дүүргийн сангийн тайланд аудит хийж байгаа аудиторуудтай хамтран ажиллав.

Төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн ажилтнуудад, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан гаргах чиглэлээр тухай бүр мэргэжил, арга зүйн зааварчилгаа өгөхөөс гадна заавар, чиглэл, анхаарах асуудал боловсруулан хүргүүлэв. Үүнд:

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны жилийн эцэс, 2025 оны хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахад анхаарах асуудал, тайлангуудыг хүлээн авах хуваарийг гарган аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын газар, хэлтэст хүргүүлэн мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан.

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланг хүлээн авсан байгууллагын болон сангийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлантай тулган шалгах явцад тайлан гаргах талаар мэргэжил арга зүйн зааварчилгааг тухай бүр өгч ажилласны үр дүнд Нийгмийн даатгалын нэгтгэсэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлагнал сайжирсан.

Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна” гэж дүгнэсэн.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн танилцуулгыг бэлтгэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, 2024 он, 2025 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, аудитын дүгнэлт, биелэлт, сар бүрийн сангийн болон урсгал үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийн мэдээг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтад хуулийн хугацаанд нь байршуулав.

Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг сангийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлээс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн нэгтгэлд шилжүүлж, хаалтын болон эхлэлийн тайлан гаргах, шилэн дансанд тусад нь мэдээлэх ажлыг тус тус салбарын хэмжээнд зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж, нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын нэгтгэл тайланд тус бүр хуулийн хугацаанд оруулж, зорилтот хүрэх түвшингээ бүрэн хангасан.

#### 4.3. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсан талаар:

Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл болон мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээний тооцооллыг хийж хүргүүлснээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоолоор 2025 онд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр, 08 дугаар тогтоолоор мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг жилийн 14.20 хувиар шинэчлэн тус тус баталсан.

Банкны системд нөлөө бүхий арилжааны банкнуудаас санал авч Монголбанкнаас тогтоосон банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангасан, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан хүүгийн хэмжээнээс доошгүй санал ирүүлсэн Хаан банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк болон Төрийн банканд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус Мэргэжлийн хороо болон Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн сангийн чөлөөт үлдэгдлээс 700.0 тэрбум төгрөгийг жилийн 15.0 хувийн хүүтэйгээр мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулсан. Мэдээллийг <https://shilendans.gov.mn/> сайтад хуулийн хугацаанд байршуулан даатгуулагч, иргэдэд мэдээллэж ажилласан.

Банкуудтай байгуулсан гэрээний дагуу 5-11 дүгээр сарын хүү болох 61.2 тэрбум төгрөгийг холбогдох дансанд хүлээн авч, мөнгөн хадгаламжийн хүү хүлээн авсан тухай мэдээллийг байгууллагын <https://www.ndaatgal.mn/> цахим хуудасны шилэн данс хэсэг болон цахим хуудсаар олон нийтэд ил тод мэдээллэж ажилласан.

Мөнгөн хадгаламжийн гэрээний хугацаанд нийт 105.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор нэмэгдэх боломж бүрдсэн. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” 192 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг 2025 онд 300.0 (гурван зуун) тэрбум хүртэлх төгрөгөөр тус тус баталсан.

2024 онд худалдан авсан 100.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны хугацаа дууссан тул худалдан авах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах 179/НД-106/25 дугаар гэрээг 11 дүгээр сарын 15-ны өдөр байгуулан 9.5 хувийн хүүтэйгээр 3 жилийн хугацаатай 100.0 тэрбум төгрөгийн үнэт цаас худалдан авсан. Гэрээний дагуу хугацааны эцэст нийт 28.5 тэрбум төгрөгийн өгөөж хүртэх боломж бүрдсэн.

Хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор Засгийн газрын дотоод үнэт цаасыг 2025 онд хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй арилжаагаар худалдах хуваарь Сангийн сайдын тушаалаар батлагдсан. Нээлттэй арилжаанд оролцох эрхзүйн орчныг бүрдүүлэхийн тулд Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

#### 4.4. Тэтгэврийн нөөц сангийн талаар:

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байхаар заасны дагуу 80.0 тэрбум төгрөгийг нэмж байршуулснаар 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нөөц сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нийт 301.8 тэрбум төгрөг байна.

Тэтгэврийн мөнгөн хуримтлалын мэдээллийг даатгуулагчидад гар утасны нийгмийн даатгал аппликейшн, <https://portal.ndaatgal.mn/> систем, И-Монголиа системээр мэдээллэж ажилласан.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан “Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам”-д заасны дагуу тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг даатгуулагчийн саналд үндэслэн хөрөнгө оруулж болох зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд:

Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан журамд даатгуулагчийн саналыг 07 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор авахаар зохицуулсан. Даатгуулагчийн хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслээ сонгох боломжийг бүрдүүлж гар утасны Ndaatgal аппликэйшн болон даатгуулагчдад зориулсан цахим [www.portal.ndaatgal.mn](http://www.portal.ndaatgal.mn) хуудсаар санал авах ажлыг 2025 оны 07 дугаар сараас эхлүүлсэн.

Тэтгэврийн нөөц сангийн мөнгөжүүлсэн орлогыг Монголбанкны үнэт цаас худалдан авч хөрөнгө оруулалт хийн байршуулах боломжтой эсэх талаар мэдээлэл ирүүлж, хамтран ажиллахыг хүсэж Монголбанканд;

Засгийн газрын үнэт цаас худалдан авах боломжтой эсэх Төрийн сангийн нэгдсэн дансанд мөнгөн хадгаламж байршуулах боломжтой эсэх, байршуулах бол хүүгийн хувь хэмжээний талаар мэдээлэл ирүүлэхийг хүсэж тус тус Сангийн яаманд;

Мөнгөн хадгаламж хэлбэрээр сар бүр хүү олгох нөхцөлтэй хугацаатай хадгаламж байршуулах хүүгийн хэмжээ, хугацааны саналаа ирүүлэхийг хүсэж банкны системд нөлөө бүхий арилжааны банкуудад тус тус хүсэлт хүргүүлсэн.

Энэ хүрээнд зохион байгуулан хийсэн ажлын талаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/3109 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Мөн тэтгэврийн нөөц санд мөнгөн хөрөнгө нь байршсан иргэдээс ямар санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах санал авах ажлыг хамтран хэрэгжүүлэхээр И-Монголиа академид 05 дугаар сарын 09-ны өдөр хамтран ажиллах тухай 01/1169 дугаар албан бичиг хүргүүлсэн.

Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан журамд даатгуулагчийн саналыг 07 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор авахаар зохицуулсан. Даатгуулагчийн хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслээ сонгох боломжийг бүрдүүлж гар утасны Ndaatgal аппликэйшн болон даатгуулагчдад зориулсан цахим [www.portal.ndaatgal.mn](http://www.portal.ndaatgal.mn) хуудсаар санал авах ажлыг 2025 оны 07 дугаар сараас эхлүүлсэн.

Монголбанкнаас банкны системд нөлөө бүхий арилжааны банкны мэдээлэл авахаар 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр “Мэдээлэл хүсэх тухай” 01/2030 дугаар албан бичгийг хүргүүлж, Монголбанкны 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн Б-18/735 дугаар албан бичгээр банкны системд нөлөө бүхий арилжааны банкны жагсаалтыг хүлээн авсан.

Сангийн яамнаас тэтгэврийн нөөц сангийн хөрөнгөөр Засгийн газрын үнэт цаас худалдан авах боломжтой эсэх талаар 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн “Мэдээлэл хүсэх тухай” 01/2048 дугаар албан бичгийг хүргүүлж, Сангийн яамнаас 2025 оны 09 дүгээр 09-ний өдрийн 02/8326 дугаар албан бичгээр Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд брокерын үйл ажиллагаа эрхлэгч компаниар дамжуулан оролцох боломжтой саналыг ирүүлсэн.

Монголбанкнаас Монголбанкны үнэт цаас худалдан авах боломжтой эсэх талаар 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн “Мэдээлэл хүсэх тухай” 01/2049 дугаар албан бичгийг хүргүүлж, Монголбанкаас 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А-10/796 дугаар албан бичгээр мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулах зорилгоор банкны систем дэх төгрөгийн илүүдэл нөөцийг нээлттэй зах зээлийн үйл ажиллагаагаар татдаг бөгөөд Төв банкны үнэт цаасны арилжааг хөрөнгө оруулалтын хэрэгслээр ашиглах боломжгүй талаар хариу ирүүлсэн.

Сангийн яамнаас Төрийн сангийн нэгдсэн дансанд мөнгөн хадгаламж байршуулах боломжтой эсэх талаар 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн “Мэдээлэл хүсэх тухай” 01/2053 дугаар албан бичгийг хүргүүлж, Сангийн яамнаас 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 02/9496 дугаар албан бичгээр Төрийн сангийн нэгдсэн данснаас хүү тооцож олгох боломжгүй талаар хариу ирүүлсэн.

Мөн Монголбанкнаас ирүүлсэн банкны системд нөлөө бүхий банк (Төрийн банк, ХААН банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк)–уудад сар бүр хүү олгох нөхцөлтэй хугацаатай хадгаламжийн хүүгийн хэмжээ, хугацааны санал авахаар 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 01/2304 дугаар албан бичгийг хүргүүлж, сар бүр хүү олгох нөхцөлтэй, нэг жилийн хугацаатай хадгаламж байршуулах тохиолдолд Төрийн банк, ХААН банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банкнаас 15.11 хувь, Хас банкнаас 12.5 хувийн хүүг олгох саналыг тус тус ирүүлсэн.

Сангийн яаманд төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламжийн хүү хэд байх, хэдий хугацаагаар байршуулах боломжтой эсэх талаар 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр 01/2742 дугаар албан бичгийг дахин хүргүүлээд байна.

*4.5. Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар:*

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Нийгмийн даатгалын ерөнхий газар болон 9 дүүргийн нийгмийн даатгалын газарт төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтын хүрээнд тус газрын 2025 оны “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 242 дугаар тогтоолоор өгөгдсөн арга хэмжээний дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/189 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалын ерөнхий газар болон харъяа нийгмийн даатгалын байгууллагуудын шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан хэрэгжилтийг хангах, гарсан зөрчлийг арилган, давтан гаргахгүй байхыг холбогдох зохион байгуулалтын нэгжүүдэд чиглэл болгон ажиллалаа. Дээрх тогтоолоор өгөгдсөн арга хэмжээний биелэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/2844 дүгээр албан бичгээр хүргүүлж, 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр тус газраас гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, хэрэгжилтийг 88 хувьтай гэж дүгнэлээ.

Мөн энэхүү хяналт, шалгалтын хүрээнд илэрсэн зөрчил, дутагдын асуудлаар холбогдох чиглэлийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлж, хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлээд байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны эхний хагас жилийн үндсэн хөрөнгө, аж ахуйн материал, маягтын тооллогыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Эд хөрөнгийн тооллого явуулах тухай” А/167 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаанд зохион байгуулж ажилласан. Тооллогоор нийт 5 нэр төрлийн 5,031.9 сая төгрөгийн барилга байгууламж, 2 нэр төрлийн 62.0 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 1,216 ширхэг 486.6 сая төгрөгийн тавилга хэрэгсэл, 1,580.4 сая төгрөгийн 822 ширхэг тоног төхөөрөмж, 2 нэр төрлийн 33.8 сая төгрөгийн программ хангамж, 161.9 сая төгрөгийн биет бус хөрөнгө тус тус тоологдсон. Мөн бичиг хэрэг 8.3 сая, аж ахуйн материал 67.4 сая, сэлбэг хэрэгсэл 12.9 сая, маягт 27.2 сая төгрөгийг тус тус тоолон баталгаажууллаа. Жилийн эцсийн тооллогыг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 25-ны өдрийн хооронд хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/190, 2025 оны А/317 дугаар тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

Тус зөвлөл нь 2025 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөнд нийт 9 ажил, арга хэмжээг тусган Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөн дараах асуудлуудыг хурлаар хэлэлцүүлж протоколоор албажуулан, холбогдох дүгнэлтүүдийг гаргаж ажиллаа. Үүнд:

- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг батлах тухай;
- Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газрын хуучин конторын барилгыг актлаж данс бүртгэлээс хасах, буулгах тухай;
- Сонгинохайрхан дүүрэгт байрлах 7,048 м.кв талбайтай газрын хэмжээнд орсон өөрчлөлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, зөвшөөрөл авах тухай;
- Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын акталсан хуучин барилгын ашиглалт, хамгаалалтад хяналт тавих тухай;
- Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын газарт Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд бүртгэлтэй автомашиныг шилүүлэх асуудлыг хэлэлцэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, зөвшөөрөл авах тухай;
- Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн 2025 оны эхний хагас жилийн акталж данснаас хасах, балансаас балансад шилжүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, зөвшөөрөл авах тухай;
- Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Цогтцэций суманд байрлах тасгийн барилгын өрөөг тус сумын Засаг даргын тамгын газарт ашиглалтын гэрээгээр ашиглуулах эсэх тухай;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан машин, тоног төхөөрөмжийн элэгдлийн хугацааг өөрчлөх тухай;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын конторын барилгад чанарын шаардлага хангахгүй байгаа цонхыг хэсэгчлэн солих тухай;

- Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай;
- 2025 оны эхний хагас жилийн нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг данснаас акталж данснаас хасах, балансаас балансад шилжүүлэх тухай;
- Архангай аймгийн Хайрхан суманд байрлах нийгмийн даатгалын тасгийн барилгын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжлуулах, орон нутагт худалдан борлуулах тухай;
- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд байрлах Нийгмийн даатгалын тасгийн барилгыг Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газарт худалдан борлуулах талаар холбогдох арга хэмжээг авах тухай;
- Нийгмийн хамгааллын салбарын цахим архивын барилгаас өөрийн эзэмшлийн талбайг гэрээ эрх зүйн актаар баталгаажуулах, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд гэрээгээр ашиглуулах тухай;
- 2025 оны жилийн эцсийн Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг акталж, данснаас хасах тухай;
- 2025 оны жилийн эцсийн Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг шилжүүлэх, үнэ, ашиглах жилийг шинэчлэн тогтоох тухай;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны “Үндсэн хөрөнгийн үнэлгээг бууруулан бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 530 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих тухай;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын барилга, инженерийн шугам сүлжээ зэрэг 5 хөрөнгийг барилгын өртгөөс салгаж бүртгэх тухай;
- Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийтийн эзэмшлийн замыг данснаас хасах тухай;
- Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын бараа материалын дансанд бүртгэлтэй хөрөнгийн дансны ангилал солих, залруулах тухай;
- Цаашид ашиглах шаардлагагүй болсон 10 нэр төрлийн үнэт цаасыг акталж, данс бүртгэлээс хасах тухай;
- Архангай аймгийн Хайрхан суманд байрлах барилгыг ашиглалтын гэрээгээр сумын Засаг даргын тамгын газарт ашиглуулах эсэх тухай зэрэг болно.

Нийгмийн даатгалын ерөнхий газар болон харъяа нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглах боломжтой хөрөнгийн цаашид ашиглах жил, өртгийг шинэчлэн тогтоох, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийг зохих журамд заасны дагуу акталж данснаас хасах, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, хэрэгцээ шаардлагын дагуу хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандаж, зохих зөвшөөрлийг авч, тухай бүр шийдвэрлүүлж ажилласан. Үүнд:

- 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 11 дүгээр тогтоол;
- 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 202 дугаар тогтоол;
- 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Автомашин тоо, төрөл тогтоох тухай” 241 дүгээр тогтоол;
- 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Үндсэн хөрөнгө актлаж, данснаас хасах тухай” 238 дугаар тогтоол;
- 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” А-6/1123 дугаар албан бичгээр хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл;
- 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 284 дүгээр тогтоол;
- 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” А-6/2106 дугаар албан бичгээр хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл;
- 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн “Үндсэн хөрөнгийн үнэлгээг бууруулан бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 530 дугаар тогтоол;
- 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Үндсэн хөрөнгө актлаж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 600 дугаар тогтоол зэрэг тус тус болно.

#### **4.6.Худалдан авалтын арга хэмжээний талаар**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан 3,474.50 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 худалдан авах ажиллагааг тусгасан. Үүнд:

- Урсгал төсвөөс санхүүжүүлэх 3,229.21 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 худалдан авах ажиллагаа;
- Нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэх 192.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 худалдан авах ажиллагаа;
- Тусламжийн орлогоор санхүүжүүлэх 53.29 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 худалдан авах ажиллагаа тус тус болно.

2025 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 6 худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд тендер шалгаруулалтын баримт бичгийг 8 удаа боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар байгуулсан үнэлгээний хороо Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 13 удаа зохион байгуулж үнэлгээний хорооны хурлыг нийт 40 удаа зохион байгуулсан.

- “Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйлчилгээ” үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын баримт бичгийг 3 удаа;
- “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ түүний зохистой байдалд үнэлгээ хийх судалгааны ажлыг зохион байгуулах” тендер шалгаруулалтын баримт бичгийг 1 удаа;
- “Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн гарын авлага, танилцуулга хэвлүүлэх” тендер шалгаруулалтын баримт бичгийг 1 удаа;
- “Нийгмийн даатгалын багц хууль, холбогдох журам, дүрэм, зааврын эмхэтгэл бэлтгэх, түгээх” тендер шалгаруулалтын баримт бичгийг 1 удаа;
- “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль түүний ач холбогдлыг сурталчилсан маркетингийн бүтээгдэхүүн бэлтгэх, олон нийтэд түгээх” тендер шалгаруулалтын баримт бичгийг 1 удаа;
- “Нийгмийн даатгалын өгөгдлийн сангийн удирдлагын программ хангамж, лицензийн нийлүүлэх” тендер шалгаруулалтын баримт бичгийг 1 удаа тус тус боловсруулсан.

Худалдан авах ажиллагааны хүрээнд хуулийн хугацаанд оролцогчдын ирүүлсэн тендерийг үнэлэн зөвлөмжийг захиалагчид хүргүүлж ажилласан бөгөөд дараах 5 худалдан авах ажиллагаанд оролцогч шалгарч захиалагчтай гэрээ байгуулсан. Үүнд

1. “Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйлчилгээ” үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах НДЕГ/20250103001 дугаартай тендерт шалгарсан Дэлгэрэнгүй хууль НҮТББ-тай;
2. “Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн гарын авлага, танилцуулга хэвлүүлэх” НДЕГ/20250201006 дугаартай тендерт шалгарсан Адмон принт ХХК-тай;
3. “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ түүний зохистой байдалд үнэлгээ хийх судалгааны ажлыг зохион байгуулах” НДЕГ/20250103009 дугаартай тендерт шалгарсан Эм Эм Си Жи ХХК-тай;
4. Нийгмийн даатгалын багц хууль, холбогдох журам, дүрэм, зааврын эмхэтгэл бэлтгэх, түгээх НДЕГ/20250201007 дугаартай тендерт шалгарсан Адмон принт ХХК-тай;
5. Нийгмийн даатгалын өгөгдлийн сангийн удирдлагын программ хангамжийн лиценз нийлүүлэх багц НДЕГ/20250102012 дугаартай тендерт шалгарсан Ай Ти Зон ХХК-тай тус тус гэрээ байгуулан, хамтран ажилласан.

#### *4.7. Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагч болон Чингис хаан банк ХХК-ийн өр төлбөрийн талаар:*

Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн 104.2 тэрбум төгрөгийн авлагаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 46.6 тэрбум төгрөг (мөнгөөр 15.0 тэрбум төгрөг, хөрөнгөөр 31.6 тэрбум төгрөг) 2025 онд 8.1 тэрбум төгрөгийн төлбөр барагдаж, 57.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Чингис хаан банк ХХК-иас нэхэмжилсэн 103.6 тэрбум төгрөгийн авлагаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 19.9 тэрбум төгрөг (мөнгөөр 12.4 тэрбум төгрөг,

хөрөнгөөр 7.5 тэрбум төгрөг) 2025 онд 11.5 тэрбум төгрөгийн төлбөр барагдаж, 83.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас өр төлбөрт тооцон шилжүүлэн авсан үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулахаар хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг 5 байгууллагатай хамтран ажиллаж 189.8 сая төгрөгийн өртөгтэй БЗД, 14-р хороо, 14-р хороолол /13335/, Намъянжугийн гудамж, 11Е байр 1304 тоот хаягт байршилтай, 72.37 м.кв талбайтай орон сууцны зориулалттай 1 ширхэг үл хөдлөх хөрөнгийг иргэн С.Доржготов, Г.Мөнгөнцэцэг нартай 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн НД-93/22 дугаар "Үл хөдлөх хөрөнгийг худалдах-худалдан авах гэрээ"-ээр худалдан борлуулж, төлбөрийг нийгмийн даатгалын санд бүрэн төвлөрүүлсэн.

2025 оны жилийн эцсийн байдлаар Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас өр төлбөрт тооцон шилжүүлэн авсан 14,556.55 сая төгрөгийн үнэ бүхий 25 ширхэг, Чингис хаан банк ХХК-иас шилжүүлэн авсан 7,492.68 сая төгрөгийн үнэ бүхий 11 ширхэг, нийт 22,049.23 сая төгрөгийн үнэ бүхий 36 ширхэг худалдан борлуулаагүй хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам"-ын дагуу дээрх 2 банкнаас өр төлбөрт тооцон шилжүүлэн авсан хөрөнгийг худалдан борлуулахаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/213 дугаар тушаалаар 3 үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах нээлттэй дуудлагын худалдаа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/251 дүгээр тушаалаар 11 үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах нээлттэй дуудлагын худалдаа худалдааг зохион байгуулж, иргэн, хуулийн этгээд оролцоогүй болно. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/305 дугаар тушаалаар ..... нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулахаар ажиллаж байна. Нээлттэй дуудлагын худалдааг 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр нээнэ.

Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагч болон Чингис хаан банк ХХК-иас шилжүүлэн авсан хөрөнгүүдийг худалдан борлуулахаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас, фэйсбүүк хаяг, Монголын мэдээ сонин, хамтран ажиллаж буй хөрөнгө зуучлалын байгууллагуудаар дамжуулан зар түгээх зэрэг байдлаар худалдан борлуулах зарыг иргэд, олон нийтэд түгээн ажиллаж байна.

Өр төлбөрийг барагдуулах асуудлаар Монгол Улсын Засгийн газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар болон бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллаж байна.

1.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 75 дугаар захирамжаар "Төлбөрийн чадваргүйн улмаас санхүүгийн эрсдэлд орсон, татан буугдсан банканд байршиж байсан тусгай зориулалтын сан, төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийг буцаан төвлөрүүлж, төрийг хохиролгүй болгох ажлыг шуурхай зохион байгуулах үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийг байгуулсан. Тус ажлын хэсэгт Нийгмийн даатгалын ерөнхий газрын төлөөлөл ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаанд Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас 2.21 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан.

2.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд банк, санхүүгийн байгууллагаас авах эд хөрөнгийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагад шилжүүлэх, худалдан борлуулах болон бусад арга замаар нийгмийн даатгалын санд төлөх өр, төлбөрийг барагдуулах асуудлыг судалж, саналаа 2025 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаан танилцуулахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Боловсролын сайд, Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын сайд нарт тус тус даалгасан. Энэхүү ажлын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/199 дүгээр тушаалаар нийгмийн даатгалын санд төлөх өр төлбөрт тооцон шилжүүлэхээр банк, санхүүгийн байгууллагаас санал болгож буй эд хөрөнгийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагад шилжүүлэх, худалдан борлуулах, төлбөрийг барагдуулах бусад боломжийг судлан танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажилласан. Ажлын хэсгээс гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлээд байна.

3. Мөн урсгал үйл ажиллагааны 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд Чингис хаан банк ХХК, Капитал банк ХХК-иас авах нийгмийн даатгалын сангийн авлагыг бүрэн барагдуулахад төлбөр авагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалан эрүү, иргэн, захиргааны анхан болон давж заалдах шатны шүүх, улсын дээд шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд болон төрийн бусад байгууллагад төлөөлөх өмгөөллийн хуулийн этгээдээс хууль зүйн туслалцаа авахаар 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тендер зарласан. Энэхүү хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тендер хууль, журмын дагуу 3 удаа зарлагдаж, эхний 2 удаагийн тендерт хуулийн этгээд шалгараагүй бөгөөд 3 дахь удаа зарласан тендерт “Дэлгэрэнгүй хууль” төрийн бус байгууллага шалгаран 198.0 сая төгрөгийн гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Гэрээ байгуулсан хугацаанаас хойш Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас 1.1 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан. Мөн 30 орчим тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг шинээр олж илрүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэн, ажлын явц, тайлан мэдээг тухай бүр ирүүлэн ажиллаж байна.

#### *4.8. Олон жилийн насжилттай өр төлбөрийн талаар:*

Нийгмийн даатгалын төв сангийн өр авлагыг барагдуулах хүрээнд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд Зэвсэгт хүчний жанжин штабаас нийгмийн даатгалын санд төлөх өр төлбөрийг нэхэмжилж, Өндөргэгээн ХХК, Их тэргүүн ХХК, Монтех ХХК-г болон итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийг болон иргэн Б.Пүрэвдаваа нарыг эрэн сурвалжлуулахаар нэхэмжлэл тус тус гаргасан.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргад 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр 01/2029 албан бичгээр олон жилийн насжилттай, барагдах найдваргүй болсон татан буугдаж, дампуурсан банкуудтай холбоотой 5.4 тэрбум төгрөгийн авлагыг дээрх байгууллагуудаас ирүүлсэн албан бичиг, татан буугдсан тухай шийдвэрүүдийг үндэслэн хааж болох эсэх талаар төрийн санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэргэжил арга зүйн зөвлөмж өгөхийг хүссэн хүсэлтийг хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны 75 дугаар захирамжаар төлбөрийн чадваргүйн улмаас санхүүгийн эрсдэлд орсон, татан буугдсан банканд байршиж байсан тусгай зохицуулалтын сан (нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан), төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийг буцаан төвлөрүүлж, төрийг хохиролгүй болгох ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Энэ хүрээнд олон жилийн насжилттай төлөгдөх найдваргүй болсон иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой шүүхийн шийдвэр гарсан 780.6 сая төгрөг болон Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар татан буугдсан банкуудтай холбоотой 5.4 тэрбум төгрөг, нийт 6.2 тэрбум төгрөгийн найдваргүй авлагыг хаах талаар Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлж өгнө үү гэсэн хүсэлтийг 11 дүгээр сарын 01-ний өдөр 01/2987 дугаар албан бичгээр холбогдох баримтын хамтаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга, ажлын хэсгийн ахлагч Б.Цэнгэлд хүргүүлсэн.

#### *4.9. Мэдээллийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлэх, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой ажлын талаар:*

Нийгмийн даатгалын сангийн Нэгдсэн системийн “Даатгалын үйлчилгээ” дэд системд байцаагчийн тайлан, түүний нэгтгэлүүдийг бүрэн оруулах ажлын хүрээнд 2025 оны 4 дүгээр сард “Нэгтгэл гаргуулах тухай” 07/865 албан тоотыг хүргүүлсэн. Үүнд:

1. Байцаагчийн тайлангуудын нэгтгэлийг хавсралт маягт, зааврын дагуу гаргах;
2. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээний нэгтгэл гаргах;
3. Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн бүрийн нэгтгэлийг гаргах;
4. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ болон тайланд батлагдсан төсвийг татуулах зэрэг болно.

Цаашид төлбөрийн даалгавар /хүсэлт/-ыг системээс хэвлэх, сарын мэдээ, тайлангуудын нэгтгэлийг бүгдийг сонгох гэсэн нэг товчоор хардаг болгож сайжруулалт хийх, илгээх,

баталгаажуулах, буцаах, түгжих үйлдлийг хийх, бусад өглөг авлагын дэлгэрэнгүй бүртгэл, торгуулийн хөнгөлөлт зэрэг хөгжүүлэлтүүдийг хийлгэхээр хамтран ажиллаж байна.

Засгийн газрын нэгтгэл тайлангийн “Finferporm” системийн талаар танилцуулж, 2025 оны 3-р улирлын тайланг шивэх сургалтыг 2025 оны 10-р сарын 30, 31-ний өдрүүдэд СМТТөв дээр очиж төвийн 6 дүүрэг болон НДҮЗ, НДЕГ, 2025 оны 11-р сарын 07-ний өдөр 21 аймаг, МТТ болон 3 дүүргийн нягтлан бодогч нарт цахимаар хийж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллав. “Finferporm” систем дээр тайлангийн эхний үлдэгдэл зөв эсэх, тайланг шивж оруулах, устгал хийх талаар нэг бүрчлэн зааж, зөв эсэхийг шалган нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр сургалтыг зохион байгуулав.

## 5. ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖҮҮЛЭЛТ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ

### 5.1. Иргэд, даатгуулагчдыг нийгмийн даатгалын талаарх мэдээллээр хангах, санал, хүсэлт хүлээн авах чиглэлээр

Тайлант хугацаанд иргэд, даатгуулагчдаас цахимаар нийтдээ **6510** санал хүсэлт, асуулт, үүнээс [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) аппликейшний “Санал хүсэлт” булангаар дамжуулан **1096** санал хүсэлт, [sanal@ndaatgal.mn](mailto:sanal@ndaatgal.mn) вэб хуудсаар **438**, Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд **4976** асуулт ирснийг ажлын 5 хоногт багтаан хариуг иргэд, даатгуулагчид утсаар болон цахим хаягаар нь хүргүүлэн ажиллалаа.

-Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан ирсэн **4976** асуулт, санал хүсэлтийг агуулгаар нь ангилж авч үзвэл дийлэнх нь тэтгэмжтэй холбоотой асуудлаар ирсэн бөгөөд 79.4 хувь нь ажилгүйдлийн тэтгэмжтэй, 3.1 хувь нь хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжтэй, 4.8 хувь нь жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй, 12.7 хувь нь бусад асуудлууд эзэлж байна. Үүнд:

Хүснэгт-7

№	Ирсэн санал, хүсэлтийн төрөл	Ирүүлсэн санал хүсэлт	
		Тоо	Хувь
1	Талархал	18	0.3
2	Тэтгэвэр	103	2.1
3	Ажилгүйдлийн тэтгэмж	3953	79.4
4	Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж	238	4.8
5	ХЧТА-ны тэтгэмж	152	3.1
6	Сикос программын тухай	50	1.0
7	Аппликейшнтэй холбоотой	28	0.6
8	Сайн дурын даатгал	73	1.5
9	Эрүүл мэндийн даатгал	18	0.3
10	Ажил олгогчийн данс хаасан асуудлаар	21	0.4
11	Харилцаа хандлага	9	0.2
12	Утасны дуудлага	38	0.8
13	Хүнд суртал	56	1.1
14	Ёс зүй асуудлаар	23	0.5
15	Бусад асуудлаар	196	3.9

-Нийгмийн даатгалын [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) гар утасны аппликейшний “Санал хүсэлт” булангаар ирсэн **1096** санал, хүсэлт, гомдлыг агуулгаар нь ангилбал:

Хүснэгт-8

№	Агуулга	Асуулт, санал хүсэлт, гомдол	
		Тоо	Хувь

1	Ажилгүйдлийн тэтгэмж	654	59.7
2	ХЧТА-ны тэтгэмж	152	13.9
3	Жирэмсэн амаржсаны тэтгэмж	110	10.0
4	СДД-ын гэрээ байгуулах, шимтгэл төлөлт	54	4.9
5	Программтай холбоотой	45	4.1
6	Эрүүл мэндийн даатгал	65	5.9
7	Бусад (Чиг үүргийн бус асуулт)	16	1.5
	ДҮН	1096	100%

-[Sanal@ndaatgal.mn](mailto:Sanal@ndaatgal.mn) вэб сайтын “Санал хүсэлт” булангаар дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогчдоос ирүүлсэн 438 асуулт, санал хүсэлт, гомдлыг агуулгаар нь ангилбал:

Хүснэгт-9

№	Ирсэн санал, хүсэлтийн төрөл	Ирүүлсэн санал хүсэлт	
		тоо	хувь
1	Тэтгэвэр	38	8.7
2	Ажилгүйдлийн тэтгэмж	304	69.4
3	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	32	7.3
4	ХЧТА-ны тэтгэмж	15	3.4
5	Аппликейшнтэй холбоотой	7	1.6
6	Сайн дурын даатгалтай холбоотой	9	2.1
7	Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой	5	1.1
8	Бусад асуудлаар	28	6.4

Цахимаар ирүүлсэн гомдол, санал хүсэлтийг нийтэд нь авч үзвэл дийлэнхи нь буюу 69.4 хувь ажилгүйдлийн, 3.4 хувь нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж хугацаандаа шилжихгүй байгаа, хянагдаж бодогдсон тэтгэмжийн төлөвөө шалгуулах хүсэлт, эмнэлгийн хуудасны хугацааны талаар, тэтгэмж авах хүсэлтээ цахимаар илгээх тухай, 7.3 хувь нь жирэмсэн амаржсаны тэтгэмж, 2.1 хувь нь сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, цуцлах, нөхөн төлөх, алдангийн талаар, бусад нь сар бүрийн цэргийн болон тэтгэврийн ажилласан хугацааны нэмэгдэл орохгүй байгаа талаар, нөхөн тайлан, илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт орохгүй байна зэрэг асуудлууд эзэлж байна.

-Нийгмийн даатгалын үйлчилгээний лавлах утас (7777-1289)-нд нийт 703243 дуудлага ирснээс 537618 иргэд, даатгуулагч мэдээллийн ажилтантай холбогдон мэдээлэл авснаас ажил олгогч бүртгүүлэх, тайлан илгээх, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, сайн дурын даатгал, тэтгэвэр, тэтгэмж (хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны)-ийн хүсэлт илгээх, ажилгүйдлийн тэтгэмж, эрүүл мэндийн магадлалын талаарх мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.

Автомат хариулагчаас 26563 иргэн мэдээлэл, зөвлөгөө сонссон бөгөөд иргэдийн сонссон мэдээллийг агуулгаар нь ангилж үзвэл:

Хүснэгт-10

№	Төрөл		Мэдээлэл авсан
1	Тэтгэвэр		1829
2	Тэтгэмж	Жирэмсэн болон амаржсаны	7679
		Ажилгүйдэл	2918
		Хөдөлмөрийн чадвар алдалт	1016
		Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж	77
3	Сайн дурын даатгал		1664
4	Ажил олгогч		1414
5	Утас, данс	Утас	31
		Данс	54
6	Бусад		9881

Дээрх автомат хариулагчид хандсан 26563 иргэнээс 20673 дуудлага нь мэдээллээ бүрэн сонссон бөгөөд үүний 3646 нь ажлын бус цагаар хандсан байна.

Тайлангийн хугацаанд нийтдээ 535 дуудлагыг авалгүй алдсан бөгөөд энэ нь нийт дуудлагын 1.4%-ийг эзэлж байна.

-Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх үйлчилгээнд хяналт тавин ажиллалаа. Нийгмийн даатгалын байгууллагууд иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээлэл өгөх "Callpro" утасны дуудлагыг 3-аас илүү дуудуулахгүй шуурхай авч хэвших, цаашид хэрэглэгч өөрөө салгасан дуудлагын тоог бууруулах, аймгийн Нийгмийн даатгалын газар болон Багануур, Багахангай, Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газрууд дуудлага алдалтын тоог 10%-иас хэтрүүлэхгүй, Нийслэлийн төвийн 6 дүүргийн Нийгмийн даатгалын газар 15%-иас хэтрүүлэхгүй байхаар зорилт тавин гүйцэтгэлийг хангуулж дүгнэлт, зөвлөмж өглөө.

Энэ оны эхний 11 сарын байдлаар нийтдээ 703243 дуудлага ирснээс 537618 дуудлагад хариулж, алдсан дуудлага 165624 байна. Аймгийн Нийгмийн даатгалын газруудын хувьд дуудлага алдалт 12.4 хувьтай, нийслэлийн дүүргүүдийн хувьд 26.9 хувьтай, нийт дүнгээрээ 24 хувийн дуудлага алдалттай байна. Эхний хагас жилийн байдлаар дуудлага алдалт 6,6 хувьтай байсан бол сүүлийн хагас жил огцом нэмэгдсэн байна. Энэ нь ажилгүйдлийн даатгалын сангийн санхүүжилтээс хамааралтайгаар тэтгэмж хугацаандаа олгогдохгүй, олон хоногоор саатаж байгаатай холбогдуулан хүн ам олноор суурьшсан аймаг, нийслэлийн төвийн дүүргүүдийн хувьд дуудлага ихээр нэмэгдэж, ачаалал ихэсч байна.

Утасны дуудлага алдалтыг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 05/2989 албан бичгээр үүрэг болгосон. Мөн дуудлагын мэдээг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт онлайн хурлаар болон "НД дарга нар" вайбер групп дээр тогтмол мэдээлж анхааруулан ажилласан.

## *5.2. Нийгмийн даатгалын үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр*

Нийслэлийн төвийн 6 дүүргийн Нийгмийн даатгалын газарт үйлчилгээний болон ажлын байрны стандартын хэрэгжилтэд 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдрөөс 4 дүгээр сарын 21-ний өдрүүдэд удирдамжийн дагуу тандалт хийж, "Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээ, байцаагч ажилтнуудын харилцаа хандлага"-ын талаар сэтгэл ханамжийн судалгаа авч ажиллалаа.

Үйлчилгээний болон ажлын байрны стандартын хэрэгжилтийг НДЕГ-ын даргын 2017 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн А/99 тоот тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын утгах үйлчилгээний журам", 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/194 тоот тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)-ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт"-ыг Гадаад орчны стандарт, Дотоод орчны стандарт, Үйлчилгээний орчин, танхимын стандарт, Ажлын байрны ерөнхий стандарт, Байцаагч (ажилтан)-ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх гадаад орчны стандарт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх дотоод орчны зэрэг стандартыг үндсэн шалгуур үзүүлэлт болгон дүгнэж, үнэлгээ өгсөн бөгөөд анхаарах асуудлыг тухай бүрт дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт танилцууллаа.

Тандалт, судалгааны дүгнэлтийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын нийт ажилтнуудад танхимын болон цахим хосолсон 4 удаагийн сургалтаар танилцуулж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж өгсөн.

Мөн 9 дүүрэг, 21 аймгийн нийгмийн даатгалын газруудын иргэдэд утсаар зөвлөгөө, мэдээлэл өгч байгаа байдалд 2016 оны А/61 дүгээр "Нийгмийн даатгалын байцаагч (ажилтан)-ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам"-ын хүрээнд нийт 2 удаа (2025 оны 3 дугаар сарын 28-наас 6 дугаар сарын 02-ны өдрүүдэд) тандалт хийж дүнг мэдээллээ.

Тандалтаар Архангай, Дорнод аймгийн Нийгмийн даатгалын газрын ажилтан дуудлага аваад найрсгаар мэндэлсэн ба бусад аймаг дүүргийн Нийгмийн даатгалын газрууд “За” гэсэн хариултаар харилцааг эхэлж байсан. Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газрууд байгууллагын нэрээ танилцуулсан бол бусад газар байгууллага болон өөрийн нэрийг дурдаагүй, нийт газрууд үйлчлүүлэгчид ойлгомжтой байхаар тод, хэт хурдан биш, хэт удаан биш ажил хэрэгч байдлаар хариулт өгсөн.

Утсаар үзүүлэх үйлчилгээний байдалд хийсэн тандалтаас дүгнэхэд үйлчлүүлэгч хүссэн хариултаа авсан боловч, харилцааны ур чадвар, найрсаг харилцаа дутмаг байна. Мөн ажилтан өөрийн зүгээс өгөх хариулт дууссанаар харилцааг дуусгаж байгаа нь стандартын дагуу үйлчлүүлэгч харилцуураа тавьсны дараа ажилтан яриагаа таслах үйлдэл хийгдэхгүй байна.

### Утасны дуудлагад хийсэн тандалтыг тоон үзүүлэлтээр харуулбал:

Хүснэгт-11

№	Хариултын агуулга	Тийм	Үгүй
1	Утасны харилцуур аваад найрсгаар мэндэлсэн	2	28
2	Байгууллага болон нэрээ танилцуулсан	6	24
3	Утсаар харилцахдаа хүндэтгэлтэй харилцсан	25	5
4	Үйлчлүүлэгчид ойлгомжтой байхаар тод, хэт хурдан биш, хэт удаан биш ажил хэрэгч байдлаар ярьсан	30	0
5	Ярианы төгсгөлд үйлчлүүлэгчид таатай сэтгэгдэл төрүүлж эелдгээр яриагаа дуусгасан	12	18
6	Үйлчлүүлэгч харилцуураа тавьсны дараа ажилтан яриагаа тасалж байгаа	7	23

-Нийгмийн даатгалын байгууллагын дотоод сүлжээний “Инбит” систем дэх ажилтнуудын мэдээллийг залруулах ажлыг зохион байгуулж 12 аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын 26 албан хаагчийн мэдээллийг бүрэн оруулах, залруулах ажлыг тухайн газрын мэдээллийн технологийн мэргэжилтэнтэй хамтран хийж гүйцэтгэлээ.

Цаашид НДЕГ-ын даргын 2024 оны А/51 тоот тушаалд заасан албан тушаалын нэршлээр, утас мэйл хаягийн хамт стандартын дагуу бүрэн оруулах, хүний нөөцийн өөрчлөлтийг тухай бүрт өөрчлөн оруулж байхад хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж чиглэл өгсөн.

-“Төрийн байгууллагын төгөлдөршлийн тогтолцооны үнэлгээ, Азийн загвар байгууллага төлөвшүүлэх төсөл”-ийг Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газарт хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Монголын бүтээмжийн төв, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хооронд хамтран ажиллах гурван талт гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан. Энэхүү гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/92 дугаар тушаалаар байгуулж, ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулсан.

Уг ажлын хүрээнд Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын төсөл хариуцсан багтай хамтран “Нотолгоонд суурилсан хяналтын үнэлгээний хуудас”-ыг боловсруулсан бөгөөд төслийн багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, зөвлөн тусалж, хамтран ажилласан.

2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрууд “Азийн загвар байгууллага”-ын гэрчилгээгээ гардан авсан.

### 5.3. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах чиглэлээр

*Нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг судлах ажлын хүрээнд:*

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн А/184 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгаа авах журам”, “Тэтгэвэр, тэтгэмж авагч, даатгуулагч (иргэн)-аас авах сэтгэл ханамжийн судалгааны үлгэрчилсэн загвар”, “Бүлгийн ярилцлагын аргаар авах сэтгэл ханамжийн судалгааны үлгэрчилсэн загвар”-ыг тус тус шинэчлэн батлуулсан. Уг журмыг 2025.07.09-ний өдрийн 05/1726 тоот албан бичгээр Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлсэн.

-Иргэд, даатгуулагч, ажил олгогчдоос авах нийгмийн даатгалын мэдээллийн системийн хэрэглээний талаарх сэтгэл ханамжийн судалгааны асуумжийг боловсруулж, иргэний болон ажил олгогчийн портал систем (portal.ndaatgal.mn)-д байршуулан, дүнг нэгтгэн боловсруулж программ хангамжид гарч байгаа алдааг засах, хөгжүүлэлт, сайжруулалт хийх, тогтворжуулах, бодлогын даалгавар боловсруулах, зөвлөгөө мэдээлэл өгөх, мэргэжил арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт хүргүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд судалгаанд 1874 ажил олгогч, 3492 иргэд, даатгуулагч оролцсон ба дийлэнх нь системийн хурд, найдвартай ажиллагааг сайжруулах, техникийн алдааг багасгах, процессын шат дамжлагыг цөөлөх, программ ашиглах талаарх хэрэглэгчдэд зориулсан дэлгэрэнгүй, ойлгомжтой заавар, мэдээллийг тогтмол хүргэх зэрэг санал ирүүлсэн байна.

-Нийслэлийн 6 дүүргийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээний стандартын хэрэгжилтэд 3 дугаар сард тандалт, судалгаа хийж ажиллав. Уг ажлын хүрээнд тухайн дүүргээр үйлчлүүлж байсан 235 иргэнээс, нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээнд оролцсон 70 иргэнээс нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх 12 асуумж бүхий сэтгэл ханамжийн судалгаа авч, дүнг нэгтгэсэн. Судалгааны дүнгээр оролцогчдын дийлэнх нь тэтгэвэр, сайн дурын даатгал, шимтгэл төлөлттэй холбоотой дүрэм, журмуудыг илүү сонирхож, хууль тогтоомж, дүрэм, журмын мэдээллийг цахим орчинд олон нийтийн сүлжээгээр илүү хүртээмжтэй түгээх санал өгсөн. Байцаагчийн харилцаа хандлагад сэтгэл ханамж өндөр байгаа боловч иргэдэд өгч байгаа мэдээллээ ойлгомжтой, дэлгэрэнгүй тодорхой хүргэх, мэдээлэл дутуу авснаас иргэд дахин хандахад хүрч байгааг анхаарах зэрэг санал ирүүлсэн. Тандалт, судалгааны дүгнэлтийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын нийт ажилтнуудад танхимын болон цахим хосолсон 4 удаагийн сургалтаар танилцуулж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж өгсөн.

*Иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг танилцуулах, гарын авлагыг шинэчлэн боловсруулсан талаар:*

-Нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлах, гарын авлага, сурталчилгааны материал хэвлүүлэх чиглэлээр ОУХБ-ын “Албан бус эдийн засгийг албажуулах төсөл”-тэй хамтран ажиллаж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

-Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Албан бус эдийн засгийг албажуулах төслийн зохицуулагч Б.Мөнхтогтохтой 2025 онд хамтран ажиллах, санал солилцох уулзалтыг 01 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан. Тус уулзалтын үр дүнд нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдлыг сурталчлах зорилгоор “Нийгмийн даатгал” гарын авлага, “Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга” хэвлүүлэх, рийл, контент хамтран бүтээх, хамралтыг нэмэгдүүлэх ажлыг дэмжихэд зориулан компьютер, хувилагч төхөөрөмж худалдан авах ажлыг зохион байгуулж, хамтран ажиллахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу 2025 оны 03 сарын 14-ний өдөр Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай 40512607/0 дугаартай “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулсан.

- Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх болзолт уралдаанд тэргүүлсэн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэх 3 компьютер, 3 хувилагч, 3 скайнерийг холбогдох хууль, журмын хүрээнд гэрээ байгуулан “Ай Ти Зоне” компаниас худалдан авах ажлыг зохион байгуулсан.
- “Нийгмийн даатгал” гарын авлага, “Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга” товхимолын эхийг боловсруулж, удирдлагуудад танилцуулан эхийг баталгаажуулсан.
- Гарын авлага, танилцуулгыг хэвлүүлэхтэй холбогдуулан “Төрийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу НДЕГ-ын даргын 2025 оны 04

сарын 12-ны өдрийн А/87 дугаар тушаалаар “Үнэлгээний хороо” байгуулах тушаалын төсөл боловсруулж батлуулан, тендерийн шалгаруулалтад тавигдах шаардлага, техникийн үзүүлэлтийг бэлтгэж өгсөн. Мөн тендерт шалгарсан “Адмонпринт” ХХК-тай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулах ажлыг зохион байгуулсан.

- “Адмонпринт” ХХК-тай гарын авлага, танилцуулганы эх бэлтгэл дээр хамтран ажиллаж, “Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга” 9500 ширхэгийг, “Нийгмийн даатгал” гарын авлагыг 10000 ширхэг хэвлүүлсэн.
- Хамтын ажиллагааны гэрээний үнийн дүнгээс гарсан хэмнэлтээр гэрээний агуулга, цар хүрээнд тохируулан ном, тараах материалыг хэвлүүлэхэд үлдэгдэл санхүүжилтийг шилжүүлэх хүсэлтийг ОУХБ-ын “Албан бус эдийн засгийг албажуулах төсөл”-д уламжилж, шийдвэрлүүлэн "Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн эмхэтгэл" ном 600 ширхэг, "Сайн дурын даатгал" брошур (нугалбар) 50900 ширхэгийг хэвлүүллээ.
- Мөн төслийн хүрээнд 2025 онд хамтран хэрэгжүүлсэн ажлын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг боловсруулан ОУХБ-д хүргүүлсэн.

#### *Нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээний талаар:*

-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/48 тоот тушаалаар 2025 оныг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарласантай холбоотой 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас зохион байгуулсан нээлттэй арга хэмжээнд оролцож нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга, холбогдох дүрэм, журмыг сурталчлах, нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар мэдээлэл өгөх, аппликейшн ашиглах талаар зааварчилгаа өгөх, иргэдийн асуултад хариулах, санал хүсэлтийг хүлээн авах зэрэг ажлыг гүйцэтгэж, нийт 54 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав. Иргэд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны сунгалт болон халамжийн тэтгэвэр авагчаас нийгмийн даатгалын хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэвэр авагчаар шилжиж болох эсэх, сайн дурын даатгалын шимтгэл төлөх талаар, өндөр насны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн эрх үүсэх талаар, шимтгэл төлсөн жил, тэтгэвэр тогтоолгох нас болон нийгмийн даатгалын шимтгэл төлөх хувь хэмжээний талаар асуусан болно.

-“Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулсан “Ажилтай өрх-аз жаргалтай гэр бүл” нээлттэй өдөрлөг”-ийн бэлтгэл ажлыг хангаж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэд, олон нийт даатгуулагчдад сурталчлан, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулав. Нээлттэй өдөрлөгөөр НДЕГ-ын 10 албан хаагч, төвийн 6 дүүргийн НДГ-ын 6 байцаагч ажиллан 172 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, 21 иргэний гар утсанд аппликэйшн суулгаж, заавар өгсөн. Иргэдээс асуусан асуултыг агуулгаар нь ангилбал:

- Тэтгэврийн асуудлаар – 106
- Тэтгэмж - 22
- ХЧТА - 9
- Сайн дурын даатгал - 12
- Ажилгүйдлийн даатгал - 9
- Нэрийн данс - 2
- Аж ахуйн нэгж байгууллага шимтгэл төлөлт - 4
- Нөхөн даатгал - 3
- Санал, гомдол - 5 (Тэтгэврийн хэмжээ бага байна 2, НДШ--ийн өртэй аж ахуйн нэгжийн ажилтны шимтгэл төлөлтийн лавлагаа гарахгүй байна-3) тус тус байна.

- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санаачлагаар Залуусаа дэмжих үндэсний хөдөлгөөн ТББ-ын зохион байгуулсан “BOTGO EVENT”-ийг 2025 оны 09 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд Тусгаар тогтнолын ордны гадаа талбайд зохион байгуулсан арга хэмжээнд Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын газрууд (8 албан хаагч) болон тус газрын холбогдох албан хаагчдыг зохион байгуулан оролцсон. Арга хэмжээнд 1000 гаруй иргэн оролцож, нийгмийн даатгалын талаар мэдээлэл зөвлөгөө авсан.

- Монголын Өмгөөлөгчдын Холбооноос зохион байгуулсан хууль зүйн зөвлөгөө өгөх “Өмгөөлөгч-Танд тусалъя 2025” үйл ажиллагаанд Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газраас 4 байцаагч, ажилтан хамруулж хамтран ажилласан. Тус арга хэмжээний хүрээнд 31 иргэнд хууль, эрх зүйн мэдээлэл зөвлөгөө өгсөн байна.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ерөнхий газар, Хилийн чанад дахь монголчуудын холбоо зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, өдөрлөг зохион байгуулсан.

#### 5.4. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр

-Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд “Цахим шилжилт, их өгөгдөлд суурилсан нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжуулалтын дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулан Газрын даргын зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцүүлэн, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/138 дугаар тушаалаар батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт, баримтлах зарчим, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон;
- Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн системийн болон үйлчилгээний цахимжуулалтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлсон;
- Нийгмийн даатгалын байгууллагаас иргэд, даатгуулагч, ажил олгогчдод үзүүлж байгаа үйлчилгээний цар хүрээ, төрлийг нарийвчлан гаргаж, 81 үйлчилгээ байхаар тодорхойлсон;
- Нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжуулалтын нөхцөл байдлын шинжилгээ хийж, тулгамдаад байгаа асуудал, сайжруулах арга замыг тодорхойлсон ба үйлчилгээний цахимжуулалтын явцыг бүтээгдэхүүн тус бүрээр нарийвчлан гаргахад одоогийн байдлаар 65 хувьтай байна;
- Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 9 зорилт 50 заалт бүхий боловсруулсан;
- Цахимжуулах хөтөлбөрийн товч зураглалыг “Нийгмийн даатгалын үйлчилгээ”, “Систем хөгжүүлэлт болон дотоод бүтээгдэхүүн” зэрэг 2 хэлбэрээр боловсруулсан.

-“Нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжуулалтын дунд хугацааны хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд зарим төрлийн тэтгэвэр түүний дотор олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр тогтоох өндөр нас, энгийн өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэврийг иргэнээс баримт бичиг шаардахгүйгээр цахимжуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллахаар тусгасан. Уг ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын хамтарсан 2025 оны А/111-А/121 дүгээр, НДЕГ, Цагдаагийн ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Онцгой байдлын ерөнхий газрын даргын хамтарсан 2025 оны А/142-А/208, А/193-А/390, А/194-А/281 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэгт орж ажиллан эдгээр байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, хууль эрх зүйн болон программ хангамжийн түвшинд хийгдэх ажлуудын талаар ярилцан бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байна.

-Сумдын байцаагч нарын үйл ажиллагаанд SICOS системийг нэвтрүүлэх ажлыг турших зорилгоор Төв аймгийн Жаргалант, Борнуур, Баянчандмань сумдад Мэдээллийн технологийн төвийн программ зохиогч нартай хамтран ажиллаж, сумдын нийгмийн даатгалын байцаагч нарт зааварчилгаа, зөвлөмж өгч ажилласан. Сумын нийгмийн даатгалын байцаагч ажилтнуудын SICOS системд хийх ажлын жагсаалт, зураглалыг боловсруулж НДЕГ-ын даргын 2025.09.29-ны өдрийн А/261 дүгээр тушаалаар батлуулсан ба 2025.10.01-ний өдрөөс эхлэн сумын нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын үйл ажиллагаанд шинэ системийг нэвтрүүлээд байна.

Шинэ систем нийт байцаагч нарын үйл ажиллагаанд нэвтэрсэнтэй холбогдуулан “Тэтгэвэр, тэтгэмжийг цахимаар тогтоох, хянах, олгох, хувийн хэрэг бүрдүүлэх аргачлал”-ын төслийг боловсруулан Ажлын хэсгийн даргад хүргүүлсэн.

-Тэтгэврийн даатгалын сангаас болон ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг иргэд цахимаар илгээх боломжийг бүрдүүлэхтэй холбогдуулан систем хөгжүүлэлт хийхэд МТТ-тэй хамтран ажиллаж 2025.10.01-ний өдрөөс эхлэн иргэдийн хүсэлтийг цахимаар авч шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд даатгуулагч

өөрийн биеэр нийгмийн даатгалын байгууллагад очих шаардлагагүйгээр тэтгэврийн тогтоолт, олголт хийгдэж байна.

-Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хүсэлтийг цахимжуулах зорилгоор программын бодлогын даалгаврыг Ажлын хэсгийн холбогдох гишүүдтэй хамтран боловсруулж МТТ-д хүргүүлээд байна.

-Гадаад оронд ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэд сайн дурын даатгалын шимтгэлээ чирэгдэлгүй төлөх боломжийг бүрдүүлэх зорилгоор “ХУР” Төрийн мэдээлэл солилцооны системд нийгмийн даатгалын байгууллагатай сайн дурын даатгалын гэрээтэй иргэдийн төлбөрийн мэдээллийг байршуулах ажлыг Мэдээллийн технологийн төвд уламжлан, шийдвэрлүүлээ.

-Нийгмийн даатгалын үйлчилгээний дуудлагын төв (7777-1289)-д ашиглагдаж байгаа систем дээр MostCall ХХК-ийн хөгжүүлэлт хариуцсан инженертэй холбогдон 2025 оны 1 дүгээр сараас дуудлагын төвийн системийн хяналтын эрхийг өөрчлүүлэн, автомат хариулагчийн мэдээллийг шинэчлэн оруулах бэлтгэл ажлыг хангах, 3 дугаар сараас дуудлага хүлээн авах горим өөрчлөх, дуудлага хийсэн утасны дугаарын тайлан татуулах, дуудлагын цагийн горим өөрчлөх зэрэг системийн тохиргоог хийлгэсэн. Мөн үйлчилгээний доголдлыг тухай бүр хөгжүүлэлт хийсэн компанийн удирдлага, ажилтантай холбогдон шийдвэрлүүлж байна.

-CallPro ХХК-тай 2025 онд хамтран ажиллах гэрээний төслийг шинэчилж боловсруулан батлуулсан ба 2024 оны гэрээг дүгнэж, актыг Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.

-Нийгмийн даатгалын байгууллагуудын архивт хадгалагдаж буй 1995-2005 оны цаасан баримтыг зурган хэлбэрээр цахим сан үүсгэсэн, тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулсан ажлын талаар утсаар судалгаа авч нэгтгэн, “Ухаалаг архив”-ын цахимжуулалтыг Иргэний болон ажил олгогчийн портал систем (SICOS) системийн хүрээнд хөгжүүлэх санал танилцуулсан.

-Сүхбаатар дүүргийн Нийгмий даатгалын газрын архивын цахимжуулалтын явцтай 2 удаа газар дээр нь очиж ажиллан танилцаж, санал солилцож, тус цахим архивын системийн давуу ба сул талыг судалж цаашид салбарын хэмжээнд нэвтрүүлэх боломжийг судалж НДЕГ-ын даргад 2025.10.27-ны өдөр систем хөгжүүлэлтийн баг болон Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга Энхтөр, хэлтсийн дарга Эрдэнэчимэг нарын хамт танилцуулга хийсэн. Цаашид Өвөрхангай, Баянхонгор, Орхон, Дархан-Уул аймгуудын архивын цахимжуулалттай харьцуулсны үндсэн дээр салбарын хэмжээнд түгээхээр шийдвэрлэсэн.

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын байгууллагуудын архивын цахимжилтын талаар судалгаа авч үзэхэд уг ажил Орхон, Дархан-Уул, Ховд аймаг, Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газарт хэрэгжиж байгаа бөгөөд тэтгэврийн хувийн хэргийн цахимжилтын санхүүжилтийг орон нутгийн түвшинд шийдвэрлүүлэхээр Булган, Хэнтий аймгийн НДГ судалгаа, санал боловсруулан ажиллаж байна. Тэтгэврийн хувийн хэргийн цахимжилтын явц салбарын хэмжээнд 75% байна.

-Хиймэл оюун ухаант чатботыг нийгмийн даатгалын байгууллагын дотоод албан хэрэглээ, нийгмийн даатгалын байгууллагын фэйсбүүк болон цахим хуудасны хэрэглээнд тодорхой үе шаттайгаар нэвтрүүлэх, олон нийтэд чиглэсэн мэдлэгийн сангийн өгөгдлийг бэлтгэх, ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг НДЕГ-ын даргын 2025.09.08-ны өдрийн А/228 дугаар тушаалаар байгуулан ажиллалаа. Уг ажлын хүрээнд Аствишн компанитай хамтран дотоод албан хэрэглээнд ашиглагдах чатботыг турших ажлыг эхлүүлэн, .....хууль, дүрэм, журам холбогдох баримт бичгээр мэдлэгийн санг үүсгэсэн.

Мөн иргэд даатгуулагч, ажил олгогчдод зориулсан чатботыг Чимэгэ системс компанитай хамтран туршиж үзэхээр тохиролцон нийгмийн даатгалын талаар иргэд, ажил олгогчдоос нийтлэг асуудаг ....асуулт, хариултыг бэлтгэлээ.

#### *5.5. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр*

-Мэдээллийн лавлах 1900-1617, 1900-1950, Мобиком компанийн төлөөллүүдтэй иргэд, даатгуулагч, ажил олгогч, харилцагчдад нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх мэдээллийг шуурхай хүргэх, нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, тэтгэвэр тэтгэмж, төлбөр авах эрхээ эдлэх, санал хүсэлтээ илэрхийлэх боломжийг бий болгох зэрэгт дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах чиглэлээр уулзалт зохион байгуулав. Тус ажлын хүрээнд “Мэдээллийн лавлах 1900-1950”, “УВ лавлах 1900-1617”-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан.

-ХААН банкны “Эрдэм” цахим сургалтын платформоор дамжуулан жижиг дунд бизнес эрхлэгч нарт нийгмийн даатгалын талаарх мэдээллийг түгээх, цахим сургалтын видео, контент байршуулах зорилгоор 2025.11.12-ны өдөр 1805/НД-108/25 дугаартай “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулав.

-Хилийн чанад дахь Монголчуудын холбооны төлөөлөгчидтэй гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол улсын иргэдэд Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, ач холбогдлыг сурталчлан таниулах чиглэлээр уулзалт зохион байгуулж, санал солилцсоны дагуу хамтран ажиллах “Санамж бичиг”-ийн төслийг боловсруулж, НДЕГ-ын 05/395 дугаар албан бичгээр тус байгууллагад саналыг хүргүүлсэн. Мөн “Сайн дурын даатгал” брошурыг 5000 ширхэгийг Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл НҮТББ-д хүргүүлсэн.


Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлтэй хамтран Бельги (2025.06.28), Унгар (2025.07.06), Австри (2025.10.12) улсад ажиллаж, амьдарч байгаа монгол улсын иргэдэд нийгмийн даатгалын хууль тогтоомж, олон улсын хэлэлцээр, сайн дурын даатгалын талаар цахимаар уулзалт хийн зөвлөгөө мэдээлэл өгсөн.

-Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах ажлын хүрээнд харилцагч арилжааны банкуудтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж ажиллав.

#### 5.6. Олон нийттэй харилцах чиглэлээр:

##### Нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах:

Тайлант хугацаанд иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, харилцагч талуудад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, зөвлөгөө, мэдээллийг тогтмол ойлгомжтой




байдлаар хүргэх зорилгоор гарын авлага, сурталчилгааны хуудсыг олон нийтийн сүлжээ, цахим хуудас, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран түгээж ажиллав. Тус газрын @sigomongolia сошиал хуудас нь **176565** дагагчтай бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дагагч **28000**-аар нэмэгдсэн байна.

2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Нийгмийн даатгалын багц хууль, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, цаг үеийн мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас болон @sigomongolia сошиал хуудсаар дамжуулан нийгмийн даатгалын ач холбогдол, үйлчилгээг сурталчилсан рийл **42**, стори рийл **8**, постер мэдээлэл **370**, контент **16**, 2D видео контент **2**, 3D видео контент **2**, цаг үеийн мэдээ, мэдээлэл **237**, шууд дамжуулалт /лайв/ **4** нийт **681** удаагийн мэдээллийг бэлтгэн түгээсэн бөгөөд давхардсан тоогоор **25.191.552** /хандалтын тоо/ хүнд хүрч **97.115** удаа түгээсэн байна.

Хамгийн их хандалт авсан топ 4 контентууд:

- “Итгэлцлийн аян” /рийл/ Хандалтын тоо /245.000/, Лайк/1500/, Шэйр/1100/
- Төрийн албан хаагчид авлига ашиг сонирхлоос ангид ажиллах ёстой /рийл/ Хандалтын тоо /77.500/, Лайк/475/, Шэйр/1200/

- “Сайн дурын даатгалын ач холбогдол” /рийл/ Хандалтын тоо /215.000/, Лайк /1246/, Шэйр /613/
- “Малчин Хулан” /2D видео контент/ Хандалтын тоо /65.400/, Лайк /199/, Шэйр /761/




Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахаас гадна цаг үетэйгээ уялдуулж иргэд, харилцагчид, ажил олгогч даатгуулагчийн хүсэл сонирхолд нийцүүлэн нийгмийн даатгалын хууль тотоомжийг сурталчлах ажлыг хийлээ. Энэ хүрээнд 2025 онд 2D видео контент, 3D видео контентийг бэлтгэж, байгууллагын цахим хуудсаар түгээн ажиллалаа.



Мөн Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах хүрээнд 2025 онд 4 удаагийн шууд дамжуулалт буюу /лайв/ явуулсан. Тухайлбал “Сайн дурын даатгал”, “Олон улсын хэлэлцээр”, “Ажил олгогч даатгуулагчийн шимтгэлийн хувь хэмжээ, ажил олгогч даатгуулагчийн эрх үүрэг”, “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгох, эмнэлгийн хуудасны бичилт олголт” зэрэг сэдвээр шууд дамжуулалт хийж, давхардсан тоогоор давхардсан тоогоор нийт 5.1 сая орчим хүнд хүрсэн.



Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, харилцагч талуудад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, зөвлөгөө, мэдээллийг тогтмол ойлгомжтой байдлаар хүргэх, зорилтот бүлэгт нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар гэсэн инстаграм хуудсыг 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдөр нээсэн бөгөөд дагагчийн тоо өнөөдрийн байдлаар 521-д хүрсэн. Инстаграм хуудсаар дамжуулан 61 рийл, 140 постер нийт 201 удаагийн мэдээлэл байршуулсан. Хандалтын тоо 24.000 байна.





**Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах:**

Нийгмийн даатгалын байгууллага 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу олон нийт рүү чиглэсэн авлигын эсрэг ажиллах уриалсан 3 удаагийн богино видео контент, 15 постер, нийгмийн даатгалын үйл ажиллагаа шилэн, нээлттэй ажиллаж байгааг тодотгосон 20 постер мэдээллийг бэлтгэсэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан ёсны сошиал хаяг болон вет сайтад байршуулан олон нийтэд түгээсэн ажиллав.




Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй, орон зайнаас үйл хамааран хаанаас ч авах боломж нөхцлийг бүрдүүлэхээр 2025 онд нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжилтийг эрчимжүүлэн ажилласан. Цахимжилттай холбоотой хийгдэж байгаа ажлуудыг олон нийтэд сурталчлах ажлыг шат дараатай бэлтгэн олон нийтэд сурталчлан ажиллалаа.



2025 онд Нийгмийн даатгалын ерөнхий газраас шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын тогтвортой үйл ажиллагааг дэмжих, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгоход хамтран ажиллах зорилго бүхий "Итгэлцлийн аян"-ыг 2025 оны 09 сарын 15-наас 10 сарын 15-ны хооронд 1 сарын хугацаанд зохион байгуулж байна. Энэхүү итгэлцлийн аяны үйл ажиллагааг иргэд даатгуулагч, ажил олгогч, даатгуулагчид, олон нийтэд сурталчлах ажлыг хийлээ.



Нийгмийн даатгалын байгууллагын албан ёсны вэб сайт болох [www.daatgal.mn](http://www.daatgal.mn) сайтад 2025 онд нийт **9** төрлийн цэсэнд **727** төрлийн хууль, журам, мэдээллийг шинэчилэн оруулж, шинээр **49** видео мэдээ, **193** постер мэдээлэл, цаг үеийн мэдээ мэдээлэл **296**, **13** статистик мэдээг байршуулсан. Мөн Засгийн газраас хэрэгжүүлж буй төрийн байгууллагуудын нэгдсэн сайт болох [emongolia.mn](http://emongolia.mn) сайтад 9 дүгээр сараас хойш хөгжүүлж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 7 төрлийн цэсэнд **98** төрлийн хууль, журам, цахим үйлчилгээ мэдээллийг шинээр оруулж, **11** статистик мэдээг байршуулсан.



**Олон нийтийн асуулт, санал хүсэлтэд хариулах, эргэх холбоог хангах:**

Иргэд, даатгуулагчдын санал хүсэлтэд шуурхай хариулах, эргэх холбоог хангах зорилгоор ажиллуулж буй @sigomongolia хуудасны чатбот мессенжерт нийт **81.020** иргэн хандсанаас, автомат хариулагчаас **49.942**, зөвлөгөө мэдээлэл авсан **27.163**, холбоос руу нэвтэрсэн **3540**, санал, хүсэлт **375** ирсэн байна. Тухайлсан гомдол **23** ирснийг тухай бүр шийдвэрлэж ажилласан байна.

Байгууллагын [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) вебсайтад Байгууллагын [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) вебсайтад **2.310.554** иргэд, даатгуулагчид дараах цэсүүдэд хандаж мэдээлэл, үйлчилгээ, санал хүсэлтээ илгээсэн. Үүнд:

- Нүүр хэсэгт **1157896**

- Холбоо барих **114904**
- Хэрэглэгчийн тусламж **68552**
- Аж ахуй нэгж байгууллага **370364**
- Иргэд даатгуулагч **49371**
- Нийгмийн даатгал аппликэйшн **56472**
- Цахим үйлчилгээ **43991**
- Е-даатгал **26834**
- Санал хүсэлт **22541**

### ***Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах:***

2025 онд Zaag.mn, neguun.mn, zarig.mn, zindaa.mn, tovch.mn, shuud.mn, dorgio.mn, mass.mn, news.mn, gogo.mn, medee.mn, gerelmedia.mn, ulsturch.mn, ikon.mn, time.mn, eguur.mn, suvd.mn, mnb.mn, itoim.mn, Өглөөний сонин, Өнөөдөр сонин, Зууны мэдээ, Mongol HD, ТВ-8, Тэнгэр тв, TV-9, TV-5, Sbn, Star tv, Ulzii tv, UBS, ETV, NTV, ММ Агентлаг, С1, Parliament, MN25, Eagle TV зэрэг **45** /давхардсан тоогоор/ хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан **470** /давхардсан тоогоор/ удаагийн давтамжтайгаар нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд даатгуулагчдад хүргэж ажиллалаа.



Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, цаг үеийн мэдээг олон нийтэд хүргэхээр “Улаанбаатар ньюс” ХХК, “Их өгөгдлийн консалтинг” ХХК, “Граф Нэтворк” ХХК, “Монголын мэдээ сонин” ХМХ, “Хьюмен зэт” ХХК, “Ган-Үзэг” НҮТББ, “ Монгол Контент” ХХК, “Улаанбаатар сонин” ТББ, “Хуульч Ньюс” ХКК, “Медиа Холдинг” ХХК, “Агаржин Велт” ХХК, Сайхан байчууд” ХХК, “Энх-Арслан” ХХК, “Монголын сайн сайхны төлөө нийгмийн ил тод байдлын нэгдсэн судалгаа ”ТББ, “Би Эм Эй Эй Билэг” ХХК, “Паблик медиа” ХХК зэрэг хэвлэл мэдээллийн **24** байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж ярилцлага, зочны цаг, үйл явдлын мэдээ, постер, рийл зэргийг түгээсэн байна.

## ***6. ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗАР***

***6.1. Нийгмийн даатгалын төв сангийн орлого, зарлагын гүйлгээ, төвлөрсөн орлогыг нийгмийн даатгалын холбогдох санд хэрхэн хуваарилж байгаа байдалд аудит хийх;***

“Нийгмийн даатгалын төв сангийн орлого, зарлагын гүйлгээ, төвлөрсөн орлогыг нийгмийн даатгалын холбогдох санд хуваарилж байгаа байдалд нийгмийн даатгалын төв сангийн харилцах дансны 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуусталх хугацааны хуулга, холбогдох анхан шатны баримтыг хамруулан аудит хийв.

Аудитыг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Төв сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт:
- Холбогдох санд хуваарилж байгаа байдал:
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт олгох:

**Төв сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт:**

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар төв сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг харуулбал:

(наяд) Хүснэгт-12

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>Нийт орлого</b>	2.48	2.43	97.7%
<b>Нийт зарлага</b>	2.92	2.93	100.2%

Дээрх хүснэгтээс харахад нийт орлого 97.7 хувийн биелэлттэй, нийт зарлага 100.2 хувьтай байгаа нь зарлага төлөвлөгөөнөөс давсан гүйцэтгэлтэй байгааг харуулж байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сан тус бүрээр харуулбал:

(2025.06.30-ны өдрийн байдлаар)  
(тэрбум төг) Хүснэгт-13

	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
1	Тэтгэврийн даатгалын сан	Орлого	2,110,520.97	2,013,553.71	95.4
		Зарлага	2,698,826.52	2,667,266.41	100.7
2	Тэтгэмжийн даатгалын сан	Орлого	186,139.45	208,899.88	112.2
		Зарлага	153,509.54	148,681.95	96.8
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	Орлого	114,539.36	128,038.93	111.8
		Зарлага	32,445.83	25,407.60	78.3
4	Ажилгүйдлийн даатгалын сан	Орлого	70,191.12	74,555.33	106.2
		Зарлага	87,249.82	88,047.46	100.9
<b>Нийт дүн</b>		<b>Орлого</b>	<b>2,481,390.91</b>	<b>2,425,047.85</b>	<b>97.7</b>
		<b>Зарлага</b>	<b>2,922,178.31</b>	<b>2,929,403.43</b>	<b>100.2</b>

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл (аймаг, дүүргээр):  
Сан тус бүрийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзвэл:

- Тэтгэврийн даатгалын сангийн орлого 95.4 хувь, зарлага 100.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь орлогын дутуу төвлөрөлттэй боловч зарлага бүрэн санхүүжсэн байдал ажиглагдаж байна.
- Тэтгэмжийн болон ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого төлөвлөгөөнөөс 11–12 хувиар давсан бол ҮОМШӨ-ний сангийн зарлага 78.3 хувьтай байгаа нь тухайн сангийн зарцуулалт харьцангуй бага байгааг илтгэж байна.
- Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 106.2 хувь, зарлага 100.9 хувьтай байна.

(2025.06.30-ны өдрийн байдлаар) Хүснэгт-13

№	Аймаг, дүүргийн нэр	Орлого		Эзлэх хувь	Зарлага		Эзлэх хувь
		Орлогын төлөвлөгөө	Гүйцэтгэл		Зардлын төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Архангай	23,824.8	24,086.8	101.1	80,064.1	76,583.1	95.7
2	Баян-Өлгий	29,629.7	30,732.3	103.7	75,354.8	72,125.2	95.7
3	Баянхонгор	30,535.0	30,451.5	99.7	78,982.1	76,505.7	96.9
4	Булган	29,629.7	30,732.3	103.7	75,354.8	72,125.2	95.7
5	Говь-Алтай	20,041.0	20,222.0	100.9	49,456.5	47,191.4	95.4
6	Дорноговь	47,972.1	45,868.2	95.6	63,186.2	61,490.2	97.3

7	Дорнод	36,407.0	34,918.8	95.9	77,242.2	74,525.2	96.5
8	Дундговь	16,274.3	16,199.6	99.5	45,164.6	43,807.1	97.0
9	Завхан	25,260.4	25,212.3	99.8	68,661.7	64,270.5	93.6
10	Өвөрхангай	34,681.6	33,857.7	97.6	98,717.0	96,604.5	97.9
11	Өмнөговь	107,539.7	108,822.9	101.2	58,369.5	56,943.9	97.6
12	Сүхбаатар	22,372.9	22,441.3	100.3	52,128.0	49,289.8	94.6
13	Сэлэнгэ	49,525.5	49,518.0	100.0	106,261.3	103,613.2	97.5
14	Төв	33,074.4	33,132.8	100.2	88,541.7	85,402.7	96.5
15	Увс	26,708.0	26,808.6	100.4	70,854.9	68,163.2	96.2
16	Ховд	34,268.8	32,629.4	95.2	73,296.0	70,155.7	95.7
17	Хөвсгөл	34,558.8	33,701.7	97.5	111,173.0	107,157.9	96.4
18	Хэнтий	34,222.1	35,000.8	102.3	69,274.5	68,103.8	98.3
19	Дархан-Уул	63,686.2	63,082.5	99.1	107,969.9	104,550.0	96.8
20	Орхон	99,356.9	91,955.8	92.6	124,696.9	125,601.6	100.7
21	Говьсүмбэр	14,030.4	13,614.4	97.0	17,927.0	16,554.6	92.3
22	Баянгол	281,462.3	261,634.5	93.0	233,384.9	233,059.7	99.9
23	Баянзүрх	245,192.4	214,611.1	87.5	331,505.6	327,001.0	98.6
24	Багануур	10,827.1	17,872.7	165.1	17,198.3	33,837.0	196.8
25	Багахангай	1,939.6	2,194.6	113.2	4,955.9	4,567.0	92.2
26	Налайх	13,634.3	12,068.1	88.5	43,704.1	34,748.7	79.5
27	Сүхбаатар дүүрэг	334,929.5	334,929.5	100.0	91,665.0	154,028.7	168.0
28	Сонгинохайрхан	125,918.0	117,939.7	93.7	260,180.9	256,935.7	98.8
29	Хан-Уул	310,683.8	319,522.1	102.8	199,276.9	199,743.8	100.2
30	Чингэлтэй	343,205.0	341,286.0	99.4	147,630.1	144,717.5	98.0
<b>Дүн</b>		<b>2,481,390.9</b>	<b>2,425,047.8</b>	<b>97.7</b>	<b>2,922,178.3</b>	<b>2,929,403.4</b>	<b>100.2</b>

Дээрх хүснэгтээс харахад:

Аймаг, дүүргийн түвшинд орлогын гүйцэтгэл 87.5–165.1 хувийн, зарлагын гүйцэтгэл 79.5–196.7 хувийн хооронд хэлбэлзэж байна. Тухайлбал, Багануур дүүргийн орлого 165.1 хувь, зарлага 196.7 хувьтай гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөлт бодит гүйцэтгэлээс ихээхэн зөрүүтэйг харуулж байна.

Харин Баянзүрх дүүргийн орлого 87.5 хувь, Налайх дүүргийн зарлага 79.5 хувьтай байгаа нь орлого, зарлагын гүйцэтгэл хангалтгүй байгааг илтгэж байна.

### Шалгуур:

- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйл “Нийгмийн даатгалын сангийн орлого”, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулна”,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 12.3 дахь хэсэг “Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох дансанд сар бүр төвлөрүүлнэ”,
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 дугаар тушаалын хавсралт “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дахь хэсэг “Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар нь энэ журмын 3.1 дэх хэсэг “Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар нь нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын харилцах дансанд (цаашид “Төвлөрсөн орлогын харилцах данс” гэх) ажил олгогч, даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан болон нуусан орлогод тооцсон алданги, торгуулийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төвлөрсөн орлогын харилцах дансанд төвлөрүүлнэ”;
- Журмын 4.1 дэх хэсэг “Нийгмийн даатгалын ерөнхий газар нь төвлөрсөн орлогын харилцах дансанд төвлөрсөн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг нийт ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн ногдуулалтын хувиар 7 хоног бүр нийгмийн даатгалын холбогдох санд хуваарилах буюу сан тус бүрийн харилцах дансанд шилжүүлнэ”;
- Журмын 5.1 дэх хэсэг “Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Аймаг, дүүргийн Нийгмийн Даатгалын газруудад олгох сан тус бүрийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын

санхүүжилтийг сан тус бүрийн харилцах дансны өмнөх сарын үлдэгдлийг хасаж, дараах байдлаар олгоно” ;

### **Холбогдох санд хуваарилж байгаа байдал:**

2025 оны эхний хагас жилийн хугацаанд төвлөрсөн орлогын харилцах данснаас нийгмийн даатгалын холбогдох сангуудад нийт 2.6 их наяд төгрөг хуваарилсан байна. Үүнээс:

- Тэтгэврийн даатгалын санд 1.8 их наяд төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын санд 422.9 тэрбум төгрөг;
- Тэтгэмжийн даатгалын санд 178.5 тэрбум төгрөг;
- Үомшө-ний даатгалын санд 118.8 тэрбум төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 89.8 тэрбум төгрөг;
- Тэтгэврийн нөөц санд 25.0 сая төгрөг тус тус шилжүүлжээ.

Сарын дүнгээр авч үзвэл тэтгэврийн даатгалын санд хуваарилсан мөнгөн дүн хамгийн өндөр бөгөөд 167.9–399.2 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзсэн байгаа нь шимтгэлийн ногдуулалтын бүтцэд тэтгэврийн даатгалын эзлэх хувь өндөр байдгийг илэрхийлж байна.

Эрүүл мэндийн даатгалын санд 35.3–99.3 тэрбум төгрөгийн хооронд, тэтгэмжийн даатгалын санд 29.2–41.8 тэрбум төгрөгийн хооронд хуваарилалт хийсэн нь сангуудын хоорондын жингийн харьцаа тогтвортой байгааг харуулж байна.

ҮОМШӨ болон ажилгүйдлийн даатгалын сангийн хувьд сар бүрийн хуваарилалт харьцангуй бага дүнтэй боловч тасралтгүй хийгдсэн бөгөөд ҮОМШӨ-ний сан 8.8–45.3 тэрбум төгрөг, ажилгүйдлийн сан 11.5–20.2 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзсэн байна. Энэ нь сар бүрийн байдлаар тогтвортой хадгалагдсан бөгөөд хуваарилалтын хувь хэмжээнд хэлбэлзэл ажиглагдахгүй байна.

Холбогдох санд хуваарилж байгаа байдал (сараар)

(тэрбум. төг) Хүснэгт-14

Сар	Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	Ажилгүйдэл	Эрүүл мэнд
1	167.9	-	-	16.5	35.3
2	394.6	37.1	8.8	15.3	99.3
3	263.5	40.6	21.6	12.8	42.6
4	321.6	29.9	45.3	13.7	97.6
5	293.8	29.2	14.5	20.2	85.6
6	399.2	41.8	28.6	11.5	62.5
<b>Дүн</b>	<b>1,840.6</b>	<b>178.5</b>	<b>118.8</b>	<b>89.8</b>	<b>422.9</b>

### **Хуваарилалтын хүүгийн талаар:**

2025 оны эхний хагас жилийн хугацаанд төвлөрсөн орлогын харилцах дансанд орсон нийгмийн даатгалын шимтгэлийг холбогдох сангуудад шимтгэлийн ногдуулалтын хувьтай уялдуулан тогтмол хуваарилсан байна.

Сарын дундаж үзүүлэлтээр тэтгэврийн даатгалын санд 69.29 хувь, эрүүл мэндийн даатгалын санд 16.14 хувь, тэтгэмжийн даатгалын санд 7.43 хувь, ҮОМШӨ-ний даатгалын санд 4.52 хувь, ажилгүйдлийн даатгалын санд 2.62 хувийг тус тус хуваарилжээ.

Сар бүрийн хуваарилалтын бүтцийг харьцуулж үзэхэд сан тус бүрийн хувь хэмжээ тогтвортой хадгалагдаж, нийт 100 хувийн дүнтэй бүрэн тэнцэж байгаа нь төвлөрсөн орлогын хуваарилалт нь батлагдсан хувь, бүтэцтэй нийцэж байгааг харуулж байна.

Тухайлбал, тэтгэврийн даатгалын сангийн хуваарилалтын хувь 69.07–69.46 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийнх 16.10–16.22 хувийн хооронд хэлбэлзсэн нь статистикийн хувьд хэвийн хэлбэлзэлд тооцогдох түвшинд байна.

Иймд 2025 оны эхний хагас жилд нийгмийн даатгалын сангуудын хооронд хийсэн хуваарилалт нь шимтгэлийн ногдуулалтын бүтэц, журамд заасан харьцааг алдагдуулаагүй, сан хоорондын хуваарилалтын тэнцвэрийг хадгалсан гэж үзэж байна.

(Хүүгийн хуваарь 2025.06.30-ны өдрийн байдлаар) Хүснэгт-15

№	Үзүүлэлт	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	Дунджаар
1	Тэтгэвэр	69.46%	69.16%	69.07%	69.34%	69.31%	69.41%	69.29%
2	Тэтгэмж	7.43%	7.40%	7.44%	7.42%	7.44%	7.44%	7.43%
3	ҮОМШӨ	4.38%	4.58%	4.72%	4.48%	4.50%	4.44%	4.52%
4	Ажилгүйдэл	2.61%	2.64%	2.67%	2.62%	2.60%	2.60%	2.62%
5	Эрүүл мэнд	16.12%	16.22%	16.10%	16.14%	16.15%	16.11%	16.14%
	Нийт	100%	100%	100%	100%	100%	100%	100%

2025 оны эхний хагас жилийн хугацаанд улсын төсвөөс нийгмийн даатгалын тогтолцоонд хамрагдсан иргэдэд олгох тэтгэвэр, тэтгэмж, тэтгэмжийн шинжтэй бусад санхүүжилтийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудаар дамжуулан санхүүжүүлсэн байна.

Улсын төсвийн санхүүжилт нь тэтгэврийн даатгалын сангийн тэтгэвэр, ҮОМШӨ-ний даатгалын тодорхой төлбөрүүд, малчдын нийгмийн даатгалын шимтгэлийн дэмжлэг, даатгуулагч эх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг (эх) зэрэг зорилтот бүлгүүдийг хамарч байгаа нь халамжийн бодлоготой уялдсан гэж үзэж байна.

Аймаг, дүүргийн хэмжээнд олгосон улсын төсвийн санхүүжилтийн дүнг авч үзвэл Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүд нийт санхүүжилтийн дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал, Баянзүрх дүүрэгт 115.2 тэрбум төгрөгийн улсын төсвийн санхүүжилт олгосон нь хүн амын төвлөрөл, даатгуулагчдын тоо өндөртэй холбоотой байна. Үүнтэй адил Баянгол дүүрэгт 66.8 тэрбум төгрөг, Сүхбаатар дүүрэгт 47.1 тэрбум төгрөгийн тэтгэврийн санхүүжилт тус тус олгогдсон нь нийслэлийн төвийн дүүргүүдэд улсын төсвөөс санхүүжүүлт ордог тэтгэвэр авагчдын эзлэх хувь өндөр байгааг харуулж байна.

Сэлэнгэ, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай зэрэг хүн амын тоо харьцангуй ихтэй аймаг, хотуудад улсын төсвийн санхүүжилтийн дүн өндөр байгаа бол Говьсүмбэр, Багахангай, Багануур зэрэг хүн ам цөөн, үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлт харьцангуй бага бүсүүдэд олгосон санхүүжилтийн дүн бага байна. Энэ нь улсын төсвийн санхүүжилт нь тухайн нутаг дэвсгэрийн хүн ам, тэтгэвэр авагчдын тоо, зорилтот бүлгийн хамрагдалтаас шууд хамаарч байгааг илтгэнэ.

Малчдын нийгмийн даатгалын шимтгэлийн дэмжлэгийн санхүүжилт нь хөдөө орон нутгийн аймгуудад төвлөрсөн байдалтай байгаа бөгөөд Өвөрхангай, Хөвсгөл, Архангай, Увс зэрэг аймагт харьцангуй өндөр дүнтэй олгогдсон байна.

Харин “УТ Ээж–тэтгэвэр”, “УТ Ээж–тэтгэмж” зэрэг зорилтот санхүүжилт нь нийт дүнгээрээ бага боловч бараг бүх аймаг, дүүрэгт жигд тархсан байгаа нь бодлогын шинжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн санхүүжилт тогтвортой хэрэгжиж байгааг харуулж байна.

### Шалгуур:

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 дугаар тушаалын хавсралт “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 4.2.1 дэх заалт “Нийгмийн даатгалын ерөнхий газар нь төвлөрсөн орлогын харилцах дансанд төвлөрсөн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг нийт ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн ногдуулалтын хувиар 7 хоног бүр нийгмийн даатгалын холбогдох санд хуваарилах буюу сан тус бүрийн харилцах дансанд шилжүүлнэ”;
- Журмын 4.2.2 дахь заалт “Шимтгэлийн ногдуулалтын хувь нь ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, сайн дурын даатгуулагчийн гэрээний дагуу төлсөн нийгмийн даатгалын шимтгэлд үндэслэх бөгөөд нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд автоматаар хуваарилалт хийх боломжийг бүрдүүлсэн байна”;
- Журмын 4.2.3 дахь заалт “Төвлөрсөн орлогын харилцах дансанд хуваарилагдаагүй үлдсэн үлдэгдлээс шалтгаалан мөнгөн хөрөнгийн хуваарилалтын зөрүү үүсч болох бөгөөд тухайн сард үүссэн зөрүүг дараагийн сард, жилийн эцэст үүссэн зөрүүг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, дараа жилд тус тус залруулах арга хэмжээ авна”;

**Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт олгох:**

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад олгосон улсын төсвийн санхүүжилтийг харуулбал:

(Тэрбум.төг) Хүснэгт-16

№	Нэгжийн нэр	УТ тэтгэвэр	УТ ҮОМШӨ	ХБХ	Малчин	УТ ээж - Тэтгэвэр	УТ ээж- Тэтгэмж
1	Архангай	13,206.3	27.2	110.0	1,010.5	170.7	13.4
2	Баян-өлгий	19,619.0	63.0	179.7	679.1	188.0	14.8
3	Баянхонгор	11,239.2	4.0	151.4	970.3	102.1	8.0
4	Булган	12,406.9	34.1	85.8	609.6	54.1	4.3
5	Говь-алтай	10,138.2	3.9	67.7	568.8	78.2	6.1
6	Дорноговь	16,219.5	15.1	114.6	313.8	77.6	6.1
7	Дорнод	23,559.0	58.8	120.1	362.6	139.6	11.0
8	Дундговь	8,877.8	35.4	77.0	535.5	73.5	5.8
9	Завхан	18,479.3	11.6	74.9	715.2	100.9	7.9
10	Өвөрхангай	21,131.5	18.7	187.3	1,175.7	167.0	13.1
11	Өмнөговь	14,730.4	-	131.1	434.8	59.5	4.7
12	Сүхбаатар	12,990.2	46.1	95.2	684.1	137.1	10.8
13	Сэлэнгэ	25,641.4	35.6	137.4	362.3	61.1	4.8
14	Төв	19,884.1	38.4	104.0	643.0	95.5	7.5
15	Увс	11,563.1	24.5	143.8	753.8	178.0	14.0
16	Ховд	14,632.5	38.8	114.2	594.5	110.2	8.7
17	Хөвсгөл	25,705.3	17.6	207.6	1,088.3	159.0	12.5
18	Хэнтий	11,240.6	123.2	141.3	550.3	98.3	7.7
19	Дархан-уул	22,217.2	156.5	200.9	71.1	112.3	8.8
20	Орхон	22,526.5	147.4	184.8	58.5	120.1	9.4
21	Говьсүмбэр	3,188.6	9.4	31.7	48.3	8.8	0.8
22	Баянгол дүүрэг	66,811.2	164.3	398.8	15.3	167.8	13.2
23	Баянзүрх дүүрэг	115,248.5	212.5	602.5	46.0	222.7	17.5
24	Багануур дүүрэг	10,180.5	33.9	44.8	92.0	19.6	1.5
25	Багахангай дүүрэг	1,683.8	6.1	8.5	6.1	0.4	0.0
26	Налайх дүүрэг	13,377.1	716.4	52.4	46.0	24.8	1.9
27	Сүхбаатар дүүрэг	47,100.6	105.1	249.1	9.8	71.8	3.4
28	Сонгинохайрхан дүүрэг	79,611.4	166.5	445.7	92.0	172.0	13.5
29	Хан-уул дүүрэг	50,226.6	116.5	408.5	39.9	142.9	11.2
30	Чингэлтэй дүүрэг	43,169.3	105.6	203.8	15.3	76.2	6.1
31	Солонгос	13,206.3	27.2	110.0	1,010.5	170.7	13.4
	<b>Нийт</b>	<b>766,605.7</b>	<b>2,536.4</b>	<b>5,074.7</b>	<b>12,592.5</b>	<b>3,193.7</b>	<b>248.9</b>

Хуваарийн дагуу санхүүжилтийг олгосон байна.

**Шалгуур:**

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 дугаар тушаалын хавсралт “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 5.1 дэх хэсэг “Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Аймаг, дүүргийн Нийгмийн Даатгалын газруудад олгох сан тус бүрийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилтийг сан тус бүрийн харилцах дансны өмнөх сарын үлдэгдлийг хасаж, дараах байдлаар олгоно;
- 5.1.1 дэх заалт “Дараа сарын тэтгэврийн даатгалын сангийн зардлын санхүүжилтийг тухайн сарын 20-ны өдрөөс хойш”;
- 5.1.2 дахь заалт “Бусад сангийн зардлын санхүүжилтийн 50 хүртэлх хувийг тухайн сарын эхний ажлын 2 өдөрт, үлдэгдэл санхүүжилтийг тухайн сарын 10-ны өдрийн дотор багтаан олгоно”;

- 5.1.3 дахь заалт “Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн орлого, зарлагын мэдээний гүйцэтгэлд үндэслэн энэ журмын 5.1-д заасны дагуу хассан, олгогдоогүй санхүүжилтийг олгож болно”;

### Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэлт:

2025 оны 01–06 дугаар сарын хугацаанд төвлөрсөн орлогын харилцах дансанд нийт 2,8 их наяд төгрөг төвлөрсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэлтийг сар бүрээр харуулбал:

2025.06.30-ны өдрийн байдлаар Хүснэгт-17

Төвлөрсөн төвлөрүүлсэн орлого	харилцахад	Үзүүлэлт	Дүн (тэрбум.төг)
		1 сар	390.7
		2 сар	464.3
		3 сар	448.9
		4 сар	527.8
		5 сар	494.8
		6 сар	524.6
		<b>Нийт</b>	<b>2,851.0</b>

Дээрх хүснэгтээс харахад 4, 6 дугаар саруудад төвлөрүүлэлт харьцангуй өндөр буюу 520 тэрбум төгрөгөөс дээш байгаа бол 1 дүгээр сард хамгийн бага төвлөрүүлэлт хийгдсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэлтийг аймаг, дүүргээр нь харуулбал:

2025.06.30-ны өдрийн байдлаар (тэрбум.төг) Хүснэгт-18

№	Аймаг, дүүргийн нэрс	Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	Ажилгүй дэл	Төвлөрүүлэлтийн дүн
1	Архангай	58,091.7	3,287.1	61.5	1,027.3	27,076.6
2	Баян-Өлгий	45,305.7	3,573.2	283.5	600.8	35,605.1
3	Баянхонгор	48,824.0	3,045.5	155.5	1,203.4	30,250.2
4	Булган	42,488.3	1,967.2	165.5	1,079.5	21,779.6
5	Говь-Алтай	33,748.8	2,240.3	53.4	756.5	23,573.5
6	Дорноговь	39,733.2	3,771.0	675.5	2,073.5	59,021.3
7	Дорнод	44,841.1	3,414.2	311.6	1,871.7	41,091.6
8	Дундговь	31,068.6	1,991.4	52.9	474.6	18,191.1
9	Завхан	39,581.2	3,110.3	48.5	1,384.8	29,180.2
10	Өвөрхангай	63,429.4	3,575.5	278.5	1,618.4	38,254.9
11	Өмнөговь	36,574.6	4,702.0	265.9	3,105.5	130,785.5
12	Сүхбаатар	31,130.1	2,270.2	110.6	766.1	24,637.0
13	Сэлэнгэ	74,081.7	3,991.7	659.5	1,796.9	58,882.4
14	Төв	60,522.2	3,558.4	264.5	1,688.1	37,717.6
15	Увс	53,301.3	3,593.1	80.8	1,145.0	30,790.6
16	Ховд	49,451.0	3,869.4	455.3	1,618.2	38,085.4
17	Хөвсгөл	70,997.1	4,908.4	300.3	1,380.5	36,012.7
18	Хэнтий	49,836.0	2,955.2	1,865.5	1,444.3	39,368.8
19	Дархан-Уул	67,308.6	5,247.4	2,522.5	2,680.3	72,401.1
20	Орхон	89,216.9	6,326.9	1,752.8	2,376.7	105,327.2
21	Говьсүмбэр	12,573.6	1,179.8	222.0	579.0	16,256.0
22	Баянгол дүүрэг	141,272.1	12,650.9	983.4	10,427.4	312,325.7
23	Баянзүрх дүүрэг	179,805.0	18,893.2	1,559.0	14,302.9	253,691.5
24	Багануур дүүрэг	20,038.6	1,437.9	1,092.0	690.1	21,084.5
25	Багахангай дүүрэг	2,529.5	210.0	23.0	122.7	2,559.4
26	Налайх дүүрэг	17,391.0	1,634.4	1,276.0	1,318.4	14,892.3
27	Сүхбаатар дүүрэг	91,142.5	8,794.5	712.8	5,523.5	401,790.0
28	Сонгинохайрхан дүүрэг	143,644.3	12,908.4	1,334.3	9,356.0	140,601.2
29	Хан-Уул дүүрэг	120,111.1	14,397.2	1,287.0	10,810.9	377,604.9
30	Чингэлтэй дүүрэг	91,062.5	8,174.5	696.0	3,872.0	410,668.9

31	НДҮЗ	35.7	5.2	5.3	1.0	-
32	Солонгос		-	-	-	1,506.8
	дүн	1,849,137.2	151,684.5	19,554.8	87,096.1	2,851,013.8

Дээрх хүснэгтээс харахад Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Баянгол дүүргүүд нийт төвлөрүүлэлтийн дийлэнх хувийг бүрдүүлж байна.

Харин Багахангай, НДҮЗ зэрэг нэгжүүдийн төвлөрүүлэлтийн дүн харьцангуй бага байгаа нь эдгээр нэгжийн шимтгэл төлөгчдийн тоо, хөдөлмөр эрхлэлтийн онцлогтой холбоотой байна.

### АУДИТЫН ҮР ДҮН

Аудитаар дараах асуудлууд илэрлээ. Үүнд:

Хүснэгт-19

<i>Илэрсэн асуудал 1:</i> <b>Анхан шатны баримтын бүрдэл дутуу</b>	<b>Сангийн харилцахын баримт хадгаламжийн нэгж болгон хавтаслан үдэж, архивлахдаа эмх цэгц, дэс дараалалгүй үдсэн, дансны дэлгэрэнгүй хуулганы ард холбогдох нотлох баримт бичгүүдийг хавсаргаагүй.</b>
<i>Асуудлын ангилал:</i>	Нөлөө багатай

**Бодит нөхцөл байдал:** Аудитын явцад сангийн харилцах данстай холбоотой анхан шатны баримтуудыг хадгаламжийн нэгж болгон хавтаслан үдэж, архивлахдаа эмх цэгц, дэс дарааллыг хангаагүй, дансны дэлгэрэнгүй хуулганы ард тухайн гүйлгээг нотлох анхан шатны баримт бичгүүдийг бүрэн хавсаргаагүй байна. *Тухайлбал:* зарим шилжүүлэг, хуваарилалт, санхүүжилтийн гүйлгээнд холбогдох шийдвэр, тооцоолол, баталгаажуулсан баримт дутуу хадгалагдсан байна.

#### Шалгуур:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно";
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 45 дугаар зүйл "Албан хэрэг бүрдүүлэхэд тавих шаардлага";
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4.3 дахь заалт "баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах";

**Шалтгаан:** Анхан шатны баримтын бүрдэл, хадгалалт, архивлалтад тавих дотоод хяналт сул, баримтыг нэгтгэн бүрдүүлэх, үдэж эмхлэх талаар нэгдсэн заавар, хяналтын тогтолцоо хангалтгүй хэрэгжсэн.

**Үр нөлөө:** Анхан шатны баримтын бүрдэл дутуу байснаар санхүүгийн гүйлгээг нотлох боломж хязгаарлагдаж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бүрэн байдалд эргэлзээ үүсэх, цаашлаад хяналт шалгалт, аудитын явцад гүйлгээг баталгаажуулах боломжгүй болох эрсдэл бий болж байна.

*6.2. Капитал банкны эрх хүлээн авагчаас нийгмийн даатгалын санд хүлээн авсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, худалдан борлуулалт, түрээсийн гэрээний биелэлтэд аудит хийж, зөвлөмж өгөх;*

Нийгмийн даатгалын ерөнхий газар Капитал банкны эрх хүлээн авагчаас хөрөнгө хүлээн авсан баримт шийдвэр, хадгалалт, хамгаалалтын байдал, худалдан борлуулалт, түрээсийн гэрээний биелэлт, хэрэгжилтийг 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааг хамруулан шалгав.

Аудитыг гүйцэтгэхэд хөрөнгө хүлээн авах шийдвэр, хөрөнгө худалдан борлуулсан гэрээ, түрээсийн гэрээ, хөрөнгө худалдан борлуулсан орлого болон түрээсийн орлого хүлээн авсан харилцах дансны хуулга зэрэгт үндэслэн хөрөнгө борлуулсан, түрээслүүлсэн орлогыг тулган баталгаажуулах, хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдлыг газар дээр нь очиж үзэх, холбогдох

албан тушаалтнуудтай ярилцлага хийх зэрэг арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох баримт цуглуулах арга замаар хэрэгжүүлээ.

Аудитыг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Хөрөнгө худалдан борлуулсан орлогын барагдуулалтын байдал;
- Борлуулагдаагүй үлдсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын өнөөгийн байдал;
- Түрээслүүлж байгаа хөрөнгийн нөхцөл байдал, түрээсийн гэрээний биелэлт;

Капитал банкны эрх хүлээн авагчаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэхэмжилсэн нийгмийн даатгалын сангийн өр төлбөрт 2021-2022 онуудад 25,0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 78 ширхэг хөрөнгийг хүлээн авсан байна.

Капитал банкны эрх хүлээн авагчаас нийгмийн даатгалын сангийн өр, төлбөрт тооцон авсан хөрөнгийг он тус бүрээр харуулбал:

Хүснэгт-20

Хөрөнгө хүлээн авсан он	Хөрөнгийн тоо ширхэг	Үнийн дүн	Тогтоол шийдвэрийн огноо, дугаар
2021	46	22,123.6	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 19 дүгээр тогтоол,
2022	32	2,905.2	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоол
Дүн	78	25,028.7	

Капитал банкны эрх хүлээн авагчаас нийгмийн даатгалын сангийн өр, төлбөрт тооцон авсан хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаа болон шууд гэрээгээр худалдан борлуулах ажлыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны “Журам батлах тухай” 18 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын албан бичгээр өгсөн зөвшөөрлийг тус тус үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар удаа дараа зохион байгуулж 11.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий 61 хөрөнгийг худалдан борлуулж Нийгмийн даатгалын санд орлогыг хүлээн авч бүртгэсэн байна.

### Шалгуур 1. “Хөрөнгийн худалдан борлуулалт” асуудлын хүрээнд:

**Илэрсэн асуудал 1:** Худалдан борлуулах ажлыг зохих журмын дагуу нээлттэй дуудлага худалдаа, шууд худалдан борлуулах гэрээгээр гүйцэтгэсэн байна. Мөн зарим хөрөнгө эвдэрч муудан зах зээлийн үнэлгээ буурах, засвар үйлчилгээний нэмэлт зардал гарах зэрэг эрсдэлээс хамгаалан яаралтай худалдан борлуулах шаардлагатай.

**Асуудлын ангилал:** Нөлөө дунд зэрэг.

**Бодит байдал:** Капитал банкны эрх хүлээн авагчаас Нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн төлбөрт хүлээн авсан болон худалдан борлуулсан хөрөнгө, үлдэгдэл хөрөнгө (2024.12.31-ний өдрийн байдлаар)-ийг дараах байдлаар харуулбал:

/Сая.төг/ Хүснэгт-21

Хүлээн авсан хөрөнгийн нийт дүн		Худалдан борлуулсан хөрөнгийн орлого								Хөрөнгийн үлдэгдэл	
		2021 он		2022 он		2023 он		2024 он			
Тоо ширхэг	Мөнгөн дүн	Тоо ширхэг	Мөнгөн дүн	Тоо ширхэг	Мөнгөн дүн	Тоо ширхэг	Мөнгөн дүн	Тоо ширхэг	Мөнгөн дүн	Тоо ширхэг	Мөнгөн дүн
78	25,028.7	2	484.5	26	7,272.8	9	1,286.1	24	2,452.3	17	13,533.0

Үүнээс 2021-2024 онуудад нийт 11,5 тэрбум төгрөгийн үнэ бүхий 61 хөрөнгийг худалдан борлуулж, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 13,5 тэрбум төгрөгийн үнэ бүхий 17 хөрөнгө борлуулагдаагүй үлдсэн байна.

Худалдах, худалдан авах гэрээ байгуулан борлуулсан хөрөнгийн төлбөрийн барагдуулалтын мэдээллийг харуулбал:

/Сая.төг/ Хүснэгт-22

	Мөнгөн дүн
Худалдан борлуулсан гэрээний үнэ	11,873.4
Борлуулсан хөрөнгийн балансын үнэ	11,495.7
Балансын үнээс илүү борлуулсан	377.6
Гэрээ болон хуваарийн дагуу төлсөн	11,277.6
Төлбөрийн үлдэгдэл /2024,12,31-ний байдлаар/	595.7

Нийт 5 хөрөнгөтэй холбоотой 595,7 сая төгрөгийн төлбөрийн үлдэгдэл байна. Эдгээр төлбөр гэрээгээр тохирсон хуваарь, хугацаандаа Нийгмийн даатгалын санд төлөгдөж төлөлт хэвийн явагдаж байна. Хугацаа хэтэрсэн төлбөр байхгүй

### **Шалгуур 2. “Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт” асуудлын хүрээнд:**

**Илэрсэн асуудал 2:** Зарим хөрөнгө хуучирч муудсан, хог тоосонд дарагдсан, тоногдсон, эвдэрсэн байдалтай байна.

**Асуудлын ангилал:** Нөлөө ихтэй.

**Бодит байдал:** Борлуулагдаагүй үлдсэн 13,55 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 17 хөрөнгийн одоогийн нөхцөл байдал, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдлыг үнэлэх үүднээс уг хөрөнгийн байршиж байгаа газарт очиж үзсэн. Үлдэгдэл 17 хөрөнгийг худалдан борлуулж сангийн мөнгөн хөрөнгийг бүрдүүлэх шаардлагатай

2024 оны жилийн эцсийн байдлаар үлдэгдэл хөрөнгийн нөхцөл байдал ашиглалт хэвийн буюу бусдад түрээслүүлж байгаа 8, ашиглалтгүй, нөхцөл байдал дордсон 7, дуусаагүй барилга /газрын хамт/-2 хөрөнгө байна.

Ашиглалтгүй байгаа дээрх 7 хөрөнгө харуул хамгаалалт байхгүй, цонх хагархай тоос шороонд дарагдсан, дотор сан болон хаалга тоногдсон зэрэг байдал нь хөрөнгийг худалдан борлуулах үнэ, зах зээлийн үнэлгээг бууруулах эрсдэл үүсгэж байна.

**Илэрсэн асуудал 3:** Харуул хамгаалалт байхгүй, хөрөнгийн байдал дордсон

**Асуудлын ангилал:** Дунд зэрэг.

**Бодит байдал:** Харуул хамгаалалт тавих хүн хүч, хөрөнгө мөнгөний тал дээр хязгаарлагдмал байдалтай байна. Үүнд:

- **БГД 5-р хороонд байрлах 5 давхар барилга:** Харуул хамгаалалт тавих хөрөнгө мөнгөний асуудалтайн улмаас 1 дүгээр давхрын орох хаалгыг түгжсэн байдалтай байна.

- **Хашаа байшин:** Зуслангийн бүсэд байршилтай тул харуул хамгаалалт тавих боломжгүй.

### **Шалгуур 3. “Түрээсийн гэрээний хэрэгжилт” асуудлын хүрээнд:**

**Илэрсэн асуудал:** Түрээсийн гэрээнд заасан үүргийн биелэлт хангалтгүй, түрээсийн гэрээний үнийг хэт багаар тогтоосон, гэрээг дүгнээгүй байна.

**Асуудлын ангилал:** Нөлөө ихтэй.

**Бодит нөхцөл байдал:** Түрээсийн гэрээгээр тохирсон төлбөр, сар бүрийн төлөлт, орлого хүлээн авч бүртгэсэн байдал болон сангийн харилцах дансанд төлөгдсөн дүн зэргийг тулган

шалгахад түрээслэгч нартай сар бүрийн түрээсийн төлбөрийн тооцоо хийх, санд хүлээн авах, бүртгэх ажил хэвийн, алдаа зөрчилгүй хэрэгжсэн.

2021-2024 онуудад түрээслүүлсэн хөрөнгийн тоо болон түрээсийн орлогоор санд орсон орлогын мэдээллийг харуулбал:

/Сая.төг/ Хүснэгт-23

он	Түрээслүүлсэн хөрөнгийн тоо	Түрээслэгчийн тоо	Түрээсийн орлого
2021	7	12	51.9
2022	15	40	171.0
2023	12	33	137.2
2024	8	30	349.0
<b>Дүн</b>			<b>709.1</b>

Түрээсийн гэрээний үнийг хэт бага үнээр тогтоох, гэрээг дүгнээгүй, түрээслэгч нар түрээсийн гэрээний зарим заалтыг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:3,240 м.кв талбай бүхий үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө /Үйлчилгээний зориулалттай 4 давхар барилга, машины зогсоол, гүний худаг, уурын зуухын хамт/-ийг 2022 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн №ТГ-10/22 дугаар гэрээгээр Эрхэт монгол ХХК-д түрээслүүлсэн боловч түрээслэгч тал гэрээний дараах заалтуудыг зөрчсөн.

Түрээслүүлж байгаа хөрөнгийн м2 –ийн үнийг хэт багаар тогтоож түрээсийн орлогоор санд орох боломжтой 2,6 тэрбум төгрөгийн орлогыг алдсан байна.

Аудитын дүн мэдээг нэгтгэн тайланг удирдлагад танилцуулж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/3222 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

### *6.3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд аудит хийх;*

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 242 дугаар тогтоолд заасны дагуу Дотоод аудит, мониторингийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлтээр хэрэгжүүлэхээр тусгасан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2025 оны “Дотоод аудит хийх тухай” А/339 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтад 2025 оны 3 дугаар улирлын байдлаар аудит хийсэн.

Аудитыг дараах чиглэлийн дагуу хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол, шийдвэрийн биелэлт;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын хөрөнгийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт;
- Актлагдсан, ашиглалтын шаардлага хангаагүй хөрөнгийг зохих журмын дагуу акталж данснаас хассан байдал;
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдал;
- Хөндлөнгийн байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, түүний хэрэгжилт;

### *6.4. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх;*

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/100, А/107, А/158, А/215, А/217 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Орхон аймгийн Нийгмийн даатгалын газарт 2019-2024 оны Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдэд олгосон цагийн хөлсний бүртгэл, тооцоонд, Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газарт 2022-2024 оны, Завхан аймгийн Нийгмийн даатгалын газарт 2023-2024 оны, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт 2023-2025 оны эхний 6 сар, Мэдээллийн технологийн төвийн 2022-2025 оны эхний 6 сарыг хамруулан санхүү, үйл ажиллагааны зардлын зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгав.

Шалгалтаар илэрсэн 58.6 сая төгрөгийн зөрчилд 9 Санхүүгийн улсын байцаагчийн акт, 551.9 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Акт, албан шаардлагын биелэлтийг аймаг, дүүргээр нь харуулбал:

/Мян.төг/ Хүснэгт-24

Газрын нэр	Төлбөрийн акт					Албан шаардлага				
	Тогтоосон		Барагдуулсан		Биелэл тийн хувь	Тогтоосон		Барагдуулсан		Биелэл тийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн	
Орхон	1	3,900.0	1	3,900.0	100%					
Завхан	4	10,600.0	1	609.7	5.8%					
Сэлэнгэ						1	551.9	1	551.9	100%
Чингэлтэй	4	44,129.0		3,282.0	7.4%					
МТТ										
Нийт дүн	9	58,629.0	2	7,791.7	13%	1	551.9	1	551.9	100%

Дээрх шалгалтын дүн мэдээг Газрын даргын зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр, 07 дугаар сарын 08-ны өдөр, 09 дүгээр сарын 26-ны өдөр, 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралд тус тус танилцуулсан.

6.5. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ;

**“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;**

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны эхний 8 сарын байдлаарх хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээллийг үндэслэн хяналт-шинжилгээ хийв.

Тус бодлогын баримт бичигт Нийгмийн даатгалын чиглэлээр 2 зорилт бүхий 9 арга хэмжээ тусгагдсан байна.

Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнг зорилтоор нь харуулбал:

Хүснэгт-25

Чиглэл	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт (Хувиар)
Хүний хөгжил	1	90.0
Амьдралын чанар ба дундаж давхарга	8	92.2
Нийт	9	92.0

Хяналт-шинжилгээний дүнг арга хэмжээ тус бүрээр харуулбал:

Хүснэгт-26

Зорилт, үйл ажиллагааны дугаар	Зорилт, арга хэмжээ	Хэрэгжилт /Хувиар/
Хоёр.ХҮНИЙ ХӨГЖИЛ		
<b>2.6. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эзийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.</b>		
2.6.15.	Ажилгүйдлийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.	90
Гурав. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА		
<b>3.1. Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ</b>		
3.1.1.	Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, малчдыг нийгмийн даатгалд даатгуулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.	100
3.1.2.	Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй олгоно.	100

3.1.3.	Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно.	90
3.1.4.	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ.	90
3.1.5.	Нийгмийн даатгалын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна.	90
	Нутгийн захиргааны байгууллагатай хамтран өрхийн болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийнэ.	70
3.1.6.	Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлно.	100
3.1.8.	Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн аатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно.	90
3.1.9.	Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шатыг эхлүүлнэ.	100
Нийт дундаж үнэлгээ		92

Хяналт шинжилгээний дүнгээр:

“**Үр дүнтэй**” буюу хэрэгжиж байгаа, зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага, зохион байгуулалт сайн, цаашид үргэлжлүүлэн хэрэгжих 9 арга хэмжээ байгаагаас:

- 100 хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ;
- 90 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ;

“**Үр дүн хүлээгдэж байгаа**” буюу зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, үр дүн гарч байгаа, өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 1 арга хэмжээ;

- 70.0 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ;

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2025 оны эхний 8 сарын байдлаар 92.0 хувь буюу “Үр дүн гарсан” гэж дүгнэж Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн 02/2433 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

**Монгол Улсыг (2021-2025) хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;**

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийв.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2 зорилт бүхий 4 арга хэмжээ тусгагдсан байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг харуулбал:

Хүснэгт-27

Зорилт, арга хэмжээний дугаар	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
<b>Зорилт 2.6. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ</b>			
2.6.2.	1	Ажилгүйдлийн даатгалын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг үр дүнд суурилсан санхүүжилтийн арга	100

		хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	
<b>Зорилт 3.1. Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ</b>			
<b>3.1.1.</b>	2	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ.	100
<b>3.1.2.</b>	3	Иргэн бүр нэрийн дансандаа бодит хуримтлалтай болж, дансны үлдэгдлийн тодорхой хувийг гэр бүлдээ өвлүүлэх нийгмийн даатгалын шинэчлэл хийгдэнэ.	100
<b>3.1.5.</b>	4	Нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцийн түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.	100
<b>Нийт дундаж үнэлгээ</b>			<b>100</b>

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2025 оны жилийн эцсийн байдлаар 90.4 хувь буюу “Үр дүнтэй” гэж дүгнэж тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/3367 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

### **Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;**

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийв.

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-д 2 бүлэг, 3 зорилго, 10 зорилт, 16 арга хэмжээ тусгагдсанаас Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамааралгүй буюу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хэрэгжүүлэх 5 арга хэмжээ, Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах 2 зорилт бүхий 11 арга хэмжээ тусгагдсан байна.

Хяналт-шинжилгээний дүнг зорилт, арга хэмжээ тус бүрээр харуулбал:

(2025 оны жилийн эцсийн байдлаар) Хүснэгт-28

Зорилт, арга хэмжээний дугаар	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
<b>ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>			
<b>2.1. ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ ХҮН</b>			
<b>2.1.1. ГЭР БҮЛ, ХҮН АМЫН ОНЦЛОГТ НИЙЦСЭН БОДЛОГО</b>			
<i>2.1.1.1. Нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулж, иргэн бүрд хуримтлалын сан бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар ашиглах, тэтгэвэрээ өвлүүлэх, урьдчилан ашиглах боломжийг бүрдүүлнэ.</i>			
<b>2.1.1.1.</b>	1	Хагас хуримтлалын тогтолцоонд шилжих шинэчлэлийг үргэлжлүүлж тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг хуримтлуулах;	90
<b>2.1.1.1.</b>	2	Нийгмийн даатгалын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	100
<b>2.1.1.22.</b>	3	Тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ.	100
<b>2.1.3. НИЙГМИЙН БАТАЛГАА</b>			
<i>2.1.3.2. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөөдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.</i>			

<b>2.1.3.2</b>	1	Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх;	87.8
	2	Нийгмийн даатгалын үйлчилгээг их өгөгдөлд суурилан бүрэн цахимжуулж, тоног төхөөрөмжийг шинэчлэх;	90
<b>2.1.3.3. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч бүрийг "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал"-тай болгож, тэтгэврийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.</b>			
<b>2.1.3.3.</b>	1	Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч бүрийг "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал"-тай болгож, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх;	90
<b>2.1.3.4. Хагас хуримтлалын тогтолцоонд шилжиж, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах хууль, эрх зүйн зохицуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</b>			
<b>2.1.3.4.</b>	1	Тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах зохицуулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нарийвчлан тусгах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	100
<b>2.1.3.5. Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ</b>			
<b>2.1.3.5</b>	1	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх хуулийн төслийг боловсруулж, Улсын Их хуралд өргөн мэдүүлэх;	100
<b>2.1.3.6. Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулна.</b>			
<b>2.1.3.6.</b>	1	Засгийн газар хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шинээр байгуулах;	100
<b>2.1.3.7. Нийгмийн даатгалын сангуудын засаглалыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгийн менежментийг ил тод, шилэн болгоно.</b>			
<b>2.1.3.7</b>	1	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг нээлттэй байршуулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах	100
<b>Дундаж</b>			<b>95.8</b>

Хяналт шинжилгээний дүнгээр:

- Хэрэгжиж дууссан 100 хувийн хэрэгжилттэй “Үр дүн гарсан” 1 арга хэмжээ;
- Хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа 10 арга хэмжээ;

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр тусгагдсан Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа цаашид үргэлжлүүлэн хэрэгжих 10 арга хэмжээний хэрэгжилтийг авч үзвэл:

“Үр дүнтэй” буюу 87.8-100 хувийн хэрэгжилттэй 10 арга хэмжээ байна. Үүнд:

- 100 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ;
- 90 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ;
- 87.8 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ тус тус байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2025 оны эхний хагас жилийн байдлаар 90.4 хувь, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1611 дүгээр албан бичгээр, жилийн эцсийн байдлаар 95.78 хувь буюу “Үр дүнтэй” гэж дүгнэж тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/3367 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэв.

**Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;**

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийв.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр 1 зорилт 1 арга хэмжээ тусгагдсан байна. Үүнд:

- “Хүний хөгжлийн бодлого” бүлгийн Зорилго 3.4.1-д “Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ” зорилтын хүрээнд 3.4.1.1-д “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх” 1 арга хэмжээ;

Монгол Улсын Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2025 оны эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар 100 хувь буюу “Үр дүнтэй” гэж дүгнэж, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1611 дүгээр албан бичгээр, жилийн эцсийн тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/3367 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэв.

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад авсан Монгол Улсын хууль, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын нийт 37 шийдвэрийн 68 заалт байна.

(2025 оны жилийн эцсийн байдлаар) Хүснэгт-29

№	Шийдвэрийн нэр	Шийдвэрийн тоо	Заалтын тоо
1	Монгол Улсын хууль	2	2
2	Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол	1	1
3	Засгийн газрын тогтоол	5	5
4	Ерөнхий сайдын захирамж	1	2
5	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	14	23
6	Ерөнхий сайдын албан даалгавар	2	22
7	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол	12	13
Нийт		37	68

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, биелэлт дараах байдалтай байна.

- **Монгол Улсын хууль:** Нийт 2 шийдвэрийн 2 заалтын биелэлт “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувь;
- **Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол:** Нийт 1 шийдвэрийн 1 заалтын биелэлт “Хэрэгжих шатанд” буюу 50 хувь;
- **Засгийн газрын тогтоол:** Нийт 5 шийдвэрийн 5 заалтаас “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” 2 шийдвэр, “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн биелэлттэй 2 шийдвэр, “хэрэгжих шатанд” буюу 50 хувийн биелэлттэй 1 шийдвэр байна. Биелэлтийн дундаж 83.3 хувь;
- **Ерөнхий сайдын захирамж:** Нийт 1 шийдвэрийн 2 заалт “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн биелэлттэй. Биелэлтийн дундаж 100 хувь;
- **Засгийн газрын хуралдааны тэмдэглэл:** Нийт 14 шийдвэрийн 23 заалт байна. “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” 4 шийдвэр, “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн биелэлттэй 17 шийдвэр, “хэрэгжих шатанд” буюу 50 хувийн биелэлттэй 2 шийдвэр байна. Биелэлтийн дундаж 94.7 хувь;
- **Ерөнхий сайдын албан даалгавар:** Нийт 2 шийдвэрийн 22 заалт байна. “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн биелэлттэй 20 шийдвэр, “хэрэгжих шатанд” буюу 50 хувийн биелэлттэй 3 шийдвэр байна. Биелэлтийн дундаж 95.5 хувь;

- **Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл:** Нийт 12 шийдвэрийн 13 заалт байна. “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” 2 шийдвэр, “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн биелэлттэй 10 шийдвэр, “хэрэгжих шатанд” буюу 50 хувийн биелэлттэй 1 шийдвэр байна. Биелэлтийн дундаж 95.5 хувь;

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнг харуулбал:

Хүснэгт-30

		Бүгд		Үүнээс						
		1.в.Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол	1.е.Засгийн газрын тогтоол	1.ё.Ерөнхий сайдын захирамж	1.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	1.з.Ерөнхий сайдын албан даалгавар	2.а.Монгол Улсын хууль	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол		
<b>Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо</b>		37	1	5	1	14	2	2	12	
<b>Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо</b>		68	1	5	2	23	22	2	13	
Үнэлгээ	Хэрэгжсэн	53		2	2	17	20	2	10	
	Хэрэгжих шатанд	Тодорхой үр дүнд хүрсэн	7	1	1		2	2		1
		Удаашралтай /эрчимжүүлэх шаардлагатай/								
	Хэрэгжээгүй	Зохион байгуулалтаас								
		Хөрөнгө дутагдсанаас								
	Хугацаа болоогүй		8		2		4			2
Хэрэгжих боломжгүй										
<b>Хяналтаас хасуулах санал /хүчингүй болсон эсэх/</b>		25		2		5	6	2	10	
Дүн /хувь/		<b>94.2</b>	<b>50.0</b>	<b>83.3</b>	<b>100</b>	<b>94.7</b>	<b>95.5</b>	<b>100</b>	<b>95.5</b>	

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээгээр:

- “Хэрэгжсэн” буюу биелэлт бүрэн хангагдсан 53 заалт;
- “Хэрэгжих шатанд” буюу зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох шийдвэр гарсан, дээд шатны байгууллагад хүргүүлсэн “тодорхой үр дүнд хүрсэн” 7 заалт байна.
- “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” 8 заалт;
- “Тухайн шийдвэрт заасан хугацаа дууссан”, “бүрэн хэрэгжсэн” хяналтаас хасуулах 5 шийдвэрийн 24 заалт тус тус байна.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” гэж үнэлж, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/337 дугаар албан бичгээр, 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг 96.5 хувиар үнэлж, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1732 дугаар албан бичгээр, жилийн эцсийн байдлаар нийт 37 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 68 заалтын биелэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар 53 (88.3 хувь) нь “Хэрэгжсэн”, 7(5.83 хувь) нь “Хэрэгжих шатанд”, 8(11.8 хувь) нь “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”-гээр тус тус дүгнэж, биелэлт (дунджаар) 94.2 хувиар дүгнэж тайланг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/ 122 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэв

**Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;**

2.3.2.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХУ-ний төвийн Нийгмийн даатгалын тасаг, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын байгууллагын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой мэдээлсэн эсэхэд 2025 оны 1, 3 дугаар улирлын байдлаар, мөн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэлх хугацааг хамруулан нийт 3 удаа хяналт-шинжилгээ хийж холбогдох баримт бичигтэй тулган шалгав.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн нийт 166,791.5 тэрбум төгрөгийн 8,745 мэдээлэл байршуулахаас 8,202 мэдээллийг хугацаанд мэдээлж мэдээлэл байршуулалт 97 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 93 хувьтай байна.

Хяналт шинжилгээгээр нийт 14,410.0 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс:

- 20,039 шийдвэр гүйлгээний 6,819.8 тэрбум төгрөгийн 233 мэдээллийг мэдээлээгүй;
- 3,233 шийдвэр гүйлгээний 3,174.6 тэрбум төгрөгийн мэдээллийг илүү мэдээлсэн;
- 778,530 шийдвэр гүйлгээний 4,415.5 тэрбум төгрөгийн 310 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба хяналт шинжилгээний явцад зөрчлийг залруулж нөхөн мэдээлсэн 2,012 шийдвэр гүйлгээний 472.8 тэрбум төгрөгийн мэдээлэл байна.

Хяналт-шинжилгээгээр дээрх алдаа дутагдлаас гадна дараах нийтлэг зөрчлүүд давтагдан гарсаар байна. Үүнд:

- “Оруулах мэдээлэл байхгүй” төлөвөөр мэдээлсэн;
- Хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг бичээгүй;
- Мэдээллийг маягтын дагуу бүрэн гүйцэд оруулаагүй;
- Хавсралтад мэдээллийг pdf, excel файлаар байршуулаагүй, хөтөлбөр зориулалтыг хоосон мэдээлсэн;
- Хөтөлбөр зориулалтыг дансны дугаар, эдийн засгийн ангиллын кодоор (эдийн засгийн ангиллын нэршлээр мэдээлээгүй) мэдээлж мэдээллийг хэрэглэгчдэд зориулаагүй байх;
- Баталгаажсан тайлан, мэдээг оруулаагүй;
- Батлагдсан төсвийг орлого, зарлагын нийт дүнгээр мэдээлсэн буюу орлого, зарлагын ангиллаар мэдээлээгүй, батлагдсан төсвийн нийт дүнг харах боломжгүйгээр мэдээлсэн;
- Сан болон үйл ажиллагааны мэдээллийг зөрүүлж мэдээлэх;
- Батлагдсан төсвийн нийт дүнг харах боломжгүйгээр мэдээлсэн;
- Тухайн төсвийг бүрэн эхээр нь мэдээлэхгүйгээр зөрүүгээр мэдээлсэн;
- Өөрчлөлт ороогүй саруудад батлагдсан төсвийг дахин мэдээлсэн;
- Мэдээлсэн мэдээллийн мөнгөн дүн зөрүүтэй;
- 5 сая төгрөгөөс дээш худалдан авалт хийх байгууллагатай хийсэн гэрээний дүнг мэдээлээгүй, буруу мэдээлэх;
- Худалдан авалт хийсэн сар бүрийн мөнгөн дүнг өссөн дүнгээр мэдээлээгүй, буруу мэдээлэх;
- Худалдан авалтад газрын төлбөр, буцалтгүй тусламж зэрэг мэдээлэх ёсгүй мэдээллийг илүү мэдээлсэн;
- Мөнгө, хөрөнгө захиран зарцуулах шийдвэрийн огноог засаж оруулах (мэдээлэхдээ 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн шийдвэр мэтээр мэдээлсэн байхад Pdf файлыг нээхэд 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр гаргасан тушаал байх);
- Бонд цэст холбогдох газруудтай хийсэн гэрээг мэдээлээгүй;
- Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоогүй буюу мэдээлэх ёсгүй тушаал шийдвэрийг мэдээлсэн (ажилд томилсон, чөлөөлсөн, цалин шинэчлэн тогтоосон, цалинтай чөлөө олгосон тухай, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох, ээлжийн амралт олгох тухай, Ёс зүйн хороо, эцэг эхийн зөвлөл, тооллогын комисс байгуулах тухай гэх мэт);
- Хавсралт цэсэнд сарын мэдээг мэдээлээгүй;
- Бонд төрөлд мэдээлэх тушаал, шийдвэрийг “Бусад төрөл” цэсийн “Хавсралт файл” төрөлд мэдээлсэн гэх мэт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүн, танилцуулга, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг удирдлагад танилцуулан Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/912, 02/2768, 02/3152 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд, мөн тус газрын даргын 2025 оны 02/1090, 02/2819 дүгээр албан бичгээр Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт тус тус хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хууль холбогдох журмын хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаарх зөвлөмжийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны “Шилэн дансны зөвлөмж хүргүүлэх тухай” 02/262 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлэв.

**Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хугацаатай мэдээ тайланг гаргаж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх;**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.1-т зааснаар Нийгмийн даатгалын харьяа байгууллагуудын 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1,2,3,4 дүгээр улирлын байдлаарх шилэн дансны хөтлөлтийн тайланг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд үндэслэн нэгтгэж, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/81, Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/1719, 02/2670, 2026 оны 02/95 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэв.

Нийгмийн даатгалын байгууллагууд 2025 оны 4 дугаар улирлын байдлаар нийт 11,340 мэдээллийг байршуулахаас хугацаандаа байршуулсан мэдээлэл 11,250 хугацаа хоцроосон мэдээлэл 90 байсан ба мэдээлэл байршуулалт 100 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 99.2 хувьтай байна. Үүнд:

Хүснэгт-31

	Нийт мэдээлэх мэдээллийн тоо	Мэдээлэл хугацаанд нь байршуулсан мэдээллийн тоо	Үүнээс		Хугацаа хоцорсон мэдээлэл	Оруулаагүй мэдээллийн тоо	Нийт мэдээлэл байршуулсан хувь	Хугацаандаа байршуулсан мэдээллийн хувь
			Хугацаанд нь мэдээлсэн мэдээллийн тоо	Хугацаанд нь “оруулах мэдээлэл байхгүй” төлөвөөр оруулсан				
<b>Нийгмийн даатгалын сан</b>	5,484	5,456	2,336	3,120	28		100%	99.5%
<b>Байгууллагын үйл ажиллагаа</b>	5,856	5,794	3,091	2,703	62		100%	98.9%
<b>Нийт</b>	<b>11,340</b>	<b>11,250</b>	<b>5,427</b>	<b>5,823</b>	<b>90</b>		<b>100%</b>	<b>99.2%</b>

Дээрх хүснэгтээс харахад:

- *Нийгмийн даатгалын байгууллагын мэдээлэл байршуулалт:* Нийт 5,856 мэдээллийг байршуулахаас хугацаандаа байршуулсан мэдээлэл 5,794, хугацаа хоцроосон мэдээлэл 62, мэдээлэл байршуулалт 100 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 98.9 хувьтай байна.
- *Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт:* Нийт 5,484 мэдээллийг байршуулахаас хугацаандаа байршуулсан мэдээлэл 5,456, хугацаа хоцроосон мэдээлэл 28, мэдээлэл байршуулалт 100 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 99.5 хувьтай байна.

Шилэн дансны мэдээлэл байршуулалтыг аймаг дүүргээр харуулбал:

Хүснэгт-32

Д/д	Газрын нэр	Нийт мэдээлэл	Үүнээс	Хугацаа хоцроосон мэдээлэл
-----	------------	---------------	--------	----------------------------

				Мэдээлэл хугацаандаа орлуулсан	Мэдээлэл хугацаандаа орлуулсан			Нийт мэдээлэл байршуулсан хувь	Хугацаан даа мэдээлэл байршуулсан хувь
1	Архангай НДГ	354	353	176	177	1	-	100.0%	99.7%
2	Баян-Өлгий НДГ	354	351	186	165	3	-	100.0%	99.2%
3	Баянхонгор НДГ	354	346	182	164	8	-	100.0%	97.7%
4	Булган НДГ	354	352	167	185	2	-	100.0%	99.4%
5	Говь-Алтай НДГ	354	348	166	182	6	-	100.0%	98.3%
6	Говьсүмбэр НДГ	354	350	166	184	4	-	100.0%	98.9%
7	Дархан-Уул НДГ	354	352	159	193	2	-	100.0%	99.4%
8	Дорноговь НДГ	354	353	176	177	1	-	100.0%	99.7%
9	Дорнод НДГ	354	353	174	179	1	-	100.0%	99.7%
10	Дундговь НДГ	354	354	177	177	-	-	100.0%	100.0%
11	Завхан НДГ	354	350	161	189	4	-	100.0%	98.9%
12	Орхон НДГ	354	353	170	183	1	-	100.0%	99.7%
13	Өвөрхангай НДГ	354	353	180	173	1	-	100.0%	99.7%
14	Өмнөговь НДГ	354	354	166	188	-	-	100.0%	100.0%
15	Сүхбаатар НДГ	354	351	170	181	3	-	100.0%	99.2%
16	Сэлэнгэ НДГ	354	351	141	210	3	-	100.0%	99.2%
17	Төв НДГ	354	345	174	171	9	-	100.0%	97.5%
18	Увс НДГ	354	345	147	198	9	-	100.0%	97.5%
19	Ховд НДГ	354	353	177	176	1	-	100.0%	99.7%
20	Хөвсгөл НДГ	354	354	190	164	-	-	100.0%	100.0%
21	Хэнтий НДГ	354	352	167	185	2	-	100.0%	99.4%
22	Багануур НДГ	354	349	167	182	5	-	100.0%	98.6%
23	Багахангай НДГ	354	352	182	170	2	-	100.0%	99.4%
24	Баянгол НДГ	354	353	163	190	1	-	100.0%	99.7%
25	Баянзүрх НДГ	354	352	164	188	2	-	100.0%	99.4%
26	Налайх НДГ	354	346	172	174	8	-	100.0%	97.7%
27	Сонгинохайрхан НДГ	354	352	203	149	2	-	100.0%	99.4%
28	Сүхбаатар дүүргийн НДГ	354	354	182	172	-	-	100.0%	100.0%
29	Хан-Уул НДГ	354	354	180	174	-	-	100.0%	100.0%
30	Чингэлтэй НДГ	354	353	167	186	1	-	100.0%	99.7%
31	БНСУ дахь ХНХУ-ний төвийн НД-ын тасаг	183	182	95	87	1	-	100.0%	99.5%
32	НДЕГ төв сан	183	179	61	118	4	-	100.0%	97.8%
33	НДЕГ-МТТ	171	169	21	148	2	-	100.0%	98.8%
34	НДЕГ	183	182	99	83	1	-	100.0%	99.5%
НИЙТ		11,340	11,250	5,427	5,823	90	-	100.0%	99.2%

Дээрх хүснэгтээс харахад Дундговь, Өмнөговь, Хөвсгөл аймаг, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газрууд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бол бусад газрууд 1-9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хугацаа хоцроосон нийт 90 мэдээллээс:

- 68.9 хувь буюу 62 мэдээлэл нь байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл;
- 31.1 хувь буюу 28 мэдээлэл нь нийгмийн даатгалын сангийн мэдээлэл тус тус байна.

Хугацаа хоцроосон мэдээллийг аймаг, дүүрэг, нэр, төрлөөр нь харуулбал:

Хүснэгт-33

Д/д	Шилэн дансны мэдээллийн төрлийн нэр	Мэдээллийн тоо	Нийгмийн даатгалын сан	Байгууллагын үйл ажиллагаа
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-Эдийн засгийн ангилал	13	Баянхонгор, Говь-Алтай, Баян-Өлгий аймаг, Багануур дүүрэг	Баянхонгор, Сэлэнгэ 2, Увс аймаг 2, Багануур, Налайх дүүрэг 3 мэдээлэл
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт	9	Баянхонгор, Говь-Алтай аймаг, Багануур дүүрэг	Баянхонгор, Увс 2, Ховд аймаг, Багануур, Налайх дүүрэг
3	Санхүүгийн тайлан /2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жил/	15	Говьсүмбэр, Сэлэнгэ, Төв 2, Увс аймаг, Баянзүрх, Налайх, Солонгосын НДТасаг 2	Архангай, Завхан, Увс 2, Төв, Сонгинохайрхан дүүрэг
7	Байгууллагын батлагдсан төсөв	13	Говь-Алтай аймаг	Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Төв аймаг, Багануур, Баянгол, Налайх, Чингэлтэй дүүрэг
8	Дараа жилийн төсвийн төсөл	1		Сүхбаатар аймаг
9	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /2024 оны жилийн эцэс/	6	Говь-Алтай, Төв, Увс аймаг, Төв сан	Завхан, Увс аймаг
<b>Төсөв, гүйцэтгэл-57 мэдээлэл</b>				
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	12	Төв сан	Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Завхан, Төв аймаг, Багахангай, Налайх дүүрэг, МТТ
3	Худалдан авах ажиллагааны тайлан /2024 он/	1		Баян-Өлгий аймаг
<b>Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт-13</b>				
1	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	14	Баянзүрх дүүрэг	Баянхонгор, Булган 2, Говьсүмбэр, Сүхбаатар, Төв 3, Хэнтий аймаг, Багахангай, Налайх, Срнигинохайрхан дүүрэг, НДЕГ
2	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	4	Дорнод, Завхан, Хэнтий аймаг	Баянхонгор аймаг
3	Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл**	2	Төв сан	
<b>Бусад-20 мэдээлэл</b>				
<b>Нийт-90 мэдээлэл</b>				

Дээрх хүснэгтээс харахад Нийт 90 хугацаа хоцроож мэдээлсэн мэдээллийн төрлөөр нь авч үзвэл:

- Санхүүгийн тайлан /2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жил/ төрөлд: Хугацаа хоцроосон мэдээллийн 16.7 хувь буюу 15 мэдээлэл
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт төрөлд: Хугацаа хоцроосон мэдээллийн 15.6 хувь буюу 14 мэдээлэл;
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-Эдийн засгийн ангилал төрөлд: Хугацаа хоцроосон мэдээллийн 14.4 хувь буюу 13 мэдээлэл;

- *Байгууллагын батлагдсан төсөв төрөлд*: Хугацаа хоцроосон мэдээллийн 14.4 хувь буюу 13 мэдээлэл;
- *Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө төрөлд*: Хугацаа хоцроосон мэдээллийн 13.3 хувь буюу 12 мэдээлэл;
- *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт төрөлд*: Хугацаа хоцроосон мэдээллийн 10.0 хувь буюу 9 мэдээлэл;
- *Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /2024 оны жилийн эцэс/ төрөлд*: Хугацаа хоцроосон мэдээллийн 6.7 хувь буюу 6 мэдээлэл;
- *Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан төрөлд*: Хугацаа хоцроосон мэдээллийн 4.4 хувь буюу 4 мэдээлэл;
- *Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл төрөлд*: Хугацаа хоцроосон мэдээллийн 2.2 хувь буюу 2 мэдээлэл;
- *Дараа жилийн төсвийн төсөл төрөлд*: Хугацаа хоцроосон мэдээллийн 1.1 хувь буюу 1 мэдээлэл;
- *Худалдан авах ажиллагааны тайлан /2024 он/ төрөлд*: Хугацаа хоцроосон мэдээллийн 1.1 хувь буюу 1 мэдээлэл тус тус байна.

Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын 2025 оны 07/676 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар албан даалгаврыг ирүүлсэн.

Дээрх албан даалгаварт тусгагдсан үүрэг даалгаврыг заалт нэг бүрчлэн биелүүлж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газрын 2025 оны “Албан даалгавар хүргүүлэх тухай” 02/529 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХУ-ний төвийн Нийгмийн даатгалын тасгийн дарга нарт үүрэг болгосон.

Дээрх албан даалгаврын 1 дүгээр улирлын биелэлтийг цахимаар, 2,3,4 дүгээр улирлын биелэлтийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/1719, 02/2670, 2026 оны 02/95 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлсэн.

Мөн байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 571.7 сая төгрөгийн 5 албан шаардлага, 439.3 сая төгрөгийн 6 зөвлөмж авсан Баянгол, Багануур, Налайх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг, Баян-Өлгий, Говьсүмбэр, Төв аймгийн Нийгмийн даатгалын газарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Шилэн дансны мэдээлэл байршуулах тухай” 01/755, 01/757 01/756, 01/760, 01/753, 01/758, 01/754, 01/752 01/759 дүгээр албан бичгийг тус тус хүргүүлэв.

Мөн Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлсэн Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/1583, 02/1682 дугаар албан бичгүүдэд хууль, тогтоомж зөрчсөн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох тухай дурдсан болно.

### ***Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;***

Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын цахим хуудас (ndaatgal.mn)-т нээлттэй мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, хуулийн хугацаанд бодитой байршуулж байгаа эсэх (нээлттэй мэдээллийн ил тод байдал)-д тогтмол хяналт тавьж, улирал бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж байна.

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн ил тод нээлттэй байдалд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээгээр салбарын хэмжээнд байгууллагын цахим хуудасны мэдээлэл нийтэлж байршуулсан байдал Нийгмийн даатгалын ерөнхий газар 94.3 хувь, салбарын хэмжээнд 81.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын мэдээллийн ил, тод нээлттэй байдал 82.4 хувь;
- Хүний нөөц талаар мэдээллийн ил, тод нээлттэй байдал 79.2 хувь;
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил, тод нээлттэй байдал 82.6 хувь;
- Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил, тод нээлттэй байдал 79.8 хувь;
- Бусад мэдээллийн ил, тод нээлттэй байдал 83.1 хувьтай байна.

Мөн мэдээлэл байршуулалтыг Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг үнэлэх 4 шалгуур үзүүлэлт (мэдээллийн хүртээмжтэй байдал, хугацаандаа нийтлэгдсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн тодорхой байдал)-ээр үнэлэхэд Нийгмийн даатгалын ерөнхий газар 92.3 хувь, салбарын хэмжээнд 81.0 хувьтай байна

Хяналт-шинжилгээгээр байгууллагын цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь байршуулж мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн, дутуу мэдээлсэн, мэдээллийг шинэчлээгүй зэрэг алдаа дутагдлаас гадна дараах нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:

- Байгууллагын цахим хуудаст мэдээллийг нийтэлж мэдээлээгүй;
- Байгууллагын цахим хуудаст мэдээлсэн боловч мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгслээр мэдээлээгүй;
- Дутуу мэдээлсэн буюу мэдээллийн бүрэн бүтэн байдал хангалтгүй;
- Нийтэлсэн мэдээллийн эх сурвалж тодорхойгүй буюу мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах мэдээллийг өгөх эх сурвалжийн мэдээлэл байхгүй;
- Тухайн цэст хамааралгүй мэдээлэл байршуулсан;
- Дотооддоо тавих хяналт сул;
- Мэдээлэл байршуулах, шинэчлэх, мэдээлэл өгөх, хяналт тавих ажилтны албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаагүй;
- Мэдээлэл байршуулалтад тавих хяналт, үр дүнг үнэлэх удирдах ажилтны манлайлал хангалтгүй гэх мэт;

Иймд илэрсэн алдаа дутагдалд дүгнэлт хийж, мэдээлэл байршуулах үйл ажиллагааг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах талаарх зөвлөмжийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах тухай” 02/259 дүгээр Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн.

**6.6. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилтын хүрээнд:**

**Төсвийн ерөнхийлөн захирагч /Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/-аас төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;**

Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд/-аас Төсвийн төвлөрүүлэн захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай 2025 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтэд эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийв.

Тус гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 9 зорилтын 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан 1 зорилт, 19 арга хэмжээ;
- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн 2 зорилт, 9 арга хэмжээ;
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн 2 зорилт, 11 арга хэмжээ;
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр 4 зорилт, 30 арга хэмжээ байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг харуулбал:

“Бүрэн хангалттай” буюу 85 буюу түүнээс дээш хувиар (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн) үнэлэгдсэн 62 арга хэмжээ байна. Үүнд:

- 100 хувийн биелэлттэй 43 арга хэмжээ;
- 85-95 хувийн биелэлттэй 19 арга хэмжээ;

“Хангалттай” буюу 70-84.3 хувиар (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах) үнэлэгдсэн 6 арга хэмжээ;

“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” 1 арга хэмжээ байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн явцыг 93.7 хувиар үнэлж, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1464 дугаар албан бичгээр, 2025 оны жилийн эцсийн биелэлтийг 94.8 хувь буюу “Бүрэн хангалттай” гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/3293 дугаар албан бичгээр болон цахимаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлсэн.

**Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас зохион байгуулалтын нэгжийн даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;**

Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас зохион байгуулалтын нэгжийн дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жил болон жилийн эцсийн хэрэгжилт, биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Зохион байгуулалтын нэгжийн дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 228 арга хэмжээг тусгаж, нэмэлт 14 ажил үйлчилгээг хэрэгжүүлсэн байна.

Зохион байгуулалтын нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг харуулбал:

Хүснэгт-34

№	Газрын нэр	Арга хэмжээний тоо	Нэмэлт арга хэмжээ	Гүйцэтгэлийн хувь	
				Эхний хагас жил	Жилийн эцэс
1	Дотоод аудит, мониторингийн газар	23	14	89.8	92.1
2	Захиргаа, удирдлагын газар	46		89.7	92.6
3	Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар	28		91.1	92.8
4	Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар	15		88.1	94.7
5	Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар	18		88.4	83.9
6	Шимтгэл хураалтын удирдлага, арга зүйн газар	33		88.0	82.0
7	Хяналт шалгалтын газар	23		88.0	89.6
8	Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл	33		90.9	94.7
9	Мэдээллийн технологийн төв	9		89.9	89.4
Нийт үнэлгээний дундаж				<b>89.3</b>	<b>90.2</b>

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээгээр 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцын дунджийг 89.3 хувиар, 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дунджийг 90.2 хувиар буюу “Бүрэн хангалттай” гэж дүгнэж удирдлагад танилцуулан дүнг, үнэлгээний тайлангийн хамт Захиргаа, удирдлагын газарт хүргүүлэв.

**Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас зохион байгуулалтын нэгжийн даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;**

Төсвийн төвлөрүүлэн захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас Төсвийн шууд захирагч /Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга/-тай 2025 онд байгуулсан

гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 9 зорилт 46-50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд эхний хагас жил болон жилийн эцсийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг эрхлэх асуудлын хүрээнд зохион байгуулалтын нэгж тус бүрээр харуулбал:

Хүснэгт-35

№	Нэгжийн нэр	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн хувь	
			Эхний хагас жил	Жилийн эцэс
1	Дотоод аудит, мониторингийн газар	2	84.4	88.5
2	Захиргаа, удирдлагын газар	11	87.9	90.4
3	Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар	5	87.2	87.0
4	Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар	3	92	87.4
5	Шимтгэл хураалтын удирдлага, арга зүйн газар	5	85.6	85.3
6	Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар	10	93.8	90.9
7	Хяналт шалгалтын газар	7	82.1	47.2
8	Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл	4	84.6	81.9
9	Мэдээллийн технологийн төв	3	89.6	93.4
Нийт дундаж үнэлгээ		50	87.4	83.5

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний 2025 оны эхний хагас жил болон жилийн эцсийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг аймаг, дүүргээр нь харуулбал:

Хүснэгт-36

№	Нэгжийн нэр	Гүйцэтгэлийн хувь	
		Эхний хагас жил	Жилийн эцэс
1	Архангай аймгийн Нийгмийн даатгалын газар	85.8	83.1
2	Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын газар	87.8	86.8
3	Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газар	84.9	82.1
4	Булган аймгийн Нийгмийн даатгалын газар	85.5	82.0
5	Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын газар	88.5	84.2
6	Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газар	86.4	80.3
7	Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газар	89.9	85.6
8	Дорнод аймгийн Нийгмийн даатгалын газар	88.4	84.9
9	Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын газар	89.0	84.5
10	Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газар	89.0	85.0
11	Завхан аймгийн Нийгмийн даатгалын газар	84.9	84.5
12	Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар	90.3	86.7
13	Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын газар	88.5	85.5
14	Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын газар	87.5	84.6
15	Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын газар	88.1	85.6
16	Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газар	86.0	83.3
17	Төв аймгийн Нийгмийн даатгалын газар	87.4	81.3
18	Увс аймгийн Нийгмийн даатгалын газар	86.7	85.7
19	Ховд аймгийн Нийгмийн даатгалын газар	86.7	85.7
20	Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар	87.9	83.2
21	Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газар	86.3	81.4
22	Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газар	87.1	83.2
23	Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газар	87.3	82.7

24	Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газар	86.1	78.2
25	Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар	89.3	81.8
26	Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газар	89.5	81.5
27	Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар	88.6	83.1
28	Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газар	87.8	83.0
29	Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар	83.7	80.4
30	Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газар	88.6	86.4
Дундаж үнэлгээ		<b>87.5</b>	<b>83.5</b>

Хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг нэгтгэлээр харуулбал (2025 оны жилийн эцсийн байдлаар):

- 85.0-86.8 оноо буюу “Бүрэн хангалттай” үнэлэгдсэн 1 дүүрэг, 8 аймгийн Нийгмийн даатгалын газар;
- 78.2-84.9 оноо буюу “Хангалттай” үнэлэгдсэн 8 дүүрэг, 13 аймгийн Нийгмийн даатгалын газар байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг харуулбал:

**“Бүрэн хангалттай”** (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн) үнэлэгдсэн 30 арга хэмжээ;

- 100 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ;
- 90.0-98.0 хувийн хэрэгжилттэй 15 арга хэмжээ;
- 86.2-88.9 хувийн хэрэгжилттэй 11 арга хэмжээ;

**“Хангалттай”** (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах) үнэлэгдсэн 14 арга хэмжээ;

- 81.0-84.7 хувийн хэрэгжилттэй 10 арга хэмжээ;
- 76.3-79.0 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ;

**“Хангалтгүй”** (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон) буюу хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагаа, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай 6 арга хэмжээ;

- 55.3-63.7 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ;
- 37.3-44.9 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ;
- 10.6 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаас аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нартай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн дунджийг эхний хагас жилийн байдлаар 87.4 хувь буюу “Бүрэн хангалттай” гэж үнэлж, Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/2328 дугаар албан бичгээр, нэгдсэн тайланг Захиргаа, удирдлагын газарт, жилийн эцсийн биелэлтийн дунджийг **83.5** хувь буюу **“Хангалттай”** гэж үнэлж, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, үнэлгээний хуудсыг Захиргаа удирдлагын газарт тус тус хүргүүлсэн.

**6.7. Салбарын үйл ажиллагааг үр дүнтэй байлгах чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран ажиллах:**

**Цэргийн байгууллагаас тэтгэвэр тогтоолгох алба хаагчдын ажилласан жилийн талаарх тушаал шийдвэрийн лавлагаа, тооцоолол, мэдээллийг цахимаар солилцох ажлыг зохион байгуулах үүрэг бүхий хамтарсан Ажлын хэсгийг байгуулах;**

Төрийн байгууллагад байгаа мэдээллийг цахимаар солилцох, тэтгэвэр тогтоолгох иргэнээс баримт бичиг шаардахгүйгээр цахимжуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллах, алба хаагчдын ажилласан жилийн талаарх тушаал шийдвэр, цалингийн тооцоо мэдээллийг цахимаар солилцох үүрэг бүхий ажлын хэсгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын хамтарсан 2025 оны А/111-А/121 дүгээр тушаалаар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан 2025 оны А/142-А/208 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын хамтарсан 2025 оны А/193-А/390 дүгээр тушаалаар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын даргын хамтарсан 2025 оны А/194-А/281 дүгээр тушаалаар тус тус хамтарсан ажлын хэсгийг байгуулж, уулзалт зохион байгуулж, хууль эрх зүй, программ хангамжийн түвшинд хийгдэх ажлуудын талаар ярилцан бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байна.

Мөн Төрийн тусгай хамгаалалтын газарт тушаалын төслийг хүргүүлсэн боловч хариу ирээгүй, Шүүх шинжилгээний ерөнхий газар хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллах түвшинд программ хангамж нэвтрээгүй талаар хариуг ирүүлсэн байна.

### ***Шилэн дансны цахим хуудас (Shilen.dans.gov.mn)-т Нийгмийн даатгалын сангийн 2 төрлийн мэдээллийг автоматаар оруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;***

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулах, албан хаагчдын ажлын ачааллыг бууруулах, тэнцвэржүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/168 дугаар тушаалаар робот процессын автоматжуулалтыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж Нийгмийн даатгалын ерөнхий газар, “Би Пи Солюшн” ХХК-тай 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдөр 2025/0701 дугаар Ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.

Шилэн дансны цахим хуудас (Shilen.dans.gov.mn)-т Нийгмийн даатгалын сангийн “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ”, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” төрөлд байршуулах мэдээллийг автоматжуулж, мэдээлэл оруулах үйл ажиллагааг 2025 оны 12 душаар сарын 18-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж нэвтрүүлэв.

### ***Ажил олгогч, даатгуулагч, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт болон бусад байгуулагаас ирүүлсэн хугацаатай албан бичгийг хуульд заасан хугацаанд хариуг хүргүүлэх, зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах;***

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага болон ажил олгогч, харилцагч бусад байгууллагаас тус газарт хандаж 473 албан бичиг ирснээс 130 албан бичиг нь хариутай, иргэд, даатгуулагчаас 36 өргөдөл, гомдол ирүүлсэн ба 717 албан бичгийг бусад газруудад хүргүүлсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хоног 12.7 байна.

#### ***6.8. Төсөө санхүүгийн үйл ажиллагаа***

Тус газар нь эрхэлсэн ажлын хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ болон аудитыг хийж гүйцэтгэсэн ба 21 аймгийн холбогдох тайлан мэдээ, санхүүгийн баримтыг цахимаар авч ажилласан.

Мөн Орхон аймгийн Нийгмийн даатгалын газарт Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн зардал, Сэлэнгэ, Завхан аймгийн Нийгмийн даатгалын газрын санхүү, үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн бөгөөд томилолтын зардалд 4.0 сая төгрөгийг зарцуулсан.

Нэгжийн албан хаагчийн ажлын ачаалал их орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

#### ***5.9. Бусад мэдээлэл***

### ***Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй удирдлагаас өгсөн нэмэлт үүрэг даалгавраар өгөгдсөн биелээгүй ажил үйлчилгээ:***

**Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын даргын 2024 онд гаргасан тушаалын үндэслэлд хяналт-шинжилгээ хийх;**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Хяналт-шинжилгээний ажил зохион байгуулах тухай” А/68 дугаар тушаалаар 2024 онд гаргасан захиргааны акт (А болон Б тушаал)-д хяналт-шинжилгээ хийх 02/02 дугаар удирдамж, хяналт-шинжилгээ хийх “Ажлын төлөвлөгөө”, “Ажил үүргийн хуваарь”-ийг батлуулав.

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 онд гаргасан тушаал, шийдвэрийг дараах, асуудлын хүрээнд нягтлан шалгана. Үүнд:

- Захиргааны актын үндэслэл болгож буй заалт нь холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх;
- Захиргааны акт нь Засгийн газрын шийдвэр болон эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, стандарттай нийцэж байгаа эсэх.

Дээрх тушаалаар баталсан удирдамжийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2024 оны 02/650 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн.

Удирдамжид заасны дагуу аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас холбогдох баримт бичгийг гаргуулан авсан.

**6.10. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн үүрэг, нэгжийн дотоод ажил үүрэг****Эрсдлийн үнэлгээ хийх журам боловсруулж батлуулах;**

Нийгмийн даатгалын байгууллагын зорилго, үндсэн чиглэл, үйл ажиллагаа, эрсдэл, стратеги зорилттой уялдуулан “Эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын төслийг боловсруулсан.

Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2025 оны 03 дугаар тогтоолоор “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын удирдлагын бодлого”, “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар”, “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал”-ыг баталсан.

Дээрх төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг үндэслэн салбарын онцлогт нийцүүлэн өөрчлөх шаардлага үүссэн тул Нийгмийн даатгалын байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх журмыг холбогдох өөрчлөлтийг хийн 2026 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахаар бэлтгэж байна.

**Нийгмийн даатгалын ерөнхий газар /ndaatgal.mn/-ын цахим хуудсанд байрших нээлттэй мэдээллийг байршуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;**

Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай” А/20 дугаар тушаалыг баталсан бөгөөд тушаалаар байршуулах мэдээллийн жагсаалт, мэдээлэл байршуулах нэгж, хугацаа, хуваарь зэргийг баталсан.

Уг тушаалаар тус газар нь Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3-д заасан Байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Дотоод аудитын тайлан, Санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, Шилэн дансны хөтлөлт, акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Нийгмийн даатгалын байгууллагын цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй.

Тушаалын дагуу тус газраас байгууллагын цахим хуудаст Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/-аас төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсыг (2021-2025) хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд

хийсэн хяналт-шинжилгээний тайлан, Шилэн дансны хөтлөлтийн тайлан, Дотоод аудит, мониторингийн газраас хийж хэрэгжүүлсэн аудит, хяналт шинжилгээний тайлан зэрэг нийт 14,368 kb хэмжээтэй 20 мэдээллийг гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулж мэдээлэхээр Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газарт хүргүүлж мэдээлсэн.

***Нийгмийн даатгалын байгууллагаас 2026 онд өндөр насны тэтгэвэрт гарах албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмжийн тооцоололд мониторинг хийх;***

2026 оны төсвийн төслийн саналд тусгах төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн зөв тооцсон эсэхэд хяналт-шинжилгээ хийж, тооцооллыг шалгах, гаргасан алдаа дутагдал, илэрсэн зөрчлийг арилгуулах, үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж өгөх, удирдлагыг бодит мэдээллээр хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2026 оны төсвийн төслийн саналд тусгах төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламжийн тооцооллыг холбогдох баримт бичгийг үндэслэн тулган шалгав.

Хяналт-шинжилгээг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаа, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох дундаж цалин хөлсийг зөв тооцсон эсэх;
- Нийт олгох тусламжийн хэмжээг зөв тодорхойлсон эсэх;

Хяналт-шинжилгээгээр 27 албан хаагчид 928.6 сая төгрөгийн өндөр насны тэтгэвэр гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тооцооллыг хийж Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.

Хяналт-шинжилгээгээр илэрсэн зөрчил, алдаа дутагдал, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж удирдлагад танилцуулсан.

***Нийгмийн даатгалын мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох байцаагч, албан хаагчдын нэрсийн жагсаалтад хяналт тавьж, дүн шинжилгээ хийж нэрсийн жагсаалтыг холбогдох газарт хүргүүлэх;***

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны “Журам батлах тухай” А/137 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журам”-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт ажиллаж байгаа нийгмийн даатгалын улсын байцаагчдын нэрсийн жагсаалтад 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 13-ны өдрүүдэд хяналт-шинжилгээ хийв.

Захиргаа удирдлагын газраас тэргүүлэх мэргэшлийн зэрэг олгох 48, зөвлөх мэргэшлийн зэрэг олгох 58, зөвлөх мэргэшлийн зэрэг олгох 237 нийт 343 байцаагчийн нэрсийн жагсаалт ирүүлсэн ба мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур хангасан эсэхийг Нийгмийн даатгалын байцаагчаар ажилласан хугацааны нотлох баримт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ, ёс зүйн зөрчил, сахилгын шийтгэлтэй эсэх зэрэг холбогдох баримт бичигтэй тулган нягтлав.

Тус хяналтаар ажилласан жил хүрээгүй, улсын байцаагчийн эрхгүй, өндөр насны тэтгэвэрт гарсан, улсын байцаагчийн 2 удаагийн шалгалтад ороогүй зэрэг шалтгаантай 19 ажилтан байсан ба мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох албан хаагчийн болон хасагдах албан хаагчийн нэрс, тайлбарын хамт жагсаалтын хамт гаргаж Захиргаа удирдлагын газарт хүргүүлсэн.

***Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын төв орон нутгийн байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт;***

Үндэсний аудитын газраас нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг улирал бүр нэгтгэв.

Алдаа, зөрчлийн дүнг харуулбал;

/Мян.төг/ Хүснэгт-37

		Нийгмийн даатгалын сан	Байгууллага	Нийт
Нийт зөрчлийн дүн	Тоо	84	127	214
	Дүн	3,869,293.4	4,241.5	3,864,110.4
Алдаа /залруулга/	Тоо	27	30	57
	Дүн	2,799,932.7	918.2	2,800,850.8
Төлбөрийн акт	Тоо	1	10	11
	Дүн	0.7	50.7	51.4
Албан шаардлага	Тоо	20	36	55
	Дүн	889,821.2	2,200.1	891,977.8
Зөвлөмж	Тоо	35	51	90
	Дүн	170,114.4	1,072.5	171,230.4
Хариуцлага тооцуулах албан шаардлага	Тоо	1	0	1
	Дүн	9,424.4	-	9,424.4

Тус аудитын дүгнэлтээр салбарын хэмжээнд нийт 3,864,110.4 сая төгрөгийн төлбөр, зөрчил илэрснээс:

- Санхүүгийн тайланд 2,800,850.8 сая төгрөгийн залруулга;
- 51.4 сая төгрөгийн 11 акт;
- 891,977.8 сая төгрөгийн 55 албан шаардлага;
- 171,230.4 сая төгрөгийн 90 зөвлөмжийг ирүүлсэн байна.

Байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгийн нэгтгэлээр:

- Өөрчлөлтгүй 46;
- Хязгаарлалттай 5;
- Дүгнэлт өгөхөөс татгалзсан 1;

*Дээрх илэрсэн зөрчлийн барагдуулалтыг дараах байдлаар харуулбал:*

(Хувиар) Хүснэгт-38

	Нийгмийн даатгалын сан	Байгууллага	Биелэлт
Алдаа /залруулга/	100	96.7	98.4
Төлбөрийн акт	100	100	100
Албан шаардлага	61.4	100	80.7
Зөвлөмж	89.7	96.1	92.9
Нийт дундаж	<b>87.8</b>	<b>98.2</b>	<b>93.0</b>

Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын ерөнхий газар, түүний харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангийн нэгтгэл, аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Аудитын акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” А/75 дугаар тушаалыг батлуулж, Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/ 672 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлэв.

Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолын дагуу 2024 оны байгууллагын санхүүгийн аудитын тайлангаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг нотлох баримт бичгийн хамт

ирүүлэх тухай Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/675 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нэгтгэн Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 02/1679 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд, мөн 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нэгтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдөр 01/2014 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газарт тус тус хүргүүлэв.

### **ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

*6.11. Иргэдээс Нийгмийн даатгалын байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын агуулга, бүтэц, чиг хандлага, шийдвэрлэлтийн чанар байдал, өргөдөл гомдолд тусгагдсан асуудлуудад хяналт- шинжилгээ хийх;*

Нийгмийн даатгалын ерөнхий газарт 1,3 дугаар улирал, дүүргийн Нийгмийн даатгалын газар, албан тушаалтанд 2025 оны 1 дүгээр улиралд, аймгийн Нийгмийн даатгалын газар, албан тушаалтанд 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 3 дугаар улиралд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэл, түүнд ашиглаж байгаа программ, өргөдөл, гомдлын агуулга, шийдвэрлэлтийн байдал, өргөдөл гомдолд тусгагдсан асуудлуудад судалгаа хийх, үр дүнг тооцох, шийдвэрлэлтийн үйл ажиллагаа, дээд газарт хүргүүлж байгаа өргөдөл гомдлын мэдээ зэрэгт 2 удаа хяналт-шинжилгээ хийв.

#### **Өргөдөл, гомдлын бүртгэл, түүнд ашиглаж байгаа программын ашиглалт:**

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд өргөдөл, гомдлын бүртгэлд Able, ERP, E-Doc, E-office зэрэг 1-3 программ хангамжийг ашиглаж байгаа хэдий ч программаас холбогдох мэдээ, мэдээллийг гаргаж мэдэхгүй, программын ашиглалтын талаарх мэдээлэл дутмаг хэвээр байгаа ба Булган, Говьсүмбэр, Дорноговь, Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын газрууд өргөдөл гомдлыг программ ашиглахгүй, өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэрт бүртгэж байна.

Нийгмийн даатгалын байгууллагад 2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 11,118 өргөдөл ирснээс:

- Албан хаагчаас 862;
- Иргэдээс 10,256 өргөдөл гомдол ирсэн байна.

Нийт ирүүлсэн өргөдлийн 74.93 хувь буюу 7,618 нь Нийгмийн даатгалын ерөнхий газар, Засгийн газрын олон нийттэй харилцах газрын 11-11 төв, дүүргийн Нийгмийн даатгалын газарт, 25.07 хувь буюу 2,571 нь аймгийн Нийгмийн даатгалын газарт ирүүлсэн байна.

Шинжилгээг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Өргөдөл гомдлын бүртгэл, түүнд ашиглаж байгаа программын ашиглалт;
- Өргөдөл, гомдлын жил, улирлын мэдээний чанар;
- Бүртгэлд өргөдөл гомдлын утга, агуулгыг бүртгэсэн байдал, чиг хандлага;
- Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн үйл ажиллагаа, бүртгэлд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг бүртгэсэн байдал, шийдвэрлэлт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэх;
- Нийгмийн даатгалын байгууллагаас өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар хийж хэрэгжүүлсэн ажил;

Хяналт-шинжилгээнд иргэдээс Нийгмийн даатгалын ерөнхий газар болон аймгийн Нийгмийн даатгалын газруудад 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуусталх хугацаанд ирүүлсэн 3,089 өргөдөл, гомдлын дүн мэдээг хамруулсан.

Дүн шинжилгээнд хамрагдсан өргөдөл гомдлын тоон мэдээллийг аймаг, дүүргээр нь харуулбал:

Хүснэгт-39

№	Аймаг, дүүргийн нэр	Ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэсэн	Хяналтад байгаа	Шийдвэрлэлтийн хувь	Нийт өргөдөлд эзлэх хувь	Нийт өргөдлөөс		Хариу өгсөн	Дундаж хоног	Хугацаа сунгасан	
							Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд	ЭММЗөвлөлд			Тоо	Хоног
1	Нийгмийн даатгалын ерөнхий газар	518	515	3	99.4	16.8	85	51	8,573	17	160	1,067
2	Архангай	184	183	1	99.5	6.0	110	1	2,649	14		
3	Баян-Өлгий	46	45	1	97.8	1.5	18	0	1,302	28	11	540
4	Баянхонгор	286	285	1	99.7	9.3	59	15	1,381	5		
5	Булган	191	175	16	91.6	6.2	26	0	2,829	15		
6	Говь-Алтай	31	31	0	100	1.0	6	0	304	10	1	13
7	Говьсүмбэр	23	20	3	87.0	0.7	1	0	119	5	1	30
8	Дархан-Уул	58	58		100	1.9	7	0	528	9	4	58
9	Дорнод	20	20		100	0.6	5	0	627	31	13	237
10	Дорноговь	146	146		100	4.7	32	0	1,198	8	2	120
11	Дундговь	65	65		100	2.1	50	1	858	13	2	60
12	Завхан	91	91		100	2.9	22	0	1,403	15	3	90
13	Орхон	215	215		100	7.0	7	0	2,443	11		32
14	Өвөрхангай	32	32		100	1.0	13	0	290	9	1	30
15	Өмнөговь	33	33		100	1.1	15	0	609	18	4	10
16	Сүхбаатар	165	165		100	5.3	58	0	2,861	17	99	1,586
17	Сэлэнгэ	161	147	14	91.3	5.2	3	11	1,887	12		
18	Төв	138	138		100	4.5	36	1	2,082	15	13	136
19	Увс	222	222		100	7.2	69	0	4,234	19	8	240
20	Ховд	110	105	5	95.5	3.6	56	3	2,541	23	12	248
21	Хэнтий	78	76	2	97.4	2.5	0	0	1,993	26		
22	Хөвсгөл	276	276		100	8.9	113	0	3,818	14	3	90
		<b>3,089</b>	<b>3,043</b>	<b>46</b>	<b>98.1</b>	<b>100</b>	<b>791</b>	<b>83</b>	<b>44,529</b>	<b>14</b>	<b>337</b>	<b>4,587</b>

Хяналт-шинжилгээнд хамрагдсан нийт 3,089 өргөдөл, гомдлоос:

- 16.8 хувь буюу 518 нь Нийгмийн даатгалын ерөнхий газар;
- 9.3 хувь буюу 286 нь Баянхонгор аймаг;
- 8.9 хувь буюу 276 нь Хөвсгөл аймаг;
- 7.2 хувь буюу 222 нь Увс аймаг;
- 7.0 хувь буюу 215 нь Орхон аймаг;
- 0.7-6.2 буюу 1,572 нь бусад аймгийн Нийгмийн даатгалын газарт ирүүлжээ.

Нийт 3,089 өргөдөл, гомдлоос 3,043 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 46 өргөдлийг шийдвэрлээгүй, шийдвэрлэлт 98.1 хувьтай байгаагаас Нийгмийн даатгалын ерөнхий газарт 3, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор аймагт тус бүр 1, Булган аймагт 16, Говьсүмбэр аймагт, 3, Сэлэнгэ аймагт 14, Ховд аймагт 5, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газарт 2 өргөдөл шийдвэрлэгдээгүй байна.

Нийт өргөдлийн 25.6 хувь буюу 791 нь Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд, 2.7 хувь буюу 83 нь Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдол байна.

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэлд бүртгээгүй байна.

Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн талаарх ирүүлсэн тоон мэдээ, мэдээллээс үзэхэд өргөдөл гомдол хариуцсан албан хаагчид өргөдөл, гомдлын тэргүү, товч утга, өргөдөл ирүүлэх болсон шалтгаан зэргийг зөв бүртгэдэггүй, шийдвэрлэлтийн байдалд болон бичиг хэрэг,

дотоод ажил хариуцсан ажилтнуудын хийж гүйцэтгэж байгаа үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй, мэргэшил, арга зүйгээр хангадаггүй, судалгааг үнэн зөв гаргадаггүй зэрэг алдаа хэвээр байгаа нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд тухайн байгууллагын эрх баригч болон эрх бүхий албан тушаалтан хяналт тавина" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйг харуулж байна.

Хяналт-шинжилгээгээр илэрсэн алдаа дутагдал, зөрчил, дүгнэлтийг гаргаж, цаашид авах арга хэмжээний саналыг удирдлагад танилцуулж хяналт-шинжилгээний дүн мэдээ, тайланг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/1216 дугаар албан бичгээр, 3 дугаар улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээний тайланг цахимаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

Мөн хяналт-шинжилгээгээр илэрсэн зөрчилд үндэслэн зөвлөмжийг Дотоод аудит, мониторингийн газрын 2025 оны "Зөвлөмж хүргүүлэх тухай" 02/1650 дугаар албан бичгээр зохион байгуулалтын нэгжийн болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн.

***Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх;***

Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 39 дүгээр тэмдэглэл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 1/2207 дугаар албан бичгийг үндэслэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээг дараах чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хуулиар тусгайлан эрх олгосон хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэх;
- Хавсралтаар баталсан журмын доторх үндэслэл болгож эшлэл хийсэн заалтууд болон бусад зохицуулалтууд нь шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх;
- Бүртгэлтэй шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болгосон шийдвэрээ тухай бүр ирүүлж санд холбогдох хөдөлгөөн хийсэн эсэх;
- Захиргааны хэм хэмжээний актын шинжийг агуулаагүй, дотоод зохион байгуулалт, зохицуулалтын шинжтэй эсхүл ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй болсон шийдвэр байгаа бол хүчингүй болгон сангаас хасуулах арга хэмжээ авсан эсэх;
- Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй шийдвэр байгаа бол хуульд нийцүүлэн бүртгүүлэх арга хэмжээг авах;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 5 захиргааны хэм хэмжээний акт байгаа бөгөөд хэрэгжилтийн явцыг 100 хувь буюу холбогдох шийдвэр нь тавьсан зорилгодоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан "Бүрэн хэрэгжсэн" гэж үнэлж хяналт-шинжилгээний үр дүн, танилцуулга, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг удирдлагад танилцуулж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1263 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

***Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төв 11-11 утсанд ирүүлсэн өргөдөл, гомдол, саналын мэдээллийн бүртгэл, шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ хийх;***

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны "Тайлан авах тухай" 09/1384 дүгээр албан бичигт "Иргэдээс ирүүлсэн нийт өргөдөл, гомдол, хүсэлтийн 20 хувьд улирал бүр хяналт-шинжилгээ хийх" гэж заасны дагуу 2025 оны 02 дугаар улиралд Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвийн 11-11 дуудлагын утсанд ирүүлсэн Нийгмийн даатгалын

байгууллагын чиг үүрэгт хамааралтай иргэд, ажил олгогчоос ирүүлсэн өргөдөл, гомдол, саналын мэдээлэл, бүртгэлд хяналт-шинжилгээ хийж гүйцэтгэв.

Иргэд, олон нийттэй харилцах төвийн 11-11 дуудлагын “Нийгмийн даатгал” цэсээр 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 06 дугаар 06-ны өдрийг дуусталх хугацаанд Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамааралтай иргэдээс нийт 2,013 санал, гомдол, шүүмжлэл, лавлагаа, хүсэлт ирүүлсэн байна.

Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвийн 11-11 дуудлагын утсанд ирсэн гомдол, хүсэлтийн:

- 29.0 хувь буюу 578 нь аймгийн Нийгмийн даатгалын газарт;
- 50.5 хувь буюу 1,007 нь дүүргийн Нийгмийн даатгалын газарт;
- 20.5 хувь буюу 408 нь хаяг тодорхой бус байна.

Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газраас 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар тоон мэдээ, судалгааг 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр ирүүлсэн тул шийдвэрлэгдээгүй гомдол, хүсэл байхгүй бөгөөд ирүүлсэн судалгаа нь олон удаа буцсан, өргөдөл, гомдлын товч утга, шийдвэрлэсэн байдлыг бичиж ирүүлээгүй, өргөдлийн хаасан утга зөрүүтэй зэрэг алдаа, дутагдал байна.

Мөн Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвийн 11-11 дугаарт ирүүлсэн гомдол, санал, хүсэлтийн бүртгэл, шийдвэрлэлтийн талаарх ирүүлсэн мэдээллээс үзэхэд дараах нийтлэг алдаа байна. Үүнд:

- Иргэд олон нийттэй харилцах төвөөс нийгмийн даатгалын чиг үүрэгт хамааралгүй гомдол мэдээллийг шилжүүлсэн;
- Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газраас мэдээ, судалгааг хугацаанд нь ирүүлээгүй, судалгааг үнэн зөв, бүрэн гаргаж өгөөгүй;
- Мэдээ, судалгааг тайлант хугацаагаар тасалбар болгон ирүүлээгүй;
- Ирүүлсэн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжгүй, маягтад дурдсан мэдээллийг ирүүлэхгүй байх, дутуу ирүүлэх, ирүүлсэн мэдээллийг буцааж засварлуулах зэргээр хугацаа их шаардагдсан;
- Өргөдлийн тэргүү, шийдвэрлэсэн байдлыг тодорхой бичээгүй буюу программд оруулсан утга хангалтгүй, ойлгомжгүй, тодорхой бус байдлаар оруулсан;
- Тухайн асуудал шийдвэрлэгдсэн эсэх нь тодорхой бус байхад өргөдлийг хаасан;
- Харьяа байгууллагад шилжүүлсэн өргөдлийн хариуд хяналт тавиагүй зэрэг болно.

Хяналт-шинжилгээний дүн мэдээ, тайлан, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг удирдлагад танилцуулан Дотоод аудит, мониторингийн газрын 2025 оны 02/1680 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

***Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх;***

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийв.

Албан даалгавар нь 4 хэсэг, 26 заалтаас бүрдэж байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх, удирдлага болон албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах хүрээнд 5 заалт;
- Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт, бусад хууль тсгтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах хүрээнд 10 заалт;
- Дотоод хяналтыг сайжруулах, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах хүрээнд 8 заалт;
- Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах хүрээнд 3 заалт;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр албан даалгаврын 23 заалтын 9 (39.1 хувь) нь “бүрэн хэрэгжсэн”, 9 (39.1 хувь) нь “хэрэгжих шатанд”, 5 (21.7 хувь) нь “хэрэгжилт хангалтгүй”-гээр тус тус дүгнэгдэж, биелэлт дунджаар 74.4 хувь буюу “Хэрэгжсэн” гэж үнэлж дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан Газрын даргын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралд танилцуулав.

***Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/277 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, биелэлтэд хийсэн судалгаа, хяналт-шинжилгээ хийж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэх;***

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Мэдээлэл ирүүлэх тухай” ХЭГ/2738 дугаар албан бичгийн дагуу Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх нийтлэг журам”-д зааснаар салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, 2025 онд гарсан Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтэд 2025 оны 10 дугаар сарын 21-ны өдрөөр нэгтгэсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ хийв.

Хяналт-шинжилгээг дараах чиглэлийн дагуу ажиллав. Үүнд:

- Давхардал, хийдэл байгаа эсэх;
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар;
- Алдаа дутагдал, зөрчил байгаа эсэх;
- Санал, дүгнэлт боловсруулах;
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн бүртгэл, хэрэгжилт, биелэлтийг гаргахад анхаарах асуудал;

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны эхний 10 сарын байдлаар Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавар зэрэг нийт 21 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 44 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг хянах, алдаа дутагдлыг сайжруулах талаар санал боловсруулах, үнэлэх ажлыг зохион байгуулсан ба хяналтад авсан заалтаас хэрэгжилтийг оны эхний 10 сарын байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад авсан 21 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 47 заалтын хэрэгжилт, биелэлтийг оны эхний 10 сарын байдлаар 37 (78.7 хувь) нь “хэрэгжсэн”, 3 (6.4 хувь) нь “Хэрэгжээгүй”, 7 (14.9 хувь) нь “Хугацаа болоогүй”-гээр тус тус дүгнэж, биелэлт (дунджаар) 89.9 хувиар үнэлж, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/2959 дүгээр албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Хяналт-шинжилгээгээр илэрсэн алдаа дутагдалд үндэслэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Үүрэг даалгавар хэрэгжүүлж ажиллах тухай” 01/3075 дугаар албан бичгээр Зохион байгуулалтын нэгжийн болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХҮТ-ийн нийгмийн даатгалын тасгийн дарга нарт хүргүүлэв.

***Удирдамжийн дагуу Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт ажиллах;***

Захиргаа удирдлагын газрын даргын 2025 оны “Шалгалтын удирдамж”-ийн дагуу Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт 2025 оны 06 дугаар сарын 03,04-ний өдрүүдэд тус газрын албан хаагчаас ирүүлсэн өргөдөл, гомдолд дурдсан асуудлын үндэслэлийг шалгав.

Шалгалтыг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Гомдол мэдээлэлд дурдагдсан асуудалтай холбоотой шаардлагатай баримт, тайлбарыг гаргуулан авч судлах;
- Орон тоо, томилгоо, төрийн албан хаагчийн хувийн хэргийн хөтлөлт, ажлын цагийн ашиглалт, газрын даргын тушаал шийдвэр, газрын дотоод зохион байгуулалттай танилцах;

- Албан хаагчидтай уулзаж ярилцах;
- Газар, хэлтсийн даргаас гомдолд дурдсан асуудлаар тайлбар, тодруулга авах;
- Албан хаагчдаас асуумж судалгаа авах;
- Шалгалтын явц, үр дүнг фото зураг, дуу, дүрсээр баталгаажуулах зэрэг болно.

Шалгалтын дүн мэдээ, тайланг удирдлагад танилцуулав.

***“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын хэрэгжилт, 2026 онд олгох мөнгөн урамшууллын тооцооллыг хянах:***

2026 оны төсвийн төслийн саналд тусгах төрийн захиргааны албан хаагчид олгох мөнгөн урамшуулал тооцох дундаж цалин хөлс, төрийн албанд болон төрийн захиргааны албан тушаалд ажилласан жил, нийт олгох тусламж, урамшууллыг зөв тооцсон эсэхэд хяналт-шинжилгээ хийж, тооцооллыг шалгах, гаргасан алдаа дутагдал, илэрсэн зөрчлийг арилгуулах, үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж өгөх, удирдлагыг бодит мэдээллээр хангах зорилгоор аймаг, сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2026 оны төсвийн төслийн саналд тусгах төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшууллын тооцооллыг холбогдох баримт бичгийг үндэслэн тулган шалгав.

Хяналт-шинжилгээг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Төрийн захиргааны албан тушаалд ажилласан хугацаа, мөнгөн урамшуулал олгох дундаж цалин хөлсийг зөв тооцсон эсэх;
- Нийт олгох тусламжийн хэмжээг зөв тодорхойлсон эсэх;

Хяналт-шинжилгээгээр 11 албан хаагчид олгох 95.5 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг хасаж 25 албан хаагчид 222.6 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгох тооцооллыг хийж Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.

Хяналт-шинжилгээгээр илэрсэн зөрчил, алдаа дутагдал, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж удирдлагад танилцуулсан.

***Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх сэргээх, эрх баталгаажуулах шалгалтад орох байцаагч, ажилтнуудын нэрсийн жагсаалтад мониторинг хийх, сорилын сан бүрдүүлэх, шинэчлэн боловсруулах, хянах, сургалт зохион байгуулах, шалгалтын бүрэлдэхүүнд ажиллах;***

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс 12 дугаар сарын 11-ний өдрүүдэд зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд Захиргаа удирдлагын газраас ирүүлсэн нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалтад орох нийт 521 албан хаагчдын нэрсийн жагсаалтад Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын журам”-д заасан нөхцөл, шалгуурыг хангасан эсэхийг холбогдох, баримт бичигтэй тулган нягталж, улсын байцаагчийн эрх шинээр олгох, баталгаажуулах, сэргээх болон журмын 2.4-д заасан нөхцөл шалгуурыг хангасан шалгалтад орох 477 албан хаагч, шалгуур хангаагүй 44 албан хаагчдын нэрсийн жагсаалтыг гаргаж Ажлын хэсэгт хүргүүлсэн.

Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай” А/304 дүгээр тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай нууц хадгалах гэрээг Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх сэргээх, эрх баталгаажуулах шалгалтын сорилын сан бүрдүүлэх, шинэчлэн боловсруулах, хянах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж ажлын хэсгээс ирүүлсэн 6 хуулийн хүрээнд ерөнхий мэдлэг шалгах 180 сорил, 80 онол арга зүйн бодлогыг шинэчлэн боловсруулан хянаж нягталж ажлын хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хүргүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шалгалтын хуудасны загвар батлах тухай”, А/303 дүгээр тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын

Захиргаа удирдлагын газрын даргын баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх сургалтын хөтөлбөр”-т заасан Монгол Улсын Үндсэн хууль Аудитын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэрэг сэдвийн хүрээнд цахим хичээлийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж сургалтад давхардсан тоогоор 966 албан хаагч хамрагдав.

Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолоор баталсан “Хяналт шинжилгээ хийх журам, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ын хүрээнд дээрх журмын танилцуулга, журмыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, “Бодлогын баримт бичиг болон байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнахад анхаарах асуудал” сэдвээр сургалтыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын Ахлах референт Д.Отгон, ахлах шинжээч Ш.Бумаажав нар 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулав. Сургалтад 55 албан хаагч танхимаар, 132 албан хаагч цахимаар оролцов.

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалтын бүрэлдэхүүнд ажиллаж 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Нийслэлд, 2025 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 10-ны өдрүүдэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газарт зохион байгуулж 81 албан хаагчаас ерөнхий мэдлэгийн, онол, арга зүйн, албан хэрэг хөтлөлтийн шалгалтыг авч, шалгуулагчид шалгалтын дүнг танилцуулан гарын үсэг зуруулж, дүн мэдээг гаргаж холбогдох баримт бичгийг ажлын хэсэгт хүргүүлсэн.

#### *6.12.Журам, маягтын загвар боловсруулж батлуулах;*

***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх тооны тайлан, мэдээлэл судалгааны болон мэдээлэл лавлагааны маягтын загварыг шинэчлэн боловсруулж, батлуулах;***

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загвар, тэдгээрийг хэвлүүлэх, үнэ тогтоох, зарцуулах, тайлагнах журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална” гэж заасан.

Мөн Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ын 3.2.13-д “даатгуулагч, хүн, ажил олгогчид үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгож, үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах.” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх 14 төрлийн тооны тайлан, мэдээлэл судалгааны, 10 төрлийн мэдээлэл лавлагааны баримт, бичгийн маягтын жагсаалт (загвар)-ыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/204 дүгээр тушаалаар, иргэдэд, даатгуулагч, ажил олгогчдод илүү ойлгомжтой, ашиглахад хялбар, нэг стандартаар үйлчлэх зорилгоор тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр авагчийн мэдээлэлд хяналт тавих 8 төрлийн баримт бичгийн маягтын загварыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/281 дугаар тушаалаар батлуулав

#### ***Хяналт шалгалтын нэгдсэн журмыг боловсруулан батлуулах;***

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.9-д зааснаар “Хяналт шалгалтын нэгдсэн заавар”-ыг батлуулахаар боловсруулж Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/298 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтын нэгдсэн журам” батлуулав.

***“Нийгмийн даатгалын ерөнхий газрын ажилтан, албан хаагчдад үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам”-ыг боловсруулан батлуулах;***

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-н 2.6-д “Төсвийн шууд захирагч энэ журамд нийцүүлэн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох нарийвчилсан журмыг баталж болно” гэж заасны дагуу “Нийгмийн даатгалын ерөнхий газрын ажилтан, албан хаагчдад үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам”-ыг боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025

оны “Журам батлах тухай” А/260 дугаар тушаалаар баталж, Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/2442 дугаар албан бичгээр Зохион байгуулалтын нэгж болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлэв.

## 7. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

### 7.1. Нийгмийн даатгалын чиглэлээр:

“Нийгмийн даатгалын хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилт, өмнөх онд хийгдсэн шалгалтын мөрөөр зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг шалгаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх” зорилтын хүрээнд нийт 8 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж, дотоод болон гадагшаа чиглэсэн хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1.1.Нийгмийн даатгалын багц хуулиуд болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг батлагдсан удирдамжийн дагуу нийт 7 аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийх;

1.2.Их, дээд сургууль, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах;

1.3.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулах;

1.4.Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтад хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргуулан нэгтгэх;

1.5.Хорин нэгэн аймаг, есөн дүүргийн Нийгмийн даатгалын газрын дотоодын хяналт шалгалтын хагас, бүтэн жилийн тайланг хугацаанд нь гаргуулж, нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэлийн тайлантай тулган баталгаажуулж нэгтгэх;

1.6.Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт шалгалтын талаар тусгагдсан арга хэмжээний биелэлтийг газар тус бүрээр дүгнэж, үнэлгээ өгөх;

1.7.Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтэд, цахимаар шалгах ажлыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах;

1.8.Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтэд, цахимаар шалгах ажлыг Гадаадын иргэн харьяатын газартай хамтран зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах гэсэн нийт 8 төрлөөр хяналт шалгалтын ажлыг энэ онд хийж гүйцэтгэлээ.

***Нийгмийн даатгалын багц хуулиуд болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг батлагдсан удирдамжийн дагуу нийт 7 аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт төлөвлөгөөт хяналт шалгалтын талаар:***

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Дундговь, Сэлэнгэ, Завхан, Орхон аймаг болон Багахангай, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, өмнөх шалгалтын мөрөөр зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын үр дүн, гүйцэтгэлийг 2018 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааг хамруулан шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллаа.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгаж ердийн болон хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр шинээр тогтоолгосон нийт 17 015 иргэний тэтгэврийн тогтоолт, олголтын үндэслэлийг мөн давхардсан тоогоор нийт 234 791 тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөлд тулгуурлан шалгалаа.

Мөн дээрх аймаг дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн 947 аж ахуйн нэгж, байгууллагын давхардсан тоогоор нийт 21 370 удаагийн шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авч баталгаажуулсан байдал, ажилгүйдлийн даатгалын сангаас 2 657 даатгуулагчид олгосон тэтгэмжийн үндэслэл мөн тэтгэмжийн даатгалын сангаас 74 051 даатгуулагчид олгосон жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн үндэслэлийг анхан шатны баримт болон мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөлтэй тус тус тулган шалгалаа.

*Шалгалтад хамрагдсан тоон үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:*

Хүснэгт-40

№	Шалгалт хийсэн аймаг, дүүрэг	Шалгалтад хамрагдсан огноо	Санхүүгийн жил	Хувийн хэргийн тооллого	Тэтгэврийн олголт /цахим/	Тэтгэврийн шинэ болон нөхцөл тэтгэврийн тогтоолт	Тэтгэмж		Шимтгэлийн тайлан авалт	
							Цах	Цаас	Цах	Цаас
1	Багахангай	2022-2024	3	830	2 319	256	61	605	13	183
2	Дундговь	2018-2023	6	349	50 577	2 705	897	15 946	16	532
3	Чингэлтэй	2022-2024	3	1 165	77 210	6 831	1 031	41 046	10 337	6 700
4	Сэлэнгэ	2023-2024	2	1 140	42 637	4 084	381	12 933	98	490
5	Завхан	2023-2024	2	639	27 088	2 199	287	3 521	177	712
6	Орхон	2019-2023	5	-	34 960	940	-	-	2 112	-
<b>Нийт дүн</b>		<b>2018-2024</b>	<b>21</b>	<b>4123</b>	<b>234 791</b>	<b>17 015</b>	<b>2 657</b>	<b>74 051</b>	<b>12 753</b>	<b>8 617</b>

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу энэ онд нийт 7 аймаг дүүргийн Нийгмийн даатгалын газар төлөвлөгөөт хяналт шалгалтын ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газарт шалгалт хийх албан томилолтын төсвийн зардал байхгүй тул төлөвлөгөөт хяналт шалгалтыг хойшлуулан 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийгдэхээр хүлээгдэж байна.

Мөн түүнчлэн шалгалтаар газрын даргын баталсан удирдамжийн дагуу хуримтлагдсан шимтгэлийн өртэй аж ахуйн нэгж байгууллагын хуримтлагдсан өр авлагыг барагдуулах, Улсын байцаагч нарын тогтоосон актын эрх зүйн үндэслэл, сайн дурын даатгуулагч нарын хамралт, гэрээний үндэслэл болон дээд газраас ирсэн тушаал шийдвэрийн биелэлт, газрын даргын А,Б тушаалын үндэслэл, ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хэрэгжилтийг шалгах ажлыг тус тус зохион байгуулан ажилласан.

*Шалгалтад хамрагдсан тоон үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:*

Хүснэгт-41

№	Шалгалт хийсэн аймаг, дүүрэг	Шалгалтын хугацаанд барагдуулсан өр авлаг	УБ-ийн актын эрх зүйн үндэслэл	СДД гэрээний хэрэгжилт	Дотоод ажил		
					Дээд газрын тушаал шийдвэр	Газрын даргын А,Б тушаал	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт
1	Багахангай	261,7	32	272	128	145	85
2	Дундговь	60,6	249	25660	287	473	249
3	Чингэлтэй	1416,2	548	1209	106	211	2133
4	Сэлэнгэ	1213,8	118	1152	61	159	509
5	Завхан	340,0	207	1079	98	172	343
<b>Нийт дүн</b>		<b>3292,3</b>	<b>1154</b>	<b>29372</b>	<b>680</b>	<b>1160</b>	<b>3319</b>

Төлөвлөгөөт хяналт шалгалтаар Тэтгэврийн даатгалын сангаас нэр бүхий 252 иргэдэд тэтгэврийг илүү тооцож олгосон нийт 3103,8 сая төгрөгийг нөхөн түлүүлэхээр, 216 иргэнд дутуу тооцож олгосон 142,2 сая төгрөгийн нөхөн олгохоор, баримтын бүрдэл дутуу 119 хүний дутуу бүрдүүлсэн баримтыг нөхөн бүрдүүлэхээр, хуурамч бичиг баримт бүрдүүлж, үндэслэлгүйгээр тэтгэвэр тогтоолгосон нэр бүхий 123 хүнтэй холбоотой 3030,1 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, нийт төлбөрийн 71,2 хувийг барагдуулаад байна.

*Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг хүснэгтээр харуулбал:*

*Хүснэгт-42*

№	Шалгалт хийсэн аймаг, дүүрэг	Тэтгэврийн даатгалын сан /сая.төг/		Тэтгэмжийн даатгалын сан /сая.төг/		Хуурамч бичиг баримт бүрдүүлсэн зогсоох актын дүн /сая.төг/	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Багахангай	18	25,6	3	2,4	3	118,5
2	Дундговь	15	19,6	14	7,3	1	16,4
3	Чингэлтэй	252	321,2	9	2,8	9	222,5
4	Сэлэнгэ	34	19,9	5	6,9	48	2 141,6
5	Завхан	122	92,3	1	0,8	14	311,03
6	Орхон	11	2,6	-	-	10	220,1
Нийт дүн			481,2		20,2	123	3 030,1

***Их, дээд сургууль, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажилласан талаар:***

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 04 өдөр “Аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж”-ийн удирдамжийн дагуу Их, дээд болон коллежийн, түүнчлэн ерөнхий боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, шалгалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газартай хамтран зохион байгуулсан.

Шалгалтад Их, дээд болон коллежийн, түүнчлэн ерөнхий боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн 184 аж ахуйн нэгж, байгууллага хамруулан зөрчилгүй 92 ажил олгогчид зөвлөмж өгч 92 аж ахуйн нэгж, байгууллагад 4 116.6 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 889.01 сая төгрөгийн шимтгэл, 436.5 сая төгрөгийн алданги, бүгд 1 325.5 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, илэрсэн зөрчлийн 81.04 хувь барагдуулан ажиллалаа.

***Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулсан талаар:***

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж”-ийн дагуу Хяналт шалгалтын газар болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газартай хамтран зохион байгуулан, шалгалтын дүнг нэгтгэн үр дүнг тооцон ажиллалаа.

Шалгалтаар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын 719 аж ахуйн нэгж, байгууллага хамруулан шалгаж, үүнээс 463 ажил олгогчид зөвлөмж өгч, 256 аж ахуйн нэгж, байгууллагад 1055,3 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 208,1 сая төгрөгийн шимтгэл, 90,4 сая төгрөгийн алданги, 15,3 сая төгрөгийн торгууль, нийт 313,7 сая төгрөгийн акт, алданги тогтоож, илэрсэн төлбөр зөрчлийн 51,2 хувийг барагдуулан ажиллалаа.

***Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтад хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргуулан нэгтгэсэн талаар:***

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт хийгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг барагдуулах талаар тогтмол хяналт тавьж ажиллалаа.

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд 2024 оны жилийн эцсийн байдлаар 567.4 сая төгрөгийн төлбөр зөрчлийн авлагатай байсан бол 623,5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 503,1 сая төгрөгийг барагдуулж, холбогдох сангуудад нөхөн төлүүлж бөгөөд илэрсэн төлбөл зөрчлийг санхүүгийн тайланд авлагаар тусгаж, 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 687,8 сая төгрөгийн төлбөр зөрчлийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн дүн оны эхнээс 21,2 хувиар өссөн харагдаж байгаа шалтгаан нь тэтгэврийн даатгалын сан дээр хийгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн барагдуулалт нь Нийгмийн даатгалын сангаас олгох Тэтгэврийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт “тэтгэврээс нэг удаа суутгах суутгалын хэмжээ нь тэтгэвэр авагчийн сарын тэтгэврийн хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байна” гэж заасны дагуу илүү авсан тэтгэврийн нөхөн төлүүлэх, барагдуулалт удаашралтай байгаа нь төлбөр зөрчлийн авлага оны эхнээс өссөн харагдаж байна.

Түүнчлэн хяналт “Нийгмийн даатгалын хяналт шалгалтын нэгдсэн журам”-ын 9.5 дахь “Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт, шалгалтын чиг үүрэг бүхий нэгж нь аймаг, дүүргийн хяналт шалгалтын улирлын нэгтгэсэн тайланг дараа улирлын эхний сарын 8-ны өдрийн дотор нэгтгэнэ” гэж заасны дагуу 2025 оны жилийн эцсийн Хяналт, шалгалтын тайлан нэгтгэхээр хүлээгдэж байна.

***Хорин нэгэн аймаг, есөн дүүргийн Нийгмийн даатгалын газрын дотоодын хяналт шалгалтын хагас, бүтэн жилийн тайланг хугацаанд нь гаргуулж, нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэлийн тайлантай тулган баталгаажуулж нэгтгэсэн талаар:***

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2010 оны 38 дугаар тушаалаар баталсан “Дотоодын хяналт шалгалтын тайлан мэдээ гаргах аргачлал заавар”-ын дагуу 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн даатгалын газрын дотоодын хяналтын шалгалтаар 2025 онд хийсэн дотоодын хяналт, шалгалтын ажлын тайланг нэгтгэн ажиллалаа.

Аймаг дүүргийн хяналт шалгалтын тайлангийн нэгтгэлээс үзэхэд оны эхэнд 2 788,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 2025 онд дотоодын хяналт, шалгалтаар нийт 3 557,1 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлэн улсын байцаагчийн акт тогтоож, нийт 6 345,5 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс нийт 3 013,7 сая төгрөгийн авлагыг барагдуулж, нийгмийн даатгалын санд төвлөрүүлэн 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 3 331,9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн дүн оны эхнээс 19,4 хувиар өссөн харагдаж байгаа шалтгаан нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хийгдсэн төлөвлөгөөт шалгалт 4 дүгээр улиралд хийгдэж, актын барагдуулалт 51,2 хувь байгаа нь төлбөр зөрчлийн авлага оны эхнээс өссөн харагдаж байна.

***Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт шалгалтын талаар тусгагдсан арга хэмжээний биелэлтийг газар тус бүрээр дүгнэж, үнэлгээ өгсөн талаар:***

Тус газрын мэргэжилтнүүд нь хагас болон бүтэн жилээр өөрсдийн хариуцсан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлттэй танилцаж, үнэлгээ өгч Хяналт шалгалтын газрын даргаар хянуулж, баталгаажуулан, Захиргаа, удирдлагын газарт тухай бүр хүргүүлэн ажилласан.

***Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтэд, цахимаар шалгах ажлыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран зохион байгуулж, үр дүнг тооцож ажилласан талаар:***

Тэтгэврийн даатгалын сангийн эрсдэлээс хамгаалах, цахим хяналт шалгалт сайжруулах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны Хамтран ажиллах тухай” 01/1527, 01/2808 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт цахим хяналт шалгалтыг хамтран зохион байгуулах, мэдээлэл солилцох тухай албан тоот явуулж, уулзалт зохион байгуулан тус газраас Эрүүл мэндийн даатгалын сангаас сүүлийн гурван жил эмнэлгийн тусламж үйлчилгээ аваагүй иргэдийн судалгааг гаргуулан авч, цахим хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал, төлбөрийг сүүлийн 3 жилийн хугацаанд гаргуулаагүй нийт давхардсан тоогоор 31 647 тэтгэвэр авагчийн судалгааг гаргуулан авч, Мэдээлэл технологийн төвд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар тус бүрээр ангилан, Нийгмийн даатгалын газарт нийт 24372 тэтгэвэр авагч нарын мэдээллийг хүргүүлж, тэтгэврийн олголтыг цахимаар хянах, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, илүү авсан тэтгэврийг нөхөн төлүүлэх, дүнг нэгтгэх ажлыг зохион байгууллаа.

Шалгалтаар нийт 25 тэтгэвэр авагчтай холбоотой нийт 195,0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн, улсын байцаагчийн акт тогтоож, илүүл авсан 140,8 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулан биелэлт 72,2 хувьтай ажилласан байна.

***Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтэд, цахимаар шалгах ажлыг Гадаадын иргэн харьяатын газартай хамтран зохион байгуулж, үр дүнг тооцож ажилласан талаар:***

Тэтгэврийн даатгалын сангийн эрсдэлээс хамгаалах, цахим хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Гадаадын иргэн харьяатын газарт албан тоот явуулан, Монгол улсын харьяатаас гарсан 25 иргэдийн нийт 379,8 сая төгрөгийн олголтын үндэслэлийг шалгах ажлыг зохион байгуулсан бөгөөд шалгалтаар нийт 5 тэтгэвэр авагч нарт илүү олгогдсон нийт 29,8 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, улсын байцаагчийн акт тогтоож, зөрчлийн 100 хувь барагдуулан ажилласан байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын харьяатаас гарсан боловч гарсан хугацаа нь тодорхойгүй нэр бүхий 20 иргэний тэтгэврийн олголтыг шалгах ажлыг 2026 онд үргэлжлүүлэн хийгдэхээр хүлээгдэж байна.

2.Тус газар нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний “Үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, хамрах хүрээг нэмэгдүүлэх, хуримтлагдсан өр, авлагыг барагдуулах” зорилтын хүрээнд нийт 8 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж, биелэлтэд хяналт тавьж ажиллаж, дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан байна.Үүнд:

- ❖ Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/298 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын хяналт шалгалтын нэгдсэн журам”-ыг батлан, эрх зүйн актыг улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэн хянуулж баталгаажуулан, аймаг дүүргийн Нийгмийн даатгалын газарт цахимаар танилцуулан мөрдөж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.
- ❖ 2025 онд аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хариутай 181, хариугүй 331, нийт 512 албан бичгийг хүлээн авсан. Хариу хүргүүлэх 181 бичгээс 8 бичиг нь шийдвэрлэх түвшинд, 173 албан байгууллагын хариуг хугацаанд нь хүргүүлж ажиллав. Иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн 206 өргөдөл, гомдлыг хүлээн авч өргөдөл гомдлыг бүрэн шийдвэрлэж хариу өгч ажилласан байна.

- ❖ Засгийн газрын 2023 оны 362 дугаар тогтоолоор баталсан “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм”-ийн 4.4-т “Төв болон салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга гомдол, хүсэлтийг хүлээн авч ажлын нэг өдөрт багтаан бүртгэж, тухайн зөвлөлийн даргад тухай бүр хүргүүлэх бөгөөд төв болон салбар зөвлөл нь уг дүрмийн 4.5-д заасны дагуу буцааснаас бусад тохиолдолд гомдол, хүсэлтийг 30 хоногт багтаан хянаж шийдвэрлэнэ” гэж заасны дагуу тус зөвлөлд 2025 онд хөдөлмөрийн нөхцөлөөр ажилласан жилээ тооцуулахаар 32, малчнаар ажилласан жилээ тооцуулахаар 58, тэтгэмж, шимтгэлтэй холбоотойгоор 24 нийт 114 даатгуулагчаас ирүүлсэн гомдол, хүсэлтийг 11 удаагийн хурлаар хэлэлцүүлэн 37 хүнд тэтгэвэр, тэтгэмж олгох, 77 хүн нотлох баримт хангалтгүй, тэтгэвэр, тэтгэмж тогтоон олгох боломжгүй гэсэн шийдвэрийг хүргүүлэн ажилласан.
- ❖ Нийгмийн даатгалын хуримтлагдсан өр барагдуулах ажлын хүрээнд Багахангай, Чингэлтэй дүүрэг, Дундговь, Сэлэнгэ, Завхан, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрыг шалгах явцад 1 байгууллагад албан шаардлага өгч, 116 байгууллагатай өр авлага барагдуулах гэрээ байгуулсан, 172 байгууллагын дансыг хааж, 126 ажил олгогчийн өрийг бүрэн болон хэсэгчлэн барагдуулж нийт 3,2 тэр бум төгрөгийг шимтгэлийн өрийг төлүүлж ажилласан байна.
- ❖ Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/117 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн хурлыг 2025 онд 7 удаа зохион байгуулж, хурлаар Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын хүсэлтээр 49 хүний, Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын хүсэлтээр 1 хүний, Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын хүсэлтээр 2 хүний, 3 ажил олгогчийн гомдол болон 7 иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг ажлын хэсгийн хурлаар тус тус хэлэлцэв. Хурлаар 7 иргэний 29.4 сая төгрөгийн улсын байцаагчийн актыг хүчингүй болгож 55 иргэний хүсэлтийг дахин судлуулахаар, 121 аж ахуйн нэгжийн 906.4 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 213.5 сая төгрөгийн улсын байцаагчийн акт алдангийг тооцохдоо итгэлцүүрээр өсгөж буруу тогтоосныг хүчингүй болгож дахин акт тогтоохоор, 2 аж ахуйн нэгж, байгууллагын 5474.3 сая төгрөгийн цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос улсын байцаагчийн акт, алданги 1929.6 сая төгрөгийг хүчингүй болгохоор шийдвэрлэн хариуг холбогдох аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлэн ажилласан.

## *7.2. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар хийж хэрэгжүүлсэн ажил*

2025 онд Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт болон бусад холбогдох эрх бүхий байгууллагын албан бичиг болон бусад мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг нийт 3 удаа зохион байгуулан ажилласан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 05 дугаартай “Сүхбаатар дүүргийн болон бусад Нийгмийн даатгалын газарт нөхөн тайлагнасан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн үндэслэл, Мэдээллийн технологийн төвийг шалгах удирдамж”-ийн аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт нөхөн тайлагнасан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн үндэслэл, Мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагааны төсөвт зардлын зарцуулалт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, төсвийн шууд захирагчийн гаргасан захиргааны акт /А, Б тушаал/, үйл ажиллагаанд мөрдөж буй дүрэм журам, гэрээ, тендерийн баримт бичгийн хууль зүйн үндэслэлийг шалгаж дүгнэлт, зөвлөмж өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 09 дүгээр “Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, дүүргийн нийгмийн даатгалын газарт хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт нөхөн тайлагнасан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн үндэслэлийг шалгах ажлын тус газрын болон аймаг, дүүргийн мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулан ажилласан.

Шалгалтаар Сүхбаатар дүүргийн болон бусад Нийгмийн даатгалын газарт нөхөн тайлагнасан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн үндэслэлийг шалгаж ажилтанд олгоогүй байх магадлалтай цалин хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тусган үндэслэлгүйгээр, хуурамчаар тайлагнасан 3 аймаг, 6 дүүргийн нийгмийн даатгалын газарт

32 ажил олгогчтой холбоотой 487 хүний 20 753,8 сая төгрөгийн цалин хөлсийг мэдээллийн сан бүртгэсэн зөрчлийг илрүүлсэн бол 2 дахь удаа зохион байгуулсан шалгалтаар үндэслэлгүйгээр, хуурамчаар тайлагнасан байх магадлалтай 6 дүүргийн 26 ажил олгогчтой холбоотой 306 хүний 13 576,6 сая төгрөгийн цалин хөлсийг мэдээллийн сан бүртгэсэн зөрчлийг илрүүлж ажилласан.

Зөрчилтэй байх магадлалтай нийт 58 ажил олгогчийн жагсаалтыг Тагнуулын ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт тус тус мэдээллийг шалгуулахаар хүргүүлэн шалгуулж байна.

Мөн түүнчлэн Нийгмийн даатгалын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албан, Санхүүгийн зохицуулах хороо, Татварын ерөнхий газрын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хамтран баталсан “Финанс мониторинг” нэгдсэн арга хэмжээний дагуу Банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг Хяналт шалгалтын газар болон Нийслэлийн төвийн 6 дүүргийн Нийгмийн даатгалын газрын улсын байцаагч нар нийт 60 банк бус санхүүгийн байгууллагуудын Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Шалгалтаар нийт 35 аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу тооцсон нийт 719,6 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдох 171,0 сая төгрөгийн шимтгэл, 77,6 сая төгрөгийн алданги, нийт 248,2 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн, улсын байцаагчийн акт тогтоож, төлбөр зөрчлийг 100 хувь барагдуулан ажиллалаа.

Мөн шалгалтаар нийгмийн даатгалын шимтгэл ногдох их хэмжээний орлогыг нуусан байж болзошгүй үндэслэлээр 5 аж ахуйн нэгж байгууллагын 302 даатгуулагчид олгосон 1,2 тэрбум төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл дутуу тооцсон зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлэн ажиллалаа.

### *7.3. Нийгмийн хамгааллын чиглэлээр:*

Монгол Улсын Засгийн газрын 420 дугаар тогтоолоор баталсан Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны зорилт, бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүртээмжтэй хүргэх үүднээс Нийгмийн даатгалын багц хууль, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд болон бусад холбогдох тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил арга зүйгээр хангаж салбарын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.

### ***Эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэхэд соён гэгээрүүлэх, зөвлөн тусалж, хэрэглэгч, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажилласан талаар:***

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтаас зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтад нийгмийн хамгааллын хяналтын байцаагч нар бүрэн хамрагдсан.

2.Хяналт үнэлгээний үндэсний хороо, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хамтарсан нийгмийн хамгааллын салбарын хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах 2 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулж аймаг, дүүргийн 28 нийгмийн хамгааллын байцаагчид онлайнгаар хамрагдсан.

3.Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн Үйлдвэрчний эвлэлийн холбооноос "Хэлэлцүүлэг хийх тухай" албан бичиг ирүүлсэн дагуу Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны байрны 4 давхрын хурлын заланд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Ууганбаатар, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч Ч.Бүжинлхам нарын хамт “Ажил олгогчийн тайлангийн цахим систем” сэдвийн хүрээнд зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцов.

4. Нийслэлийн Прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Б.Соёлсайхан Нийгмийн даатгалын ерөнхий газарт Зөрчлийн хэрэг бүртгэлтийн талаар сургалт зохион байгуулж 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч нар цахимаар оролцсон.

5. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын шийдвэрээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нар болон нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчдыг оролцуулсан онлайн хурал зохион байгуулж зөвлөгөө мэдээлэл өгсөн.

- Хурлын шийдвэрийг үндэслэн 12 заалт бүхий ажлын чиглэл боловсруулан 21 аймаг, 9 дүүрэгт хүргүүлэн ажилласан. Салбарын хэмжээнд 6 удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг зохион байгуулах, үр дүнг тооцох, төлбөр зөрчлийн барагдуулалтын талаар тухай бүр арга зүйгээр хангаж ажилласан.

### **Удирдлага, зохион байгуулалтаар:**

-Тайлант хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулсан газрын дарга болон аймаг дүүргийн НХХ улсын байцаагчдын төлөвлөгөөнд тусгуулан оруулсан.

-Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийхтэй холбоотойгоор аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад шалгалтын удирдамж, чиглэлийг хүргүүлсэн.

-Аймаг, дүүргийн нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагчдын хяналт шалгалтын зардлын тооцооллыг гаргаж, батлуулсан.

-Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>1</sup> дэх хэсэг, Монгол Улсын Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 02 дугаар тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу хийгдсэн төлөвлөгөөт шалгалт, урьдчилан сэргийлэх шалгалтын танилцуулгууд, шалгалтын дүнгийн тайланг удирдамж тус бүрээр нь нэгтгэлийг хийж гүйцэтгэсэн.

-Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа болон Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны талаар 2023, 2024, 2025 онд авсан арга хэмжээний судалгааг гаргаж ГБХНХЯ-руу хүргүүлсэн.

-Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, салбарын хяналтын тоон мэдээ тайланг тогтоосон хугацаанд гаргаж хүргүүлсэн.

- Улсын хэмжээнд Нийгмийн хамгааллын чиглэлээр хийгдсэн Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын явцад Зөрчлийн 3 хэрэг нээж шалган шийдвэрлэсэн, Хялбаршуулсан журмаар 75 зөрчил шалган шийдвэрлэж 52,4 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч торгуулийн мөнгийг бүрэн барагдуулан ажилласан байна.

-Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудаас зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлд заасан “Нийгмийн даатгалын ерөнхий хууль зөрчих” зөрчлийн 1-9 дэх зөрчлийг шалган шийдвэрлэсэн тоон мэдээлэл, судалгааг 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн даатгалын газруудаас авч нэгтгэн гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон УИХ-ын гишүүн Б.Түвшинд хугацаанд нь цахимаар болон цаасаар хүргүүлсэн.

### **Хүний нөөцийн үйл ажиллагааны талаар:**

-Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчдын нэгдсэн судалгааг гаргаж ГБХНХЯ-руу хүргүүлсэн.

-2025 онд нийт 34 байцаагч ажиллахаас Булган, Хэнтий аймгууд Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчгүй, “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2 байцаагч, Баянзүрх дүүргийн 1 байцаагч, Сонгинохайрхан дүүргийн 1 байцаагч тус тус

цомхотгол хийгдэж жилийн эцсийн байдлаар 3 ахлах, 25 улсын байцаагч нийт 28 нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагч ажиллаж байна.

-2025 онд нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчид нийт 126 хүн/өдөр ажиллахаас 126 хүн/ өдөр ажилласан.

**Албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн талаар:**

1.Шинээр батлагдсан болон шинэчлэгдсэн, одоо мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм журмыг судалж, зохих хууль эрх зүйн мэдлэгээ байнга дээшлүүлэн ажиллаж байна.

2.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны шинэтгэл ба цэгцрэх хөдөлгөөн” сэдэвтэй 7:4:10 вебинар сургалт

3.“Ажил олгогчийн тайлангийн цахим систем” сэдвийн хүрээнд зохион байгуулсан сургалт болон 7 хоног бүрийн мэдээллийн цагийн сургалтуудад хамрагдсан.

4.Удирдлагын академийн Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 1 байцаагч, ахлах түшмэлийн сургалтад 1 байцаагч, ММНБ институтээс зохион байгуулдаг мэргэжлийн тасралтгүй хөгжил сэдвээр 120 цагийн танхимын сургалтад хамрагдаж, Мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрх олгох шалгалтыг амжилттай өгч хугацаагүй эрхээ баталгаажуулсан.

5.Захиргаа удирдлагын газраас зохион байгуулсан Монгол бичгийн анхан шатны танхимын сургалтад хамрагдаж хөрвүүлэн уншиж, бичиж, албан хэрэг хөтлөх, өргөдөл гомдлын хариу, албан бичиг боловсруулах чадварт суралцаж өдөр тутамдаа ашиглан хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Төлөвлөгөөт шалгалтын талаар:**

Монгол Улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө”-ний дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/78 дугаар тушаалаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр 08-07/01 дугаартай цахилгаан, эрчим хүч, дулаан үйлдвэрлэх, түгээх, дамжуулах болон 08-07/02 дугаартай Боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбаруудын нийт 351 объектод хяналт шалгалт хийхээс 78,8 хувь буюу 273 аж ахуй нэгж байгууллага хамрагдаж 21,2 хувь буюу 78 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа нь зогссон болон улсын байцаагчгүйн улмаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Шалгалтаар илэрсэн зөрчилд дутагдалд давхардсан тоогоор нийт 1456 зөрчил илрүүлж 636 заалт бүхий улсын байцаагчийн 146 хугацаатай албан шаардлагыг хүргүүлж, 544 заалт буюу 85.5 хувийн биелсэн байна.

Мөн 114 даатгуулагчтай холбоотой 63.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, алданги нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн 91 акт тогтоож, нийт төлбөр зөрчлийн 67.5 хувь буюу 42.9 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд нөхөн төлүүлж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 21 аж ахуй нэгж, байгууллагад 23.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 100 хувь барагдуулж ажиллаа.

Хяналт шалгалтыг удирдамжид заасан хугацаанд нь хийж гүйцэтгэн, нэгтгэсэн мэдээ тайланг хугацаанд нь Гэр бүл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газарт цахимаар болон цаасаар хүргүүлсэн

**Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын талаар:**

**Ажилгүйдлийн даатгалын сангийн шалгалт:**

- Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 08-07/06 дугаартай удирдамжийг үндэслэн аймаг, дүүргүүдийн Нийгмийн даатгалын газрын Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын бүрдүүлэлт, зарцуулалтад Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагчид Говь-Алтай, Төв, Хэнтий аймаг болон Багануур, Налайх дүүргүүдийн Нийгмийн даатгалын газарт, бусад аймаг,

дүүрэгт Нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагчид 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 12-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

Тус шалгалтаар Булган аймаг, Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газруудын ажилгүйдлийн даатгалын сан хяналт шалгалтад хамрагдаагүй, бусад 20 аймаг, 8 дүүрэгт хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар ажилгүйдлийн тэтгэмжийг илүү олгосон 591 даатгуулагчийн 550.6 сая төгрөгийн тэтгэмжийг санд буцаан төвлөрүүлэх тухай улсын байцаагчийн 27 акт тогтоож, дутуу олгосон 262 даатгуулагчийн 141.9 сая төгрөгийг даатгуулагчдад сангаас нөхөн олгох тухай улсын байцаагчийн 18 акт тогтоож, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай давхардсан тоогоор 55 заалттай улсын байцаагчийн 18 албан шаардлагыг 13 аймаг, 5 дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлсэн.

Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн шалгалтаар илэрсэн нийт 692.5 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс барагдуулалт нь 301.1 сая төгрөг буюу 43.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Авсан арга хэмжээг төрөл тус бүрээр харуулбал:

*1. Ажилгүйдлийн даатгалын санд шалгалтаар илэрсэн зөрчилд авсан арга хэмжээ:*

Булган аймаг, Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газруудын ажилгүйдлийн даатгалын сан хяналт шалгалтад хамрагдаагүй, Архангай, Өвөрхангай аймгуудын Нийгмийн даатгалын газруудын ажилгүйдлийн даатгалын санд зөрчил илрээгүй, бусад 18 аймаг, 8 дүүрэгт нийт 692,8 сая төгрөгийн 853 зөрчил илрүүлснээс ажилгүйдлийн тэтгэмжийг илүү олгосон 591 даатгуулагчид хамаарах зөрчилд 550.8 сая төгрөгийг санд буцаан төлүүлэх, тэтгэмжийг дутуу олгосон 262 даатгуулагчид хамаарах зөрчилд 141.9 сая төгрөгийг нөхөн олгох улсын байцаагчийн акт тогтоосон.

/Илэрсэн зөрчлийн мэдээ/  
Хүснэгт-43

№	Нийгмийн даатгалын газрын нэр	Илүү олгосон		Дутуу олгосон		Нийт зөрчил	
		Зөрчил	Мөнгөн дүн	Зөрчил	Мөнгөн дүн	Зөрчил	Мөнгөн дүн
1	Баян-Өлгий аймаг	7	9,232,429.0	1	1,762,327.0	8	10,994,756.0
2	Баянхонгор аймаг	9	9,764,077.0	5	2,392,801.0	14	12,156,878.0
3	Говь-Алтай аймаг	17	4,810,628.0	10	3,811,969.0	27	8,622,597.0
4	Говьсүмбэр аймаг	22	27,566,071.0	-	-	22	27,566,071.0
5	Дархан-Уул аймаг	11	6,839,607.0	-	-	11	6,839,607.0
6	Дорноговь аймаг	16	12,094,084.1	-	-	16	12,094,084.1
7	Дорнод аймаг	21	25,389,691.0	3	3,103,080.0	24	28,492,771.0
8	Дундговь аймаг	5	4,621,371.0	-	--	5	4,621,371.0
9	Завхан аймаг	26	16,525,260.9	8	7,157,469.3	34	23,682,730.2
10	Орхон аймаг	28	30,387,320.0	18	21,641,229.0	46	52,028,549.0
11	Өмнөговь аймаг	14	15,397,740.0	12	10,784,992.0	26	26,182,732.0
12	Сүхбаатар аймаг	12	11,073,151.0	38	9,773,118.0	50	20,846,269.0
13	Сэлэнгэ аймаг	30	33,192,370.5	12	8,770,501.2	42	41,962,871.6
14	Төв аймаг	64	37,746,819.9	39	23,962,631.4	104	62,474,265.4
15	Увс аймаг	13	10,239,740.3	5	3,150,558.4	18	13,390,298.7
16	Ховд аймаг	7	4,297,790.0	2	730,576.0	9	5,028,366.0
17	Хөвсгөл аймаг	10	13,068,110.7	18	9,033,655.0	28	22,101,765.7
18	Хэнтий аймаг	128	70,423,559.2	24	9,621,331.0	152	81,809,552.3
19	Багануур дүүрэг	20	19,805,471.0	9	1,904,229.2	29	21,709,700.3
20	Баянгол дүүрэг	7	40,369,691.0	1	844,875.0	8	41,214,566.0

21	Баянзүрх дүүрэг	13	13,672,087.0	-	-	13	13,672,087.0
22	Налайх дүүрэг	15	9,614,203.9	46	17,391,881.2	61	27,006,085.1
23	Сонгинохайрхан дүүрэг	17	23,077,140.3	1	473,346.0	18	23,550,486.3
24	Сүхбаатар дүүрэг	2	2,036,962.0	-	-	2	2,036,962.0
25	Хан-Уул дүүрэг	17	28,495,944.0	-	-	17	28,495,944.0
26	Чингэлтэй дүүрэг	63	71,100,003.0	10	5,679,384.6	89	76,779,418.6
<b>Нийт</b>		594	550,841,352.3	262	141,989,953.9	853	695,360,783.7

Хяналт шалгалтыг удирдамжид заасан хугацаанд нь хийж гүйцэтгэн 2025 оны 06 сарын 17-ны НДЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар танилцуулагдаж, 2025 оны 06 сарын 25-ны 01/1552 дугаар Ажилгүйдлийн даатгалын санд хийсэн хяналт шалгалтын тайлан хүргүүлэх тухай албан бичгээр Гэр бүл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газарт цахимаар болон цаасаар хүргүүлсэн.

*2.Барилга угсралт, барилгын материал, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт:*

Монгол Улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө”-ний дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 08-07/05 дугаартай удирдамжаар барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 36, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2, нийт 38 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн.

Шалгалтаар илэрсэн зөрчилд улсын (ахлах) байцаагчийн нийт 34,504.6 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн 23 даатгуулагчтай холбоотой 3 акт, улсын (ахлах) байцаагчийн 200 заалт бүхий 32 хугацаатай албан шаардлага, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 4,700.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.

Мөн 20 аж ахуйн нэгж, байгууллагын 211,843.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өрнөөс 10 аж ахуйн нэгж, байгууллагын 102,374.5 мянган төгрөгийг барагдуулсан байна

*3.Уул уурхай, хүнд үйлдвэр газрын тосны бүтээгдэхүүн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт:*

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 08-07/03 дугаартай удирдамжаар “Уул уурхай, олборлолт, хуурай замаар хийгдэх ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг аж ахуй нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу 10 аймгийн нийт 47 аж ахуйн нэгж, байгууллагад шалгалт хийсэн.

Шалгалтаар илэрсэн зөрчилд дутагдалд давхардсан тоогоор нийт 345 зөрчил илрүүлж 200 заалт бүхий улсын байцаагчийн 33 хугацаатай албан шаардлагыг хүргүүлж 111 заалт буюу 32,1 хувь биелсэн байна.

Мөн хяналт шалгалтын явцад 370 ажилтантай холбоотойгоор 222,412.8 мянган төгрөгийн хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос тооцон 57,254.9 мянган төгрөгийн шимтгэл, алдангийн акт тогтоож, уг төлбөрийг Нийгмийн даатгалын сангийн дансанд 100 хувиар барагдуулж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 7 байгууллагад 8,450.0 мянган төгрөгийн торгох шийтгэл оногдуулж бүрэн барагдуулж ажилласан.

Шалгалтын хугацаанд уул уурхайн болон тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг 9 аж ахуйн нэгжийн нийт 189,739.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өрийг хянан шалгаснаар 185,485.3 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын төвлөрсөн санд төлүүлж, өр авлагыг бүрэн барагдуулсан.

*4. Ус хангамж, сувагжилт, хог хаягдлыг хуримтлуулах, түгээх зайлуулах, боловсруулах, ариутгах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт:*

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 08-07/04 дугаартай удирдамжаар Ус хангамж, сувагжилт, хог хаягдлыг хуримтлуулах, түгээх зайлуулах, боловсруулах, ариутгах чиглэлээр 14 аймаг, 1 дүүргийн 34 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн.

Шалгалтаар илэрсэн зөрчилд улсын (ахлах) байцаагчийн 102 заалт бүхий 17 хугацаатай албан шаардлага хүргүүлж 83,4 хувийг биелүүлэн, Зөрчлийн тухай хуулийн дагуу 2 байгууллагад 1,500.0 мянган төгрөгийн торгох шийтгэл оногдуулж бүрэн барагдуулж ажилласан.

***Төлөвлөгөөт бус зөвлөн туслах үйлчилгээний талаар:***

-Нийгмийн даатгалын хуулиудын шинэчлэл, SICOS программын хэрэгжилттэй холбоотойгоор нийт 136 иргэд, даатгуулагч, ажил олгогчдод утсаар болон амаар /биечлэн/ зөвлөгөө өгч, хариу хүргүүлэн ажилласан.

-Хяналт шалгалтын газрын улсын (ахлах) байцаагч нар иргэдтэй уулзаж зөвлөгөө, мэдээлэл өгөх хуваарийн дагуу нийт 182 иргэнтэй биечлэн уулзаж, тавьсан санал хүсэлтийг хүлээн авч, зөвлөгөө, мэдээ, мэдээлэл өгч ажилласан.

***Төлөвлөгөөт бус шалгалтын талаар:***

1.ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар “Монголын СОС хүүхдийн хотходын нийгэмлэг”-т хийсэн хяналт шалгалтын ажлын хэсэгт орж ажилласан.

2. ГБХНХЯ-ны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 сарын 16-ны өдрийн “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Бринкс Монгол ХХК-д шалгалт хийсэн

3.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 09 дүгээр “Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, дүүргийн нийгмийн даатгалын газарт хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдэд хяналт шалгалт хийж ажилласан.

4.Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хамтран баталсан “Финанс мониторинг” нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/206 дугаар тушаалаар баталсан “Банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийн дагуу дүүргүүд дэх Нийгмийн даатгалын газрын хяналт шалгалтын улсын байцаагч нарыг оролцуулан нэр бүхий банк бус санхүүгийн байгууллагуудад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

5. ГБХНХЯ-ны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 сарын 16-ны өдрийн “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Бринкс Монгол ХХК-д шалгалт хийсэн.

***Дотоод ажил үйлчилгээ:***

- ХНХЯ-д шийтгэлийн хуудасны захиалга өгч, мөн шийтгэлийн хуудасны биелэлтийг албадан гүйцэтгүүлэх ажиллагааг прокурорын хяналтад хүлээлгэн өгсөн.
- Газрын даргын үүрэг болгосны дагуу Portal.ndaatgal.mn болон SICOS программын шинэчлэл, хэрэгжилт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тогтоолт, олголттой холбоотойгоор утасны дуудлагад хариу өгч ажиллалаа.
- Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудын хяналт шалгалтын мэдээг хүлээн авч, нэгтгэлийг хийж гүйцэтгэсэн.
- ХНХЯ-ны Салбарын хяналтын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Нийгмийн хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчдын судалгааг хүргүүлсэн.

- ХШГ-ын 14 хоног тутмын хийсэн ажлын тайланг газрын дарга болон тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна.

-Аж ахуйн нэгж байгууллагын зөрчил дутагдал гарч буй шалтгаан нь хууль тогтоомж, дүрэм, журам шинэчлэгдэж байгууллагын удирдлага, нягтлан бодогчийн хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл дутмагаас зөрчил дутагдал гарах нөхцөлийг үүсгэж байна.

-2025 оны нийт шалгалтын хүрээнд 3228 зөрчил илрүүлж Улсын /ахлах/ байцаагчийн 925,859.6 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож зөрчлийн тухай хуулийн дагуу 52,450.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, Улсын /ахлах/ байцаагчийн нийт 1193 заалттай 243 хугацаатай албан шаардлага хүргүүлэн ажилласан.

-Улсын хэмжээнд Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад ажиллах явцад хяналт шалгалт хийсэн тухайн сарын 01-ний байдлаар нийт 132 аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн 6,449.0 сая төгрөгийн өр төлбөрөөс шалгалтын хугацаанд 65 аж ахуйн нэгж, байгууллагын 1,543.2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг бүрэн болон хэсэгчлэн барагдуулж ажилласан байна.

## 8. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн Технологийн төв нь нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, төрийн болон бусад байгууллагууд, ажил олгогч, иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар хүргэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 онд дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

### 8.1.Засгийн Газрын тогтоолыг хэрэгжүүлэв.

- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан “Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу даатгуулагчийн мөнгөжүүлэхээр тооцсон болон мөнгөжүүлэхэд бэлэн орлогын хэмжээг сар бүр тооцоолж, иргэд даатгуулагчид “Нийгмийн даатгал” аппликейшн, Portal.ndaatgal.mn вэб систем, E-Mongolia порталаар авах боломжийг бүрдүүлэв.
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 221 тоот тогтоолын дагуу “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай”, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай”, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулиудын дагуу бүх тэтгэвэр авагчдийн тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 6%-иар нэмэгдүүлэн тооцох хөгжүүлэлтийг хийж нэвтрүүлэв. Ингэснээр бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689.0 мянган, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 572.4 мянган төгрөг болж нийт 550.0 орчим мянган тэтгэвэр авагчдын тэтгэврийг цаг хугацаанд нь олгох нөхцөл бүрдсэн.

### 8.2.Шинээр бүтээгдэхүүн хөгжүүлэн нэвтрүүлэв.

1. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг хэлэлцэн шийдвэрлэсэн мэдээллийг бүртгэх, хянах, баталгаажуулах үйл ажиллагааг программчлан шинээр дэд систем хөгжүүлэн нэвтрүүлэв. Ингэснээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох үйл ажиллагаа орон зай хамаарахгүйгээр явагдах боломж бүрдсэн.
2. НДЕГ-ын даргын 2024 оны А/107 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам”-д заасан аргачлалын дагуу даатгуулагчийн 2024 он ба түүнээс өмнөх хугацаанд сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээнээс илүү төлсөн шимтгэлийг автоматаар тооцоолон буцаан олгох бүтээгдэхүүнийг хөгжүүлэн нэвтрүүлсэн.
3. Нийгмийн даатгалын нийт бүтээгдэхүүн үйлчилгээний тоон мэдээллийг дэлгэрэнгүй харах боломж бүхий “Dashboard”-ыг шинэчлэн боловсруулж нэвтрүүлсэн. Уг “Dashboard”-оос

нийгмийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний нийт 25 төрлийн багц мэдээллийг харьяалагдах аймаг, дүүргээр задлан дэлгэрэнгүй харах боломжийг бүрдүүлсэн.

### 8.3. Сумдад мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэв.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд ашиглагддаг мэдээллийн нэгдсэн системийг нийт 320 сумын байцаагчийн хэрэглээнд бүрэн нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэв. Энэ ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулан хэрэгжүүлэв. Үүнд:

- SICOS системийг сумдад нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд сумдын байцаагчдыг хөдөлгөөнт интернэтийн төхөөрөмжөөр хангаж, интернэт холболтыг бүрдүүлэх, системд хандах VPN холболтын тохиргоо хийх, хэрэглэгчийн эрх олгох зэрэг техникийн бэлтгэл ажлыг гүйцэтгэв.
- Сумын байцаагчдад системийн хэрэглээний практик олгох зорилгоор Төв аймгийн 3 сум, Дундговь аймгийн 2 сумын байцаагчдад тэтгэвэр, тэтгэмж болон орлогын бүтээгдэхүүн дээр хэрхэн ажиллах талаар ажлын байрны сургалтыг зохион байгуулан, системийн бодит орчинд ажиллах туршилт хийлгэв.
- Улсын хэмжээнд 320 сумын байцаагчдыг хамруулан, системийг ашиглах заавар, анхаарах асуудал болон цаашдын хэрэглээний чиглэлийн талаар ZOOM хэлбэрийн онлайн сургалт зохион байгуулав.

SICOS системийг сумдад нэвтрүүлснээр байцаагч өөрийн сумынхаа ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хүлээн авах, шинэ ажил олгогч бүртгэх, ажил олгогчийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сайн дурын даатгуулагчийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, мөн тэтгэвэр, тэтгэмжийн хүсэлтийг үүсгэх, даатгуулагчийн хүсэлтээр нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа гаргаж өгөх боломжийг бүрдүүлсэн.

### 8.4. Мэдээллийн нэгдсэн системд хөгжүүлэлт, сайжруулалт хийж нэвтрүүлэв.

Салбарын хэмжээнд ашиглагдаж буй мэдээллийн нэгдсэн системд хууль тогтоомжийн өөрчлөлт, хэрэглэгчийн хүсэлтээр шаардлагатай хөгжүүлэлт, сайжруулалт хийх ажлыг тогтмол гүйцэтгэн ажиллав. Тухайлбал:

- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Гадаад харилцааны болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны “Адилтгах албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” А/48, А/130 тоот хамтарсан тушаалын дагуу:
  - Цэргийн атташе, атташегийн туслахаар ажиллаж байсан даатгуулагчийн төрлийн 01001 кодоор тайлагнасан хугацааг цэргийн алба хаасны тэтгэвэр дээр хамтад нь тооцох
  - ТЕГ, АТГ зэрэг байгууллагаас даатгуулагчийн төрлийг 01001 кодоор тайлагнасан хугацааг цэргийн алба хаасны тэтгэвэр дээр хамтад нь тооцох болон бусад холбогдох өөрчлөлтүүдийг системд оруулж цэргийн атташе гэсэн нөхцөлөөр тэтгэвэр тогтоох боломжийг бүрдүүлэв.
- Үндсэн хуулийн цэцийн гишүүн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход, хүсэлт гаргах үед мөрдөж байсан албан тушаалын болон НДЕХ-ийн 19 дүгээр зүйлд заасан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулан тооцохтой холбогдуулан УИХ-аас 1995-2023 онуудад баталсан цалингийн мэдээллийг системд оруулсан. Ингэснээр тухайн жилд ажиллаж байсан ҮХЦ-ийн дарга, гишүүний цалингаар өндөр насны тэтгэвэр тогтоох боломж бүрдсэн.
- Ажил олгогчийн НД7Б тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн акт, алданги, торгуулийн дүнг тусад нь хүснэгтэд харуулах өөрчлөлтийг хийж, уг дүнг нийт шимтгэл төлсөн дүнд тооцон харуулдаг болгов.
- Сайн дурын даатгалын алдангийн мэдээллийг Зөрчил дэд системд бүртгэж нэгдсэн хэлбэрээр хөтлөх боломжийг бүрдүүлэв. Ингэснээр даатгуулагчийн мэдээлэл, алдангийн дүн болон нийгмийн даатгалын сангуудын задаргааг системд оруулж алданги тооцох, баталгаажуулах, нэхэмжлэл үүсгэх ажиллагаа бүрэн автоматжсан.
- Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг бүртгэх системийн хөгжүүлэлтийг хийж, туршин шалгав. Энэхүү ажлын хүрээнд 50,000 воны шимтгэлийг системд бүртгэн, гараас оруулсан ханшийн мэдээлэлд үндэслэн төгрөгт хөрвүүлэх боломжийг бүрдүүлэв. Мөн

хөрвүүлсэн дүн дээр хуулийн дагуу 8.5 хувийн шимтгэлийг тооцох, шимтгэлээс үүсэх авлага болон төлөлтийн нөхөн ногдуулалтын мэдээллийг бүртгэх, тэтгэврийн шимтгэл болон цалингийн нэхэмжлэлийг автоматаар үүсгэн хаах хөгжүүлэлтийг хийв.

- Тэтгэвэр, тэтгэмжийн актын мэдээллийг системд бүртгэх хөгжүүлэлтийг хийж туршин нэвтрүүлэхэд бэлэн болгов.
- Улсын бүртгэлийн газраас нас барсан иргэдийн мэдээллийг жагсаалтаар авч нийгмийн даатгалын мэдээллийн санд нас барснаар бүртгэх, авч байсан холбогдох бүтээгдэхүүнийг нь дуусгавар болгох үйлдлийг систем автоматаар хийх боломжийг бүрдүүлэв.
- Сайн дурын даатгуулагч шинээр гэрээ байгуулан тухайн сардаа багтаан мөнгөө төлөөгүй тохиолдолд гэрээг системээс хүчингүй болгох хөгжүүлэлтийг хийв.
- СДД-ын даатгуулагч гэрээний хугацаанд АЖД-д хамрагдаж шимтгэл төлсөн тухайн сарын нэхэмжлэхийг идэвхгүй болгох (02001 кодтой даатгуулагчийн хувьд хамаарахгүй) өөрчлөлтийг оруулав.
- Цагдаа болон шүүхийн байгууллагад ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг хүргүүлэх зориулалтаар дэд систем хөгжүүлэн НДЕГ-ын мэдээллийн ажилтанд ашиглах боломжийг бүрдүүлсэн.
- АЖТДШНТТ хууль, МХХЭТДШНТТ хуулийн хүрээнд хийгдсэн нөхөн даатгалын регистрийн дугаар алдаатай бүртгэгдсэнээс болж хөрвөөгүй байсан мэдээллийг нэгж дээрээ хөрвүүлэх боломжийг бүрдүүлэв.
- Иргэн өөрөө хүсвэл [www.Portal.ndaatgal.mn](http://www.Portal.ndaatgal.mn) веб системээр хаягийн мэдээллээ УБЕГ-аас татаж өөрчлөх боломжийг бүрдүүлэв.
- Системийн ашиглалтын талаар байцаагч ажилтнуудаас ирүүлсэн асуултыг бүртгэн, олон давтамжтай ирж буй асуултын хариултыг бэлтгэн хэрэглэгчийн үйлчилгээний бүртгэл /Support/-г үүсгэн нийтдээ 200 гаруй асуулт, хариулт бүртгэсэн бөгөөд цаашид асуулт хариултын санг нэмэх боломжтой юм.
- Салбарын нийт байцаагч ажилтнуудаас бүтээгдэхүүн үйлчилгээний хүсэлт үүсгэх явцад гарсан тулгамдаж буй асуудлаа шийдвэрлүүлэх хэрэглэгчийн хүсэлтийг цахимаар хүлээн авч асуудлыг судлах, хянах, удирдах, шийдвэрлэх зориулалт бүхий JIRA платформыг нэвтрүүлсэн. Энэ онд уг платформуор нийтдээ 1300 гаруй хүсэлт ирснээс 70%-ийг нь эцэслэн шийдвэрлэж байцаагч ажилтнуудад зөвлөгөө өгч ажиллав.
- Нэгжүүдийн санхүүгийн тайлан, мэдээ гаргах чиглэлээр:
  - o АЖД болон СДД-ын хавсралт тайлангийн нэгтгэл гаргах
  - o “Тайлангийн өндөрлөгөө” хийх
  - o Санхүүгийн тайланг өндөрлөж, гүйлгээний хаалт хийх
  - o Сарын мэдээний нэгтгэл гаргах
  - o Улирал, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэл гаргах
  - o Бараа материалын дэлгэрэнгүй тайлан гаргах
  - o Салбар хооронд бараа материалын шилжүүлэг хийх зэрэг хөгжүүлэлтүүдийг нэмж хийж нэвтрүүлэв.

#### **8.5.Мэдээллийн нэгдсэн системээр салбарын 2024 оны сангийн санхүүгийн тайланг гаргах ажлыг амжилттай зохион байгуулав.**

Мэдээллийн нэгдсэн системээр төв орон нутгийн нийгмийн даатгалын 30 нэгжийн 2024 оны жилийн эцсийн сангийн санхүүгийн тайланг гаргахтай уялдуулан системд шаардлагатай өөрчлөлт хөгжүүлэлт хийх, нэгжүүдэд аргачлал, заавар, чиглэл, зөвлөгөө өгөх, сургалт явуулах, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулан нэгжүүдээс ирүүлсэн асуудлуудыг цаг тухайд нь шийдвэрлэн ажиллав. Тухайлбал:

##### **А. Системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлт:**

- Ажил олгогч, сайн дураар даатгуулагчийн тайлангийн шалгах баланс болон бусад хавсралт тайлангууд, санхүүгийн нэгтгэл тайлан болон хавсралт тайлангууд, мөн хүний тооноос хамаарсан тайлангуудыг системээр гаргах хөгжүүлэлтийг хийж Дундговь аймгийн НДГ-тай хамтран туршин тестлэж нэвтрүүлсэн.

- Тэтгэвэр, тэтгэмж, сайн дурын болон ажил олгогчийн бүтээгдэхүүнүүдэд шаардлагатай хөгжүүлэлтүүдийг хийж нэвтрүүлсэн. . . . гэх мэт.

**Б. Заавар, аргалчлал, зөвлөгөө өгөх чиглэлээр:**

- Санхүүгийн чиглэлээр бүх нэгжийн ахлах нягтлан бодогч, сангийн нягтлан бодогч, тэтгэвэр тэтгэмж, ажил олгогч хариуцсан болон хяналтын байцаагч нарт тэтгэврийн тайланг шалгах баланстай тааруулах, сайн дурын даатгалын тайлан, акт, алдангийн тайлан, харилцахын үлдэгдэл зөрүүлж байгаа гүйлгээнүүдийн талаар аргачлал заавар өгсөн.

- Бүтээгдэхүүний чиглэлээр бүх нэгжийн тэтгэвэр, тэтгэмжийн болон үйлчилгээний хэлтсийн дарга, байцаагч, сангийн болон ахлах нягтлан бодогч нартай нэг бүрчлэн тулж ажиллан тулгамдсан асуудлуудыг цаг тухайд нь судлан аргачлал заавар зөвлөгөө өгч ажилласан.

**В. Сургалтын чиглэлээр:**

Санхүүгийн жилийн эцсийн тайлан гаргахтай холбогдуулан байцаагч ажилтнуудад дараах сэдвүүдээр онлайн болон танхимын сургалт хийсэн. Үүнд:

1. Аймаг, дүүргийн НДГ-ын санхүү бүртгэл, тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн нийт 125 байцаагчид “Тэтгэврийн зөрүү хуваарь үүсгэх”, “Тэтгэврийн олголт хаах”, “Үйлдвэрлэлийн ослын сангаас хариуцах ногдуулалт үүсгэх” сэдвээр онлайн сургалт;

2. Аймаг, дүүргийн НДГ-ын тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн дарга, тэтгэмжийн байцаагч, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, сангийн нягтлан бодогч зэрэг нийт 112 байцаагчид “Тэтгэмжийн тайлан” гаргах сэдвээр онлайн сургалт;

3. Дундговь аймгийн НДГ-ын ажилтнуудтай хамтран аймаг, дүүргийн НДГ-ын тэтгэврийн хэлтсийн дарга, тэтгэврийн байцаагч, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, сангийн нягтлан зэрэг нийт 133 байцаагчид “Тэтгэврийн тайлан” гаргах сэдвээр онлайн сургалт;

4. Байцаагч ажилтнуудын мэдээллийн нэгдсэн систем ашиглалтын ур чадварыг сайжруулах зорилгоор тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ, СДД болон албан журмын даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний чиглэлээр болон Зөрчил дэд системээр аймаг, дүүргийн НДГ-ын байцаагчдад ажлын нэг өдрийн танхимын болон онлайн сургалт явуулсан. Уг сургалтад танхимаар 76, онлайнгаар 100 гаруй байцаагч ажилтнууд хамрагдсан. Мөн ажил олгогч, даатгуулагчийн портал системийн ашиглалтаар хичээл заасан.

**Г. Хэрэглэгчийн гарын авлага бэлтгэх чиглэлээр:**

1. “Тэтгэврийн олголт цуцлах” талаар гарын авлагыг шинээр боловсруулан байцаагч ажилтнуудад цахимаар хүргүүлсэн.

2. Хоёр ба түүнээс дээш тэжээгчээ алдсан тэтгэврийн бүтээгдэхүүний нийлбэр цалинг хэрхэн тооцож тогтоолт хийх зааврыг бэлтгэн байцаагч ажилтнуудад цахимаар хүргүүлсэн.

3. Шинээр боловсруулан нэвтрүүлсэн JIRA программын гарын авлагыг бэлтгэн байцаагч ажилтнуудад цахимаар хүргүүлсэн.

4. СДД-ын алданги хэрхэн тооцох талаарх гарын авлагыг бэлдэж хүргүүлсэн.

**8.6.Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох шалгалтын ажиллагааг мэдээллийн технологиор дэмжин ажиллав.**

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох шалгалтыг зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг амжилттай гүйцэтгэв. Үүнд:

- Шалгалтын 2.0 мянган асуулт, хариултын 8.0 мянган хувилбарыг хөрвүүлэн шалгалтын мэдээллийн санг бүрдүүлэх;
- Шалгалтад хамрагдах нийт 434 ажилтны системд нэвтрэх нэр, нууц үгийг үүсгэх, дэлгэрэнгүй мэдээлэлийг программ хангамжид оруулах, шалгалтын хуваарь үүсгэх, шалгалтын дүнгийн хуудасны тохиргоо хийх;
- Шалгалт авах нийт 8 танхимын 170 орчим компьютерийн тохиргоог нэг бүрчлэн хийх, хэвлэгч холбон тохируулах, акт, торгууль, албан бичгийн файлын форматыг хуулж бэлдэх. . . гэх мэт.

**8.7.Нэгдсэн мэдээллийн санг бодит цагийн горимоор цуглуулан ашиглах нөхцөлийг бүрдүүлэн ажиллав.**

Төв орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагад өдөр бүр үүсгэж буй иргэд даатгуулагч, ажил олгогчийн мэдээллийг цаг тухай бүр онлайнгаар цуглуулан нэгдсэн мэдээллийн санг шинэчлэн баяжуулав. Үүний үр дүнд төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогч, төрийн болон бусад байгууллагад нийгмийн

даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг бодит цагийн горимоор найдвартай хүргэх боломж бүрдэж, цахим үйлчилгээний хүртээмж, тасралтгүй ажиллагаа хангагдсан.

**8.8.Нэгдсэн мэдээллийн сангаас 200 орчим удаагийн мэдээллийн боловсруулалт, судалгаа, тооцоолол гаргав.**

Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сангаас яам, агентлаг, төрийн болон бусад байгууллагын хүсэлтээр нийтдээ 200 гаруй удаагийн мэдээллийн боловсруулалт, судалаа гаргаж хэрэглэгчдийг цаг тухайд нь мэдээллээр ханган ажиллав. Томоохноос дурдвал:

*УИХ-ын байнгын хороо болон УИХ-ын гишүүдийн хүсэлтээр:*

- 2015-аас 2025 оны 1 дүгээр улирлын байдлаарх даатгуулагчийн цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, төлсөн шимтгэлийн хэмжээ, даатгуулагчийн тоон мэдээллийг 4 удаа;

- 2020-2025 оны байдлаарх Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс болон салбарын тоон мэдээллийг;

- НДС-гаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.7-д заасан нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээг 2021 оноос 2025.08 сарын байдлаар;

*Үндэсний статистикийн хороонд:*

- ҮСХ-ны даргын 2013 оны 1/158 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2024 оны 4-р улирал, 2024 оны жилийн эцсийн байдлаарх ААНБ-ын даатгуулагчдын тоо, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, сарын дундаж цалинг өгөгдсөн интервал, хүйс, аймаг болон бүс, эдийн засгийн ангилал, ажил мэргэжлийн код, өмчийн хэлбэр, хариуцлагын хэлбэрээр. /Нийт 34 хүснэгтэн мэдээллийг 2 удаа/

- ҮСХ-ны даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаарх нийгмийн даатгалын салбарын *нийт 28 хүснэгтэн* мэдээллийг;

*Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд:*

- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө, дундаж тэтгэврийн хэмжээг өгөгдсөн интервалын дагуу тэтгэврийн төрөл болон хүйсээр;

- Цэргийн ТА, ХЧА-ын тэтгэвэр авагчдын хөдөлмөрийн чадвараа алдсан жил, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хөдөлмөрийн чадваргүй иргэний тоон мэдээллийг;

- Иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон бусад гэрээгээр ажиллагсдын мэдээллийг;

- Сүүлийн 5 жилд тэтгэвэр авсан тэтгэвэр авагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, нэрийн дансны мэдээлэл, нийт авсан тэтгэврийн дүн, тэжээгчээ алдсан үүссэн эсэх талаар мэдээллийг;

- 2024 онд малчин, туслах малчин төрлөөр сайн дурын даатгалд даатгуулсан нийт даатгуулагчийн нас, хүйс, шимтгэл төлсөн сар, “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” болон “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хуулиар нөхөн тооцсон эсэх мэдээллийг;

- 10-аас дээш жил шимтгэл төлсөн, тэтгэврийн эрх үүсгээгүй, “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хуулиар нөхөн даатгалд хамрагдсан нийт даатгуулагчийн нас, хүйс, нөхөн төлсөн сарын мэдээллийг;

*Татварын ерөнхий газарт:*

- 2024 оны байдлаарх нийт даатгуулагчдын цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилгах орлогын хэмжээ, төрлийн код, ногдуулсан шимтгэлийн хэмжээ зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг;

*Боловсрол, шинжлэх ухааны яаманд:*

- Жагсаалтаар ирүүлсэн, Боловсролын зээлийн сангаас зээл авсан иргэдээс төрийн байгууллагад ажилласан даатгуулагчдын тоон мэдээллийг;

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт:*

- Халамжийн тэтгэвэр авдаг 65.0 мянган иргэнийг тэтгэвэр авдаг эсэх мэдээллийг;

*Шинэ хоршоо салбар дундын уялдааг хангах үндэсний хороонд:*

- УБЕГ-т хоршоогоор шинээр бүртгүүлсэн 9.3 мянган хоршооноос нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн хоршооны даатгуулагчдын тоон мэдээллийг;

*Авлигатай тэмцэх газарт:*

- Нэр бүхий ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг 9 удаа;

*ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн шалгах алба, Экологийн цагдаагийн албанд:*

- Нэр бүхий ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг нийтдээ 60 удаа . . . гэх мэт.

### 8.9.Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд 60 багц сервисээр мэдээлэл хүргэж тогтвортой ажиллагааг хангаа.

1. Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан нийгмийн даатгалын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар үзүүлэх зориулалт бүхий, иргэд даатгуулагч, ажил олгогчийн мэдээллийг агуулсан, 60 гаруй төрлийн сервисийн хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.

2. ХУР системээр дамжуулан үзүүлэх цахим үйлчилгээг өргөжүүлэх хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогын хэмжээг E-Mongolia порталаар харуулах сервисийг шинээр боловсруулан ХУР системд байршуулсан.

- Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолын дагуу тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах хүсэлтийг ХУР системээр дамжуулан E-Mongolia порталаар цахимаар авах сервисийг шинээр боловсруулан хүргүүлсэн.

- Тэтгэврийн тусгай зохицуулалт, зарим иргэний нэмэгдэл гэх мэт нэмэгдэлтэй тэтгэвэр авагчийн мэдээллийг үндсэн тэтгэвэртэй нь нэгтгэж гаргах сервисийг боловсруулан ХУР систем рүү хүргүүлсэн.

- Олон мөнгө авагчтай тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудасны сервисийг боловсруулан ХУР системд хүргүүлсэн.

3. Үндэсний статистикийн хороотой мэдээлэл солилцох чиглэлээр дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:

- ҮСХ-ны даргын 2013 оны 1/158 дугаар тушаалаар батлагдсан 34 нэр төрлийн маягтын дагуу даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын мэдээллийг цахим хэлбэрээр дамжуулах нөхцөлийг бүрдүүллээ. Үүний үр дүнд эдгээр мэдээллийг дундын серверт байршуулан (баазаар өгөх хэлбэрээр) тогтмол, түргэн шуурхай мэдээлэл солилцох боломж бүрдсэн байна.

- ААНБ-ын дор дурдсан томоохон мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системээс авах сервисийг боловсруулан хүргүүлсэн. Үүнд:

\*\*\*Байгууллагын регистр, хаяг байршил, ЭЗҮАС ангилал, хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр

\*\*\*Даатгуулагчийн төрөл тус бүрээр даатгуулагчдын тоо болон төлөх шимтгэлийн мэдээлэл. Үүнээс:

-эмэгтэй даатгуулагчдын тоо, төлөх шимтгэлийн дүн,

-гадаад даатгуулагчдын тоо, төлөх шимтгэлийн мэдээлэл.

Энэхүү шийдэл нь мэдээллийн хүртээмж, найдвартай байдлыг сайжруулан, даатгуулагчтай холбоотой статистик болон дүн шинжилгээний мэдээллийг илүү нарийвчлалтай гаргах нөхцөлийг бүрдүүлж байна.

### 8.10.Иргэд даатгуулагч, ажил олгогч, харилцагч байгууллагуудад үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээг өргөжүүлэв.

Иргэд, даатгуулагч, ажил олгогч руу чиглэсэн цахим үйлчилгээг өргөжүүлэх хүрээнд дараах боломжуудыг бүрдүүлэн ажиллалаа. Тухайлбал:

*A. Portal.ndaatgal.mn веб системд өөрчлөлт, хөгжүүлэлт хийж нэвтрүүлэв.*

- Даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэвэр, ҮОМШӨ-ний хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ цахимаар гаргах нөхцөлийг бүрдүүллээ. Ингэснээр даатгуулагчаас цаасан баримт шаардахгүйгээр нийгмийн даатгалын мэдээллийн санд тулгуурлан даатгуулагчийн мэдээллийг цахимаар шалган тэтгэврийг цахимаар тогтоох боломж бүрдсэн. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээс хойш нийтдээ 210 даатгуулагч цахимаар хүсэлтээ гаргасны 72.5%-ийг шийдвэрлэсэн байна.

- Ажил олгогчийн портал системийн хэрэглэгчийн эрхийн удирдлагыг сайжруулав. Байгууллагын дарга, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтан өөрийн ажлын чиг үүрэгт тохирсон эрхээр нэвтрэх боломжтой болж, эрхийн хуваарилалт, хязгаарлалтыг илүү тодорхой болгов.

- Нийгмийн даатгалын тайланг тоон гарын үсгээр баталгаажуулан илгээх боломжийг бүрдүүлэв. Ингэснээр ажил олгогчид илүү найдвартай, баталгаатай байдлаар тайлангаа илгээх

нөхцөл бүрдсэн. Үүнийг нэвтрүүлснээр одоогийн байдлаар 1.0 мянга гаруй ажил олгогч сар бүр тайлангаа тоон гарын үсгээр баталгаажуулан илгээсэн байна.

- Ажил олгогчдод системийн шинэчлэлт, өөрчлөлт болон бусад шаардлагатай мэдээллийг шуурхай хүргэх зориулалтаар “Зар мэдээний булан” шинээр нэмэв.

- ҮОМШӨ-ий даатгуулагчийн сэргээн засах төв болон сувилалд ирэх буцах унааны зардлын хүсэлтийг Portal.ndaatgal.mn вэб системээр цахимаар авах хөгжүүлэлтийг хийж туршин нэвтрүүлэхэд бэлэн болгов.

- Цахим архивын программ хангамжид бүртгэсэн мэдээллийг SICOS системд ашиглах боломжийг бүрдүүллээ. Ингэснээр мэдээллийн дамжуулалт автоматжиж, байцаагч ажилтнуудын гар ажиллагаа болон өдөр тутмын ачаалал буурна. Үүний үр дүнд иргэд, даатгуулагчдад үзүүлэх үйлчилгээний хурд, чанар сайжирч, бичиг баримт шалгах, мэдээлэл баталгаажуулах үйл ажиллагаа богиносж, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрэн хангагдах болно.

#### *Б. Мэдээлэл солилцох сервис шинээр боловсруулан нэвтрүүлэв.*

Е-Mongolia порталаар дамжуулан даатгуулагч жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон ажилгүйдлийн тэтгэмж, мөн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг цахимаар гаргах боломжийг бүрдүүлэх зориулалтаар холбогдох 4 төрлийн сервисийг шинээр боловсруулан И-Монгол академи УТҮГ-т хүргүүлсэн.

#### *В. “Тэтгэврийн нөөц сан”-гийн мөнгөжүүлсэн орлогыг тооцон олон сувгаар цахимаар хүргэх ажлыг зохион байгуулав.*

- Даатгуулагч “Нийгмийн даатгал” аппликейшн, Portal.ndaatgal.mn веб болон Е-Mongolia системүүдээр “Мөнгөжүүлсэн хуримтлал”-ын мэдээллээ он, оноор сонгож харах боломжийг бүрдүүллээ.

- 2025 оны 05 дугаар сард “Тэтгэврийн нөөц сан”-д байршуулсан 25.0 тэрбум төгрөг, 10 дугаар сард байршуулсан 40.0 тэрбум төгрөгийг даатгуулагчдад хуваарилан мөнгөжүүлсэн орлогоор бүртгэсэн. Энэхүү мэдээллийг даатгуулагч “Нийгмийн даатгал” аппликейшн, “Е-Mongolia” портал, Portal.ndaatgal.mn системээр дамжуулан цахимаар харах боломжийг бүрдүүлсэн.

#### *8.11.Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар хүргэв.*

Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР систем болон нийгмийн даатгалын Portal.ndaatgal.mn веб системээр дамжуулан иргэд, даатгуулагч, ажил олгогч, харилцагч байгууллагуудад нийгмийн даатгалын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар тогтмол хүргэн ажиллав. Үүний дүнд мэдээллийн нэгдсэн систем (Sicos)-ээр 259.2 мянган, Portal.ndaatgal.mn системээр 216.2 мянган, нийт 475.5 мянган тэтгэвэр, тэтгэмжийн болон сайн дураар даатгуулах үйлчилгээ авах хүсэлт, мөн сар бүр 61.9 мянган ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цахимаар хүлээн авч 98.0%-ийг шийдвэрлэсэн байна. Тухайлбал:

- Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, шимтгэл төлөх нийт 153.4 мянган хүсэлтийг хүлээн авч 98.9%-ийг шийдвэрлэсэн байна;

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох, жирэмсний болон амаржсаны тэтгэмж тогтоох, олгох, ажилгүйдлийн тэтгэмж тогтоох, олгох нийт 230.9 мянган хүсэлтийг хүлээн авч 97.5%-ийг шийдвэрлэсэн байна.

- Өндөр нас, ХЧА-ны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр шинээр тогтоолгох, мөн тэтгэврээ өөрчлөн тогтоолгох 80.8 мянган иргэний хүсэлтийг хүлээн авч 96.9%-ийг шийдвэрлэсэн байна.

- Тэтгэвэр олголт:

\*сар бүр дунджаар 530.1 мянган тэтгэвэр авагч (давхардсан тоогоор нийтдээ 6.1 сая)-ийн тэтгэвэр олголтын тооцооллыг системээр тооцоолон цаг хугацаанд нь холбогдох банк руу илгээсэн байна.

- Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан:

\*нийт 61.9 мянган ажил олгогчийн сар бүр илгээсэн 681.1 мянган удаагийн, давхардсан тоогоор 8.8 сая албан журмын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 100% цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн байна.

\*ажил олгогчоос цахимаар илгээсэн 81.1 мянган албан журмаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн байна.

- Эмнэлгийн хуудас:

\*992 эрүүл мэндийн байгууллагаас 176.7 мянган албан журмын болон сайн дурын даатгуулагчийн, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 58.5 мянган даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн, нийт 235.2 мянган эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн байна.

- Лавлагаа тодорхойлолт:

\*нийгмийн даатгалын портал системээр 79.3 мянган даатгуулагч, 92.7 мянган ажил олгогч QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолт цахимаар авсан байна.

- E-Mongolia нэгдсэн портал:

\*иргэд даатгуулагч, ажил олгогч 5.9 сая удаагийн лавлагаа тодорхойлолтыг цахимаар авсан байна. Үүнд:

\*Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт /англи, монгол хэл/: 5.5 сая

\*Нийгмийн даатгал төлж байсан эсэх тодорхойлолт: 273.5 мянга

\*Өндөр нас, ХЧА, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас /англи, монгол хэл/: 86.2 мянга

\*Иргэн/даатгуулагч/-д НДС-гаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт: 61.2 мянга

\*ХЧА-ын хувь, хугацаа тогтоосон акт: 51.2 мянга

\*Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа: 55.6 мянга

\*Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт: 204.

- [www.opendata.gov.mn](http://www.opendata.gov.mn):

\* Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн Газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", 200 дугаар тогтоолоор баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын дагуу 2025 оны эхний хагас жилийн байдлаарх нийгмийн даатгалын 16 нэр төрлийн нээлттэй мэдээллийг тус бүр дөрвөн форматаар хувирган [www.opendata.gov.mn](http://www.opendata.gov.mn) болон [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) вэб сайтуудад цаг хугацаанд нь байршуулсан.

### *8.12. Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2024 оны жилийн эцсийн үлдэгдлийн тооцооллыг хийв.*

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн “Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” 2025 оны 10 тоот тогтоолын дагуу нийт 1.7 сая даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2024 оны жилийн эцсийн байдлаарх үлдэгдлийн тооцооллыг хийж шалгав.

### *8.13. Салбарын байгууллагуудын сүлжээ, шилэн кабель, интернэтийн үйлчилгээ болон компьютер, техник хангамжийн хэвийн ажиллагааг ханган ажиллав.*

Төв орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын 32 нэгж, нийслэлийн төрийн үйлчилгээний 4 цэг, нийслэлийн 5, орон нутгийн 10 тасгийн дотоод сүлжээ, техник хангамжийн хэвийн ажиллагааг ханган ажиллах хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:

#### *○ Шилэн кабелийн үйлчилгээ:*

Нийслэлийн 15, орон нутгийн 19 нэгж /нийт 34/-ийн шилэн кабелийн урсгалын хурд 20mbps-40mbps байсныг 70mbps болгон нэмэгдүүлэв. Шилэн кабелийн хурдыг нэмснээр өгөгдөл дамжуулах хурд, багтаамж болон сүлжээний тогтвортой байдал сайжирч, саатал буурч, олон хэрэглэгч зэрэг ачаалал үүсгэх үед сүлжээ асуудалгүй ажиллах боломжийг бүрдүүлсэн.

#### *○ Интернэтийн үйлчилгээ:*

Иргэд, даатгуулагч болон ажил олгогчдод нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай, найдвартай хүргэх, мөн мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор салбарын хэмжээнд ашиглаж байсан интернэтийн хурдыг 280Mbps-ээс 400Mbps болгон нэмэгдүүллээ. Ингэснээр мэдээлэл татах, илгээх үйл явцыг түргэсгэж, цахим

үйлчилгээнүүд сааталгүй, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэв. Мөн ажилтнуудын өдөр тутмын ачааллыг бууруулж, байгууллагын дотоод сүлжээний нэвтрэх чадвар болон өгөгдөл дамжуулалтын найдвартай байдлыг нэмэгдүүлэх давуу тал бий болсон.

Түүнчлэн SICOS системийг сумдад нэвтрүүлсэнтэй уялдуулан шинээр 280 ширхэг хөдөлгөөнт интернэтийн төхөөрөмж, дагалдах дата эрхийг худалдан авч хуваарилан байцаагч ажилтнуудыг ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Ингэснээр ажилтнуудын мэдээлэл дамжуулах, системд холбогдон ажиллах боломж нэмэгдэж, SICOS системийн ашиглалт хэвийн, тасралтгүй явагдах нөхцөл бүрдсэн.

○ **Дотоод сүлжээний үйлчилгээ:**

Баянхонгор аймгийн нийгмийн даатгалын газрын ажлын байр нүүсэнтэй холбогдуулан шилэн кабелийн холболтыг нүүлгэн шилжүүлэх ажлыг харилцагч байгууллагатай хамтран зохион байгуулж сүлжээний тохиргоо үйлчилгээг хийж ажиллах нөхцөлийг бүрдүүлэв. Мөн Хөвсгөл аймаг, Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын газрын дотоод сүлжээ доголдсоныг шуурхай илрүүлж, сүлжээний рутерийг шинээр сольж хэвийн ажиллагааг хангав.

○ **Техник хангамжийн засвар үйлчилгээ:**

Төв орон нутгийн нийгмийн даатгалын 19 нэгжээс засвар, үйлчилгээ хийлгэхээр ирүүлсэн нийт 71 компьютер, техник хангамжийг хүлээн авч оношлон сэлбэг, эд ангийн гэмтлийг засах, эд ангийг шинээр солих, мөн форматлах, үйлдлийн систем сэргээх, оффиссын болон вирусын программ хангамж суулгах, шаардлагатай бусад тохиргоо үйлчилгээг хийх ажлуудыг гүйцэтгэв.

Салбарын хэмжээнд ашиглагдаж буй мэдээллийн нэгдсэн системийн үндсэн мэдээллийн баазыг ажиллуулах зориулалт бүхий хадгалах төхөөрөмж /сторэйж/-ийн ашиглалтын хугацаа дуусан хуучирч тог хэлбэлзсэний улмаас эвдэрч үндсэн тохируулагч хавтан буюу контроллер нь шатсан. Үүний улмаас бүтээгдэхүүний үйл ажиллагаа зогсож, системүүдийн хэвийн ажиллагаанд доголдол үүссэн. Энэхүү доголдол, саатлыг арилгах хүрээнд өгөгдлийн санг бүхэлд нь сэргээх, мөн Сикос, Портал болон байгууллагын үйл ажиллагааны системүүдэд үүссэн доголдлыг сэргээх томоохон ажлуудыг бусад байгууллагатай хамтран гүйцэтгэж шуурхай арга хэмжээ авч ажиллав.

○ **Бусад үйлчилгээ:**

Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын сервер компьютерүүдийг унтраахтай уялдуулан хуучин системийг ашиглах хэрэгцээ шаардлага үүсч байгаа тул газар бүрийн (нийт 30 сервер) өгөгдлийн сангуудыг Мэдээллийн технологийн төвд байрлах шинэ серверт нэгдсэн байдлаар хуулж авах ажлыг зохион байгуулж туршин шалгах ажлыг гүйцэтгэж байна. Ингэснээр нэгжүүд хуучин систем болон шинэ систем дээрх мэдээллээ тулган шалгах боломж бүрдэх юм. Түүнчлэн орон нутагт ашиглагдаж буй серверүүдийн ашиглалт, үйлчилгээ, мэдээллийн аюулгүй байдлыг тус тусд нь хангах бус, нэгдсэн байдлаар удирдах нөхцөл бүрдэнэ.

## 9. ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ТӨВ ЗӨВЛӨЛ

### 9.1. Эрүүл мэндийн магадлалын хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл нь эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр доорх баримт бичгийг боловсруулж батлуулав. Үүнд:

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын “Мэдээлэл солилцох тухай” А/125, А/212 дугаар хамтарсан тушаал 2025/05 сард;

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол – 1

“Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн ҮОМШӨ-ий даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай” 12 дугаар тогтоол;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал-38

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/12 дугаар тушаалаар 3 аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/01 сард;

2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/19 дугаар тушаалаар 3 аймаг, 1 дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/02 сард;
3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Шилдэг эрүүл мэндийн магадлалын зөвлөл”-ийг шалгаруулах А/37 дугаар тушаалаар баталсан 2025/02 сард;
4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/52 дугаар тушаалаар 1 аймаг, 1 дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/03 сард;
5. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/73 дугаар тушаалаар Сэтгэцийн өвчний салбар зөвлөл, 1 аймаг, 1 дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/03 сард;
6. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Тушаал хүчингүй болгох тухай” А/84 дүгээр тушаал 2024/04 сард;
7. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/93 дугаар тушаал 2024/04 сард;
8. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/97 дугаар тушаал 2024/04 сард;
9. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Нийгмийн даатгалын ерөнхий газраас Орхон аймагт зохион байгуулах хяналт, шалгалтын удирдамж, албан томилолтын зардлын төсөв батлах, томилолтоор ажиллуулах тухай” А/100 дугаар тушаал 2024/04 сард;
10. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах тухай” А/101 дүгээр тушаал 2024/04 сард;
11. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Хөдөлмөрийн чавар алдалтын хувь, хугацаа тогтоолгон гадаад улсад амьдарч байгаа иргэдийг дахин магадлах хяналт, шалгалтын удирдамж батлах тухай” А/104 дүгээр тушаал 2024/04 сард;
12. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/113 дугаар тушаалаар 3 аймаг, 2 дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/04 сард;
13. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Шалгалтын танилцуулгатай танилцсан, үүрэг өгөх тухай” А/127 дугаар тушаал 2025/05 сард;
14. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/135 дугаар тушаалаар Мэргэжлээс шалтгаалсан өвчний эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/05 сард;
15. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/146 дугаар тушаалаар 2 аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/05 сард;
16. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Шалгалтын танилцуулгатай танилцсан, үүрэг өгөх тухай” А/150 дугаар тушаал 2025/05 сард;
17. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Шалгалтын танилцуулгатай танилцсан, үүрэг өгөх тухай” А/151 дүгээр тушаал 2025/05 сард;
18. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Хөтөлбөр батлах тухай” А/152 дугаар тушаал 2025/05 сард;
19. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Захиргааны акт хүчингүй болгох тухай” А/156 дугаар тушаал 2025/06 сард;
20. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/164 дүгээр тушаал 2025/06 сард;
21. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/157 дугаар тушаалаар 3 аймаг, 2 дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/06 сард;

22. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/164 дүгээр тушаал 2025/06 сард;
23. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/203 дугаар тушаалаар Сэтгэцийн өвчний эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, 3 аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/07 сард;
24. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/214 дүгээр тушаалаар Сэтгэцийн өвчний эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/08 сард;
25. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/222 дугаар тушаалаар Дорноговь, Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/08 сард;
26. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/219 дүгээр тушаалаар Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/08 сард;
27. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/229 дүгээр тушаалаар Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/09 сард;
28. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/233 дугаар тушаалаар Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/09 сард;
29. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/247 дугаар тушаалаар Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ аймаг, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/09 сард;
30. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Захиргааны акт хүчингүй болгох тухай” А/156 дугаар тушаал 2025/06 сард;
31. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/255 дугаар тушаалаар Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/09 сард;
32. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/258 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/09 сард;
33. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/271 дүгээр тушаалаар Хөвсгөл аймаг, Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/10 сард;
34. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/272 дугаар тушаалаар Завхан, Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/10 сард;
35. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/295 дугаар тушаалаар Орхон, Дорнод, Говь-Алтай, Төв, Говьсүмбэр, Сүхбаатар, Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/10 сард;

36. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/327 дугаар тушаалаар Хэнтий аймаг, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/11 сард;
37. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/348 дугаар тушаалаар Сэтгэцийн өвчний эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, Ховд аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/12 сард;
38. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/390 дүгээр тушаалаар Завхан, Увс аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан 2025/12 сард;

#### ЭММТЗ-ийн даргын баталсан удирдамж-4

1. “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн судлаач бүлэг байгуулан ажиллах удирдамж” 2025/02 сард;
2. Магадлагч эмч нарын өглөөний ярилцлага зохион байгуулах удирдамж 2025/02 сард;
3. Нийслэлийн дүүргүүдийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулах удирдамж 2025/05 сард;
4. Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд ижил мэргэжилтний үзлэгийг цахимаар зохион байгуулах удирдамж 2025/05 сард;

#### 9.2. Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанарыг сайжруулах чиглэлээр

Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, даатгуулагч, хүнд үзүүлэх эрүүл мэндийн магадлалын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох, дотоодын хяналтыг эрчимжүүлэх, салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2025 оны “Шилдэг Эрүүл мэндийн магадлалын зөвлөл шалгаруулах” ажлыг зохион байгуулав. Уг ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/37 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Шилдэг Эрүүл мэндийн магадлалын зөвлөл шалгаруулах удирдамж”, тушаалын хоёрдугаар хавсралтаар “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг дүгнэх үнэлгээний хуудас”, тушаалын гуравдугаар хавсралтаар “Магадлагч эмчийн ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлт” батлуулан салбар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын байгууллагын дарга нарт 2025 оны 02 дугаар сард хүргүүлэв. Шилдэг эрүүл мэндийн магадлалын зөвлөл шалгаруулах үр дүнгийн тайланг 2025 оны 12 дугаар сард Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл авч, нэгтгэн тус үнэлгээний хуудасны дагуу 14 шалгуур үзүүлэлтээр, 0-10 оноогоор үнэлж, 69 хүлээн ба түүнээс доош үнэлгээ авсан тохиолдолд “Хангалтгүй”, 70-89 оноогоор үнэлэгдсэн тохиолдолд “Хангалттай”, 90-100 оноогоор үнэлэгдсэн тохиолдолд “Бүрэн хангалттай” гэж үнэлэв. Үнэлгээний хуудсаар авсан онооны байдлаар:

- 91 оноо авч “Бүрэн хангалттай” үнэлэгдсэн Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл “Шилдэг эрүүл мэндийн магадлалын зөвлөл”
- 88 оноогоор “Хангалттай” гэж үнэлэгдсэн Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл дэд байр
- 86 оноогоор “Хангалттай” гэж үнэлэгдсэн Увс аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь гутгаар байрыг тус тус эзлэв. Үнэлгээний хуудсаар үнэлэхэд 69 болон түүнээс доош оноо авч “Хангалтгүй” үнэлгээг Баянхонгор, Говьсүмбэр, Дархан-Уул, Хэнтий аймгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлүүд үнэлэгдэв. Цаашид хангалтгүй үнэлгээ авсан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын удирдлагад хууль, дүрэм, журмыг баримтлан хэрэгжилтийг ханган ажиллах тухай чиглэл, зөвлөмж хүргүүлэв.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох

үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулийн өөрчлөлтөд тусгах 6 санал боловсруулж, Бодлогын хэрэгжилт судалгааны газарт уламжлан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/763 тоот албан бичгээр, Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, цуцлах ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх, сэргээн засах сувиллын тусламж үйлчилгээнд хамрагдсан байдал болон эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэлд хяналт тавихад эрүүл мэндийн байгууллагаас шаардлагатай мэдээллийг солилцох зорилгоор мэдээллийн жагсаалт, эрүүл мэндийн магадлалын зөвлөлд цахимаар илгээх үечилсэн дүгнэлтийн загварыг тус тус боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/901 тоот албан бичгээр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Санал уламжлах тухай” албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах саналын төсөл боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэв. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177, А/433 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”-д өөрчлөлт оруулах саналыг “Санал ирүүлэх тухай” ЭММТЗ-ийн даргын 09/67 тоот албан бичгийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлэн санал авч нэгтгэж, журамд өөрчлөлт оруулах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Санал уламжлах тухай” 01/1477 тоот албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл нь магадлалын үйл ажиллагааг шинэ түвшинд хүргэх, салбарын өмнө тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, суурь судалгаатай болох замаар нотолгоонд суурилсан эрүүл мэндийн магадлалын статистик тоон мэдээлэлтэй болох зорилгын хүрээнд “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн судлаач бүлэг” байгуулан ажиллаж байна. Тус “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн судлаач бүлэг байгуулан ажиллах удирдамж”, хөтөлбөр, сэдэв, бүлгийн хуваарилалтыг Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргаар батлуулж, Төв зөвлөлийн даргын 2025 оны 09/16 тоот албан бичгээр салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга нарт хүргүүлэв. Судлаач бүлгийн сургалтад хамрагдахаар аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн нийт 89 эмч, мэргэжилтнүүд хамрагдах хүсэлт ирүүлснээс 60-70 хувийн ирцтэйгээр оролцож байна. Баталсан удирдамж, хуваарь, хөтөлбөрийн дагуу Дэлхийн банкны Ковид-19 төслийн мэргэжилтэн, АУ-ны доктор А.Энхжаргал, АШУҮИС-ийн НЭМ-ийн сургуулийн Орчны эрүүл мэндийн тэнхмийн эрхлэгч АУ-ны доктор С.Мягмарчулуун нар цахим болон танхим хосолсон хэлбэрээр дараах 5 удаагийн сургалтыг зохион байгуулав. Үүнд:

- Судалгааны үндсэн ойлголт, арга зүй
- Судалгааны өгүүлэл, илтгэлийн талаарх ерөнхий ойлголт
- Судалгааны ажлын удирдатгал хэсэг хэрхэн бичих тухай ерөнхий ойлголт
- Судалгааны ажлын сэдэв, аргачлал сонгох
- Судалгааны ажлын хэвлэлийн тойм, өгүүлэл хэрхэн унших, бичих тухай ойлголт зэрэг сэдвүүдээр орсон байна.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн судлаач бүлэг нь 2025 оны 02 дугаар сараас 11 дүгээр сар хүртэлх хугацаанд зохион байгуулагдаж баталсан сэдвийн хүрээнд магадлагч эмч нар судалгааны арга аргачлалд суралцах, судалгааны ажлын үр дүн, статистик боловсруулалт хийх, нэгтгэн дүгнэх чадварт суралцаж мэдлэг чадвар, дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын баталсан “Магадлагч эмч нарын өглөөний ярилцлага зохион байгуулах удирдамж”-д заагдсан хуваарийн дагуу эхний хагас жилд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч нар нийт 5 удаагийн уулзалт ярилцлагыг зохион байгуулав. Үүнд:

- Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс 2025 оны 01 сарын 31-ний өдөр анхны уулзалтыг зохион байгуулж, “Магадлагч эмч нарын өглөөний ярилцлага зохион байгуулах удирдамж, хуваарь”, “Шилдэг Эрүүл мэндийн магадлалын зөвлөл шалгаруулах удирдамж”, “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг дүгнэх үнэлгээний хуудас”, “Магадлагч эмчийн ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг тус тус танилцуулав.
- Архангай, Сүхбаатар аймаг, БЗД – 2025-02-28;

- Дархан-Уул, Дорнод аймаг, Багануур дүүрэг – 2025-03-28;
- Төв, Ховд аймаг, СХД – 2025-04-25;
- Баянхонгор, Хэнтий, Хан-Уул – 2025-05-30-ны өдрүүдэд тус тус цахим хэлбэрээр зохион байгуулав.

Магадлагч эмч нарын өглөөний ярилцлагыг сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гаригт хуваарийн дагуу аймаг, дүүргийн 3 магадлагч эмч 1 баг болон хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааны магадлан шийдвэрлэхэд гарч буй алдаа зөрчил, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн өнөөгийн байдал, сайжруулах арга зам зэрэг магадлалын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг дэвшүүлэн нээлттэй ярилцлага өрнүүлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал хэлэлцэн, шийдвэрлэх арга замыг тодорхойлж нэгдсэн ойлголтод хүрч байгаараа ач холбогдолтой байна.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 2025 оны 09/17 тоот албан бичгээр Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинээр нэвтрүүлэх цахим программын хөгжүүлэлтэд тусгах 164 санал бүхий программын даалгавар, тэтгэмжийн программын магадлагч эмчийн хяналтын дэд системийн хэсэгт тусгах 7, нийт 171 санал боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төвд 2025 оны 02 сард хүргүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Мэдээлэл солилцох тухай” 01/557 тоот албан бичгээр Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг магадлан шийдвэрлэх, эмнэлгийн хуудасны бичилт, олголтын болон эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн төлбөр, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн үндэслэл зэрэгт цахимаар хяналт тавих боломжийг бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч нартай “Хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах гэрээ” байгуулж хамтран ажиллах талаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт албан хүсэлт хүргүүлсэн болно. /2025.04 сар/

Дээрх ажлын хүрээнд Мэдээллийн технологийн төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран иргэний эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл солилцох үйл ажиллагааны урьдчилсан туршилтыг Багануур дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн программд тулгуурлан хийв. /2025.06 сар/

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс эмнэлгийн хуудасны бичилт, олголттой холбоотой тушаал шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах, даатгуулагчид эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж, олгох үйл явцад тулгарч буй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх арга замыг хэлэлцэх зорилгоор “Эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж олгоход анхаарах асуудал” сэдэвт цахим хэлэлцүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулав. Энэхүү хэлэлцүүлгийн зорилго нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны А/177, А/443 дугаар тушаалаар баталсан “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам” болон эмнэлгийн хуудасны бичиж, олгохтой холбоотой тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар санал солилцож, нэгдсэн ойлголтод хүрэх юм. Цахим хэлэлцүүлэгт Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл, Мэдээллийн технологийн төв, Эрүүл мэндийн цахим систем хөгжүүлэгч байгууллагын төлөөлөл, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч нар болон эмнэлгийн хуудсыг бичиж, олгох эрх бүхий эрүүл мэндийн байгууллагын 1000 гаруй эмч, мэргэжилтнүүд оролцов.

Тус хэлэлцүүлгээр Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс “Эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж, олгоход анхаарах асуудал” сэдвээр мэдээлэл өгч, даатгуулагчид эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж, олгох үйл явцыг чирэгдэлгүй, тэгш хүртээмжтэй үзүүлэх арга замыг тодорхойлоход чиглэсэн цахим системийн хөгжүүлэлтийг хэрхэн хийх талаар хэлэлцэж, оролцогчдын асуултад хариулт өгч, санал солилцов.

“Эрүүл мэндийн магадлалтай холбоотой тушаал шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарах асуудал” сэдэвт цахим уулзалт хэлэлцүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулав.

Энэхүү хэлэлцүүлгийн зорилго нь эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, түүнийг шийдвэрлэх арга замыг хэлэлцэх, магадлалын үйл ажиллагаанд оролцогч

эмч, мэргэжилтнүүдэд зонхилон тохиолдох өвчний иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэхэд анхаарах асуудлаар санал солилцож, нэгдсэн ойлголтод хүрэх юм. Уулзалт хэлэлцүүлгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дарга Т.Лхагвадорж нээж, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсч, үг хэлэв.



Тус уулзалт хэлэлцүүлэгт аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 250 гаруй дарга, гишүүд оролцов.

Уулзалт хэлэлцүүлгийн үед:

1. Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс 2024 онд зохион байгуулсан үйл ажиллагааны товч тайлан, 2025 онд хийхээр төлөвлөж буй ажлууд цаашид анхаарах асуудал сэдвээр Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дарга Т.Лхагвадорж;
2. Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн хамтарсан болон дахин магадлалаар илэрч буй нийтлэг зөрчил дутагдал, цаашид анхаарах асуудал сэдвээр магадлагч эмч Ц.Гансүх;
3. 2024 оны жилийн эцсийн тоон тайлангийн дүн шинжилгээ, тайлан гаргахад анхаарах асуудлууд сэдвээр магадлагч эмч Д.Тэмүүжин;
4. Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн хурлын оролцоо, хуралдсан цагийн судалгааны дүнгийн танилцуулга сэдвээр магадлагч эмч Д.Тогтохжаргал нар тус тус илтгэл танилцуулга хийв.

Сургалтын явцад даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар оролцогчид асуулт асууж, холбогдох эмч, мэргэжилтнүүд хариулт мэдээлэл өгч, тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэв.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурлын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан “Төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэнээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээ шат дамжлагагүй шуурхай болно” гэсэн зорилт, цахим Монгол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд цахим шинэчлэл нэвтрүүлэх даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох үйл ажиллагааны чанарыг сайжруулах, үнэн зөв, шуурхай шийдвэрлэх, аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн ачааллыг тэнцвэржүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах, төрийн байгууллага хоорондын мэдээллийн солилцоог сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд цахим шинэчлэл нэвтрүүлэх хөтөлбөрийг боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Тушаал батлах тухай” А/152 дугаар тушаалаар батлуулж, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын “Тушаал хүргүүлэх тухай” 09/71 тоот албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд цахим шинэчлэл нэвтрүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд эрүүл мэндийн магадлалын өнөөгийн байдлын дүн шинжилгээ, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө, цахим шинэчлэлийн үед шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн санхүүгийн тооцоолол, цахим программын процессын зураглалыг гаргав. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/164 дүгээр тушаалаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөг боловсруулж бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төвийн болон сувиллын сонгон шалгаруулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/97 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийг байгуулан сонгон шалгаруулалтад оролцох сувиллуудын баримт, бичгийг 2025 оны 06 дугаар сард хүлээн авч ажиллав. Тус сонгон шалгаруулалтад оролцохоор материалаа ирүүлсэн сувилаллуудын баримт бичигт үзлэг, шалгалт хийж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгуулагчид сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам”-ын 3-т зааснаар “Сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагад тавигдах шаардлага”-ыг хангасан эсэхэд үнэлгээ өгч дараах сувиллуудыг сонгон шалгаруулж, хамтран ажиллах гэрээ байгуулахаар болов.

- Альфамедикал центр ХХК
- Галт халуун рашаан ХХК
- Ананд хужирт ХХК
- Сэргээн засах клиник эмнэлэг
- Уламжлалт анагаах ухааны технологийн хүрээлэнгийн Ургамал сувилал
- Си Си хатан ХХК
- Хос шинэс ХХК

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм” болон холбогдох эрхзүйн баримт бичгийг үйл ажиллагаандаа баримтлан, даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын талаар, судалгаа шинжилгээ хийх, хууль тогтоомжийн хүрээнд харилцан мэдээлэл солилцох чиг үүргийн хүрээнд Эрүүл мэндийн байгууллагын цахим мэдээллийн санд тулгуурлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар харилцан мэдээлэл солилцох зэрэг чиглэлээр Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран ажиллах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын “Хамтран ажиллах тухай” 01/293 тоот албан бичгийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэв. Тус албан бичгийн хүрээнд төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлж Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл нь Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 2025 оны 04 дүгээр сард байгуулав. Тус санамж бичгийн хүрээнд эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцож буй эмч мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтад хамруулж, магадлалын үйл ажиллагаатай холбоотой судалгаа, шинжилгээ хийх, эрдэм шинжилгээний бага хурал хамтран зохион байгуулах зэрэг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэн ажиллав.

2025 оны эхний хагас жилийн байдлаар Сэтгэцийн болон Мэргэжлээс шалтгаалсан өвчний Эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн 38 удаагийн хуралд Төв зөвлөлийн магадлагч эмч нар оролцож, нийт 1424 даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг магадлан шийдвэрлэв. Үүнээс шинээр 68 иргэнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоож, 1142 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгаж, 141 иргэнийг цуцалж, 27 даатгуулагчийн хөдөлмөрийн нөхцлийг өөрчилж, баримт бичгийн бүрдэл дутуу үндэслэлээр 19 иргэнийг буцааж холбогдох баримт бичгийг бүрдүүлэн шийдвэрлэв. Үүнээс:

Мэргэжлээс шалтгаалсан өвчний Эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн 20 удаагийн хуралд Төв зөвлөлийн магадлагч эмч оролцож, шинээр 22 иргэнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоож, 27 иргэнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг нэмж, 503 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгаж, 96 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцалж, 27 иргэний хөдөлмөрийн нөхцлийг сольж, мэргэжлээс шалтгаалсан өвчин илрээгүй үндэслэлээр 19 иргэнийг буцааж, нийт 694 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цахим хэлбэрээр магадлан шийдвэрлэв.

Сэтгэцийн өвчний салбар зөвлөлийн 18 удаагийн хуралд Төв зөвлөлийн магадлагч эмч оролцож 46 иргэнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоож, 639 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгаж, 45 иргэнийг цуцалж шийдвэрлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу “Ижил мэргэжилтний үзлэг”-ийг 2025 оны 06 дугаар сард нийслэлийн төвийн 6 дүүрэгт танхимаар, Багануур, Налайх дүүрэг болон 21 аймагт цахим хэлбэрээр зохион байгуулав. Уг үйл ажиллагаанд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 140 гаруй эмч, мэргэжилтнүүд оролцов. Ижил мэргэжилтний үзлэгээр Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн цахим хяналтаар зөрчилтэй байх магадлалтай жагсаалтад бүртгэгдсэн 145 даатгуулагч, хүнийг сонгож, картын бичилт, шинжилгээний бүрдэл, хяналтын явц, ЭММЗ-ийн хуралд бэлтгэсэн дүгнэлт, оношийн үндэслэлтэй танилцаж, иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтооход баримтлах гарын авлагын шалгуурын дагуу үнэлгээг хуваарийн дагуу бусад зөвлөлийн магадлагч эмч, нарийн бичгийн дарга, дотор, мэдрэл, гэмтэл, мэс засал, сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн эмч нараас бүрдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй баг үнэлгээ хийв. Энэ удаагийн “Ижил мэргэжилтний үзлэг” нь өөрийн болон бусад зөвлөлийн мэргэжил нэгт эмч нарынхаа үйл ажиллагааг харьцуулан алдаа дутагдлаа залруулах, сайн туршлагаас суралцах, улмаар даатгуулагч, хүнд эрүүл мэндийн магадлалын үйлчилгээг холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх талаар ахиц дэвшил гарах боломжийг бүрдүүлснээрээ чухал ач холбогдолтой болов.



Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл 2015 оноос эхлэн жил бүр аймаг, дүүргийн эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд болон эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүдийг хамарсан “Эрдэм шинжилгээний бага хурал”-ыг зохион байгуулдаг бөгөөд 2025 оны эрдэм шинжилгээний бага хурлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулагдах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хамтран 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

“Эрүүл мэндийн магадлалын шинэчлэл” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын удирдамжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах тухай” А/101 дүгээр тушаалаар батлуулж, аймаг, дүүрэг болон холбогдох Эрүүл мэндийн байгууллагуудад Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1044, 01/1061 тоот албан бичгээр тус тус хүргүүлэн хурлын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд одоогийн байдлаар 15 төрлийн актын маягыг цаасан хэлбэрээр ашиглаж байна. Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх үечилсэн дүгнэлт, саналыг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд цахимаар илгээх үечилсэн дүгнэлтийн загвар боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/901 дүгээр албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд уламжлан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны “Мэдээлэл солилцох тухай” А/125, А/212 дугаар хамтарсан тушаалаар батлуулав.

Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэлтэй холбоотой бичгээр ирүүлсэн 23, өөрийн биеэр болон утсаар ирүүлсэн 35, нийт 58 өргөдөл, гомдлыг хүлээн авч, “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийг үндэслэн Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөлүүд болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн шинжээч эмч нараар дүгнэлт гаргуулан, хянан шийдвэрлэж бичгээр болон бусад хэлбэрээр хуулийн хугацаанд хариу хүргүүлэв.

Засгийн газрын 1111 төвөөс шилжүүлсэн 10 өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэн хариуг хугацаанд нь хүргүүлэв.

### 9.3.Хяналт, шалгалтын чиглэлээр

#### Дахин магадлал:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс дахин магадлал зохион байгуулах нэгдсэн удирдамж”-ийн дагуу Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн магадлагч эмч нар Орхон аймаг болон Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдэд хяналт, шалгалтыг зохион байгуулав.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн 5 удаагийн дахин магадлалаар дээрх аймаг, дүүргүүдийн нийт 1420 иргэнийг дахин магадалж үүнээс 1212 (85.4%) даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр, 32(2.3%) даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг өөрчилж, 51 (3.6%) даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцлахаар шийдвэрлэж, онош баталгаажуулах шинжилгээнд 23 (1.6%) иргэнийг илгээв. Хяналт, шалгалтын хугацаанд магадлалд хамрагдаагүй 101 (7.1%) иргэн байна. Мөн илэрсэн зөрчил дутагдлыг арилгах Нийгмийн даатгалын санд учруулсан 7016706 төгрөгийн хохирлыг буцаан төлүүлэхээр Улсын байцаагчийн акт тогтоож биелэлтийг хангуулж ажиллав. Хяналт шалгалтын хугацаанд аймаг, дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвөөс бичиж, олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн, амаржсаны эмнэлгийн хуудасны үндэслэлд эрүүл мэндийн байгууллагын E-health, Health.gov.mn, Andmed.mn, Medsoft программд тулгуурлан хөдөлмөрийн чадвар түр алдсаны 4165, жирэмсэн, амаржсаны 1083 эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэлд хяналт тавив. Мөн тус шалгалтын үед Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн 200 орчим эмч, мэргэжилтнүүдэд Эрүүл мэндийн магадлалын хууль эрхзүйн шинэчлэлт түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар сургалт зохион байгуулав.

➤ Баянгол дүүргийн дахин магадлалыг 2025 оны 02 дугаар сарын 18-27-ны өдрийг хүртэл зохион байгуулав. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус дүүрэгт хөдөлмөрийн чадвар алдсан 5574(2.2%) даатгуулагч, хүн байна. Дахин магадлалаар нийт 300 даатгуулагч, хүнийг түүвэрлэсэн ба үүнээс:

- Халдварт өвчнөөр – 28 /9.3%/
- Сэтгэцийн өвчнөөр – 3 /1%/
- Дотрын өвчнөөр– 184 /61.3%/
- Мэдрэлийн өвчнөөр – 26 /8.6%/
- Нүдний өвчнөөр – 5 /1.6%/
- Чих, хамар, хоолойн өвчнөөр – 43 /14.3%/
- Мэс заслын өвчнөөр – 4 /1.3%/
- Гэмтлийн өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон – 6 /2%/ даатгуулагч, хүнийг

хамруулахаар төлөвлөснөөс нас барсан 8, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 4, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа цуцалсан байсан 3, шилжсэн 6 нийт 21 даатгуулагч, хүнийг хасаж тооцон нийт 279 /91.0%/ даатгуулагч, хүнийг бичиг баримтад үндэслэн, оношийн баталгаажилт, оношилгоо, шинжилгээний бүрдэл дутуу эсхүл амбулаторийн картад хавсарган ирүүлээгүй 20 гаруй иргэнийг биеэр байлцуулан дахин магадлав. Үүнээс:

- Хэвээр - 267 (95.6%)
- Заалт, хувь өөрчилсөн – 2(0.8%)
- Цуцалсан - 9 (3.2%)
- Шинжилгээнд – 1(0.4%) даатгуулагч, хүнийг шинжилгээнд хамруулахаар шийдвэрлэв.

Дахин магадлалын явцад 2025 онд Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвөөс бичиж, олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн, амаржсаны эмнэлгийн хуудасны үндэслэлд эрүүл мэндийн байгууллагын E-health программд тулгуурлан цахимаар хяналт хийхэд хөдөлмөрийн чадвар түр алдсаны 483, жирэмсэн амаржсаны 150 эмнэлгийн хуудсыг хянахад зөрчил илрээгүй болно.

Хяналт, шалгалтын хугацаанд Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18, 25-ны өдрийн хуралд оролцож хурлын явц, даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэж буй байдал, зөвлөлийн дотоод ажилтай танилцаж, хөдөлмөрийн чадвар алдалт түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ажлын талаар болон эрүүл мэндийн магадлалын ажлыг сайжруулах талаар санал солилцож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Тухайн өдрийн хурлын ирц 90 хувьтай, нийт 130 даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлэсэнээс:

- Хэвээр – 80
- Тогтоосон – 32
- Цуцалсан – 18
- Буцаасан – 5 иргэн байв. Тухайн өдрийн хурал 8 цаг үргэлжилж, 1 даатгуулагч, хүнд дунджаар 7 минут зарцуулсан байна.


➤ 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 04-ний өдөр дуустал хугацаанд Баянзүрх дүүрэгт Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дахин магадлалыг зохион байгуулав. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус дүүрэгт хөдөлмөрийн чадвар алдсан 8586 (2.0%) даатгуулагч, хүн байгаагаас 5339 (62.2%) нь Нийгмийн даатгалын сангаас, 3247 (37.8%) нь Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч байна. Тус дүүргийн дахин магадлалаар нийт 346 иргэнийг хамруулахаар төлөвлөв: Үүнд:

- Халдварт өвчнөөр – 9 /2.6%/
- Сэтгэцийн өвчнөөр – 7 /2%/
- Дотрын өвчнөөр – 163 /47.1%/
- Мэдрэлийн өвчнөөр – 36 /10.4%/
- Нүдний өвчнөөр – 13 /3.7%/
- Чих, хамар, хоолойн өвчнөөр – 88 /25.4%/
- Мэс заслын өвчнөөр – 7 /2%/
- Арьсны өвчнөөр – 1 /0.2%/
- Гэмтэл, согогийн өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон – 22 /6.3%/ иргэнээс

түүвэрлэн нас барсан 9, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа цуцалсан байсан 2, шилжсэн 5, хамрагдаагүй 13 нийт 16 даатгуулагч, хүнийг хасаж тооцон 317 /91.6%/ даатгуулагч, хүнийг бичиг баримтад үндэслэн, оношийн баталгаажилт, оношилгоо, шинжилгээний бүрдэл дутуу эсхүл амбулаторийн картад хавсарган ирүүлээгүй 26 иргэнийг биеэр байлцуулан дахин магадласнаас:

- Хэвээр - 299 /90.6%/
- Цуцалсан - 7 /2.1%/
- Шинжилгээнд – 6 /1.9%/
- Хамрагдаагүй – 5 /1.5%/

Дахин магадлалын явцад 2024 онд Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвөөс бичиж, олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн, амаржсаны эмнэлгийн хуудасны үндэслэлд эрүүл мэндийн байгууллагын Ehealth, Health.gov.mn, Andmed.mn программд тулгуурлан цахимаар хяналт хийв. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны 3000, жирэмсэн амаржсаны 900 эмнэлгийн хуудасны үндэслэлд хяналт хийхэд хугацааг хэтрүүлсэн эсхүл үндэслэлгүйгээр бичиж олгосон, зөрчил илэрсэнгүй.



Хяналт, шалгалтын хугацаанд Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралд оролцож хурлын явц, даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэж буй байдал, зөвлөлийн дотоод ажилтай танилцаж, хөдөлмөрийн чадвар алдалт түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ажил болон эрүүл мэндийн магадлалын ажлыг сайжруулах талаар санал солилцож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Тухайн өдрийн хурлын ирц 100 хувьтай, нийт 143 даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлэв.

- Хэвээр – 101 /70.6%/
- Тогтоосон – 31/21.6%/
- Цуцалсан – 11 /7.7%%/ шийдвэрлэв. Тухайн өдрийн хурал 10 цаг үргэлжилж, 1 даатгуулагч, хүнд дунджаар 4.2 минут зарцуулсан байна.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хянан шалгахад онош заалт зөрсөн 2, заалтын хувь буруу тэмдэглэсэн 18 нийт 20 бүртгэлийн зөрчил илэрсэн бөгөөд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа магадалсан шийдвэрийн хуудастай тулгахад шийдвэрийн хуудсанд мэдээллийг зөв бүртгэсэн байв.

Харин өвчний заалтын хугацааг богиносгож сунгасан 1013 зөрчил илэрсэн бөгөөд энэ нь 2024 оны жилийн эцсийн байдлаар Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон нийт /8586/ иргэдийн 11.8 хувь, 2025 онд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа сунгуулах нийт /3593/ даатгуулагч, хүний 28.2 хувийг эзэлж байна.

➤ Чингэлтэй дүүргийн дахин магадлалыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл зохион байгуулав. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус дүүрэгт хөдөлмөрийн чадвар алдсан 3723 (2.8%) даатгуулагч, хүн байгаагаас 2119 (56.9%) нь нийгмийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч, 1604 (43.1%) нь нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авагч байна. Дахин магадлалаар нийт 306 даатгуулагч, хүнийг түүвэрлэсэн ба үүнээс:

- Сэтгэцийн өвчнөөр – 28 /9.1%/
- Нүдний өвчнөөр – 84 /27.4%/
- Чих, хамар, хоолойн өвчнөөр – 27 /9.0%/
- Мэдрэлийн өвчнөөр – 40 /13.3%/
- Дотрын өвчнөөр – 47/15.3%/
- Мэс заслын өвчнөөр – 76 /24.7%/
- Гэмтлийн өвчнөөр – 2 /0.6%/
- Халдварт өвчнөөр – 2 /0.6%/ даатгуулагч, хүнийг түүвэрлэснээс нас барсан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа цуцлагдсан, шилжсэн нийт 41 /13.4%/ даатгуулагч, хүнийг хасаж, нийт 265 иргэнийг дахин магадлахаас 222 /83.7%/ даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг бичиг баримтад үндэслэн магадлав: Үүнд:

• Хэвээр - 190 /85.6%/

• Заалтыг өөрчилж - 8 /3.6%/

• Цуцалж - 8/3.6%/

• Шинжилгээнд илгээсэн -13 /5.85%/

• Хэвээр - 190 /85.6%/

• Заалтыг өөрчилж - 8 /3.6%/

• Цуцалж - 8/3.6%/

• Шинжилгээнд илгээсэн -13 /5.85%/

Оношийн баталгаажилт, оношилгоо, шинжилгээний бүрдэл дутуу 15 /6.7%/ иргэнийг биеэр байлцуулан магадлав. Дахин магадлалд хамрагдаагүй 46 /17.5%/ даатгуулагч, хүний

хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дахин магадлалд хамруулахаар шийдвэрлэв.

Шалгалтын хугацаанд тус дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралд оролцож хурлын ирц, явц, даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэж буй байдал, зөвлөлийн дотоод үйл ажиллагаатай танилцаж, хөдөлмөрийн чадвар алдалт түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ажлын талаар болон эрүүл мэндийн магадлалын ажлыг сайжруулах талаар санал солилцож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Тухайн өдрийн хурлаар Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн ирц 90% бүрэлдэхүүнтэй /ХБИ-ний төлөөлөл хуралд оролцоогүй/-гээр нийт 67 даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнээс:

- Хэвээр – 39 /58.2%/
- Тогтоосон- 10 /14.9%/
- Цуцалж - 4/5.9%/
- Шинжилгээнд илгээсэн -14 /20.9%/

Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь тухайн өдөр 8 цаг хуралдсанаас тооцоход нэг даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэх дундаж хугацаа 8 минут байгаа нь цагийн хөлсийг төсөвлөхөд баримталсан хугацаа /7/-наас илүү байв.

Дахин магадлалын явцад Чингэлтэй дүүрэгт байрлалтай Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг болон 4 дүгээр хорооны Энэрэнгүй үйлс Өрхийн эрүүл мэндийн төвийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн, амаржсаны эмнэлгийн хуудасны үндэслэлд эрүүл мэндийн байгууллагын Medsoft болон Healthgo.mn цахим программд тулгуурлан хяналт хийж, эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж олгоход тулгамдаж буй асуудал, алдаа зөрчлийн талаар мэдээлэл солилцож, зөвлөгөө өгч ажиллав.

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Энэрэнгүй үйлс ӨЭМТ нь нийт 7 даатгуулагч, хүнд, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 55 даатгуулагч, хүнд ХЧТА-ын эмнэлгийн хуудсыг бичиж олгосон үндэслэлд хяналт хийхэд хугацааг хэтрүүлсэн эсхүл үндэслэлгүйгээр бичиж олгосон, зөрчил илэрсэнгүй.



➤ Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Нийгмийн даатгалын ерөнхий газраас Орхон аймагт зохион байгуулах хяналт, шалгалтын удирдамж, албан томилолтын зардлын төсөв батлах, томилолтоор ажиллуулах тухай” А/100 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 05 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хяналт шалгалтыг зохион байгуулав.

Хяналт, шалгалтын хүрээнд хөдөлмөрийн чадвар алдсан иргэдээс түүвэрлэн Нийгмийн даатгал болон Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч 300 даатгуулагч, хүнийг түүвэрлэсэн ба үүнээс нас барсан 4, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа цуцалсан байсан 2, нийт 6 даатгуулагч, хүнийг хасаж тооцон 294 /98.0%/ даатгуулагч, хүнийг бичиг баримтад үндэслэн, оношийн баталгаажилт, оношилгоо, шинжилгээний бүрдэл дутуу 18 иргэнийг биеэр байлцуулан дахин магадлав. Үүнд:

- Хэвээр - 241 /82.3%/
- Цуцалж - 11 /3.7%/
- Шинжилгээнд илгээсэн – 2 /1%/

- 40 даатгуулагч, хүн дахин магадлалд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хамрагдаагүй байна. Хяналт, шалгалтын хугацаанд Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралд оролцоход үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оролцоогүй, ирц 90 хувь, нийт 56 даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэлэлцэн шийдвэрлэснээс

- Хэвээр – 39 /69.7%/

- Шинээр тогтоосон – 8 /14.3%/

- Цуцалсан – 6 /10.7%/

- Буцаасан – 3 /5.3%/ оношилгоо, шинжилгээний бүрдэл дутуу шалтгаанаар 10 даатгуулагч, хүнийг биеэр байлцуулан магадлав. Тухайн өдөр 5 цаг хуралдсан бөгөөд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлэхэд нэг даатгуулагч, хүнд дунджаар 5.4 минут зарцуулж байв. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлын явцад иргэдийг шаардлагагүй оношилгоо, шинжилгээнд илгээж даатгуулагч, хүнийг буцааж байгаа алдаа дутагдал илэрч байв.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хянан шалгахад овог, нэр, регистрийн дугаар зөрүүтэй зөрчил илрээгүй бөгөөд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг 6 сарын дотор сунгуулаагүй 50 даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцлав.

Хяналт шалгалтын хугацаанд Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар, Эрүүл мэндийн газар, Засаг даргын тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газруудын фейсбүүк пейж хаягуудад хөдөлмөрийн чадвар алдалт болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудастай холбоотой хүсэлт, гомдлыг хүлээн авч буй талаар зарлал түгээсэн бөгөөд нийт 7 иргэн хөдөлмөрийн чадвар алдалттай холбоотой хүсэлт ирүүлснийг хүлээн авч хууль эрхзүйн хүрээнд шийдвэрлэв.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны нийт 8841 эмнэлгийн хуудсыг хянан баталгаажуулж шийдвэрлэснээс 2024 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон Анхны оч, Нийцэл, Мөнхийн гэгээ, Үйлс бадрах, Энхжих мандирваа, Учралтбаяр, Мөнхсүндрэл, Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төвөөс 5 ба түүнээс дээш давтамжтай болон 10 ба түүнээс дээш хоногоор бичиж, олгосон 600 гаруй эмнэлгийн хуудсыг түүвэрлэн шалгахад зөрчил илрээгүй хэдий ч Эрүүл мэндийн байгууллагад ашиглаж буй программд нэмэлт үзлэгийн бүртгэл нь зөвхөн эмнэлгийн хуудас бичсэн эмчид харагдаж буйгаас шалтгаалан зөрчилтэй мэт харагдах 60 гаруй эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэлийг иргэний амбулаторийн картын бичилттэй давхар тулган шалгасан болно.

➤ Сонгинохайрхан дүүргийн дахин магадлалыг батлагдсан удирдамжийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 18-26-ны өдрүүдэд зохион байгуулав. Дахин магадлалаар нийт 299 даатгуулагч, хүнийг түүвэрлэсэн ба үүнээс:

- Сэтгэцийн өвчнөөр – 22 /7.3%/

- Нүдний өвчнөөр – 17 /5.7%/

- Чих, хамар, хоолойн өвчнөөр – 7 /2.3%/

- Мэдрэлийн өвчнөөр – 50 /16.7%/

- Дотрын өвчнөөр – 155/51.8%/

- Мэс заслын өвчнөөр – 10 /3.34%/

- Гэмтлийн өвчнөөр – 38 /12.7%/ даатгуулагч, хүнийг түүвэрлэж нас барсан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа цуцлагдсан, шилжсэн нийт 34 /11.4%/ даатгуулагч, хүнийг хасаж, 265 иргэнийг дахин магадлав: Үүнд:

- Хэвээр - 217 /72.5%/

- Заалтыг өөрчилж - 24 /8%/

- Цуцалж – 18 /6%/

- Хүндэтгэх шалтгаантай хамрагдаагүй -5 /1.6%/

Оношийн баталгаажилт, оношилгоо, шинжилгээний бүрдэл дутуу иргэнийг шаардлагатай тохиолдолд биеэр байлцуулан магадлав.

Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цахимаар болон бичиг баримтад үндэслэн, шаардлагатай тохиолдолд иргэнийг байлцуулан шийдвэрлэж байна. Эдгээр нөхцөл байдалтай холбогдуулан салбар, аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар орж буй иргэдийг хэрхэн шийдвэрлэж буй байдалд хяналт тавин ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн

байдлаар аймаг, дүүргийн эрүүл мэндийн магадлалын зөвлөлүүд нийт 1073 удаагийн хурлаар 77738 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Цахимаар болон бичиг баримтад үндэслэн шийдвэрлэсэн – 64586 /83.1%/
- Биеэр байлцуулан шийдвэрлэсэн – 13152 /16.9%/

Мөн салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим мэдээллийн санд хяналт тавьж ажиллахад 2024 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон, сунгуулсан бүртгэлтэй 101612 иргэн байна. Үүнээс овог, нэр, регистрийн дугаарын зөрөөтэй, нас барсан болон шилжиж ирсэн, явсан хөдөлгөөнийг тухай бүр хийж буй эсэхэд Улсын бүртгэлийн мэдээлэлтэй тулган хяналт тавьж ажиллан дараах зөрчлүүдийг илрүүлж арилгуулах арга хэмжээ авч ажиллав. Үүнд:

-Овог нэр зөрүүтэй - 1862

-Регистер буруу бичигдсэн - 48

-Нас барсан хөдөлгөөн хийгдээгүй 79 иргэний бүртгэл мэдээлэлд залруулга хийлгэв.

Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлан шийдвэрлэх үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлэх, эрүүл мэндийн байгууллагатай хамтран хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, сэргийлэх эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн удирдлага, гишүүдийн ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сайжруулах, ёс зүйн хэм хэмжээг сахих, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах талаар чиглэл, зөвлөмж өгч, хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай” 01 дугаар албан даалгавар;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 01/1136 дугаар албан бичиг;
- Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 2025 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 09/12 дугаар албан бичиг;
- Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 2025 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 09/74 дүгээр албан бичиг;
- Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 2025 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 09/77 дугаар албан бичгүүдийг хүргүүлж дээрх чиглэл, зөвлөмжийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тайланг хүлээн авч нэгтгэхээр ажиллаж байна.

#### *9.4.Сургалт, судалгаа, олон нийттэй харилцах чиглэлээр*

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс магадлалын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, түүнийг шийдвэрлэх арга замыг хэлэлцэх зорилгоор “Эрүүл мэндийн магадлалтай холбоотой тушаал шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарах асуудал” сэдэвт цахим уулзалт хэлэлцүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулав.

Тус уулзалт хэлэлцүүлэгт аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 250 гаруй дарга, гишүүд оролцов.

Уулзалт, хэлэлцүүлгээр Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны товч тайлан, жилийн эцсийн тоон тайлангийн дүн шинжилгээ, 2025 онд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний талаар болон цаг үеийн байдлаар танилцуулга мэдээлэл хийж, санал солилцов.

Энэ удаагийн уулзалт, хэлэлцүүлгээр эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааг боловсронгуй болгох, дотоодын хяналтыг сайжруулж гарч болох алдаа зөрчлөөс сэргийлэх, даатгуулагч хүнд үзүүлэх хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэх үйл ажиллагааг хүртээмжтэй, чирэгдэлгүй үзүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцож нэгдмэл ойлголтод хүрснээрээ ач холбогдолтой болов.



2024 оны жилийн эцсийн байдлаар нүдний өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдсан 13000 орчим иргэн байгаа бөгөөд энэ нь нийт хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн 12.5 хувийг эзэлж, тэргүүлэх өвчлөлийн нэг болоод байгаа учраас Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл нь аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн магадлагч эмч нарыг мэргэжлийн хувьд чадавхижуулах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/93 дугаар тушаалаар нүдний сургалт зохион байгуулах удирдамж, хөтөлбөрийг батлуулж, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 09/54 тоот албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлүүдэд хүргүүлэв.

Тус удирдамжийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл нь Монголын торлог, шилэнцрийн нийгэмлэгтэй хамтран “Нүдний өвчний орчин үеийн оношилгоо, эмчилгээ, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтооход анхаарах асуудал” сэдэвт сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулав.

Сургалтад аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч нар оролцсон бөгөөд Нийгмийн даатгалын багц хууль болон эрүүл мэндийн магадлалтай холбоотой эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтийн талаар болон хөдөлмөрийн чадвар алдалтын зонхилох шалтгаан болж буй нүдний өвчний орчин үеийн оношилгоо, эмчилгээ, авлигын гэмт хэрэг түүний хор хөнөөл, ажлын байрны стресс менежментийн хичээл зааж, эмч нарын асуултад хариулт өгч, санал солилцов. Энэхүү сургалтыг Монголын торлог шилэнцрийн мэргэжлийн нийгэмлэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн түшиц эмнэлэг “Сондра” болон “Болор мэлмий”, “Орбита”, “Солонго” нүдний эмнэлгүүдтэй хамтран зохион байгуулж, Магадлагч эмч нарт нүдний өвчний оношилгоо, эмчилгээний талаар хичээл зааж, дээрх эмнэлгүүдэд дадлага хийлгэн чадавхжуулж нийт оролцогчдод багц цагийн сертификат олгосноороо онцлог, ач холбогдолтой болов.



Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран жил бүр зохион байгуулдаг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн талаарх ээлжит сургалтыг цахим хэлбэрээр 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулав.

Сургалтад салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 250 гаруй дарга, гишүүд хамрагдаж Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн

комиссар М.Жамъянчойжил авлигын шалтгаан, нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалтын талаар дэлгэрэнгүй мэдээллийг хийв.

Сургалтын үеэр оролцогчдын сонирхсон асуултад хариулж, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд авах арга хэмжээ, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх талаар жишээ, тохиолдлуудыг танилцуулан, холбогдох хууль, тогтоомжийн талаар мэдээлэл өгөв.



Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн 4.8 дахь заалтад “...гадаад улсад хорт хавдар, сүрьеэ, эрхтэн шилжүүлэх болон бусад өвчний шалтгаанаар 132 хоногоос дээш хугацаагаар эмчлүүлж байгаа даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг шийдвэрлэхдээ үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдсан, эмчлүүлж байгаа талаарх тухайн улсын эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, биеийн эрүүл мэндийн байдлын талаарх дүгнэлтийн эх хувь болон тухайн улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яам, эсхүл Консулын газрын тодорхойлолт, итгэмжлэл, хүний хувийн хүсэлтэд үндэслэн салбар болон аймаг дүүргийн магадлалын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ...” гэж заасан заалтын хэрэгжилтийн хүрээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон гадаад улсад амьдарч байгаа иргэдийн судалгааг авч нэгтгэн дүгнэв. Тус судалгаагаар гадаад улсад амьдарч байгаа хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 110 иргэн байгаа ба үүнээс 83 /75.5%/ нь хөдөлмөрийн чадвар алдалтыг 1-3 жилээр сунгуулж, 18 /16.4%/ нь хугацаагүйгээр сунгагдсан байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын зонхилох шалтгаан нь хорт хавдрын I, II үе, бөөрний архаг дутагдал, чихрийн шижин, нүдний өвчин, эмгэгүүд байгаа ба тэдгээрийн 74 /67.3%/ нь нийслэлд, 36 /32.7%/ нь орон нутгийн харьяалалтай иргэд байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоолгосон иргэд 21 улсад ажиллаж амьдарч байгаа бөгөөд Солонгос, Франц, Америк, Герман, Чех улсад иргэдийн 69.6% нь амьдарч байна. Иргэдийн дундаж наслалтыг тооцоход 43.6 настай, 20-55 насны иргэд 90.9%-ийг эзэлж байна. Тус судалгаанаас үзэхэд эдгээр иргэд гадаад улсад байнга амьдардаг, түр хугацаагаар ажиллаж буй эсвэл эмчлүүлж байгаа эсэхийг тодорхойлох боломжгүй байгаа тул цаашид судалгаанд хамрагдсан гадаад улсад амьдарч буй нэр бүхий иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэсэн сүүлийн шийдвэрийн хуудасны хуулбар болон “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн 4.8-д заасан нотлох баримтын хуулбарын хамт Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд ирүүлэхээр шийдвэрлэв.

Салбар болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга, гишүүдийн хуралд оролцсон байдал даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэхэд зарцуулж буй дундаж хугацааг тодорхойлж, цагийн хөлс олголтыг хянах зорилгоор салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 2025 оны 01-04 дүгээр сарын хооронд хуралдсан байдалд шаардлагатай баримт бичгийг хүлээн авч, нэгтгэн дүгнэв. Тус судалгаагаар хуралд оролцсон гишүүдийн бүртгэл, хуралдсан цагийн судалгаа, хурлын тэмдэглэл, цагийн бүртгэл, олгосон цагийн хөлсний баримтыг хүлээн авч нэгтгэн дүгнэхэд салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлүүд 8-20 удаагийн хурлаар 69-1721 даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэж нийт 2194.11 цаг хуралдаж, 1 даатгуулагч, хүнд дунджаар 8.11 минут зарцуулсан байгаа нь 1 даатгуулагч, хүнд зарцуулах цагийн төсвийн тооцоолох 7 минутаас илүү байна. Зөвлөлийн хуралд дарга, гишүүдийн оролцсон цагийн бүртгэлийг нэгтгэн дүгнэхэд харилцан адилгүй байгаа бөгөөд зарим аймаг, дүүргийн зөвлөлийн үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл, орлогч даргын ирц хангалтгүй байна. Иймд Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дарга “Дотоодын хяналтыг сайжруулах тухай” 2025

оны 09/43-09/52, 09/63 тоот албан бичгийг салбар болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга нарт хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахаар хугацаатай үүрэг өгч ажиллав.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 16 телевиз болон цахим сүлжээгээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолт болон Эмнэлгийн хуудасны бичилт, олголттой холбоотой асуудлаар мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дарга Т.Лхагвадорж нь 15 телевиз /MTV, TV9, TV58 Монгол HD гэх мэт/-д эрүүл мэндийн магадлалтай холбоотой асуудал;
- Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Гансүх MNB телевизид даатгуулагч хүний хөдөлмөрийн чадвар алдалтын талаарх мэдээлэл;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан ёсны фейсбүүк пейж хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд 2025 оны 03 дугаар сард төв зөвлөлийн магадлагч эмч Д.Анхбаяр, Д.Тэмүүжин нар лайв хийж хүргэв

Уг лайваар 300000 гаруй иргэдэд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэрхэн тогтоолгох, эмнэлгийн хуудас хэрхэн бичүүлэх талаар мэдээлэл хүргүүлэв. Уг лайваар 300 000 гаруй иргэдэд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэрхэн тогтоолгох, эмнэлгийн хуудас хэрхэн тогтоолгох, эмнэлгийн хуудас хэрхэн бичүүлэх талаар мэдээлэл хүргэв.

#### 9.5.Тайлагнах, мэдээлэх үйл ажиллагааны чиглэлээр

Салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 2024 оны жилийн эцсийн тоон тайланг нэгтгэж удирдлагад танилцуулан ГБХНХЯ, ЭМЯ-нд хүргүүлэв.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн тоон тайлангийн нэгтгэлээр 2024 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 101612 хүн байна. Энэ нь өнгөрсөн оны тоон үзүүлэлттэй харьцуулахад 1.0 хувиар буурсан байна. Үүнээс Нийслэлийн хэмжээнд 37424 (36.8%) даатгуулагч, хүн, орон нутгийн хэмжээнд 60137 (59.2%) даатгуулагч, хүн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон байна.

Улсын хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоолгосон 10245, сунгуулсан 91367, цуцлуулсан 8693, нас барсан 2287, хөдөлмөрийн нөхцөл өөрчилсөн 47, ажлын цаг хорогдуулсан 2 хүн байна. СӨЭММСЗ болон МШӨЭММСЗ-өөр 4051 (4.0%) хүн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон байна.

Нийт хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 101612 хүнээс нийгмийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч 62447 (61.4%) хүн, нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч 39165 (38.6%) хүн байна. Хүйсийн байдлаар үзвэл хөдөлмөрийн чадвар алдсан хүний 59.7% нь эрэгтэй, 40.3% нь эмэгтэй байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн байдлаар эрэгтэйчүүдийн тоо 6.2%, эмэгтэйчүүдийн тоо 10.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон хүний 45.3% нь хөдөлмөрийн чадвараа бүрэн, 54.7% нь хагас алдсан байна.

Дотор, сэтгэц, мэдрэл, гэмтэл, нүдний өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон нийт хүний тоо өмнөх оны мөн үетэй (80453) харьцуулахад 0.7%-иар буурч 79812 болсон байна. Энэ нь нийт хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэж буй өвчлөлийн 78.6 хувийг эзэлж сүүлийн 3 жил хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна.

## 10. ШИМТГЭЛ ХУРААЛТЫН УДИРДЛАГА, АРГА ЗҮЙ

### 10.1. Сангийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар орлогын хэмжээг 6,943.7 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 5,455.6 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулахаас 5,232.9 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, төлөвлөгөөг 95.9 хувиар биелүүлсэн. Үүнд:

-Тэтгэврийн даатгалын санд 4,606.1 тэрбум төгрөгийн орлого оруулахаас 4,240.7 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөг 92,1 хувиар;

-Тэтгэмжийн даатгалын санд 414.5 тэрбум төгрөг оруулахаас 479.4 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөг 115.6 хувиар;

-YOMШӨ-ний даатгалын санд 272.2 тэрбум төгрөг оруулахаас 353.9 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөг 129.9 хувиар;

-Ажилгүйдлийн даатгалын санд 162,6 тэрбум төгрөг оруулахаас 158,8 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж төлөвлөгөөг 97.6 хувиар тус тус биелүүлсэн байна.

*Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг аймаг, дүүрэг тус бүрээр харуулбал:*

*/мян.төг/ Хүснэгт-44*

№	Газрын нэр	2025 оны төсөв	Гүйцэтгэл	Хувь
1	Архангай	51,182,863.9	49,555,738.25	96.8
2	Баян-Өлгий	64,474,903.9	61,892,759.55	96.0
3	Баянхонгор	56,205,295.7	56,191,305.93	99.9
4	Булган	41,007,442.3	39,254,699.04	95.7
5	Говь-Алтай	43,419,053.4	41,244,660.36	94.9
6	Дорноговь	104,981,595.9	99,708,280.97	94.9
7	Дорнод	79,333,451.3	72,327,993.10	91.1
8	Дундговь	35,015,966.6	33,568,292.41	95.8
9	Завхан	54,620,061.4	50,900,879.50	93.1
10	Євєрхангай	74,111,150.9	70,004,476.48	94.4
11	Ємнєговь	235,977,075.5	233,285,233.22	98.8
12	Сїхбаатар	48,451,876.7	46,830,441.97	96.6
13	Сэлэнгэ	108,111,500.5	106,190,533.69	98.2
14	Тєв	71,725,613.5	68,187,728.47	95.0
15	Увс	57,564,784.0	54,926,897.91	95.4
16	Ховд	74,509,225.9	67,729,913.77	90.9
17	Хєвсгєл	74,417,975.3	70,277,783.46	94.4
18	Хэнтий	74,448,481.2	71,882,710.57	96.5
19	Дархан-Уул	139,226,072.5	135,775,827.63	97.5
20	Орхон	217,806,910.9	191,070,126.54	87.7
21	Говьсїмбєр	30,772,077.6	27,409,891.58	89.0
22	Баянгол	617,152,468.8	557,116,545.68	90.2
23	Баянзїрх	536,357,465.3	462,622,862.30	86.2
24	Багануур	42,723,344.0	38,149,192.59	89.2
25	Багахангай	4,250,240.0	4,631,459.65	108.9
26	Налайх	27,124,143.9	26,348,175.37	97.1
27	Сїхбаатар	736,454,081.2	707,053,802.04	96.0
28	Сонгинохайрхан	274,736,470.5	250,601,982.32	91.2
29	Хан-Уул	682,349,852.1	679,357,747.24	99.5
30	Чингэлтэй	759,198,986.4	738,352,269.29	97.2
31	Солонгос	6,208,582.0	2,980,103.23	48.0
<b>ДҮН</b>		<b>5,455,574,056.70</b>	<b>5,232,871,137.19</b>	<b>95.9</b>

#### 10.2. Нийгмийн даатгалын хамралтын талаар:

2025 оны 12 дугаар сарын байдлаар өмнөх оны суурь түвшингөөс 93.4 хувь буюу 7.1 мянган ажил олгогч, 112.2 мянган хүнийг албан журмын даатгалд шинээр хамруулан ажилласан.

-Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/10 дугаар тушаалаар “2025 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч, албан журам, сайн дураар даатгуулагчийн тооны төлөвлөгөө”-г батлуулж, аймаг дүүргийн нийгмийн даатгалын газарт чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажилласны үр дүнд 2025 онд хүрэх түвшингээс 85.7 хувь буюу 23,1 мянган хүнийг сайн дурын даатгалд шинээр, нийт хамрагдвал зохих малчдын тоог 125.6 хувь буюу 10.7 мянгаар нэмэгдүүлж ажилласан байна.

-Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, ажил эрчимжүүлэх 3 удаагийн чиглэлийг аймаг дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн ажилласан.

-Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр ОУХБ-ын “Албан бус эдийн засгийг албажуулах төсөл”-тэй хамтран “Нийгмийн даатгалын албан хаагчдыг чадавхжуулах” сургалтыг зохион байгуулсан. Мөн “Зохистой хөдөлмөрийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хүрээнд ОУХБ болон холбогдох байгууллагуудтай уулзаж санал солилцон ажилсан.

-Олон нийтэд нийгмийн даатгалын хууль тогтоомж, сайн дурын даатгалын ач холбогдлыг суртачилан таниулах мэдээлэл хүргэх зорилгоор С1 телевиз, Монголын үндэсний Олон нийтийн радиод ярилцлага, НДЕГ-аас тогтмол зохион байгуулдаг лайваар мэдээлэл хүргэж иргэдийн сонирхсон асуултад хариулт өгч ажилласан.

-ГБХНХЯ-аас зохион байгуулсан 2 удаагийн Нээлттэй хаалганы өдөрлөг, МУИС-ийн багш оюутнууд, МОХ-оос зохион байгуулсан “Ботго эвент”-д оролцож багш оюутнуудад зөвлөгөө мэдээлэл хүргэн ажилсан.

-Гадаад улсад ажиллаж амьдарч байгаа монгол улсын иргэдийн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Хилийн чанад дахь монголчуудын зөвлөлтэй хамтран АНУ, Австрали, Ази, Европ тивийн төлөөлөл, БНСУ дахь ХНХҮТ-ийн алба хаагч нарт, Бүгд найрамдах Чех улсад ажиллаж амьдарч байгаа монголчуудад цахим мэдээлэл, уулзалт зохион байгуулж Нийгмийн даатгалын ач холбогдол сайн дурын даатгалын талаар мэдээлэл зөвлөгөөг хүргэн ажилсан.

-Төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны хүрээнд “Бизнесээ томруулъя” ТББ-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд жижиг дунд бизнес эрхлэгчдэд сайн дурын даатгалын ач холбогдлыг таниулах зөвлөгөө мэдээлэл хүргэн ажиллаж байна.

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН АВЛАГЫН ТАЛААР:

*/Аймаг, дүүрэг харьцуулалт/ Хүснэгт-45*

Газрын нэр	НДША /тэрбум.төг/		Авлага өссөн дүнгээр /тэрбум төг/
	2024.12.31	2025.12.31	
Аймгийн НДГ	81.4	88.2	6.4
Дүүргийн НДГ	438.3	485.5	47.2
Нийт дүн	520.1	573.7	53.6

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарласан. Зорилтот жилийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/47 дугаар тушаалаар жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг батлан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн шимтгэлийн өрийг бууруулах талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнд 2025 оны эхний үлдэгдэл 520.1 тэрбум төгрөгийн шимтгэлийн өрөөс 12 дугаар сарын байдлаар 262.9 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг 50.5 хувиар бууруулсан боловч нийтдээ 663.0 тэрбум төгрөгт хүрч энэ онд 405.8 тэрбум төгрөгийн өр шинээр үүсч байна

#### 10.3. Шимтгэлийн өрийг бууруулах чиглэлээр төлөвлөгөө гарган ажилласан талаар:

-Шимтгэлийн авлага барагдуулах арга замыг судлах, цаашид өрийг барагдуулах, холбогдох арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/197 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын менежментийн төлөвлөгөө”-г баталж аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

-Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу ажил олгогчийн шимтгэлийн өрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор өндөр өртэй аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, даатгуулагчдад учирч болох санхүүгийн болон нийгмийн эрсдлийн талаар ойлгуулах, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, нийгмийн даатгалын байцаагч ажилтнуудад чиглэл өгөх, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан. Уг ажлын хэсэг Орхон, Булган аймаг, Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газруудад ажиллан удирдамжийн хугацаанд хуримтлагдсан шимтгэлийн авлага үүсгэсэн 4,760 ажил олгогчийн 32.2 тэрбум төгрөгийн өрийг барагдуулсан.

-Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2023 онд баталсан А/199 дүгээр тушаалын дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж, хуримтлагдсан 223.8 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулсан.

Хүснэгт-46

Авсан арга хэмжээ	Авсан арга хэмжээ		НДША барагдсан	
	АО тоо	Мөнгөн дүн	АО тоо	Мөнгөн дүн
Албан шаардлага хүргүүлсэн	2 568	107.8	1 149	39.5
Данс хаасан	15 525	230.0	4 570	56.9
Уулзалт хийсэн	2 924	133.3	1 685	43.3
Гэрээ байгуулсан	2 103	201.6	1 215	79.8
Шүүхэд шилжүүлсэн	361	27.8	235	4.3
<b>Дүн</b>	<b>23 481</b>	<b>700.5</b>	<b>8 134</b>	<b>223.8</b>

/Тайлбар: авлага барагдуулах арга хэмжээ нь дээрх журмын дагуу шат дараалан авч байгаа тул авлагын мөнгөн дүн, ажил олгогчийн тоо нь давхардсан дүнгээр илэрхийлэгдсэн болно/.

-Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” А/306 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу ажлын хэсэг 2025 оны 11-р сарын 07-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газруудын шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлт, шимтгэлийн өрийг барагдуулах, шимтгэлийн хуримтлагдсан өрийг барагдуулах талаар ажил олгогчийн удирдлагатай уулзалт зохион байгуулж тэмдэглэл хөтлөх, улсын байцаагчийн албан шаардлага, харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох мэдэгдэл хүргүүлэх, данс хаах, шимтгэлийн өр барагдуулах гэрээ байгуулсан ажил олгогчдын эргэн төлөлтийг тулган шалгах ажлыг зохион байгууллаа. Ажлын хэсэг удирдамжийн хүрээнд хуримтлагдсан 4.4 тэрбум төгрөгийн өрийг барагдуулсан.

-Аймаг дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас шимтгэлийн өрийн хэмжээ өндөр, насжилт ихтэй, анхаарал татах хэмжээнд хүрсэн 113.4 тэрбум төгрөгийн өртэй 147 ажил олгогчийн эрх бүхий албан тушаалтнуудтай утсаар холбогдон, шимтгэлийн өрийг барагдуулах чиглэлээр уулзалт зохион байгуулан ажиллаж байна. Үүний үр дүнд 1.9 тэрбум төгрөгийн шимтгэлийн өр нийгмийн даатгалын санд төвлөрсөн байна.

#### 10.4. Шимтгэлийн өр барагдуулах талаар төрийн байгууллагуудтай хамтран ажилласан талаар:

-Сангийн яаманд 02 дугаар сард 01/484 албан бичгээр 23.7 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн 405 төсөвт байгууллагын мэдээллийг;

-Боловсролын яаманд 02 дугаар сард "Хамтран ажиллах тухай" 01/339 дугаартай албан бичгээр 2024 оны жилийн эцсийн байдлаар 1.3 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн 118 төсөвт байгууллага, мөн 09 дүгээр сард "Хамтран ажиллах тухай" 01/2096 дугаартай албан бичгээр 11.3 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн 402 боловсролын төсөвт байгууллагын жагсаалтыг хүргүүлж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дээрх байгууллагуудын шимтгэлийн өрийг барагдуулах, цаашид өр үүсгэхгүй байх талаар удирдлагуудад холбогдох чиглэл өгч хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэхийг хүссэн хүсэлтийг;

-Аж үйлдвэр, эрдэс баялагийн яаманд 2025 оны 9-р сард "Хамтран ажиллах тухай" 01/2096 дугаартай албан бичгээр 100,0 сая төгрөгөөс дээш хэмжээний, нийт 86.9 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн 90 аж ахуйн нэгж байгууллагын жагсаалтыг;

-Эрүүл мэндийн яаманд 09 сард "Хүсэлт хүргүүлэх тухай" 01/2095 дугаартай албан бичгээр 39.2 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн 137 төрийн, орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, бүсийн оношилгоо болон аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвүүдийн жагсаалтыг;

-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 2025 оны 03 дугаар сард "Хамтран ажиллах тухай" 01/574 дугаартай албан бичгээр 2024 оны жилийн эцсийн байдлаар 24.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн өр үүсгэсэн 407 эрүүл мэндийн байгууллагуудын, 09 дүгээр сард "Хамтран ажиллах тухай"..... дугаартай албан бичгээр 49.6 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн 522 байгууллагын жагсаалтыг хүргүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй байх шалгуур үзүүлэлтийг нэмэлтээр оруулж өгч хамтран ажиллах тухай хүсэлтийг;

-Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгт 03 дугаар сард 01/570 дугаартай "Хамтран ажиллах тухай" албан бичгээр салбар 53 байгууллагууд нь нийгмийн даатгалын шимтгэлийг сар дамжуулан төлсөнөөс өр үүсгэсэн тул сардаа багтаан шимтгэлээ төлж, цаашид өр үүсгэхгүй байх талаар;

-Гадаадын иргэн, харьяатын газарт 06 дугаар сард "Хамтран ажиллах тухай" 01/1451 дугаартай албан бичгээр гадаадын хөрөнгө оруулалттай компани, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажилчдын болон тухайн гадаадын иргэнтэй холбоотой үүссэн шимтгэлийн өрийг барагдуулах талаар хамтран ажиллах хүсэлтийг тус тус хүргүүлээд байна.

#### *10.5. Хуулийн байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд:*

-Цагдаагийн ерөнхий газарт 2025 оны 05 дугаар сард 01/1252 дугаартай албан бичгээр удирдлагын түвшинд уулзалт зохион байгуулан санал солилцох хүсэлтийг хүргүүлэн, хүсэлтийн дагуу 2025 оны 06 дугаар сард холбогдох удирдлагууд уулзалт хийн, санал солилцож, Эрүүгийн цагдаагийн албаны эрэн сурвалжлах хэлтэст 2025 оны 10-р сард 01/2647 дугаартай албан бичгээр 287 хариуцагчаар оролцох хуулийн этгээдийг эрэн сурвалжлах, оршин суугаа газрыг тогтоох ажиллагааг орон нутагт зохион байгуулахад харьяа Цагдаагийн газар, хэлтсүүдийг нийгмийн даатгалын газруудтай хамтран ажиллах тухай хүсэлтийг;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай нийгмийн даатгалын байгууллагад холбогдох гүйцэтгэх баримт бичгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлэх талаар хамтын ажиллагааны "Санамж бичиг"-ийг байгуулсан. Үүнтэй холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын хамтарсан ажлын хэсэг байгуулан шимтгэлийн болон сангийн өр төлбөр, барагдуулахад хамтран ажиллах 2025 оны төлөвлөгөө батлагдан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтын ажиллагааны "Санамж бичиг"-ийн хүрээнд 2025 онд 149 аж ахуйн нэгж, байгууллагын 9.3 тэрбум төгрөгийн шимтгэл, 294.7 мян.төгрөгийн алдангийг барагдуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын шимтгэлийн өрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр НД-85/25 дугаартай "Ажил гүйцэтгэх гэрээ"-г 3 сарын хугацаатай байгуулан "Өмгөөллийн цэгц хүч" ХХН-тэй хамтран ажилласан. Үүний үр дүнд тус хуулийн фирм нь Банкны төлбөр барагдуулах албаны шийдвэр гүйцэтгэгч нартай хамтран ажиллаж тодорхой хаяггүй, нэр дээр нь хөрөнгөгүй нь тогтоогдсон, түдгэлзүүлсэн болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хийгдсэн нийт 11 хуулийн этгээдийн 289.4 мянган төгрөгийн хуримтлагдсан шимтгэлийн өрийг төлүүлсэн байна.

**10.6. Итгэлцлийн аян зохион байгуулсан ажлын талаар:**

-Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бууруулах, ажил олгогч, даатгуулагчдыг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/244 дүгээр тушаалаар “Итгэлцлийн аян”-ыг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг дуустал 1 сарын хугацаатай зохион байгуулсан. Аяны хугацаанд 105.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн өрийг барагдуулсанаас 5 808 аж ахуйн нэгж байгууллагын 63.8 тэрбум төгрөгийн хуримтлагдсан шимтгэлийн өр барагдсан.

МҮЭХ, МҮХАҮТ, МАОЭНХ-нд гишүүн ажил олгогч нарт “Итгэлцлийн аян”-ны холбогдох мэдээллийг хүргэн, сурталчилан таниулах, түгээх ажлыг зохион байгуулж хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлэн ажилласан.

**10.7. Сургалт сурталчилгаа хийсэн ажлын талаар:**

-Нийгмийн даатгалын ерөнхий газар Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн ажлын албатай хамтран Нийгмийн даатгалын байгууллагын удирдлага, байцаагч, ажилтнуудад авлагын удирдлага, барагдуулах арга зам, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор НДҮЗ-ийн дэргэдэх орон тооны бус Мэргэжлийн хороо, Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүд “Нийгмийн даатгалын байгууллагын авлагын менежмент, авлагыг барагдуулах арга зам” сэдвээр танхимаар аймаг, сум, дүүргийн 69 байцаагч ажилтнууд танхимаар, цахимаар 423 ажилтнууд сургалтанд хамрагдсан.

Өмгөөллийн цэгц хүч хуулийн фирмтэй хамтран 10-р сарын 14-ны өдөр “Шүүхээр шийдвэрлэж буй хэрэг, маргаан, хэрэгжилтийн өнөөгийн байдал”, 10-р сарын 22-ны өдөр “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийтлэг журам”, 10-р сарын 31-ний өдөр “Төлбөр төлөгч хуулийн этгээд болон төлбөр төлөгч иргэнээс төлбөр гаргуулах ажиллагаа” сэдэвт сургалтуудыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор сургалтад төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын холбогдох чиг үүргийн албан хаагчид танхимаар 186, цахимаар 426 хамрагдсан.

Хуримтлагдсан шимтгэлийн өрийг барагдуулах талаар 2025 оны 9-р сард “Итгэлцлийн аян” зохион байгуулсантай холбогдуулан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудас болон цахим орчинд богино хэмжээний бичлэг буюу рийл бэлтгэн байршуулах, орон нутгийн тв радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр удирдлагын манлайлал үзүүлэн ярилцлага өгч, мөн ажил олгогч, даатгуулагчдад зориулсан сургалт сурталчилгааны ажлыг 1761 удаа зохион байгуулж нийт 4.9 мянган ажил олгогч болон 33.8 мянган даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн.

Уг аяны талаар Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийгмийн даатгалын албан хаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, ажил олгогч, даатгуулагчдын эрх зүйн мэдлэг, мэдээллийг сайжруулах шимтгэл төлөлтийн идэвхийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготойгоор МҮОНТ, “Тэнгэр телевиз”, “Time.mn”, “SBN телевиз”, “Ийгл телевиз” Өдрийн сонин зэрэг олон нийтийн мэдээллийн сувгаар видео ярилцлагад 5 удаа оролцож ажилласан.

Ажил олгогч болон даатгуулагчдийг шимтгэлээ хугацаанд нь төлөөгүйгээс үүсэх эрсдэл болон ажил олгогч, даатгуулагчийн хүлээх эрх, үүрэг, нийгмийн даатгалд даатгуулсны ач холбогдолыг сурталчилсан мэдээ 5, постер 36, рийл 5, анимэйшн контент 2, видео ярилцлага 2-ыг бэлтгэн түгээн ажилласан.

**11. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСАГ****11.1. Ерөнхий мэдээлэл**

Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасаг нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг болон холбогдох бусад хууль тогтоомжуудыг тус тус хэрэгжүүлэн ажилласан.

2025 оны 12 дугаар сарын байдлаар Бүгд Найрамдах Солонгос Улсад Монгол Улсын 58,868 иргэн богино болон урт хугацааны эрхээр оршин сууж байна. Үүнээс ихээр оршин сууж буй иргэдийн визний ангиллаар дурдвал, аяллын эрхтэй 15,247, оюутан 13,251, хэлний бэлтгэлийн оюутан 6,232, гэр бүлийн буюу дагалдан эрхтэй 4,634, Солонгос иргэнтэй гэр бүл болсон 2,176, дээд сургуульд төгссөний дараа ажил хайх эрхтэй 1,850 иргэн байгаагаас гадна 2024 оны мэдээгээр 15,654 иргэн хууль бусаар оршин сууж байна. Өнөөгийн байдлаар БНСУ-д 3,943 хөдөлмөрийн гэрээт ажилчин ажиллаж байх ёстойгоос 2,224 нь гэрээгээр ажиллаж байгаа бөгөөд 1,719 нь хууль бус руу шилжсэн байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/169 дүгээр “БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” тушаалаар төвийн орон тоог 22, Нийгмийн даатгалын тасгийн орон тоог 7-оор тогтоож, тасгийн төрийн захиргааны 4, төрийн үйлчилгээний 3 албан хаагчийн албан тушаалын нэршлийг сольсон.

1. Тасгийн дарга
2. Шимтгэл төлөлтийн хяналт, нийгмийн даатгалын хамралт, шимтгэлийн орлого хариуцсан мэргэжилтэн
3. Сангийн тайлан, нийгмийн даатгалын хамралт, шимтгэлийн орлого хариуцсан мэргэжилтэн
4. Дотоод хяналт, нийгмийн даатгалын хамралт, шимтгэлийн орлого хариуцсан мэргэжилтэн
5. Судалгаа, тоон мэдээллийн сан, нийгмийн даатгалын хамралт, шимтгэлийн орлого хариуцсан мэргэжилтэн
6. Сургалт сурталчилгаа, нийгмийн даатгалын хамралт, шимтгэлийн орлого хариуцсан мэргэжилтэн
7. Гүйцэтгэлийн тайлан мэдээ, нийгмийн даатгалын хамралт, шимтгэлийн орлого хариуцсан мэргэжилтэн

2025 оны 06 дугаар сараас тасгийн 2 үндсэн ажилтан 3 хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөтэй, түр орон тоогоор 1 ажилтан ажиллаж байна.

2025 онд Монгол Улсаас БНСУ-д 1000 ажилчин ирэх квоттой байснаас 53,5% буюу 535 гэрээт ажилчин ирсэн байна.

### *11.2. Монгол Улсаас БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирж буй ажилчдыг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгэээ олгох ажлын хүрээнд*

Монгол Улсаас БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалтын дагуу Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар хамруулан ажиллаж байна.

“Солонгос улсад гэрээгээр ажиллагсдын шимтгэлийн программ”-д өссөн дүнгээр 24,498 даатгуулагчийн мэдээлэл бүртгэгдсэн байна.

Программын хөдөлгөөний цэсэд 2025 онд 1675 гэрээт ажилчин бүртгэгдсэн байна.

НДЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалын дагуу 2025 онд нийт 671 хөдөлмөрийн гэрээт иргэдийг тэтгэврийн даатгалд албан журмаар шинээр хамруулах төлөвлөгөөтэй.

Мөн онд Монгол Улсаас 1000 хөдөлмөрийн гэрээт ажилтан ирэх квоттой байснаас 53.5% буюу 535 ажилтан ирсэнд нийгмийн хамгааллын хэлэлцээрийг сурталчлан танилцуулж, ажил олгогчдод албан бичиг, зөвлөмжийг хүргүүлж, гэрээ байгуулан, нийт 315 /12 сарын урьдчилсан төсөөллөөр/ буюу 53.8 хувийг тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулсан.

Хөдөлмөрийн гэрээ дууссан, хууль бус болсон, ҮТА-д шимтгэл төлсөн болон бусад шалтгааны улмаас 106 даатгуулагч даатгалаа зогсоосон байна.

Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу нийт 609 даатгуулагчид гэрчилгээ олгосон. Үүнд шинээр 216, хугацаа сунгасан 312, ажлын байраа сольсон зэрэг шалтгаанаар дахин олгосон 81 байна.

**11.3. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаас бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхэлж, амьдарч буй иргэдийг нийгмийн даатгалд сайн дураар хамруулах, Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ олгох ажлын хүрээнд**

А/10 дугаар тушаалын дагуу 2025 онд 503 иргэнийг шинээр хамруулах төлөвлөгөөтэй. БНСУ-д хөдөлмөрийн гэрээнээс бусад хэлбэрээр оршин суугаа 360 иргэнийг /12 сарын урьдчилсан төсөөллөөр/ даатгалд хамруулж, гэрээ байгуулсан, нийт 1,461 даатгуулагч бүртгэлтэй байна. Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу нийт 567 даатгуулагчид гэрчилгээ олгосон. Үүнд шинээр 287, хугацаа сунгасан 206, ажлын байраа сольсон зэрэг шалтгаанаар дахин олгосон 74 байна.

Тэтгэвэрт гарсан, Монгол буцсан, өөрийн хүсэлтээр цуцалсан болон бусад шалтгааны улмаас нийт 133 даатгуулагч гэрээгээ цуцалсан.

“Сикос” программд нийт 281 гэрээний хяналтыг хийхэд 130 зөрчил илэрсэн. Үүнээс гэрээ байгуулаагүй 1, боловсруулж байгаа төлөвтэй 1 гэрээ байсан бөгөөд нийт 66 зөрчил бүрэн засагдсан. 62 гэрээний “хүсэлт гаргах газар” талбарыг буруу сонгосон байсныг мэргэжилтнүүдэд анхааруулан ажилласан.

**11.4. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд Тус тасгийн нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн орлого**

НДЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 дүгээр тушаалын дагуу тус тасаг 2025 онд 5,031,742,000 төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй.

Тус тасаг тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл 457,990,000.00 вон буюу 1,136,570,899.55 төгрөг, сайн дурын даатгалын шимтгэл 1,734,461,071.32 төгрөг, нийт 2,871,031,970.87 /12 сарын урьдчилсан төсөөллөөр/ төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 57,06 хувиар биелүүлсэн.

**Орлогын төлөвлөгөөний биелэлт /урьдчилан төсөөллөөр/**

Хүснэгт-47

/2025.12.31-ний дүнгээр/

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого	Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын эхний өдрийн МБ-ны
		Воноор	Төгрөгөөр	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр		
1	419,302,833.33	48,090,000	112,049,700.00	158,039,718.00	48,090,000	270,089,418.00	64	2.33
2	419,302,833.33	41,380,000	98,484,400.00	128,864,004.00	41,380,000	227,348,404.00	54	2.38
3	419,302,833.33	44,690,000	105,915,300.00	133,333,528.00	44,690,000	239,248,828.00	57	2.37
4	419,302,833.33	39,680,000	94,041,600.00	160,138,135.00	39,680,000	254,179,735.00	61	2.37
5	419,302,833.33	39,560,005	98,900,012.50	135,392,296.00	39,560,005	234,292,308.50	56	2.5
6	419,302,833.33	36,889,995	95,545,087.05	146,013,519.00	36,889,995	241,558,606.05	58	2.59
7	419,302,833.33	33,580,000	88,987,000.00	138,249,848.00	33,580,000	227,236,848.00	54	2.65
8	419,302,833.33	30,390,000	77,798,400.00	132,815,813.00	30,390,000	210,614,213.00	50	2.56
9	419,302,833.33	34,530,000	89,087,400.00	136,306,578.00	34,530,000	225,393,978.00	54	2.58
10	419,302,833.33	33,400,000	85,504,000.00	150,700,524.00	33,400,000	236,204,524.00	56	2.56
11	419,302,833.33	37,900,000	95,129,000.00	157,303,554.16	37,900,000	252,432,554.16	60	2.51
12	419,302,833.33	37,900,000	95,129,000.00	157,303,554.16	37,900,000	252,432,554.16	60	2.51
	5,031,634,000	457,990,000	1,136,570,899.55	1,734,461,071.32	457,990,000.00	2,871,031,970.87	57.06	

Шимтгэлийн орлогыг төвлөрүүлэхийн тулд “Солонгос улсад гэрээгээр ажиллагсдын программ”, сайн дурын даатгалын “sicos” программаас гэрээний хугацаа, шимтгэл төлөлтийн тооцоог хянаж, шимтгэлийн авлага барагдуулах, хугацаанд нь шимтгэлийг төлүүлэхийн тулд

ажил олгогчдод анхааруулж, 1583 нэхэмжлэхийг ажил олгогчид хүргүүлж, даатгуулагчидтай 4276 удаа утсаар холбогдож, нийт 1237 удаа масс мессеж илгээсэн.

Тайлант хугацаанд 11 удаагийн өглөг, авлагын мэдээ гаргасан. Нийт 770 даатгуулагчийн 3357 сарын 466,168,908 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Ингэснээр өнгөрсөн оны жилийн эцэстэй харьцуулахад авлага барагдуулалт 75,3 хувиар өссөн байна. Тодруулбал, тэтгэврийн даатгалын 307 даатгуулагчийн 1735 сарын 261,764,075 төгрөгийн, сайн дурын даатгалын 463 даатгуулагчийн 1622 сарын шимтгэлийн авлага болох 204,404,833 төгрөгийг барагдуулсан.

#### *Нийгмийн даатгалын мэдээллийн санд даатгуулагчдын төлсөн шимтгэлийн орлогыг бүртгэх*

Сайн дурын даатгалын шимтгэлийн орлогыг өдөр бүр Хаан банкнаас татаж, нийт 338 файл үүсгэн “Сикос” программд таниулсан. Мөн албан журмын даатгалын шимтгэлийг өдөр бүр БНСУ-ын 3 банкнаас татаж, 6667 гүйлгээг нийт 744 файл үүсгэн “Солонгос улсад гэрээгээр ажиллагсдын шимтгэлийн программ”-д болон “Сикос” программд таниулсан байна.

2024 оны сангийн тайланг “Сикос” программаар гаргахтай холбоотойгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Албан журмын даатгуулагчдын 2024 оны 9800 орлогыг “Сикос” программд нэг бүрчлэн таниулсан.

- Сайн дурын даатгуулагчдын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого нь бутархай дүнгээр орсон 139 гэрээг засварласан.

- Тайлангийн шалгах балансад танигдаагүй орлогыг таниулахаар “Сикос” программын зөрчил цэсээс 401 зөрчлийг шүүж, засварласан.

- “Сикос” системийн хөгжүүлэлттэй холбоотой 0-3 настай хүүхдээ асарч буй эхчүүдийн гэрээ алдаатай байгуулагдсанаас шалтгаалж давхардсан 91 даатгуулагчийн төрөл буруу орсныг сар болгоны ногдуулалт хийгдсэний дараа программд засалт хийж байна.

#### *Төвлөрүүлсэн орлогыг нийгмийн даатгалын санд шилжүүлсэн болон тайлагнасан байдал*

БНСУ-ын 3 банканд төвлөрүүлсэн албан журмын даатгалын шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн банкны харилцах дансанд сар бүрийн 25-ны өдөр, сайн дурын даатгалын шимтгэлийг “Хаан” банкны холбогдох дансаар өдөр бүр шилжүүлж, нийт 11 удаагийн сарын мэдээг “Sicos” программаар боловсруулан НДЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт тайлагнасан. Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг 11 удаа байршуулсан.

Энэ хугацаанд хагас жил, 3 улирлын сангийн тайланг Сикос системээр боловсруулан гаргасан.

#### *11.5. Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын Нийгмийн хамгааллын хэлэлцээр, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, төрийн үйлчилгээг хүргэх, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд*

##### *БНСУ-д оршин сууж байгаа Монгол Улсын нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдлыг сурталчлах чиглэлд*

Тус улсад оршин сууж буй Монгол Улсын иргэд, даатгуулагчдад хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах үүднээс “БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” социал хуудсаар сайн дурын даатгалын ач холбогдол болон жирэмсэн амаржсаны тэтгэмж, өндөр насны тэтгэврийн даатгалын талаар 2 удаагийн контент, нийгмийн даатгалын талаар 1 удаагийн подкаст, 6 удаагийн рийл хийж социал хуудсаар түгээсэн байна.

##### *Явуулын үйлчилгээг үзүүлж, иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжуудыг сурталчлан таниулах*

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, иргэдийг сайн дурын даатгалд хамруулах зорилгоор нийт 18 удаагийн явуулын үйлчилгээг зохион байгуулж, 365 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Тухайлбал,

- 02 дугаар сарын 15-ны өдөр Гуанжү хотноо БНСУ-д суугаа МУ-ын ЭСЯ-ны Консулын хэлтэстэй хамтран зохион байгуулсан явуулын үйлчилгээнд ирсэн 16 иргэнд,
  - 03 дугаар сарын 16-ны өдөр Сөүл хотын Ёндунпү дүүрэгт болсон “Залуусын хөдөлмөрийн гарц” өдөрлөгт оролцсон 11 иргэнд,
  - 04 дүгээр сарын 26-ны өдөр Мугпү хотноо БНСУ-д суугаа МУ-ын ЭСЯ-ны Консулын хэлтэстэй хамтран зохион байгуулсан явуулын үйлчилгээнд ирсэн 6 иргэнд,
  - 05 дугаар сарын 03-ны өдөр Чонжү хотод болсон сагсан бөмбөгийн тэмцээнд ирсэн 10 иргэн, даатгуулагчид,
  - 05 дугаар сарын 13-ны өдөр Ансон хотод ажиллаж буй 11 гэрээт иргэнд,
  - 05 дугаар сарын 18-ны өдөр Сөүл хотын Ханнам дүүргийн Оннури сүмд ирсэн 50 иргэнд,
  - 05 дугаар сарын 27-ны өдөр Сөүл хотын Шинхан их сургуулийн 32 оюутан залуучуудад,
  - 06 дугаар сарын 06-ны өдөр Тундэмүн ёгса мүнхуа гунвон буудлын орчинд 18 иргэнд,
  - 07 дугаар сарын 06-ны өдөр Хунсон, Чонан хотууд, 12-ны өдөр Пусан хот, 13-ны өдөр Пажу хотын “Баяр наадам”-ын арга хэмжээнд оролцсон 34 иргэнд,
  - 08 дугаар сарын 12-ны өдөр БНСУ-ын Инчон хотын Бүпён, Сонхаг дүүрэг болон Сувон хотын Куоньсонь, Пальдаль дүүргүүдэд ажиллаж, амьдарч буй 17 иргэнд,
  - 9 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны Консулын хэлтэс, Пусан хотод суугаа Консулын газартай хамтран Гванжү хот болон тус бүс нутгийн ойр орчмын хотуудад ажиллаж, амьдарч буй 29 иргэнд,
  - 10 дугаар сарын 04-ний өдөр Чонжү хотод зохион байгуулагдсан гэрээт иргэдийн намрын фестивалд 20 иргэнд,
  - 10 дугаар сарын 24-нөөс 26-ны өдрүүдэд “MAMF-2025” Олон соёлт гадаад иргэдийн наадамд оролцож тухайн бүс нутгийн ойр орчмын хотуудад ажиллаж, амьдарч буй Монгол Улсын 22 иргэнд,
  - 11 дүгээр сарын 02-ны өдөр Ижонбү хотод зохион байгуулагдсан “We Love Mongolia festival-6” бэсрэг наадмын үеэр төрийн үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэж, нийт 45 гаруй иргэнд,
  - 11 дүгээр сарын 05-ны өдөр Гёнги аймагт байрлах метал боловсруулах үйлдвэрт ажиллаж буй 18 хөдөлмөрийн гэрээт ажилчдад,
  - 11 дүгээр сарын 14-ний өдөр БНСУ-ын “INHA” их сургуульд суралцаж буй 10 оюутанд,
  - 11 дүгээр сарын 16-ны өдөр Чонан хотын Монгол иргэд ихээр цуглардаг Ноёнтон Монгол зоогийн газарт биечлэн очиж 6 иргэнд,
  - 11 дүгээр сарын 29-ний өдөр БНСУ-ын Чэжү хотод оршин суугаа 10 иргэнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулсан.
- Мөн эрүүл мэндийн үнэгүй үзлэг оношилгоог Монгол иргэдийн дунд Сөүл хотын нэр бүхий эмнэлэгтэй хамтран 10 удаа зохион байгуулж, 129 иргэнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулсан.
- Дээр дурдсан ажлын хүрээнд нийт 55 иргэнийг сайн дурын даатгалд хамруулсан нь өнгөрсөн оны жилийн эцсийн дүнгээс 5-аар илүү байна.

### *Иргэд даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх*

Тайлант хугацаанд төв дээр биечлэн ирсэн 480 иргэн, утсаар 3,531, цахимаар /чат-бот/ 101, нийт 4112 иргэнд Нийгмийн хамгааллын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч ажилласан.

Иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн нийгмийн даатгалын мэдээллийн сангаас лавлагаа авах 576, нийгмийн даатгалын аппликейшнд бүртгүүлэх 91, даатгуулагчийн тодорхойлолт, эмнэлгийн тодорхойлолтын орчуулга авах 31, нийт 698 хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн.

Иргэд, даатгуулагчдаас гаргасан 13 өргөдлийг шийдвэрлэж, ташаарсан орлого болох 8,780,190 төгрөгийг буцаан олгосон.

### *Мэргэжилтнүүдийг чадавхжуулах болон иргэд даатгуулагчид чиглэсэн сургалт зохион байгуулах*

НДЕГ-ын даргын баталсан төлөвлөгөөний дагуу 9, 10, 11 саруудад мэргэжилтнүүдийг чадавхжуулах 11 удаагийн сургалтыг нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдол, эрх

зүйн шинэ орчин, шинэчлэгдсэн болон шинэ зохицуулалт, “Сикос” программ, төрийн албаны нийтлэг чиг үүрэг зэрэг сэдвийн хүрээнд цахим сургалт зохион байгуулж, мэргэжилтнүүд 100% хамрагдсан. Иргэд, даатгуулагчдад 3 удаагийн цахим сургалт зохион байгуулж ажилласан. Үүнд:

- 07 дугаар сарын 05-ны өдөр цахим сургалт,
  - 08 дугаар сарын 17-ны өдөр “Нийгмийн даатгалын ач холбогдол”-ын талаарх цахим сургалт,
  - 11 дүгээр сарын 30-ны өдөр “Нийгмийн даатгалд сайн дураар хэрхэн хамрагдах тухай” сэдвээр цахим сургалт,
- Түүнчлэн 11 дүгээр сарын 30-ны өдөр БНСУ-д оршин сууж буй иргэдийн дунд цаашид авах хүсэлтэй сургалтын сэдвийн талаар судалгаа авсан,

### *Бусад ажлын хүрээнд*

НДЕГ-ын даргын зөвлөлийн гишүүдтэй цахим уулзалтыг 3, 8 дугаар саруудад 2 удаа зохион байгуулж, үйл ажиллагаа, тулгамдсан асуудлын талаар ярилцаж, холбогдох мэдээ, мэдээллийг хүргүүлсэн.

НДЕГ-ын даргын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу БНСУ-ын тэтгэврийн даатгал болон үйлдвэрлэлийн ослын нөхөн олговрын талаарх 6 сэдвийн хүрээнд нийт 177 хуудас материалыг солонгос хэлнээс монгол хэл рүү орчуулж, холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

### *11.6. Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлт гаргасан иргэдийн буцаан олголтыг шийдвэрлүүлэх ажлын хүрээнд*

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар ирүүлсэн 12 ээлжийн 48 иргэний 211,344,890.00 вон нэхэмжилсэн хүсэлтийг холбогдох бичиг баримтын хамт тус улсын Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлж, 6 ээлжийн 25 иргэний 123,503,850.00 воньг буцаан олгуулсан.

Тус тасаг тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл 457,990,000.00 вон буюу 1,136,570,899.55 төгрөг, сайн дурын даатгалын шимтгэл 1,734,461,071.32 төгрөг, нийт 2,871,031,970.87 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 57,06 хувиар биелүүлсэн байна.

1. Тайлант хугацаанд 675 иргэнийг нийгмийн даатгалд шинээр хамруулсан, гүйцэтгэл хувьтай байна.

2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө бүрэн биелэгдээгүй шалтгаан нь:

-2024, 2025 онд тус тасгийн нийгмийн даатгалын сангийн төлөвлөгөөг өмнөх онуудаас 66.9%-иар огцом нэмэгдүүлсэн.

-2025 оны гэрээт ажилтны квот ашиглалт 53.5% байсан.

-Тасгийн хүний нөөц тогтворгүй, үндсэндээ хагас жилээс хойш 5 хүнтэй ажилласан.

-Төвийн шатахуун, томилолтын зардал хангалтгүйгээс явуулын үйлчилгээ багассан.

-Иргэд тогтвор суурьшилгүй, шилжилт хөдөлгөөн их, утасны дугаараа байнга сольдог.

-Хөдөлмөрийн гэрээт иргэд БНСУ-ын “Үндэсний тэтгэврийн даатгалын тухай” хуулийн 127 дугаар зүйлд зааснаар тухайн улсад ажил, хөдөлмөр эрхлээд Үндэсний тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн зарим гадаад улсын иргэн нутаг буцахдаа ажил олгогчийн болон өөрийн төлсөн шимтгэлээ нэг удаа буцаан 100 хувь авдаг тул Монгол Улсын нийгмийн даатгалд хамрагдах нь эрс багассан.



